


А.Амарсайхан

АРВАН ДӨРӨВТЭЙ ТОМ ХҮН



Хүмүүн цасиг цуврал 1

Арван дөрөвтэй том хүн
Зохиолч: А.Амарсайхан
Редактор: Б.Галаарид

ISBN: 978-99962-2-800-1

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Урт нүүдэл

Урьд нь нүүдэл хийнэ гэхээр хүү бөөн баяр болдог байж. Гэр буулгах, авдар сав ачаалах, үхэр тэргэнд суух, шинэ нутаг үзэх гээд бүх зүйл сонин содон. Өдөржингөө сэтгэл сэргэж, хөл хөнгөрөөд, ер бусын байдагсан. Гэтэл энэ удаагийн нүүдэл долоон настай Доржсүрэн хүүгийн хувьд залхмаар урт сунжрав. Удаан лазан алхаатай үхэр тэргээр өдөржин сажлуулна гэдэг туулж барагдашгүй уйтгар. Нэг уулыг давахаар нөгөө уул гараад ирнэ. Энэ гүвээний цаана хот харагдах болов уу? гээд тэсч ядахаар дараачийн гүвээ цэлсхийн тэнгэрийн хаяаг далдалчихна. Хүүгийн тэвчээр үнэнхүү барагдаад байлаа.

Хөллөгөөний шар залхуутайяа газар хороож, тэрэгний яйжиг дугуй чихар яхар дуугарна. Халуун нар зулай дээрээс шарж, ам цангаана. Дашмагтай хүйтэн цайнаас уух гэхээр,

-Дахиад л “Зогсоод өгөөч” гэж гунганаж ахыг уурлуулмаар байна уу? хэмээн эгч нь аашилна. Түүний түмэн зөв. Олон дахин зогсож морь харвал томчуудын ундууг хөдөлгөх нь мэдээж хэрэг. Энэ нүүдэл хэзээ нэг юм дуусч, хүссэнээрээ хүйтэн цай залгилж, дураараа хөлөө тэнийлгэж, гүйж харайдаг болно доо? гэж бодохоос цаг мөч өнгөрөхгүй.

Тэр үеийн Архангай аймгийн Авзагахайрхан сум, өнөөгийн Булган аймгийн Гурванбулаг сумын нутаг Хар бухын голоос гарсан нүүдэлчид хэд хоног явж буй нь энэ. Нар гудайж орой болох тийшээ хандахад Гомбо ах нь “Өртөө илүү явчихлаа. Одоо бууна даа” гэж хэлээд буудаллах газраа сонгоно. Гэрийн таван ам бүл эзгүй хээр ундуй сундуй буудаллаж, хэдэн унь холбон туурга нөмрүүлж, шовоохой гэгч түр оромж барьж хоноглоно. Өглөө эртлэн босцгоож, хээрийн хар цай даргиулж, хам хум унд уусан болоод л хэдэн шараа хөллөн хөдөлнө. Ингээд л нүүдлийн дуусдаггүй урт гэлдрээн эхэлнэ.

Эхний өдрийнхөө орой тэд Дашинчилэнгийн ойролцоо Шар тал гэдэг газар хоноглосон. Ган төмрөөр бүтээсэн оньсон тэргээр биш өвсөн тэжээлтэй махан бодьтой буянт малаа хөсөглөж яваа болохоор үхрээ амрааж идүүлнэ. Дулаахан шөнө бол гадаа унтах агаад огторгуйн түмэн оддыг ажиглан хэвтэнэ гэдэг соньхон. Голдуу гол ус, худаг шанд тааруулж буудаллах ч, заримдаа ундгүй газар таарна. Долоон даваа гэгч рүү ойртоод, ах нь “Ус ч үгүй газар хононо шүү” гээд замаасаа ундны усаа авч тээхэд хүү “Тэр газар нь очоод усаа барчихвал яана аа?” гэж санаа зовнисон юм. Гэвч хөсөг Долоон даваагаар ажралгүй өнгөрч, Бад, Лүн ч гэх шиг этгээд хачин нэртэй газруудаар дайрч, аанай л хээр хөдөөгүүр буудаллан, саадгүй сайн явсаар байлаа.

Нар баруун уулын толгой руу гудайж, орой боллоо. Нүүдлийн магнайд үхэр тэргээ хөтлөн, чөдрийн ганц морио хааяа нэг давиран гэлдрүүлж яваа Гомбо ах, сүүлийн тэргэнд суусан ээж рүү эргэж хараад,

-Нохойн дуу ч ойртлоо доо. Тээр тэнд хүрэнгэж байгаа хөтлөөр даваад л нийслэл хот харагдана шүү дээ гэхэд ээж нь,

-Ээ, Богд минь өршөө..., гэж уулга алдлаа. Хоёр эгчийнх нь царай гэрэлтээд явчихлаа. Доржсүрэн хүү ч тэргэн дээрээ өндөлзөж, тэр хот гээч гоё юмыг бушуухан харахсан гэж

яарлаа.

Үйлдвэр комбинатын цагдаагийн салаанд алба хаших болсон Гомбо ах нь ээж болон хэдэн дүүгээ хот газар бараадуулж, ажилтай албатай, хүний зэрэгтэй болгоно гэж сэтгэл шулуудсанаас эднийхэн нүүдэл хийсэн нь энэ. Ах нь гялгар товч, улаан дөрвөлжин тэмдэгтэй, гоё хувцастай давхиж ирээд,

-Бүгдээрээ нүүцгээнэ. Хотын хүмүүс болно! гэхэд нь Доржсүрэн, хотод очвол би ч бас ах шигээ цэргийн хүн болно гэж баярласан билээ.

Шар хөвийн дөрөлж давмагц алсад олон байшингууд, утаа баагисан өндөр яндан торойтол гарч ирээд хараа булаалаа. Цагаан, яагаан, шаргал, бор саарлаар алагласан нийслэлийг барааг ширтэн, “Ийм олон байшин байдаг гэж үү?” хэмээн хүү гайхлаа. Гайхам чамин барилгууд, тэдгээрийн хооронд шоргоолж шиг хөлхөх хүмүүс, наашаа цаашаа давхих олон машинууд нь үлгэрийн юм шиг содон. Энэ бүх ид шидийг гайхан харж, тэргэн дээрээ өндийсөн чигтээ алмайрч байтал ах нь,

-Орой болчихлоо. Энэ хавьдаа хоноглоно доо гэж байна. Баярлах бас л болоогүй болж таарах нь энэ! Яваад яваад хүрч болдоггүй яасан хол хот вэ? гэж хүү дотроо харууслаа.

Эмээлт гэгч газар тулга тулж, борцтой шөлөө пор порхийлгэн буцалгаж, оройн хоолоо идэцгээв. Гэрийнхэн бүгд унтахаар хажуулцгааж, тэр дорхноо нойрондоо дийлдлээ. Доржсүрэн харин орон дотроо эргэж хөрвөөж, огт унтах янзгүй. “Маргааш хот орно. Зөндөө гоё чихэртэй, Хайрханы цохио шиг өндөр хоршоонд орж үзнэ” гэсэн амттай бодлууд цээжинд хурган, нойр хулжаана. “Давхар байшингийн хамгийн дээд цонх руу яаж ордог бол? Над шиг жаахан хүүхдүүд хаданд тоглож байгаа юм шиг авираад гарчихаж болно. Гэтэл томчуул авирч чадахгүй яах вэ? Хачин юм аа?” гэж хүү гайхан бодсоор байлаа.

Өглөө сэрмэгцээ өндийвөл гадаа ах дуу алдаад, хэн нэгнийг зүхэж бачимдах дуулдлаа. Ээж бас шогшроод, халаглаад л байх. Яасан юм бол оо? гэж хүү гайхаад, шагайлаа. Тэгтэл чөдрийн ганц морийг нь хулгайч аваад арилсан байлаа. “Явгарчихсан болохоор цаашаа нүүхгүй. Хот үзэх өнгөрлөө!” хэмээн хүү айлаа. Гэвч ах нь шал өөр зүйл хэлж, санаа амраав.

-Төвхнөх газраа эртхэн хүрч гэрээ барина гэснээ цайгаа бушуухан ууцгаах юм болцгоов. Шарнуудаа усалж хөллөсний дараа, ачааны өмнө морьтой гэлдэрдэг байсан Гомбо ах нь үхэр тэргээ явган хөтлөн хотын зүгт ширтэн, хүнд хар гутлаа пэр пэрхийлгэн алхаж явлаа.

Эднийхэн Архангай аймгийн Их Тамир сумаас гаралтай хүмүүс. Тэндээсээ зэргэлдээ сум руу нүүн ирж амьдарч байтал 1931 онд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэ хуваарилалт явагдаж, Архангай аймгийн Авзагахайрхан сумын айл болцгоосон. Тэднийг хот нүүснээс хэдэн жилийн дараа Авзагахайрхан нь шинээр байгуулагдсан Булган аймгийн харьяанд шилжээд, Гурванбулаг, Хишиг-Өндөр хоёр сум болж хуваагдсан гэдэг.

Өнөөгийн Хишиг-Өндөр сумын харьяат ард Жамъянжав гэдэг их буянтай хүний хаяаг бараадаж, мал ахуйд нь туслан, ээж хүүхдүүд аж төрж байж. Гомбо ах нь айлын адуу хариулдаг. Зунд Жамъянжав гуай арваад үнээ зааж өгөөд, “Энэ хэдийг саагаад, сүү саалийг нь

ав. Тос ааруул хураа” гэдгээр барахгүй гүүгээ бариулж, айраг уулгадаг өгөөмөр нэгэн. Хот руу нүүхэд нь,

-Та хэд тэнд очоод болмооргүй бол буцаад нүүгээд ирээрэй. Би хажиглахгүй, харин ч хамаатан саднаа ирж байгаа юм шиг баярлаад л угтана. Ажил алба нь олноод тэндээ төвхнөх бол тэргэндээ мод ачаад, нутгийн хүнд дайчихна биз гээд хэдэн сайхан шар хөллөсөн тэрэгнүүдээ гаргаж өгч байж. Энэ нүүдэл 1934 оны зун болсон юм.

Зүлгэн дээр гэрээ барив

Түрүүлж ирээд ажил албатай болж төвхнөсөн том хүүгээ бараадан нүүж ирж буй эзэгтэй үйлдвэр комбинатаас арагш, одоогийн Авто засварын завод байгаа жалганд, сайхан ногоон зүлгэн дээр ая тухтай тэгшхэн талбай сонгож, бор гэрийнхээ ханыг шийрлэлээ. 1934 онд тэр орчмын газар ямар ч барилга байшингүй зэлүүд, хивс дэвсчихсэн юм шиг ногоон ширэг байсан хэрэг.



Хүмүүс аль эвтэйхэн, ажил албандаа ойр гэсэн газраа сонгоод гэрээ барьчихна. Хөдөө талдаа тархан буусан малчин айлууд шиг л энд тэндгүй гэрүүд харагдана. Хоорондоо бас ч үгүй нилээн зайтай бууцгаана. Хашаа хороо гэж байхгүй, задгайд барьсан гэрүүд энд тэндгүй харагдаж, гадуур нь хүүхэд шуухад тоглоон гүйлддэг байлаа. Засаг захиргаанаас зөвшөөрөл авна гэх зүйлийг мэдэхгүй. Тэгэх шаардлага ч байхгүй. Хэн ч тэднийг дуртай газраа гэрээ барилаа гэж хөөж туухгүй, зүлгэн дээр гэрээ бариад зүгээр л амьдарчихдаг амгалан сайхан цаг байж. Хэд хонож, ээж эгч нар нь үйлдвэрт ажилд ороод байтал Гомбо ах нь,

-Аз болж нутгийн тохьтой томоотой хүн тааралдлаа гээд хүрч ирлээ. Жамъянжав гуайн үхэр тэрэгнүүдэд мод ачаад, нутгийн Дорж гэгч хүнээр буцаан дайж явууллаа. Ингээд л эднийхэн эргэлт буцалтгүй, хотын айл болчих нь энэ.

Шинэ тулгар байгуулагдсан Аж үйлдвэрийн комбинат ажилчдыг олноор элсүүлж, нийслэлийн хорооны бор залуус оёдолчин, эсгүүрчин, эсгийчин, засварчин гэгдэж цоо шинэ цаг үеийн, цоо шинэ хүмүүс болон өнгө жавхаа орж, эрдэм номд тайлагдаж, танигдашгүй болцгоож байв. Хөдөө нутгаас өөрийн гэх мал хөрөнгөгүй ядуу дорой ардууд нийслэлд ирж, үйлдвэрийн ажилчнаар элсэж, шинэ үеийнхний эгнээг нэмлээ. Цалинтай орлоготой, албатай амьдралтай болсон нэг нь хөдөө тийш садан хамаатандаа хэл сураг дуулгаж, цаадуул нь яаран нүүж ирцгээж, үйлдвэр комбинат гэх айл ам бүлээ нэмсээр л байсан хэрэг. Сүм хийдүүдийг тарааж, бага дунд мяндагтай, ядуу лам нарыг ч олноор нь ажилчин ангийн эгнээнд нэгтгэлээ. Малчин Монгол үйлдвэржсэн Монгол болох эхлэл тавигдаж, үхэрчин хүү Цэрэндорж, үйлчин хүү Цэрэндорж болох нь тэр. Энэ бүх хүмүүсийн эгнээнд Архангайгаас нүүж ирсэн эзэгтэй Лхамжав, түүний хүү Гомбо, арван дөрөвхөн настай ихэр охин Дэндэв, Сэрээтэр нар багтаж, энэ өрхийн түүх шинэ хуудсаа нээсэн нь энэ байв.



Долоон настай хүүд түм түжигнэж бум бужигнасан хот газрын юм бүхэн гайхаад баршгүй. Дунд голын хойно харагдах олон байшингаар өдөржин нүд хужирлана. Хотын хүмүүс хачин чамин хувцас өмсөнө. Бас гоё сүйх тэрэг, машин унан нааш цааш давхилдана. Зарим зүйл нь аймшигтай. Нэгэн удаа гэрийнхээ гадаа зогсож байтал өмнө талдаа гялгар цагаан төмөр тас зуурсан, хий агаарт дэнжигнэсэн хачин хүн тэднийх рүү ирж явна. Гайхан ажвал хийсэх мэт хурдлан яваа тэр хүний хөл дор хоёр нарийхан дугуй эргэлдэх нь аймаар. Шидэт юм хөлөглөсөн тэр хүн юу юугүй хийсч ирээд гэр дайрах нь уу гэлтэй. Хүү айсандаа чанга гэгч орилон гэр рүүгээ гүйж орлоо.

-Унадаг дугуйтай хүн л байна шүү дээ! Юунаас нь айдаг байна аа? гэж эгч нар нь уцаарлалаа. Хүү айсан хэвээр, хаалга руу түгшүүртэй харж, биеэ туулай шиг хураан хярах нь өхөөрдөм. Өнөөх аймшигтай хүн үүдээр сүнхийн өнгөрөв.

-Нялх амьтан, айлгүй яах вэ! Манай хөдөө ийм унаа байх биш! гэж хэр баргийн юманд дуугардаггүй ээж нь ам нээлээ. Хааяа нэг ам ангайхаараа, “За, яах вэ” гэхчээд сууж байдаг ээж нь түүнийг өмөөрч “хэтэрхий олон” үг хэлснээр барахгүй, хүүгээ аргадаж тайвшруулан мөөмөө амлууллаа. Айлын бага хүүхэд болохоор Доржсүрэн ийнхүү мөөм хөхөж эрхлэнэ. Ээжийгээ “Мөөмөө” гэж дуудна. Арван нас өнгөртлөө мөөмөө хөхсөөр л байсан гэдэг. Түүнийг ингэж нялхамсахад нь “Бяруу шиг том болчихоод. Мөөмөө хөхөөд л..!” гэж хоёр эгч нь шоолно. Хүү тоох ч үгүй эрхэлсээр л байна.

Бяцхан хүү унадаг дугуй гэгч тэр аймшигтай юманд яагаад ч дасахгүй. Дугуйтай хүн ирж яваа харагдвал гэртээ бушуухан гүйж ороод, байдгаараа сандран нуугддаг байлаа. Одоо ер шүргэж буй хөгшин “Унадаг дугуйтай хүнээс айдаг, мөн ч хөгийн хүн байж дээ, би” гээд инээдэг.

Задгай талд тараад буучихсан айлууд руу цахилгааны шугам татах тухай бодох бүү хэл зүүдэлдэг ч үгүй байсан үе. Оройд цөгцөнд барьсан дэнгийн гэрэл ёлтолзоно. Оросод үйлдвэрлэсэн цэнхэр савтай урт лааг хааяа нэг барихаар өдөр шиг гэрэлтэй санагдана. Тэр лаа нь хэр барагтаа олддоггүй ховор эд бөгөөд дэлгүүрт ирсэн сураг гараад л алга болчихдог байлаа. Хүнсний зүйлс их хямдхан. Арван хэдэн төгрөгөөр шөлний хонь авчихдаг, одооныхыг дөрөв тав нийлүүлсэнтэй тэнцэх том талхыг дэлгүүрт хэдхэн мөнгөөр худалдана. Хөдөөнөөс ирсэн таван хүний амьдрал ийм л байдалтай эхэлж, пошхийгээд л явчих нь тэр.

Комбинатын сургуульд

1935 онд Доржсүрэн хүү найман нас хүрч, сургуульд орлоо. Тэр үеийн сургууль сайн тохижиж амжаагүй, Комбинатын зургаан байрны нэгнийх нь булангийн жижигхэн өрөөнд хоёр анги, дэлгүүрийн урд талын байшинд нөгөө хоёр анги нь хичээллэж байлаа. Хожим нь зургадугаар сургууль болон өргөжсөн энэхүү ном эрдмийн бяцхан өргөөг тэр үеийн нийслэлийнхэн “Комбинатын сургууль” гэж нэрлэдэг байлаа. Хичээлийн эхний өдөр,

-Овог хэн бэ? гэж багш Доржсүрэнгээс асуулаа. Хүүхдүүдээ бүртгэж, журнал бичгээ хөтлөх гэсэн нь тэр. Хүү эцгийгээ мэдэхгүй учраас сандарлаа. Эцэг нь түүнийг ухаан орохоос өмнө нас барчихсан гэдэг. “Миний аав ямар хүн байсан юм бэ?” гэж асуугаад аавынхаа тухай яриулж байснаас биш, яагаад ч юм аавынхаа нэрийг ээжээсээ асууж байсангүй. “Тэртээ хариад, ээжээсээ аавын нэрийг асуугаад ирье” гэлтэй биш. Тэгэх юм бол хүүхдүүд шоолно.

-Овог хэн бэ? гэж багш дахин асуулаа. Хүү таг.

-За тийм байж. Хамгийн том ахыг чинь хэн гэдэг вэ?

-Гомбо гэдэг. Энэ хариултыг сонсоод багш журнал дээрээ юм бичлээ. Бяцхан хүүг ахаар нь овоглож, “Гомбын Доржсүрэн” гээд бүртгэчихсэн нь тэр байлаа. Түүнийг насан туршид нь дагасан Гомбын гэдэг овог ийм түүхтэй. Харин түүний эцэг Архангай аймгийн Их Тамир сумаас гаралтай Гэндэн гэдэг хүн байсан гэдэг.

Хичээл эхлээд хэд хоноод байтал тоо бодлогын хичээл дээр “Танай бод хэд вэ?” гэсэн асуултад хариулж ирэх даалгавар өглөө. “Танайх хэдэн модтой вэ? гэж асуудаг нь ямар учиртай юм бол оо?” гэж зэрвэс сонссон хүү гайхлаа. Гэрийнхээ гаднах түлээний гуалингуудаа тоолж, бичээд очиж байв. Комбинатын сургууль уртаашаа дөрөвхөн ангитайгаар барахгүй ангид арван хэдүүлэхнээ сурна. Бүр есөн хүүхэдтэй анги ч байсан гэдэг.

Сургуульд цөөн хэдхэн багш ажиллана. Ангийн багш нь Төмөртоого гэж Нисэхэд ажиллаж байсан гэлцдэг, сайхан залуу байх. Төмөртоого, Данзанбалжир хоёр багшийг хүүхдүүд “Гоё багш” гэгцгээнэ. Төмөртоого багш нь туранхайвтар, түргэн хөдөлгөөнтэй, хөнгөн шингэн. Шавь нартаа яг л өөрийн хүүхдүүд мэт элгэмсүү. Дандаа инээд алдаж явах. Данзанбалжир багш өндөр нуруутай, ханагар өргөн цээжтэй, зүүн хацартаа мэнгэтэй. Хоёр гараараа сурагч ширээ тулаад бөхийсөн байтал өмнөх хүүхдийн толгой цээжнээс нь тээр доор харагдана. Хоёр багш хоёул их сайхан зантай болохоор сургуулийн бүх сурагчид энэ хоёр багшдаа их сайн. Тэр хоёрт тоогдох гэж байдгаараа мэрийдэг байлаа.



Ээжийнхээ өврөөс гараагүй нялхамсуу хүү хотын хүүхдүүдийн дунд ороод шал өөр хүн болж эхэллээ. Хүүхдүүдийг дагаад Туул гол руу очиж тоглоно. Комбинат орчмоор чөлөөтэй явдаг болсон төдийгүй заримдаа ангийнхнаа дагаад хотын төвөөр ч алхдаг болов. Ээжийнхээ мөөм хөхдөг гэдгээсээ ичиж, хүүхдүүдээс тас нууна. Мөөм гэгчийг мартаад долоо найман жил болчихсон ангийнхаа хүүхдүүд шиг ганцаараа унтаж, бие даасан том эр хүн болох гэж битүүхэндээ мачийна. Гэлээ ч гэртээ орж ирээд л энэ бүх бодлоо мартаад ээждээ эрхэлж эхэлдэг байлаа.

Комбинатын сургуулийн захирал нь Бизъяа гэх овжин төрхтэй, туранхайвтар шөвөлзсөн шар хүн байлаа. Том хар машинтай. Түүнийг нь Монгол кино үйлдвэр хөлсөлж луу хээтэй болгон будаад, “Сүхбаатар” кинонд Богд хааны машин болгон зураг авалт хийж байсан түүхтэй. Бизъяа захирал их сайн хүн. Цөөхөн сурагчиддаа их дотно. Хүүхдүүдээ аваад Налайх гэхчлэн газруудаар аялал хийж, уурхай үзүүлж, тайлбарлаж ярьж өгдөг байлаа.

Япон, Англид элчин сайд байсан, нэрт дипломатч Дамбадаржаа гуайн гэргий Дуламсүрэн гэдэг багш Доржсүрэнгийн ангийг дараа нь дааж авч байлаа. Даалгавар хийгээгүй, хичээлээ цээжлээгүй хүүхдүүдийг чимхэж шийтгэнэ. Багшдаа чимхүүлэхгүйн тулд хичээхгүй бол горьгүй. Тоо бодлого, монгол хэл, байгаль, газрын зүй, биеийн тамир гээд орох ёстой бүх хичээлүүдийг сургууль заана. Биеийн тамирын хичээлийг голдуу гадаа хийх бөгөөд өвлийн хүйтэн цагт ангидаа ширээ сандлаа хойш хураачихаад орчихдог. Арван хоёрхон хүүхэдтэй болохоор багтахгүй гэхийн зовлонгүй.

Биеийн тамирын багш нь харин Ванчиг гэх нилээд зэрлэг эр байлаа. Байнга л хутга шидэх сургууль хийж байна. Тэр үед овоолго гэх үзүүлбэр ихэд дэлгэрч, наадам цэнгүүн болгон дээр

үзүүлнэ. Ванчиг багш хүүхдүүдээр овоолго хийлгэх дуртай. Үлгэрлэж хэлбэл бие биенийхээ мөрөн дээр зогсож улам дээшээ цоройж тэмүүлсээр, хүнээр босгосон цамхаг, уран барилга болох ёстой. Хамгийн дээр нь ихэвчлэн хөнгөн биетэй жижигхэн хүүхдийг гаргах нь мэдээж. Өндөрт гарсан жижигчүүдэд газар тээр дор харагдаж, хөл дор нь тулгуур болон зогсох олон хүүхэд чичрэн тэнцэгнэж, уначих вий гэхээс үнхэлцгээ хагартал айна. Алдаа гаргавал багш шийтгэнэ. Ванчиг багш хүүхэд рүү хутга шидсэн хэргээр ажлаасаа халагдаж байж. Аз болоход Дашням гэгч хүүхдийн булчинд хутганы үзүүр өнгөцхөн шигдээд тогтсон байсан гэдэг.

Мэдээж сурагчид сиймхий гарвал зүгээр байхгүй, зүггүйтэх нь ойлгомжтой. Зүггүйтсэн хүүхдийг үстэй дээлийн дотрыг нь гадагш харуулан өмсүүлж анги хэсүүлнэ. Арзайсан нэхий дээлтэй, үзлийн царайтай сахилгагүйчүүдийг хүүхдүүд “Еэ еэ, бөөвөө” хэмээн хоолой нийлүүлэн шоолж бах таваа хангадаг байлаа.

Насан туршийн найзууд

Талаар нэг тарж буусан айлуудын дундуур хоёр хөвгүүн алхсаар таван ханатай бор гэрийн гадаа ирмэгцээ зогсож зөөлхөн исгэрнэ. “Гараад ир. Бид ирчихлээ!” гэсэн нууц дохио өгч байгаа нь энэ. Томчуул нь бүгдээрээ үйлдвэрт ажиллаж, Доржсүрэн хүү гэртээ ганцаараа голдуу байдаг хэдий ч юмыг яаж мэдэхэв ийнхүү сэргэмжлэнэ. Ах Гомбо ээлжгүй үе нь таарвал хүүхдүүдийг “Нийлж дэмий тэнэж, тархигүйтэх нь үү?” гэж аашилж магадгүй учраас болгоомжлох нь зөв. Исгэрэгч нар бол түүний ангийн найз Цагаан, Самдан гэх дэлчгэр хөх хөвгүүд. Хөдөөний эрх танхил хүү найз нөхөдтэй болж, комбинатын бор хөвгүүдийн нэг болж “нийгэмшиж” амжсан нь энэ.

Гурван найз амралтын өдрөө хотын төвөөр алхаж, усны гудамж, хятад шийяанзны орчмоор хөлхөж, энэ тэрийг сониучирхаж өнгөрөөнө. Гандан хавь руу харин зүглэхгүй. Шашин шүтлэгийг нийтээр жигшиж, хорт могой хэмээн сурталдаж, лам нарыг ардын дайсан болгож байсан үе болохоор тэднээс хол байх ёстой гэж үзнэ. Одоогийн Урт цагаан байгаагийн хавиар байрлаж байсан захаар явна. Голдуу хятад худалдаачид жижигхэн лангуунууд эгнүүлэн тавиад, элдэв ногоо, сонгино сармис, танзуур еэвэн зэргийг наймаална. Монгол панзчид хөөрөг гаанс, эмээл хазаарын наймаа хийнэ. Гурван хүү энэ бүхнийг сонирхож, хэрэгт дурлаж, томчуудын яриа сонсоно. Тэгэхгүй бол амралтын урт өдөр өнгөрөхгүй. Зуны халуун өдөр бол Туул голын усанд өдөржин шумбан наадацгаана.



Ажлын өдрүүд арай өөрөөр өнгөрнө. Үдээс өмнөх ээлжинд хичээллээд харьж ирцгээсний дараа гэртээ хэдэн минут ч бололгүй гурван найз цугларна. Самдангийн аав Эсгийлэх үйлдвэрт ажилладаг Санжмятав гэж өвгөн байх. Ээж нь ч бас тэнд ажилладаг, хоёулаа албандаа явчихдаг болохоор тэднийх эзгүй. Тийм болохоор хүүхдүүд эрх дураараа байцгаана. Цагаан гэрээсээ жаахан гурил, Доржсүрэн шөлний тос авчирна. Ингээд л хувь нийлүүлсэн үйлдвэрийн хийцтэй цайгаа даргиулна. Яг л хэзээ язааны өвгөд шиг хөлсөө чийхартал ууцгаана. Гурван хүү яагаад ч юм ийнхүү эмгэд өвгөдийн цайнд дурладаг байж. Харин орой тийшээ гэр гэртээ харьж даалгавраа хийцгээнэ. Томчууд цугларсан хойно нүдэн дээр нь хичээл номоо хийх нь нэр төрд нэмэртэй.

Доржсүрэн, Цагаан, Самдан гурвуул ийнхүү үй зайгүй найзалж, хаа ч явсан салахгүй. Гучаад оны бор өдрүүдийг хамтдаа өнгөрөөн, зүггүйтэж хөглөж ахуйдаа Доржсүрэн нэгэн насны найз нартайгаа учирснаа мэдээгүй л явж. Энэ хоёр дэлчгэр хөх хөвгүүний нэг нь хожим “Нэгдүгээр сургуулийн Цагаан” гэж олонд алдаршсан гавьяат багш болж, нөгөө нь “Үйлдвэр комбинатын театрын жүжигчин, Монгол улсын соёлын тэргүүний ажилтан Самдан” гэж

дуудуулан тайзнаа гарч, үзэгчдийн нижигнэсэн алга ташилтаар шагнуулсан нэр хүндтэй хүмүүс болцгоосон. Энэ хоёр насан туршдаа Доржсүрэнтэй найз хэвээрээ л явсан билээ.

Доржсүрэнгийн ээж Дагжийн Лхамжав гэж хүн байлаа. Хөдөөнөөс ирмэгцээ оёдлын үйлдвэрт гэрийн цагаан бүрээс оёж байснаа, гутлын үйлдвэрт гар гутал утлагчаар ажиллаж эхэллээ. Хоёр эгч нь анх арван дөрөвгэй гутлын үйлдвэрт орж байснаа бодвол хэдийнэ хоёр жил ажиллаж амжаад, сайн гэгддэг оёдолчин эсгүүрчин болцгоосон, ах нь комбинатын цагдаагийн салаанд албаа үргэлжлүүлэн хашсаар л байлаа.

Эрх дүү нь сургуульд орж, үеийн хүүхдүүдийн дунд орж, өөрчлөгдөж байгааг ах эгч нар ажиж “Овоо доо, одоо л хүн болох нь” гэж сэм хэлэлцэнэ. Гэвч ээж гэдэг хүн үгэнд нь орохгүй бага хүүдээ мөөм хөхүүлж эрхлүүлсэн хэвээр. Ил далд мөөм хөхөж эрхэлдгийг нь эс тооцвол Доржсүрэн хотод ирснээр бас ч гэж догь эр хүн болж, их зүйлийг мэдэж авч амжсан байлаа. Олон давхар байшингийн хамгийн дээд давхарт гишгүүртэй шатаар хялбархан гэгч алхаад гарчихдаг болохыг нүдээрээ үзэж, өнөөх хармагцаа амиа гартлаа айдаг унадаг дугуй гэгч зүйлээ өөрийн гараараа барьж, оролдож үзсэнээр барахгүй дугуйтай болохыг мөрөөддөг болчихсон гүйж явлаа.

Эднийх автозаводын хавьцаах жалганд хоёр жил аж төрөөд, одоогийн 120 мянгатын автобусны буудал, Удирдлагын академийн ойролцоох газар луу нүүлээ. Дараа нь ахин нүүж Архин заводын хашааны ёроолд бууснаар гэртээ цахилгаан гэрэлтэй болж, “нар гарч” байлаа. Тэр үеийн Архин завод одоогийнх шигээ том байсангүй, хуучин муу модон хашаан дотор нэг нь архи, нөгөө нь шар айрагны үйлдвэр гэх хоёр жижигхэн байшин байж. Энд цагдаа Гомбо ах нь харуулд гарна. Рэнцэнхорлоо гэх, хожим нь Хотын цагдаагийн газар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хурандаа болсон хүн Комбинатын цагдаагийн салааны даргаар ажиллаж байлаа.

Арав үзсэн кино

Тэр үеийн хүүхдүүд хэрхэн яаж чөлөөт цагаа өнгөрөөдөг байсан нь сонин. Одооны хүүхдүүдэд, ном унших, РС тоглох, кинотеатрт очих, телевиз үзэх, спортын секцэд явах, хэлний дамжаанд суух гээд цагаа нөхцөөх зүйл тоо томшгүй олон. Телевиз үзлээ гэхэд, “Сагсан бөмбөгийн тэмцээн үү? Холливудын кино юу? Хүүхэлдэй юу?” гээд зуу гаран суваг солих сонголттой.

Гэтэл гучин хэдэн оны хүүхдүүдэд үзэх харах, цаг нөхцөөх зүйл ховор байж. Анхны кинотеатр болох “Ард” байгуулагдсан байсан ч тэнд нь хүүхдийн кино гарах гэж бараг л үгүй. Телевиз РС хоёр бүр сураг ч үгүй цаг үе байлаа. Бөмбөгөр ногоон театрт жүжиг үзэх гэхээр насанд хүрээгүй гээд оруулахгүй. Ном гэдэг зүйл ховор бөгөөд, хүүхдийн ганц нэг ном гардгийг дамжуулж уншаад бараг л цээжилчихсэн. Ангиараа, найзуудаараа талцан лапта маатаг гэх орос тоглоом тоглоно. Хааяа нэг хүүхдийн кино ирэхэд нь тасалбар авахын төлөө алаан хядаан болтлоо шахцалдаж, тэр шинэ киног хэд дахин давтан үзнэ. Тэр үеийн хүүхдүүдийн хэлдгээр “Сайхан Пашли” буюу “Сайхан Василиса” гэдэг орос үлгэрийн киног л гэхэд Доржсүрэн, Самдан, Цагаан гурвуулаа арван хэд дахин үзэж байж.



Хятад шийяанз гэгчид бас л хүүхдийг оруулахгүй. Арга саам хийн хэдэн удаа тийш орж, ший янгуу гэгчийг үзэж байлаа. Нүүр амаа хачин гайхалтай будсан, эрээн мяраан хувцастай хүмүүс хятад хэлээрээ шулгалналдаад л, уйлж нэг үзээд, инээж нэг үзээд, ий-уу-яа-аан гэж уянгалуулан дуулаад л, хөгжим нь ёнгиноно. Эхлээд харахад инээдтэй ч юм шиг, сайхан ч юм шиг байснаа дорхноо уйдаж хаячихаад гарна. Сүүлд нь дахиад л үзмээр санагдаж, нуугдаж ороод, бас л юу ч ойлгохгүй болохоор нь хавчигнаж жаахан сууснаа, орхиод гараад ирсэн гэдэг.

Хүүхдүүд л болсон хойно зүггүйтнэ. Богд уулын ар өөд гарцгааж, чулуу чавхаар байлдана. Зайсан болон түүний зэрэгцээ толгойнуудыг хувааж аваад, өөрсдийн газар нутаг болгоно. Комбинатын хүүхдүүд өөрийн өмчний өндөрлөгтэй, хотоос ирдэг хүүхдүүд бас өөрийн газартай. Ингээд л дайсны газар нутгийг эзлэхийн төлөө хоёр тал болон тулалдаанд орж, чулуугаар байлдана. Хожим нь олонд нэртэй гавьяат жүжигчин болсон Батсүх гэхэд л тэр тулалдаануудад “шархдаж” үүдэн шүдээ онгойлгож байж. Дайсны талын хүү чавхаар харваад шүдийг нь цөмлөчихсөн хэрэг. Заримдаа багш нар чулуугаар байлдаж байгааг нь мэдээд яаран ирнэ, цагдаа ч ирэх нь бий. Томчуудын барааг хармагцаа л “дайчид” бут үсрэн зугтаах агаад баригдана гэж бараг л үгүй.

Газар бүрт орос суртал нэвтэрч, малчин монголчууд европжиж байлаа. Шинэ жилийг өргөн тэмдэглэж, Богд уулнаас гацуур огтолж ирээд чимэглэн, багт наадам хийцгээнэ. Онц сурсан хүүхдүүдэд өвлийн өвгөний бэлэг гардуулж, тааруухан сурлагатай нэг нь алиалагчийн дуранд өртөж нүүр улалзана. Гурван найз “Гэртээ ёлк засья” гэж ярилцав. Шөнө гарч, гудамжны таримал гацуурыг цавчиж үзэв. Их чимээ гараад байх юм гэнэ. “Томчуул мэдвэл алганы амт мэдрэх хэрэг гарна. Больцгооё” гэж шийдэцгээв. Дараа шөнө нь чарга чирээд Яармагийн Хүйсийн ам өөд явцгааж, харанхуйд ямар ч гэсэн нэг мод унагааж авав. “Энэ чинь гацуур биш шүү дээ” гэж нэг нь үглэлээ. “Чимэглэж л байвал ямар нь ч яадгийм” гэж нөгөө нь мэдэмхийрэв. Гурвуул унагаасан модоо чирсээр гэртээ иртэл шинэс модны газар чирэгдсэн тал нь юу ч үгүй болтлоо халцайчихсан байх юм гэнэ. “Халцгай талыг ар талд нь гаргачихна” гэлцээд, “гацуур”-аа чимэглэж байж.

Гурван хүү сурлага сайтай хэрнээ сахилгагүй. Байнга л хэрэг тарьж явна. Дуламсүрэн багшаараа чимхүүлнэ. Ангийн багш гурван найзыг хүмүүжүүлэх гэж их зүдэрнэ. Тархигүй гурав сургуулийн нутаг дэвсгэр дотор Дуламсүрэн багшийн хараа хяналтаас мултрахгүй. Гэвч сурагч хүн өдөржин сургууль дээр уяатай байдаггүй болохоор хичээл тармагц л аргамжаа алдуурч, хаа ч хүрчихсэн явж мэдэх. Доржсүрэнгийн ээж эрх хүүдээ үг хэлэх бүү хэл ах эгч нараас нь өмөөрч, хир халдаахгүй. Харин Цагааны ээж нь хөл муутай, таяг тулж явдаг хүн байх агаад гурван дэлчгэрийг сахилгагүйтсэн мэдээ дуулдвал шууд л таягаараа тоншино. Сахилгагүйтлээ гээд юу базаах вэ, гуанзнаас хоол авчраад, багшийн ширээн дээр тавиад ангийн хэдэн хүүхэд хувааж идэж байсан нь их том хэрэг гэгдэж, сургууль даяар яриа болно. Ингээд л анги хэсэх шийтгэл хүртэнэ.

Гурван найз амь нэгтэй. Нэг нь таван төгрөг оллоо гэхэд гурвуулаа хамтдаа зарцуулна. Гуанзанд орсон ч хамтдаа, дэлгүүр хэссэн ч хамт л явна. Цагаан сараар айл хэсэж, хишиг цуглуулсан ч гурвуулаа. Тэр үеийн хүүхдүүд шинэ жилээр ч, цагаан сараар ч айл хэсдэг байлаа. Айлын бэлэгний мөнгө цуглуулахыг “Жин татна” гэж нэрлэнэ. Айлууд голдуу нэгт, гуравт өгөх бөгөөд таван төгрөг ч өгчихдөг өгөөмөр эзэгтэй байх. Ийм их мөнгө аваад хүүхдүүд бөөн баяр болж, “Тэднийх таван төгрөг өгч байна!” гэсэн чухал мэдээг бусад хүүхдүүдэд хүргэнэ. Гурвуул мөнгөө нэгдсэн нэг “Сан”-д хуримтлуулна. Айлаас гарч ирээд,

-Чамд хэдийг өгч вэ?

-Надад нэгт өгсөн байна гэлцэн мөнгөө тооцно.

-Чамд гурвыг өгсөн байтлаа, бид хоёрт яахаараа нэг нэгийг өгдөг билээ? гэлцэн өөх өгсөн айлаа, үүдэнд гараад чихийг нь жингэнүүлнэ. Айлд ороод бууз банш идэж дайлуулах сонин биш. Хонины тарган махыг гараар татаж хийсэн, уулын зэрлэг сонгиноор амталсан, одооныхоор бол хамгийн “ориг”, “байгалийн цэвэр хүнс” болох сайхан буузыг хоол гэж үзэхгүй. Хэнийд ч байдаг л зүйл гэж тооцно. Харин “Жин татаж” ахиу мөнгө цуглуулах л хамгийн чухал. Баяр өнгөрмөгц дундын санд цугласан мөнгөөрөө гуанзанд орно гэдэг л тэдний хамгийн дуртай, хамгийн сайхан зүйл. Хятад гуанзны хоол гэдэг гайхамшигтай амттай. Төгрөг тавин мөнгөөр таваг хуйцаа авч подойтол цадна, шарсан мах нь салахын аргагүй. Бас бор ходоодоо дүүртэл компот ууна.

Хурууны үнэтэй аялал

Комбинатын хойд талд хэдэн “барак” гэх байшин байх. Хоёр газар хичээллэдэг байсан сургуулийг нэгтгэж тэрхүү байшингуудын нэгэнд байрлуулав. Хөнгөн хялбар хийцтэй, түр суух зориулалтаар түргэн хугацаанд босгосон барилгыг оросууд “барак” гэж нэрлэдэг гэдгийг хүүхдүүд багшаасаа сонсож мэдээд, “Манай сургууль хэзээ хоёр давхар гоё байшинтай болох бол оо?” гэж мөрөөдөж, шинэ гоё сургуулиа төсөөлөн бодож суусан гэдэг.

Доржсүрэнгийн анги дөрөвхөн эмэгтэй, найман хөвгүүнтэй. Агваан гээд хожим Аж үйлдвэрийн комбинатад ажиллаж, гавьяат цолтон болсон хүү Доржсүрэн, Цагаан, Самдан гуравтай хамт сурна. Гаадан гэж охин ангийн дарга. Дарга нилээд ширүүн үүрэг даалгавар өгнө. Ангид ариун цэврийн комисс ажиллана. Нямаа гэх сүрхий хэл амтай охин энэ комиссын дарга. Нямаа дарга ариун цэврийг их чанга шалгадаг учраас цэвэрч байхгүй бол горьгүй. Ариун цэврийн комиссын даргын дэвтэрт олон удаа муу дүн тавиулвал энэ нь ангийн багшийн сонорт хүрч, даамжраад сургуулийн хэмжээнд яригдаж, анги хэсэх шийтгэл ч авч мэднэ. Тийм болохоор ус зөөж, усанд орж, цамц, нусны алчуураа угаахгүй бол болохгүй.

Салдаггүй гурав бүтэн сайн өдөр чарга чирээд мөсөнд явцгаана. Комбинатын хавийн мөс бохир тул одоогийн Удирдлагын академи байгаагийн энд ирж мөсөө авна. Гол дээр ирээд зүгээр байхгүй. Мөс мөргөлдүүлж баахан тоглоно. Хэсэг тоглоод гэнэт ямар зорилготой ирснээ санаж, чаргаа чирэн гэр лүүгээ яаран алхацгаана. Гэртээ ирээд гол дээр удсанахаа шанг хүртэж, баахан үглүүлж загнуулж аваад, мөсөө хайлуулж, ариун цэврээ сахиж Нямаа даргын шалгалтад бэлтгэцгээнэ.

Амралтын өдөр болохоор голын мөсөн дээр хийдэг өөр нэгэн чухал “ажил” бий. Гурван найз голын мөсөн дээр тэшүүрээр гулгаж наадах дуртай. Эсгий гуталд олсоор бэхэлсэн “Какс” тэшүүртэй хүүхдүүд “Бенц” унасан юм шиг л додигор. Комбинатын харалдаа хавиас гулган явсаар Сонгинын амралт хүрнэ. Тэр үед тэнд Эхчүүдийн амралт гэж байж. Өглөө мөсний аялалд мордсон хүүхдүүд өдөр тийшээ гулгаж тэшсээр буцаж ирцгээнэ. “Норвег” гэдэг урт ганган тэшүүр бол ховор эд. Ганган хар шаахайд хадаж бэхэлсэн “Норвег”-той том ах нарыг хараад хүүхдүүд атаархана. Гэхдээ яах вэ эсгий гуталд олсоор эрчилж бэхэлсэн “Какс” нь хүүхдүүддээ болоод л байна.

Нэгэн амралтын өдөр мөсний аялалдаа явдгаараа яваад Сонгино хүрлээ. Өвлийн илч муутай ч гэлээ нар ээсэн сайхан дулаахан өдөр таарсан тул хэдүүлээ тоглож эхлэв. Өдөржин дураараа тоглосон хүүхдүүд нар хэвийхийг ч анзаарсангүй. Нэг хартал нар жаргаж байна гэнэ. Бушуухан буцахгүй бол очоод жавгий хүртэх нь мэдээж тул хар гүйхээрээ тэшин гэрийн зүг хурдалцгаав. Гэтэл хэрэг бишидлээ. Орой болж голын жавар эхэлсэн тул замдаа үзээгүйгээрээ даарч, бээрч хөлдөх шахсан гурван амьтас гэрийн бараа харцгаав. Доржсүрэн гэртээ орж хоёр эгчийн эрүүний шөлийг бага зэрэг уугаад, хоол ундаа идэж суутал хөл эвгүй болоод байх юм гэнэ. Тэгтэл хөлийн хоёр хуруугаа хөлдөөчихсөн байх нь тэр! Ах эгчдээ жаал загнууллаа. Ээж нь түүний хөлийг нь гаргаад хөлдсөн хурууг нь цасаар үрж өгч байв. Ингэж л хурууны үнэтэй аялал хийж байсан хөгтэй адал явдал түүнд бий.

Үнэгүй хонь

Доржсүрэнгийн эгч юу юугүй төрөх дөхчихөөд байлаа. Гэрийнхэн бараг л бүгдээрээ шахам үйлдвэр дээрээ ажилтай. Завтай хүн байсангүй. Ээж Доржсүрэнг хоёр найзтай нь дуудаад,

-Малын зах руу яваад, шөлний хонь хөтлөөд ир! Хүмүүсээр сайн заалгаад тарган хонь аваарай. Замдаа алдчихав аа! гээд гучин төгрөг өгч гэнэ. Салдаггүй гурван найз мөнгийг өвөртлөөд, том наймаа хийнэ гэхээс ихэд маадгар алхацгаав. Том хүн шиг хонь үзнэ, мөнгөө тоолж өгнө гэж бодохоор гайхалтай сайхан. Бушуухан наймаа хийе гэхээс яарч, малын зах руу нисэх шахам гүйлдсэн хэрэг. Хэдхэн минутын дараа хүрэх газраа ирээд амьсгаадан зогсож байсан гэдэг. Бас болоогүй ээ, нэг нь хонь оосорлох дээсийг хэзээ язааны адуучин шиг эвхээд мөрөвчилчихсэн. Догиос догь улсууд.

Малын зах одоогийн Нарны гүүрийн хойд талд, саяхныг хүртэл Тээврийн товчоо байсны орчимд төвлөрч байж. Малын панзчингууд бүдүүн нарийн дуугаар,

-Тарган хонь шүү. Говийн таана амтагдсан махтай! гэж үгээ олохгүй наймаагаа магтацгаана. Доржсүрэн, Цагаан, Самдан гурав холбоотой хонины сүүл барьж, нуруу тэмтэрч үзэж, инээд хүрэм хэвлүүхэн дүр эсгэн алхацгаав. Томчуудад шог харагдаж байгаагаа өөрсдөө огтхон ч мэдсэнгүй.

-Энэ хонь ямар үнэтэй вэ? Тэр нь хэд вэ? гэж эздээс нь шалгаана. Ихэнх наймаачин гурван нусгай хүүг тоохгүй. Зарим нэг нь,

-Хонь гучин төгрөг. Дөнгөж өнөө өглөө ирсэн тарган хонь шүү, аваарай! гэж уриалгахан хариулна. Юмыг яаж мэдэх вэ, энэ нусгайнууд хонь авчих ч юм билүү гэж горьдож байгаа бололтой гар дагуулан ширтэнэ. Олон хонины нуруу илбэх тусам толгой эргэж самуурах шинжтэй. Хүүхдүүд алийг нь авахаа мэдэхгүй, хонины нуруу сүүл базлан, үнэ асуун хөлхсөөр л. Хоёр бүтэн тойрох гэж байтал панзчдын тэвчээр алдрах нь тэр!

-Таван төгрөггүй байж малын нуруу маажиж малтаад байх! Зайл! гэж нэг хөгшин уурлаж байна. Цаад талд нь нилээд цээж өвчтэй байрын ханхалзсан эр,

-Наад муусайн нусгайнуудад юуных нь мөнгө байх вэ. Таван төгрөг гаргаад үзүүлчихвэл хонио үнэгүй өгчихье л дөө гэж байна. Хонь авахаар харж явсан хүмүүсийн хор шар буцалсан нь илт.

-Хүүхдүүд минь таван төгрөгөө гаргаад үзүүлчих. Бид хамгийн сайн хонийг нь шилээд өгье гэлцэж байна. Өнөөх эр,

-Хн. Эдэнд тав бүү хэл, ганц төгрөг ч байхгүй. Ийм нусан журнуудад бааснаас өөр юу байдаг юм? гэж хамраараа дуугаран, ханхалзсан хэвээр. Хэрэгт дуртай хөгшид, аманцар авгайчууд,

-Та гуравт мөнгө байвал үзүүлчихээч! гээд тэсч ядна. Цагаан гартаа атгаж явсан гучин төгрөг рүүгээ хяламхийснээ, зориг ороод, мөнгөө үзүүлчихлээ. Эргэн тойрны хүмүүс баярлан дуу

алдаад, шуугиад явчих нь тэр! Тэгтэл өнөөх ханхар эр таг. Тэнд байсан хүмүүс,

-Хүүхдийн аз харьчихна. Хонио өг! хэмээн чанга дуу хадааж, өнөөх панзчин руу давшиллаа. Наймаачин ам буцвал бариад идчих нь гарцаагүй шинжтэй.

-Аль вэ, бид нар хонь шилээд өгье. ...Энэ нь ч тарган юм уу, ...Тэр ч арай дөнгүүр юм уу? гэлцсээр догшин байрын халзан хонь холбооноос сугалаад хөтлөөд ирж байна. Цээж өвчтэй эр худлаа инээсэн болоод,

-Ганц хониор хотойдог эр биш! гэж ханхалзлаа. Хэдий гаднаа их үг хэлж байвч, дотроо дурамжхан байгаа нь илэрхий. Ам түргэдсэндээ харууссаар хонио өгч явуулахчаа боллоо. Хүмүүс наймаачныг харан доогтой жуумайж, хонь авч яваа хүүхдүүд рүү сэтгэл ханасан нүдээр харсаар хоцорч байж.

Гурван найз үнэгүй хонио нэг нь хөтлөөд, хоёр нь туусан шиг гэр лүүгээ ирцгээв. Гэрийнхэн ажлаа тарж цуглараад, “Юугаа ч мэдэхгүй гурван нусгай яаж хонь авчрах вэ? Ямар л олигтой юм авчраа гэж..?” гэлцэн хэл амаа билүүдэцгээж сууж. Тэд гарч ирээд нүдээ том болгон гайхлаа.

-Овоо доо, сайхан тарган хонь байна шүү дээ! Хэдээр аваа вэ? гэлцэн дуу алдацгаалаа.

-Өгсөн мөнгөөр чинь л авлаа! гэж Доржсүрэн зориг муутай хариуллаа. Гурван найз үнэгүй хонь авснаа тас нуухаар хуйвалдсан нь энэ. Гэрийнхэн нь “Мундаг хонь авчээ!”, “Айхавтар амьтад юм!”, “Яаж ийм хонь таарав аа!” гэж ам булаацалдаад, хүүгийн царай улайсныг анзаарсангүй. Гучин минутын дараа гэхэд л салдаггүй гурав цээж түхгэр эрийн буянаар хятад гуанзанд оччихсон ширмэн тогооны мах зооглож, халуун тогооны шөл хүртэж, тансаглаж суусан гэдэг.

Эмч болчих дөхсөн нь

1939 онд Доржсүрэн хүү дөрөвдүгээр анги төгслөө. Тэр үеийн Нэгдүгээр эмнэлгийн ойролцоо байрлаж байсан Хүн эмнэлгийн сургуульд элсэв. Хожим нь нэртэй сайн эмч болсон цагаан Дулмаа гэх охин, мэс засалч гавьяат эмч болсон Долгор гэгч эмэгтэй хүүхдийн нэртэй хүү гээд үе тэнгийнхэнтэйгээ бужигнаад, гайгүй сайн суралцаж байлаа.

Хэдэн сар өнгөрөөд байтал найзуудынх нь ярилцах эвгүй үг чих дэлсэх болж, санаа зовниов. Үй зайгүй найз Цагаан, Самдан хоёр нь “Танай сургуульд чинь үхсэн хүнийг хагалдаг юм гэнэ лээ! Чи одоо яана?” гээд л нүдээ том болгоцгооно. Энэ үгэнд хүү үнэн голоосоо эвгүйцнэ. Сургуульдаа илт дургүй болчихлоо.

Комбинатын дэргэд Фабрик заводын сургууль гэж нээгдсэн байсныг очоод үзвэл бүх юм нь таалагдав. Тэр сургуулийн ойролцоо очоод хэдэн цагаар ч хамаагүй харж зогсдог боллоо. Дархны багаж бариад ажиллаж байгаа үе тэнгийн хүүхдүүдийг цонхоор нь шагайж харах бүрд нүд сэргэнэ. Тэр хүүхдүүд онгоц машин хийж байгаа ид шидтэнүүд шиг л харагдах нь гайхамшигтай.

Энэ сургууль хагас цэргийн зохион байгуулалттай тул үд болмогц сурагчид жагсаалаар алхан ирж комбинатын гуанзанд хоол иднэ. Адилхан хар нэхий дээлтэй, цэрэг малгайтай хүүхдүүд жагсаалд жигдрээд, гараа яралзтал хаялан, тип тапхийтэл хөл нийлүүлэн алхах нь үнэнхүү гоё. “Эдэн шиг гоё хувцас өмсөөд, алхаж явах юмсан” гэж цаг үргэлж мөрөөдөх боллоо. Доржсүрэн удаан тэссэнгүй. “Талийгч болсон хүний гэдэс хагалж байхаар дархан мужааны багажаар ажилладаг, ийм гоё хувцастай хүн больё” гэж сэтгэл шулуудлаа. Ингээд л хүн эмнэлгийн сургуулиа орхиод, Фабрик заводын сургууль руу гүйж очсон хэрэг. Нэг газар зургаан сар сурчихсан хэрнээ хаячихаад, нөгөө рүү ирж байгаа болохоор “Намайг яагаад ч авахгүй байх даа..?” гэж их айж, арай гэж өрөөний хаалгаар даваад, чичэрч түгдчин зогслоо.

-Хүү минь яах гэж явна? гэж багшийг асуухад,

-Би танай сургуульд ормоор байна., гэж зориг муутай хэлж. “Хүн эмнэлгийн сургуулийг орхиод ирж байгааг минь мэдчих вий” гэж айж толгойгоо маажин гутлын хоншоороо ширтэв. Багш хаана гэртэй, хэний хүүхэд болохыг асуугаад,

-Гутлын үйлдвэрийн ажилчин Лхамжавын хүүхэд. Комбинатын дунд сургууль төгссөн... гэхийг сонсоод журналдаа бүртгэж аваад,

-За, хичээлдээ суу! гэж. Үнхэлцгээ хагартал айж зогссон хүү урт гэгч амьсгаа аваад ширээний ард очиж суужээ. Хүссэн сургуульдаа ийм амархан орчихлоо гэхэд итгэмээргүй.

Комбинатын дошин дээр өссөн, ажилчны амьдрал мэддэг хүүхэд сургуульд нь ирж байгаад багш олзуурхаж, ангидаа даруйхан бүртгэж авсан нь энэ. Тэр үед юм нарийн болоогүй байсан учраас тэгтлээ бичиг баримт шалгаж, сүйд болоогүй гэдэг. Тэгээд ч сайн дураараа сургуульд сурья гэдэг хүн ховор. Сургах гэж хүчээр хүүхэд олж ирдэг байсан цаг. Ингэж л түүний өдрийн бодол, шөнийн зүүд биелж, өнөөх гоё хувцсаа өмсөөд, жагсаалаар алхан ирж,

гуанзанд үдийн хоол иддэг болчих нь энэ. Хичээлийн жилийн дундаас орж ирсэн шинэ хүүхэд гээд гадуурхах “атаман” гарсангүй. Голдуу комбинатын айлуудын таньдаг хүүхдүүд байсан болохоор зарим нь их баярлаж угтсан гэдэг.

Хамгийн сайхан хичээл

Фабрик заводын сургууль хоёр орос, хоёр монгол ангитай. Орос ангид нь тэр үеийн орос мэргэжилтэн ажилчид, “местный” хэмээх Монголд суурьшсан орос иргэдийн хүүхдүүд суралцана. Ерөнхий боловсролын хичээлүүд, монгол хэл, тоо физик бүгдийг нь үзнэ. Мэргэжлийн хичээл Доржсүрэнд гойд таалагдана. Дөрвөн жилийн сургуульд байхдаа хичээл гэдэг зүйлд ингэж ухаан алдатлаа дурлаж байсангүй. Гэтэл энэ сургууль руу ирсэн биш маргаашийн хичээлийг тэсэн ядан хүлээж, хийж байгаа зүйлдээ үнэн сэтгэлээсээ шимтдэг болсон нь гайхам. Амьдралдаа үзсэн хамгийн сайхан хичээлүүд нь Уран дархны сургуулийн ширээний ард өрнөж байсан гэдэг. Дархны хичээлийг Кузнецов гэгч орос багш заана. Бас Ванданшарав гэдэг монгол багштай.

Тискинүүд ярайтал зоочихсон танхим байх. Тэнд анхны дадлагын хичээл эхэлж, тискинд дөрвөлжин мод хавчуулаад, хуурай шиг хэлбэртэй болгон зассан модоор үрүүлээд зогсоочихоор нь гайхлаа. Тэгтэл хуурай тэгшхэн бариулж сургаж байгаа нь тэр юм байж. Багш дундуур нь явж, хуурайг яаж барих, яаж зогсох, яаж хөдлөхийг бүгдийг заана. Хуурайгаа тэгшхэн барьж суртал нь модоор мод үрүүлж байв.

Арван хэд хоног мод үрээд байтал боллоо гэж үзсэн юм байлгүй төмрөөр юм хийлгэж эхэллээ. Хүн эмнэлгийн сургуулиас оргож ирсэн хүүгийн нар гарах нь энэ. Хоёр гурван цагаар төмөр хуурайдуулаад зогсоочихоор зарим нэгэнд нь уйтгартай байхад, харин Доржсүрэн уйдаж завгүй. “Яагаад орос багшийн хуурайдсан төмөр эв эгц болоод байна? Яавал багш шигээ тийм тэгш хуурайдаж сурах вэ?” гэж бодохоос цаг өнгөрөхийг анзаарахгүй.

-Хуурай барьж чадахгүй хүн бэлдцийнхээ хоёр талыг нь бөөрөнхийлчихдөг. Харин зөв хуурайдвал эв эгц гадаргуу үүсдэг хэмээн багш нь заана.

Удалгүй бахь хийлгэнэ гэлээ. Хүү чихэндээ итгэсэнгүй. Бахь гэдэг зүйлийг барьж байснаас биш өөрийн гараар хийнэ гэхээр нойр хулжиж, маргаашийн өдрийг секунд тоолох нь холгүй хүлээсэн гэдэг. Хүссэн өглөө нь болж, ангийнхан сургуулийн халуун төмрийн дархны газар луу орцгоов. Тэнд ажилладаг орос ажилчин бахины хоёр гуяны бэлдцийг улайдсан төмрөөр давгаж, дөнгөж зүглүүлсэн болоод л гаргана. Харин сурагчид цааш гүйцээж хийх ёстой. Бэлдцийг бахь болгох бүх боловсруулалт, засварыг гараараа хийж, маргааш юуг нь гүйцээх бол гэхээс тэсч ядаж, хичээлдээ яаран ирнэ. Энэ бол Доржсүрэнгийн амьдрал дахь хамгийн сэтгэлд хоногшсон, гайхамшигт өдрүүд байлаа.

Дараа нь хайч хийлгэлээ. Алх, сүх мэтийн хялбар багажийг хийхэд ядах юмгүй гэж хэлэхээр болтлоо дадлагажив. Энэ бүхний эцэст сайн сурсан, дархны ажилд ур дүйтэй, авьяастай хүүхдүүдийг нь ялгаад илүү нарийн юм руу орууллаа. Доржсүрэн нарийн дархны ажилд сонгогдож бөөн баяр боллоо. Штангел, циркуль гээд нарийн багажуудыг ч хүртэл өөрийн гараар хийж үзэх нь тэр. Токарийн суурь машин дээр ажиллаж сурлаа. Гаргаж өгсөн зургийн дагуу төвөгтэй хийцтэй бэлдцийг нямбайлан зорно. Алдаа гаргавал багш нар нь заана.

Уран дархны сургуулийн захирал Анударь гээд настай буриад. Юм сайн хийсэн хүүхдийг үнэлж, дэмжиж чаддаг ухаалаг хүн. Сурагчдын сайн хийсэн бүтээлийг самбарт тавьж

урамшуулна. Хийсэн зүйлээ самбарт, нэр хаягтайгаа тавигдсаныг хараад баярлаж догдолж байсан нь хэзээ ч мартагддаггүй гэдэг.

Уран дархны сургуулийн хүүхдүүд зуны амралтаар бусад сургуулийн хүүхдүүд шиг амрахгүй. Үйлдвэрт дадлага хийж, комбинатын аж ахуйн ажлуудад дайчлагдана. Хожим Жаргалантын Сангийн аж ахуй болсон газрын ойролцоо байх Морин завод гэж нэрлэдэг байсан нутаг руу хадланд явах болов.

-Ашгүй дээ. Энэ эрх хүүхэд мөөмнөөсөө холдох нь гэж хоёр ихэр эгч нь баярлалаа. Уран дархны сургуулийн том сурагч болчихсон хэрнээ нууцаар мөөмөө хөхөж, ээжийнхээ өвөрт унтсаар л байсан нь энэ.

-Муу хүү минь хэцүүднэ. Багшаас нь чөлөө гуйх юм биш үү? гээд ээж том хүү Гомбо руугаа харлаа. Цаадах нь дуугарсангүй. Эрх хүү гэрээсээ хол, олон хоногоор хадланд яваад эр хүн болчихоод ирсэн гэдэг.

Доржсүрэнгийн хувьд хоёр эгчийн, бусад хүүхдүүдийн хувьд эцэг эхийн үглэж дуулахаас хол, хөдөө хээр дураараа байцгаана гэдэг зүйрлэх юмгүй сайхан байж. Хадлангийнхан хоёр майхантай. Нэгэнд нь эмэгтэй сурагчид, нөгөөд нь эрэгтэйчүүд байрлана. Хадлангийн дарга, багш, тогооч гурав тусдаа гэртэй. Комбинатын аж ахуй хариуцсан ажилтан Гүрбазар гэгч, орос эхнэртэй эр хадланг ахалж, хүүхдүүдтэй хамт байна. “Хадланчид” орой ажлаасаа буухдаа том гэгч бухал чирч ирцгээнэ. Харанхуй болсны дараа бухлаа шатааж, галын наадам хийж хөгжицгөөнө. Өдөржин ажилласан багачууд наадаж хөгжих нь зүйн хэрэг гэж боддог юм уу, хадлангийн ахлагч галын наадмыг нь хориглохгүй. Эсрэгээрээ таашаалтай хандана. Шөнө дунд өнгөртөл шуугилдаж дуулалдсан хүүхдүүд комбинатаас сурагчдад олгосон нэхий уутан хөнжилдөө ороод бөх гэгч унтацгаана. Нэг л мэдэхэд шинэ өглөө ирчихсэн, Гүрбазар гуайн “Хүүхдүүд ээ, босоорой!” гэх дуу хадаж байна. Ингээд л хүндэт хадланчдад зоог бэлтгэхээр тусгайлан томилогдсон тогоочийн хийсэн аагтай цайнд боорцог хөшиглөн ханатлаа идэж аваад ажилдаа гарцгаана. Хүүхдүүдэд үүн шиг зугаатай ажил үгүй.

Ардын жүжигчний машинд

Үйлдвэрийн яамны сайд Дангаа гэж том дарга байлаа. Тэр сайдын тэргийг хожим ардын жүжигчин болж, өвлийн өвгөн аав гэж ард түмэнд алдаршсан Гомбосүрэн гуай барьдаг байлаа. Дангаа гуай монгол дээлээ ихэд дээдэлж, байнга өмсөх дуртай, европ хувцас ердөө өмсөж харагддаггүй хүн. Гомбосүрэн гуай ч бас монгол дээлнээс салахгүй. Дарга жолооч хоёр ижилсэх гэсэн юм шиг л харагдана. Үйлдвэрийн яам комбинатын нутаг дэвсгэрт нарийн төмөр замын конторын ойролцоо байрлана.

Сайд “ЗИМ” гээд гялгар хар тэрэг унах агаад, комбинатын хүүхдүүд тэр гоё тэргийг их шохоорхоно. Гомбосүрэн гуай гэр лүүгээ үдийн ундандаа ирээд, тэргээ тавиад орчихоор нь очиж цонхоор нь шагайна. Шил толийг нь барьж үзнэ. Гишгүүр дээр нь гарч дэвхэрч намалзуулж тоглоно. Хамар өөд нь авирна. Тэгж байтал Гомбосүрэн жолооч, "Хүүед!" гээд л чанга хашгирч, хүүхдүүд бут үсрэн алга болдог байлаа.



Нэг өдөр Самдан, Цагаан, Доржсүрэн гурав сайдын хар тэргийг сонирхож зогсов. Хаалганы цайрдсан бариулаас нь барьж үзэж, гялгар толинд нь нүүрээ харлаа. Самдан шилэнд хамраа шалчийтал наагаад доторх цаг шиг зүүтэй, олон тоотой хачин дугираг юмнууд, гоё суудлыг нь сонирхлоо. Нэг мэдтэл Гомбосүрэн гуай гараад ирчихсэн зогсож байна. Салдаггүй гурав чавхдан зугтаах ч сөгөөгүй, балай хүмүүс шиг таг хөшлөө. Гэнэт тулснаас ийнхүү нам гацсан хэрэг.

-Машинд сууж үзмээр байна уу? Хөх нохойнууд? гэж жолооч асуулаа. Гурвуул юу ч хэлж чадахгүй мэлэрсэн хэвээр. Тэгтэл Самдан сэхээ оров бололтой,

-Машинд уу? гэж асуулаа.

-Тийм. Машинд сууж үзмээр байна уу? гэж давтан асууж байна. Нүүр лүү нь харвал тоглож байгаа шинжгүй. Тэгэхээр нь гурвуулаа арын суудалд нь ороод суучихлаа. Хойшоо чиглэн давхиад хот дундуур өнгөрч байна. Сайдын тэрэг намалзаад л, гайхамшигтай гоё. Тэгтэл цаашаа давхиад л байх юм. Хотоос гараад явчихлаа. Одоогийн 22-ын товчооноос цааш, Өнчин цагаан гээч газар руу хүрээд ирэх юм гэнэ. Тэр үед тэр хавийн газар ямар ч барилга үгүй, зэлүүд тал байж. Гомбосүрэн гуай жуумалзаад, их сайхан зантай байгаа шинжтэй.

-Гурвуулаа бууж морь харна аа! гэж байна.

-Тэгье гэж Самдан цовоо дуугараад, машинаас гурвуулаа их додигор бууцгаалаа. Ойрхон шиг зогсоод морь харах гэтэл,

-Тийшээ хол оч. Замд ойр сарьж болдоггүй юм. Хийморьт муу! гэлээ. Гурвуул алсхан шиг очоод морь харсан болж додомдох зуураа эргээд хартал машин хөдөлж байна.

-Хүүе, ах аа. Хүүе, хүүе! гээд араас гүйтэл хожимджээ. Сунагар хар тэрэг намалзтал давхисаар холдоод явчихлаа. Эргэн тойрон зэлүүд тал. Хот тээр холд харагдаж, байшингууд танигдах төдий сүүмэлзэнэ.

-Гурвуулаа одоо яах вэ? гэж Цагаан бачимдлаа.

-Буцаад ирэх гэж байгаа юм болов уу? гэж Самдан дуугарч байна. Нээрээ ч тийм юм болов уу гэж горьдоод хартал хар тэрэг давхисаар холдсоор байх бөгөөд бараа сураггүй болох шинжтэй.

-Бид гурвыг яаж байгаа юм бол оо? гэж Самдан бухимдаж байна. Машиныг нь үргэлж буртаглаад, зовж арчсан шилийг нь хөлстэй гараараа халгартуулаад, ажил болгож тохируулсан толийг нь нааш цааш нь мушгиад байхаар Гомбосүрэн гуай хариугаа авч байгаа гэдгийг ойлгох муу санаа арван хоёр гуравхан настай гурван хүүд байсангүй. Гурвуул унжралдаад алхаад байлаа, алхаад байлаа. Хот улам л хол харагдана. 22-ын товчоо гэдэг 22 километр газар шүү дээ. Хөлөө холготол алхаж, нар жаргаж харанхуй болсон хойно нэг юм гэртээ харьж байж. Сайдын жолоочид чадуулаад, дээр нь нэмж эгч нараасаа банга хүртэв.

-Хаашаа тэнээд алга болчихдог хүн бэ? гээд л баахан аашилцгаав. Гурван найз тэр өдрөөс хойш Гомбосүрэн гуайн машин руу эгцэлж харахгүй болтлоо хаширсан гэдэг. Сайдын гялгар хар тэрэг зогсож байвал зам буруулж, хорь гучин метр зайтай холуур өнгөрдөг болж байж. Хэдий хаширтлаа чадуулсан ч гэлээ Ардын жүжигчин хүний жолоодсон, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Төрийн сайдын машинд суугаад намалзуулж явсан нь гайхалтай сайхан дурсамж болж үлдсэн нь мэдээж хэрэг. Гомбосүрэн гуай хүн танихдаа гаргууд. Тэр гурвыг хэний хүүхдүүд, хаана байдгийг сайн мэддэг байж. Өнөөх гурав том хүмүүс болсон хойно, дал наяд онд ч тааралдахаараа “Хөх нохой, чи юу?” гээд инээдэг байж. Саяхан хоёр мянга хоёр гурван оны үед, нас барахаас нь өмнөхөн Доржсүрэн Хөгжим бүжгийн сургуулийн урд явж байгаад, Гомбосүрэн гуайтай тааралдаж. Тэгтэл бас л инээгээд,

-Хүүе, хөх нохой. Сайн уу? гэж байсан гэдэг. Гомбосүрэн гуай гучаад оны үед комбинатын ар, одоогийн 120-ийн орчимд аж төрдөг. Доржсүрэнгийнхтэй гэр нь бараг л айл шахам ойрхон байлаа. Тэр үед айлууд задгай буучихдаг болохоор Гомбосүрэн гуайн үдийн цайндаа ирж байгаа, ажил руугаа буцаж байгааг хүүхдүүд андахгүй. Их цэмцгэр хүн болохоор гутал хувцас нь ч, машин нь ч цэмцийтэл угааж арччихсан гялалзаж байна. Гэтэл өнөөх гурван хөх нохой тэргийг нь халгартуулж давхар ажил удаад байхаар нь хариу чадсан нь тэр байж. Сайдын ганган хар тэргэнд гараа хүргэж үзэхийг хүсэхгүй хүүхэд гэж хаа байх вэ?

Сайдын жолоочийн гэргий шанз тоглодог, хөгжимчин хүн байлаа. Гомбосүрэн гуай жүжигчний гараагаа комбинатын хөлөөвт уран сайханд явж эхэлсэн гэдгийг комбинатын ажилчид сайн мэднэ. Энэ л хөлөөвөөс Сүрэнхорлоо, Гомбосүрэн, Охиноо, Батсүх гээд

Монголын тайз дэлгэцийн нэртэй жүжигчид төрж байжээ.

Хэлмэгдлийн бараан сүүдэр

Тэр үед хазгай гишгэж, алдаа гаргасан бүхнийг “Японы тагнуулын хорлон сүйтгэх ажиллагаа” хэмээн цоллож, яллаж байлаа. Дээврээс мөс унаад даргын толгой шалбалчихлаа гэхэд үйлдвэрийн жижүүр, цэвэрлэгч хоёрыг хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан тагнуул гэх энүүхэнд.

Хүүхдүүд л хойно бодох санах юмгүй зүггүйтэж хөгжилдөнө. Монголын түүхэнд аймшигтай хар толбо үлдээсэн он жилүүд үргэлжилж байгааг мэдрэх сөгөөгүй. Шөнө машинтай хүмүүс ирээд хүн бариад явчих нь хачин. “Тэрийг бариад явчихсан гэнэ, энийг бариад явчихсан гэнэ” гэлцэн томчуул шивэр авир ярьцгаана. “Хачин юм аа... Яагаад хүмүүсийг бариад явчихдаг юм бол оо..? Тэгээд дандаа шөнөөр барьдаг нь ямар учиртай юм бэ?” гэж хүүхдийн гэнэн ухаанаар эргэн тойрноо болж буй үйл явдлыг тунгаан бодох авч, учрыг нь ойлгохгүй. Баригдаад явсан хүмүүсээс хааяа ганц нэг нь буцаад ирчихсэн явж харагдана. Эргэж ирэхгүй сураггүй алга болчих нь олон. Нэг шөнө эгчийнх нь нөхөр Намсрайг машинтай хүмүүс ирээд бариад явчихлаа. Томчууд уйлаад л байх юм. Тэгтэл хэд хоногийн дараа суллагдаад л ирлээ. Эгч нь нөхрийнхөө энгэрийг налаад уйлаад суучихлаа. “Суллагдаад ирлээ гээд баярлах байтал, яагаад уйлж байгаа юм бол оо?” гэж бодож байж. Ажил цуглана. Нэг дарга нь байхгүй. “Энэ дарга хайчсан бэ?” гэхээр араас хүн нудраад, “Чш, шөнө баригдаад явсан гэнэ ээ” гэнэ.

Доржсүрэнгийн хүргэ ах Дагвабазар Нэгдүгээр цахилгаан станцын даргаар ажиллаж байлаа. Тэр ээлжийнхээ амралт аваад, Сөгнөгөрийн амралтанд амарч байх хооронд нь орлож үлдсэн хурандаа Пэлжээ ажилчдынхаа хүнсэнд зориулж мах авах гэрээ хийж. Үйлдвэрчний Төв Зөвлөлийн Лувсандорж гэдэг дарга гэрээг батламжилж, Дундговь аймгийн нэгэн иргэнээс мах авах болжээ. Буриад хэмээгч Шарав станцын ерөнхий ня-бо байсан бөгөөд өнөөх иргэнд 35 мянган төгрөг гаргаж өгчээ. Тэгтэл нөгөө хүн нь гэрээт махаа нийлүүлж чадсангүй. Ингээд л арваад хүнийг “эсэргүү” хэмээн цоллож хэрэгт татсан нь аймшигтай.



Эрүүл байр сууринаас дүгнэж цэгнэвэл гэрээ хийгээд махаа нийлүүлж чадаагүй этгээдтэй иргэний шүүхээр маргаан үүсгээд, хохирлоо төлж чадахгүй нөхцөлд эрүүгийн хэрэг гэж үзэж, хөрөнгийг нь битүүмжилж хураах, хорих ял шийтгэх гэх мэтээр буруутай тал хариуцлага хүлээнэ. Гэрээ хийсэн этгээд залилан хийсэн эсэхийг шалгаад тогтоочихно. Гэтэл үүнийг нь “Улсыг санаатайгаар хохироож, хорлон сүйтгэсэн” болгочихсон хэрэг. Арваад хүнийг яллах

шүүх хурал болов. Хамгийн утгагүй нь энэ гэрээнд огт оролцоогүй, ээлжийн амралттай байсан Дагвабазар даргыг бас хэрэгт татсан байлаа.

Шүүх хурал Бөмбөгөр ногоон хэмээн ардууд нэрлэдэг театрт боллоо. Хүүхэд оруулахгүй гэсэн тул Доржсүрэн эгчийгээ даган нуугдаж орсон гэдэг. Эгнэн зогссон сэжигтнүүдийн гуравдугаарт хүргэ ах Дагвабазар зогсож байгааг хүү олж харав. Ингээд Лувсандорж дарга, мах нийлүүлж чадаагүй иргэн, бас нэг албан тушаалтан гуравт буудан алах ял, гэрээ хийгдэх үед хотоос өчнөөн хол амарч байсан Дагвабазарт 10 жил, хурандаа Пэлжээ гуайд 8 жил, буриад Шарав гуайд бас нижгээд жил хорих ял шийтгэж, цааш доошилсоор хамгийн бага нь 3 жилтэй таслагдаж байж. 35 мянган төгрөгийн төлөө гурван хүнийг буудчихсан нь энэ. Ийм л хэцүү цаг байж.

Үйлдвэрийн сэлбэгийн нярав Банзар гэж өвгөн байлаа. “Би яг баригдахын даваан дээр ажилчин болсон хүн. Хэрвээ надтай ажилчин элсүүлж яваа хүмүүс тааралдаагүй бол өдийд би буудуулчихсан сураггүй байхсан” гэж хөгшин цаг зөөлөрсөн жар далаад онд сэм хуучилдаг болж байж.

Тэр Завханы нилээн томоохон хийдэд лам явж. Тэгтэл тэндхийн хийдийнхнийг хүйс тэмтэрчихсэн гэнэ, эндхийн хийдийнхнийг барьчихаж гэнэ гэх сураг чимээ дуулдаад байхаар нь хөдөөллөө гэж хийдээсээ гарч, ном судраа хаданд аваачиж нуугаад, лам дээлээ солиод аймгийн төвд бүгэж байтал ашгүй ажилчин элсүүлэх зар явж байгаа тухай сураг дуулдаж. Тэгээд л ажилчин элсүүлж яваа хүмүүс рүү “Би ажилчин болох чин хүсэлтэй. Ажилчнаар элсье” гээд яваад очсон гэдэг. Хожим нь Доржсүрэн үйлдвэрт ажилчин болсон хойноо Банзар гуайг гэртээ залж, ном уншуулдаг байж. 1990 он гарч цаг бүрмөсөн зөөлрөхөд Банзар гуай Баянхошуунд хийд байгуулж, тэргүүн лам нь болоод, шашин номоо дэлгэрүүлж байгаад насан өөд болсон байдаг.

Галзуу чоно, мөрийтэй тоглоом

Нэг жил яагаад ч юм галзуу чоно элбэгшив. Зарим оройд машинтай хүмүүс нааш цааш хөлхөлдөж,

-Өрхөө бүтээ! Гэрлээ унтраа! Хотын гортигт галзуу чоно орж ирсэн шүү! хэмээн зарлаж, анхааруулна. Айлууд ийм зар сонсвол хаалгаа дангинатал түгжээд хамраа ч цухуйлгахгүй. Зар сонсогдох л юм бол гурван найз гадаа тоглож байснаа больж, бушуухан гэр гэртээ гүйж орно. Нэг өдөр Самдан нь нүдээ оройдоо гаргачихсан гүйж ирээд, галзуу чонотой нүцгэн гараараа тулалдсан сонин адал явдлыг нүдээрээ үзсэн юм шиг ярьж өгөв. Доржсүрэн, Цагаан хоёр сонсонгуутаа л итгээд, тэр зоригтой эр шиг галзуу чоныг дарж гавьяа байгуулахсан гэх мөрөөдөлд авгаж байж. Удалгүй амтай болгон энэ адал явдлыг ярьж, шуугиж эхэлсэн юм.



Хувийн мөнгөөрөө бооцоо тавьж, тоглоом тоглох эсэх өнөө цагт хувь хүний эрх. Гэтэл гуч дөчөөд оны хууль журмаар бол энэ нь гэмт хэрэг болчихно. Хотын зард гарсан мөрийтэй тоглоомчин Суурь гэгч даалуу тоглосон “хэрэг”-тээ гурван жилийн ял сонсоод, тэр үеийн цуутай шорон Батцагаанд хоригдож байж. Шорон одоогийн 13 дугаар хороолол, “Ийст” төвийн буурин дээр байсан юм. Суурь гэгч тэр эр харгалзагч нараасаа гуйсаар байж комбинатын орчимд байдаг гэртээ нэг хоноод ирэх зөвшөөрөл авсан, үүрээр буцаж явж. “Өглөөний тооноос өмнө заавал амжиж ирээрэй” гэж харгалзагч нь хэлсэн болохоор үүр цайхаас өмнө, тав зургаан цагийн үед гэрээсээ гарсан хэрэг. Нарийн төмөр зам дагаад алхаж явтал нэгэн нохой харайгаад ирлээ гэнэ.

-Жов! гэж зандалтал тоох шинжгүй улам хурд нэмэв. Ойртоод ирэх нь чоно! Сунайсан саарал араатан архиран нүүр өөд нь цоройж байна гэнэ. Суурь ханхайсан том биетэй, нилээд овсгоотой эр. Бушуухан овоодож аваад доош нь дарж гэнэ. Чоно самардан гарнаас нь мултрах шинжтэй болохоор нь самбаачлаад хоншоороор нь зам төмөр хэд сайн мөргүүлтэл овооны нь арьс сунаад байж. Ахиулж, гараа ороогоод л мөргүүлээд байтал чоно сулбайгаад ирж. Зэвсэггүй явсан эр галзуу араатнаас амь гарснаар барахгүй, улаан гараараа түүнийг алчихсан нь энэ.

Гэнэтийн дайралтаас болсон балмагдлаас гарч, сайн сэхээрч амжаагүй байтал тэр галзуу чонын мөрийг мөшигж явсан бололтой машинтай хүмүүс давхиад ирэв. Цагдаагийн хувцастай хүмүүс машинаас буухыг хараад, “Би ялтан хүн шүү дээ, яах вэ?” гэж бодож амжив гэнэ. Тэгтэл эмнэлэгт аваачаад галзуугийн тариа хийж, сүйд майд болцгоов. Мань эр дотроо “Би ч ял нэмүүлэх нь тодорхой. Харин тус болсон харгалзагчаа ажилгүй болголоо доо. Юу гэж худлаа хэлэх вэ..?” гэж бодож сууж. Тэгтэл өнөөх цагдаа нар ч байцааж эхлэв.

-Хар үүрээр юу хийж явсан хүн бэ, та? гэж асуухад нь Суурь,

-Би Батцагаанаас оргосон ялтан хүн. Ганцхан шөнө л гэртээ хоночихоод, өглөөний тооноос өмнө амжаад оччих санаатай алхаж явсан юм. Худлаа гэвэл цасан дээр гарсан мөр шалгаарай. Оргоод цаашаа явъя гэсэн санаа огт байгаагүйг наашаа буцаж алхаж явсан мөр минь батална. Ар гэр эхнэрээ эргэчихээд, өглөөний тооноос өмнө шорондоо оччих санаатай яарч явсан юм гэж хэлж. Цагдаа нар дуу алдацгаав. Түүнийг буцааж Батцагаанд нь аваачаад,

-Танай энэ хүн галзуу чоныг нүцгэн гараараа алж, олон хүний амь нас эрүүл мэнд хохирохоос сэргийлсэн гавьяа байгуулсан учраас битгий шийтгээрэй гээд хүлээлгэж өгч гэнэ. Тэгтэл нөгөөдөр нь дээд газраас түүний гавьяаг үнэлж, ялыг нь хэрэгсэхгүй болгох шийдвэр гарган сулласан гэдэг.

Тэр үеийн Улаанбаатарт мөрийтэй тоглоом ихэд дэлгэрч байв. Аливаа юмыг хориод цагдаад байх тусам хүмүүс улам сонирхож шохоорхдогийн нотолгоо тэр. Мөрийтэй тоглоомноос болж амь насаа ч өгсөн тохиолдол бий. Нэгдүгээр цахилгаан станцын ня-бо Дамбий гэгч хүн мөрийтэй тоглоомд хувийнхаа хамаг мөнгийг алдчихаж. Дахиад ганц тоглочихвол алдсан мөнгөө авчихмаар совин татаад байдаг. Гэтэл тоглох мөнгө байхгүй. Албанаасаа 30 мянган төгрөг авч очиж тоглоод, дахиад бүгдийг нь алдаад баригдаж, хэрэгт татагдсан байдаг. Тэр хүнд буудан алах ял оноож байв. Улсын мөнгө дутаасан хүнд их хагуу шийтгэл оногдуулдаг байсан хэрэг.

Хөлөөвийн хөрш

Үйлдвэр комбинатад Хятад ажилчдын клуб нээгдлээ. Тэр үеийн хэллэгээр “хөлөөв” гээч юмтай болсон нь энэ. Заавал гадаад хөлөөвтэй болдгийн учир юу гэвэл тэр үед нийслэлийн хятад иргэдэд нутаг зааж, одоогийн Мишээл Экспо байгаа газрын хавьцаа суурьшуулж эхлээд байсан юм. Тийм болоод л тэр хүмүүст зориулсан соёл олон нийтийн газар байгуулсан хэрэг байж. Тэнд кино ший их гардаг боловч бас л насанд хүрээгүй гээд хүүхдүүдийг үзвэртээ оруулахгүй. Гурван найз хөөгдөж туугдан, зогссоор гуйсаар байж хааяа нэг орж чадна.

Нэг их удаагүй байтал Цагаан хаалганы хойхно талд Комбинатын хөлөөв гэж бий боллоо. Яг тэр байранд нь Уран дархны сургууль хичээллэдэг, хойд хаалгаараа сургууль, урд хаалгаараа хөлөөв рүү орно.

-Бид энэ байшинд хичээллэдэг Уран дархны сургуулийн сурагчид. Хөршүүд чинь байна шүү дээ! хэмээн тасалбар шалгагчид хэлж, жүжигт орох гэж зүтгэнэ. Цаадах нь тоох ч үгүй.

-Насанд хүрээгүй хүүхдийг жүжигт оруулдаггүй журамтай! гэх өнөөх үгээ хэлнэ.

-Бид тусгай сургуулийн оюутнууд. Дунд сургуулийн жаахан хүүхдүүд биш, том хүмүүс л гэсэн үг! хэмээн ятгаж үзнэ. Тасалбар шалгагчийн тэвчээр алдарна.

-Эндээс бушуухан яв! Үгүй бол захирлыг чинь дуудлаа шүү! гэж зандарч, хөөж туухад нь арга буюу холдоно. Байдал ийм учраас насанд хүрээгүй хүний “нарийн аргаар” хөлөөв рүү нэвтрэхээс өөр замгүй. Үзвэрийн танхимын цонхнуудаас аль салхивч онгорхой байгаа, түүгээр орж болох эсэхийг эхлээд тандаж ажиглана. Барилгын буланд харуул томилж зогсоох бөгөөд энэ нь хүн ирвэл исгэрч дохио өгөх үүрэгтэй. Ингээд л тээр дээр байх салхивч руу биенийгээ өргөөд оруулчихна. Салхивчаар орсон хүүхдүүд чимээгүй хярж, хөшигний араар нуугдана. Гэрэл унтарч үзэгдэл эхлэхэд сэм гараад сандалд суучихна. Ингээд л айсан бүжин шиг ийш тийш хулмалзан сууж жүжиг үзнэ. Урлагийн сайханд автаад ангайж суугаад хөлөөвийн жижүүрийн хараанд өртөөд чихдүүлж гарах ч мэр сэр тохиолдоно. “Учиртай гурван толгой”, “Шарай голын гурван хаан”, “Далан худалч” гээд хэдэн жүжиг л гарна. Эдгээрийг Доржсүрэн мөн ч олон удаа насанд хүрээгүй хүний аргаар үзэж байж. Харин концертуудад хүүхдийг чөлөөтэй оруулна. Хоёр төгрөг олчихвол жижүүрээс айж дав дувхийхгүй, мөнгөө төлсөн баатар хүн тарвайтал суугаад концертоо үзнэ.

Уран дархны сургуульд сурч байгаагийн хүчинд дугуй сэлбэхдээ гарамгай боллоо. Самдан, Цагаан, Доржсүрэн салдаггүй гурав ийш тийшээ явж, хүний хаясан обуд, руль, гинж, рам гээд есөн зүйлийн хог цуглуулж, түүнийг нь төмрийн дархан Доржсүрэн янзалж зассаар нэг л мэдэхэд унадаг дугуй босоод ирнэ. Ингэж л “насны мөрөөдөл”-өө биелүүлж өөрийн гэх унадаг дугуйтай болж хөл газар хүрэхгүй болтлоо баярлаж байж. Бага сургуулийн найзуудаас гадна уран дархны сургуульдаа олон найзтай боллоо.

Өөр сургуульд орсон хэдий ч Самдан, Цагаан хоёроосоо салдаггүй хэвээр. Өвлийн нэгэн амралтын өдөр одоогийн Урт цагааны хавиар байсан хятадын мухлагнуудаар жаал яваад буцаж, Усны гудамж уруудан алхав.

-Мөнгөтэйсэн бол хятадын морин тэргэнд суухгүй юу., гэж Самдан мөрөөдлөө. Тэгтэл морин тэргээр ус зөөдөг хятад явж байна. Тэргэн дээр усны том гэгч төмөр торхтой, түүнээсээ ус хутгаж зардаг дөрвөлжин лаазаа өлгөчихсөн нь замын энхэл донхолд хаа нэг харжигнан дуугараад л. Хятад үүрэглээд л, духалзаад л байх нь инээдтэй. Хэтэрхий том малгай нь эв хавгүй муухай харагдана.



-Энэ хужааг мөсөөр цохьчихоод зугтъя! гэж нэг нь санал гаргав. Усны гудамж дагуу мөс шиг их юм үгүй. Гурвуул тонгойн нэг нэг мөс авлаа. Хятад унтаагаараа яваад л, морь нь зөнгөөрөө гэлдрээд л байх. Зэрэгцээд ирмэгц нь гурвуул онь холбоод гал нээчихлээ. Доржсүрэнгийн мөс өлгөөтэй лаазан дээр нь буун танхийн бут үсэрч, бутархай нь хятадын толгойг цохилоо. Нөгөө хоёрын мөс ар нуруун дээр нь зэрэг шахам буулаа. Хятад цочин сэрээд,

-Хаа яа! гэж муухай чарлав. Гурван найз ч Дунд голыг чиглээд дэрхийтэл гүйлдлээ. Луухаан морин тэргээ хаяад, урт шилбүүрээ далайгаад л хойноос хөөх нь аймшигтай төдийгүй хурдан гэж жигтэйхэн. Гурван хүү Дунд голын зах хүрч чадалгүй гүйцэгдлээ. Нүүрээ дарж хамгаалаад эсэргүүцэлгүй хярахаас өөр аргагүйдэж, урт нарийн суртай шилбүүрээр хэд хэд сайн ороолгууллаа.

-Хаа яа. Яасаа муу хүүхэд байна аа! гээд л өнөөх чинь баахан уурлаж, өөрийнхөө хэлээр ч харааж зүхнэ. Гэхдээ хөөрхий минь сайн хүн таарсан байж. Хүүхдүүдийн гуя хонго, ууц нурууг нь дамнуулаад л ороолгоод байсан уу гэхээс нүүрэнд нь нэг ч хүрсэнгүй. Өвлийн зузаан хувцастай тулдаа гайгүй өнгөрч. Түүнээс биш зун таараад, нимгэн цамц өмдтэй явсан бол гувруу гартлаа шилбүүрдүүлж, хэдэн өдөр ёолох байлаа. Хөвгүүд санаандгүй явснаа гэнэт ингээд л зүггүй нь хөдөлчихдөг байсан гэдэг.

Уран дархны сургууль дахь Доржсүрэнгийн анги хориод хүүхэдтэй. Сүүлд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Намын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Юмжаагийн Цэдэнбалын хамгаалагч болсон Дамбаасүрэн тэдний ангид сурна. Банзрагч гэж охин сурдаг байсан нь хожим Дамбаасүрэнтэй гэр бүл болцгоосон гэдэг. Банзрагч нь бага сургуульд Доржсүрэнтэй нэг ангид, бусад нь дандаа дээд ангид байсан хүүхдүүд. Бүгдээрээ комбинатын сургуулийн үр сад. Хүрлээ гэж тунтгар хүү, Амгалан гээд өндөр ёхигор нөхөр хоёр санаанаас нь гардаггүй. Норжмаа гээд охин сурч байсан нь сүүлд Үйлдвэр комбинатын эмнэлэгт ажилладаг болж байж. Орос ангийн Юрка гэдэг хүү гайхалтай сайн цахилгаанчин болж, үйлдвэртээ ажиллаж байгаад нутаг буцаж Улаан-Үд хотоос цаахна аж төрдөг болж байлаа. Ира гээд охин сургуулиа төгсөөд чадалтай фрезерчин гэгдэж, сайн ажиллаж байснаа юунаас ч болсон юм бүү мэд боогоод нас барчихсан гэдэг.

Ангийнхан нь төгсөөд, бүгдээрээ Гутлын үйлдвэр, Эсгийлэх, Төмрийн тасаг, Арьс ширний үйлдвэр гээд Үйлдвэр комбинатын салбар бүрт хуваарилагдаж байлаа. Уран дархны ангийнхнаас ихэнх нь яваандаа сургууль соёлд явж, өөр ажилд шилжиж, гурав дөрөвхөн хүн л комбинатдаа үнэнч үлдсэн байдаг. Амьдралын зам гэдэг олон салаа нугачаатай байдаг нь энэ.

Арван дөрөвтэй “том хүн”

1941 оны 6 дугаар сарын 5-нд Фабрик заводын сургуулиа төгслөө. Зургааны өдөр төгсөгчдийг хуваарилахад Доржсүрэн Гутлын үйлдвэрт засварчин болж, оёдлын машин засдаг слесариар ажиллаж эхлэв. Үйлдвэрийн яндан өглөө долоо, долоо гуч, найм гээд гурав дахин дуугарна. Эхнийх нь “Сэрээрэй, босоорой!”, удаах нь “Гэрээсээ гараарай!”, гурав дахь нь “Ажил эхэллээ!” гэж хэлж буй нь тэр. Хүү эхний яндангаар ухасхийн босч ирэхэд, гэрийнхэн нь хэдийнэ босоод цайгаа чаначихсан байна. Цайгаа яаран уугаад, долоо гучийн яндантай уралдан гэрээсээ гарна. Хуучин дугуйгаа далбилзтал жийсээр гэрийн томчуудаасаа түрүүлж албандаа ирнэ. Замд гинж мултарч орооцолдох ч юм уу, дугуй хагарах ч юм уу, ямар нэг адал явдал тохиолдож, найман цагийн яндангаас хоцорвол үйлдвэрийн “боловсон хүчин” үүдэнд суучихсан,

-Нөхөр Доржсүрэн! Таван минут хожигдлоо гээд самбарт биччихнэ. Самбарт бичигдэж нүүрээ улалзуулахгүйн тулд наймын яндангаас өмнө амжих гэж ажилчид яаран ирцгээнэ.



Насанд хүрээгүй гээд, өдөрт зургаан цаг ажиллуулдаг болохоор 14 цаг гэхэд л Доржсүрэн тарчихна. Тэглээ гээд харихаа мэдэхгүй. Хэрзийсэн дугуйгаа харжигнуулан жийж, адилхан насанд хүрээгүй ажилчин Равжир гэдэг хүүтэй хамт Туулын эрэг рүү явцгаана. Ханатлаа шумбаж, нимгэн газраар ус цүл палхийлгэн гүйлдэх сайхан. Хааяа нэг ангийн тэнгэр ивээж жараахай баривал бөөн баяр болцгооно. Олзоо задгай галын цогон дээр шарж идэхэд гайхамшигтай амттай. Оройн таван цагийн яндан дуугарахад гэр лүүгээ очих ёстой гэдгээ гэнэт санана. Ханатлаа тоглож авсан хоёр хүү үйлдвэрийн ажилчидтай хамт харина. Гэрийнхэн түүний хэдэн цагт тарсан, тараад хаана явж байгаад ирснийг тэртэй тэргүй мэднэ. Хоёр эгч үглэж эхлэхэд үг дуу цөөтэй ээж нь тэсгэлгүй ам ангайж, хүүгийнхээ өмнүүр

орж өмөөрнө.

-Сайн дураараа хирнээсээ салчихаад ирж байгаа хүнийг харин ч магтвал таарна! гэнэ. Өдөржин усанд сэлж шумбасан хүн үнэг гүйцэтлээ өлссөн байх нь мэдээж. Хүү ээжийнхээ өмөөрсөнд эрэмшээд, эгч нарынхаа загнахыг тоолгүй ууттай боорцог руу ухасхийнэ. Халуун цайнд хөшиглөсөн боорцгоо ховдоглон идэж суугаа хүү рүүгээ ээж элгэмсүү харж байснаа,

-Миний хүү гүнзгий цүнхээл рүү битгий ойртоорой. Ус хэцүү шүү! гэж захиана. Хүү хэдий эрх ч гэлээ гар хумхиж зүгээр суухгүй. Гэдэс цадаж сайхан зан хөдлөөд, ухасхийн гүйж гаран, ээждээ түлээ мод хагалж, ус зөөж өгнө. Ингэж байтал Самдан, Цагаан хоёртойгоо уулзмаар санагдана. Дунд сургуульд дэвшиж суралцаад явчихсан хоёр найз нь өдийд даалгавраа хийж дуусгаад, гадагшаа гарахсан гэж хорхойсож суугаа гэдгийг хүү мэднэ.

Доржсүрэн гэрээсээ гарч Санжмятав гуайн гадаа гүйж хүрээд сэмхэн исгэрч дохио өгөх нь яг л тагнуулч шиг. Хоёр найз нь дуртай гэгч гарч ирнэ. Дунд ангийн хичээл ном ихтэй завгүй байдаг ч Доржсүрэнгээр үйлдвэрийн тухай, ажил хийх гоё эсэх тухай яриулж орой болтол сууна. Ажилчин, догь эр болчихсон Доржсүрэн рүү харж, яриаг чагнаж буй нь чин сэтгэлээсээ бахархсан байдалтай. Оройны есөн цаг, дараа нь есөн цаг гучин минутад яндан дуугарна. Энэ бол үйлдвэрийн оройн ээлж солилцох дохио. Хоёр найз нь даалгавар ихтэй үедээ ес гучийн яндангийн дуунаар дуртай дургүй тарцгаана.

Тэр үеийн Үйлдвэр комбинат гэхээр томоос том хашаа байх. Түүний дөрвөн буланд, дөрвөн өндөр жодгортой. Харуулын цамхгийг ажилчид тийнхүү “жодгор” гэж нэрлэнэ. Орой болгон тэр жодгоруудад “лүйжинчин”-гүүд гарна. Яагаад тэгдэг байсныг бүү мэд. Харуулуудыг бас л тийнхүү өвөрмөцөөр нэрлэнэ. Харуул хамгаалалт нь чанга болохоор үйлдвэр комбинатын хашаа руу гаднын хүмүүс айгаад ойртох ч үгүй.

Том хашаан дотор Гутлын үйлдвэрийн хоёр барилга, Том ширний үйлдвэр, Төмрийн тасаг, Эсгий эсгий гутлын үйлдвэр, Шевроны үйлдвэр гээд байшингууд байна. Тэр үед шеврет гэж тусдаа үйлдвэр байсангүй шевротойгоо хамт нэг дор байсан хэрэг. Энэ бүхэн дээр комбинатын захиргааны байшин нэмэгдэнэ, ингээд л болчихно. Сүүлд ноосны үйлдвэр нэмж байгуулж байж.

Гутлын үйлдвэрийн нэг давхар, бөмбөгөр дээвэртэй барилгатай зэрэгцээд эсгүүрийн тасаг гэх бас нэг дан байшин байна. Дандаа орос тоног төхөөрөмжтэй. Гутлын зуузай, толгой, түрий оёдог гүйцэтгэхийн гэх хэдэн машин, ажлын гутлын гуулин хадаасны дөрвөн ширхэг машинтай. Үрлэгний гэх ганц нэг, колодклож татдаг дөрвөн машин байх агаад тэгсхийгээд л машин тоног төхөөрөмж нь болчихно. Конвейер гэж тэр үед байсангүй. Үйлдвэрийн голлох бүтээгдэхүүн нь ажлын хар гутал буюу бакал. Үүний зэрэгцээ Торгон савхины тасагт, шевро, хромоор гутал хийх төдийгүй европ загварын ботинк туфль ч бас урлана. Туфлийн тасаг эсгүүрийн байрны ар хэсэгт байрлаж тэр цагтаа ганган дэгжин сайхан гутлууд гаргадаг байлаа.



Ажилд ороод арван хэд хоног хүүхдийн нормтой, тоглож эрхлэх цаг ихтэй жаргалтай байлаа. Тэгтэл нэг өглөө бөөн сандралдаан болоод явчихлаа. Хөгшдөөс зарим нэг нь уйлж харагдана. Үйлдвэр дээр бүх ажилчдын хурал хийж, 6 дугаар сарын 22-ны үүрээр Зөвлөлт Холбоот Улс руу Фашистын Герман дайрч, дайн эхэлсэн болохыг хэллээ. Насанд хүрээгүй хүүгийн зургаан цагийн ажлын норм худлаа болов. Өдөр бүр уртасгасан цагаар ажиллаж эхэллээ. Ингээд л өнөөх ээжийнхээ өврөөс ч гарч амжаагүй шахам жаахан хүү арван дөрөвтэй “том хүн” болчих нь тэр! Арван дөрөв гэдэг эдний гэрийнхэнд ихээхэн билэг дэмбэрэлтэй тоо. Ихэр эгч Дэндэв, Сэрээтэр хоёр нь ч бас арван дөрөвтэйдөө Аж үйлдвэрийн комбинатын ажилчин болцгоож, яг л Доржсүрэн шиг хагас өдрийн нормтой ажиллаж эхэлсэн.

“Бүхнийг фронтын төлөө!” гэсэн уриаг улаан даавуун дээр бичээд, энд тэндгүй хадаж, хурал болгон дээр дарга нар амны уншлага болгон давгаж, үйлдвэр өдөр шөнийн хоёр ээлжээр ажиллана. Монгол улс даяар хандивын хөдөлгөөн өрнөж, малчид фронтод агт морь амбан шар халзан цагаан хонио өргөж, ажилчид долоо арав хоногийн цалингаа хандивлаж байлаа. Төлөвлөгөө норм нэмэгдэж, шахуу үүргийг биелүүлэхийн төлөө нойр хоолоо умартан зүтгэнэ. Слесариудад ээлж гэж байх биш хүү шөнийн ээлж рүү дуудагдаж, хонож ажилладаг болчихлоо. Хүүхэд л болсон юм хойно слесарийн өрөөндөө ороод ширээн дээр гараад дугхийчихнэ. Зүүд нойрон дунд,

-Доржсүрэн, хүү минь босоорой. Уллагааны машин эвдрээд зогсчихлоо, бушуухан засаарай! гэнэ. Нойрмог хүү нүдээ нухлан машин руу очоод, ноцолдож эхэлнэ. Уртасгасан цаг бүү хэл хоногийн хорин дөрвөн цагаар ажилладаг болчихсон нь энэ. Нойргүй олон хоноод ирэхээр гөлийгөөд л, унтаа сэрүүн хоёрын хооронд явна. Биенээрээ тоглоом хийгээд, нүүрийг нь тосон будгаар будчихна. Нүүрээ цоохорттол будуулчихсан хэрнээ л мэдэхгүй нойрмоглож, дүйнгэтээд явах. Нэг удаа Доржсүрэн нүүрээ будуулчихаад, өдөржин явсны эцэст орой нь мэдэж уйлах, инээх хоёрыг хослуульж байж. Нүүр будсан эзэн нь олдохгүй, бүгд л мэдэхгүй гэгцээсэн нь мэдээж.

Үйлдвэрийн улаан буланд цэргийн хороо байрлаж, тасгуудыг буутай харуултай болголоо. Үйлдвэрээр дураараа явж болохгүй, нэг хаалганаас нөгөө рүү орё гэхэд үнэмлэх үзүүлж байж нэвтэрнэ. Слесарь хүү гүйцэтгэх тасагт машин тохируулчихаад, эсгүүрийн тасагт машин үзэх боллоо гэхэд тэр хооронд үнэмлэхээ гурав шалгуулж байж зорьсон газраа хүрнэ. “Хэрвээ үнэмлэхээ үзүүлэхгүй бол цэргүүд шууд л баривчлах үүрэгтэй. Хэрвээ анхааруулгыг тоохгүй үйлдвэрийн нутаг дэвсгэр лүү нэвтэрвэл буудах ч эрхтэй. Байлдааны цагийн хууль дүрэм тийм!” хэмээн дарга нар анхааруулсан байлаа.

Авьяастай бас зантай

Наваанлувсан гэж алтан гартай слесарь гутлын үйлдвэрт ажиллаж байлаа. Төд удалгүй Доржсүрэн энэ хүнийг үнэн сэтгэлээсээ бишрэх болов. Юм хийж байгааг нь хараад бүтэн цагаар ч хамаагүй суучихна. Хүүд өөр тасаг руу дуудлага ирэхэд арга буюу эргэж хоргодсоор холдоно.

Нэгэн өглөө гүйцэтгэхийн машины гол хугарч нам зогслоо. Тэхий дундуураа хугараад шинээр зорохоос өөр аргагүй болчихсон голыг Наваанлувсан гуай үзээд,

-Монгол дархны гуулин гагнуурын аргаар тогтоочихож болох юм байна гэж орос механикт тайлбарлаж хэлээд гагнахаар бэлтгэж эхлэв. Орос механик Рачунов гагнуур хийх гээд байгааг учиргүй шоолж инээдээ барьж ядлаа.

-Наад гол чинь гагнуур авахгүй ээ. Их өндөр ачаалал авдаг голыг гагнаж холбоно гэх нь инээдтэй хэрэг. Тэгээд очиж очиж гуулиар шүү! Яасан ч тогтохгүй! гээд л ёжтой жуумалзана. Чөтгөрийн нүдийг гуулиар хуураад яах вэ.., гэх утгатай үг хэлж, хашир слесарийн гагнуурыг цагийн хоосон үрлэг гэж үзсээр л. Гэтэл өнөөх чөтгөрийн нүдийг хуурч гагнасан гол нь хугарсангүй, машин хэвийн ажиллаад эхэллээ. Гэлээ ч орос эр монгол гагнуурт итгэхгүй хэвээр.

-Сайндаа л ганц хоёр цаг тэснэ биз. Хугарна даа, харж л байгаарай гэсээр л. Хоёр гурав хоног өнгөрөхөд өнөөх гол ажирсангүй. Рачунов механикийн нүд оройдоо гартлаа гайхаж, машиныг задалж голыг аваад, эргүүлж тойруулан харж, нягтлан шалгаж, удаан гэгч шинжиж байснаа толгой сэгсэрлээ. Гайхшаа барж буй нь илт.

-Чөтгөр ав. Би яагаад ч итгэж чадашгүй нь! гэлээ. Ийнхүү удтал үглэж, толгой сэгсэрч сууснаа босоод, Наваанлувсан гуайн гарыг атгалаа. Бууж өгөх нь энэ! Гол долоо, арав хоног, сар өнгөрөхөд ямар ч асуудалгүй явсаар л байсан агаад, орос эр машины дэргэдүүр гарах бүртээ өөрийн эрхгүй гол тавигдсан зангилаа руу харж толгой сэгсэрдэг зуршилтай болсон гэдэг.

“Яавал түүн шиг монгол дархны аргаар ингэж гоё гагнаж сурна даа?” гэж хүү бодож, халуун төмрийн тасагт орж гуулиар гагнах бүтэлгүй туршилт хийж суудаг болов. Яаж ч оролдоод гагнуур хөгшнийх шиг цэвэрхэн болохгүй. Наваанлувсан гуай ажигч хүн болохоор хүүгийн бодлыг нүднээс нь уншчихаад, бүтэлгүй туршилт хийгээд байгааг сэм ажсаар л байж. Нэг өглөө хүүд,

-Чиний гагнуур яагаад олигтой болохгүй байгааг чамд хэлж өгөх үү? гэх нь тэр. Энэ үгийг сонсоод Доржсүрэн мэл гайхлаа. Хөгшин дахин ам нээж,

-Би чамд гагнуур зааж өгье гэсэн юм гэлээ. Хүү чихэндээ итгэсэнгүй, догдолсон гэдэг жигтэйхэн. Монгол цоож хий. Эхлээд төмрөө эсгэж бэлд. Гагнах үед чинь би хараад заая гэж Наваанлувсан гуай хэлсэн болохоор хүү яарч, монгол цоожны бэлдэц төмрүүдийг эсгэж, хуурайдаад багш дээрээ очлоо. Гагнуурт хэрэглэх гуулиа нимгэлж давтсанаа бас үзүүллээ. Багш гууль руу ёозгүй хараад,

-Хн. Ийм зузаан гуулиар сайхан гагнуур хийнэ гэж саналтгүй. Цаас шиг болтол нь давт! гэлээ. Энэнээс цааш яагаад ч нимгэрэхгүй гэж бодоод, багшдаа үзүүлэхээр ахиад л болоогүй байна гэнэ. Бураагаа түрхэх болоход хүү бас л будиллаа. Энд дутуу тавьж байна, ингэж бариад, ингэж түрхвэл сайн гээд л заана. Олон даваа давж байж сая гагнаж болно гэсэн зөвшөөрлийг багшийн амнаас сонсож урт амьсгаа авсан гэдэг. Цоожны бэлдцээ хөгшний зааснаар аажмаар халааж байтал хөх утаа манарч, гууль мэлтэгнээд л, бураагаа дагаад гүйчихлээ. Улайдсан төмрийн холбох хэсгүүдийн ан цавыг дагаад, хайлсан гууль урсаж байгаа нь үлгэрт гардаг ид шид гэлтэй.

-Чи гууль гүйж байгаа газруудыг харж байна уу? ...Одоо галаа бага багаар хөндийрүүлсээр, холдуулж ав! гэж багш заалаа. Цоожоо хөргөсний дараа хартал бүх холбоосуудаар гууль шарлан гүйж, деталиуд хоорондоо гагнагдчихсан байна. Би ийм цэвэрхэн гагначихлаа гээд бодохоор урамтай. Наваанлуvsан гуай ийнхүү хүүтэй хамт байсаар нэг л мэдэхэд Доржсүрэнд их сайн болчихсон байлаа. Мэддэг чаддагаа сэтгэл харамгүй заана.

Хүнээр заалгалгүй өөрөө гагнуур сурчих санаатай зүтгэж бүтэлгүйтэж байснаа бодохоос ичмээр. “Технологигүйгээр ямар ч юмыг хийхгүй. Технологи маш чухал!” гэж Кузнецов багш хэлдэг байсныг саналаа. “Гуулин гагнуур ямар ч гагнуураас илүү бөх. Цахилгаан гагнуурыг салгаж болно. Автогенийг хүмүүс бөх гэж ярьдаг ч бас л салгаж болно. Харин монгол дархны гуулин гагнуур хэзээ ч салахгүй. Салгая гэхэд зориуд хөрөөдөхөөс өөр замгүй” хэмээн хашир дархчуул ярьдаг нь үнэн болохыг Доржсүрэн өөрийн гараараа туршиж, нүдээрээ харсны дараа итгэж байж.

Дайн болж байгаа болохоор орос машинуудын сэлбэг олдохоо болилоо. Байсгээд л сэлбэгээр сууж, үйлдвэр зогсож гутал овоорно. Орос багшийнхаа заавраар бүх багаж, нарийн деталиудыг гараар болоод суурь машин дээр хийж сурсны ашиг тусыг үзэх цаг мөч ирэх нь энэ. Хашир засварчин Наваанлуvsан, арван дөрвөн настай хүү Доржсүрэн хоёрт л дарга даамлууд нарийн хийцтэй сэлбэгүүдийг хийх үүрэг өгдөг боллоо. Хөгшин бол их уран, юуг ч хийчихдэг болохоор тийнхүү итгэл хүлээлгэсэн нь ойлгомжтой. Харин ээжийнхээ мөөмнөөс дөнгөж өчигдөр гарсан хүүг ингэтлээ үнэлсэн нь итгэмээргүй. Энэ бол алсуураа Наваанлуvsан гуайн ач байж. Балчир хүүг бурхан слесарь их үнэлж, төмөр боловсруулах ур ухааныг харамгүй зааж байгаа учраас “Наваанлуvsан гуайд тоогдохыг бодоход хоосонгүй хүүхэд байх” гэж дарга нар итгэх болсноос тэр.

Оёдлын машины челнокийг хонон өнжин сууж, өөрийн гараар хийдэг болов. Машинуудын челнокийг хийнэ гэдэг нарийн чимхлүүр ажил. Эхлээд цул төмөр зорж хонгиог нь хийгээд, нүхэлж гол суулгадаг байснаа, дараа нь арай боловсронгуй болгож зорохдоо голыг нь үлдээдэг боллоо. Ховилуудыг нь гаргахад ердөө 1,5 мм зузаантай натул хэмээгч нарийн хуурай хүртэл зузаадна. Хуурайг 0,5 мм болтол нь нимгэлж точилдох хэрэгтэй болно. Ховилоо гаргахад маш тэгш хуурайдах хэрэгтэй. Тэрхүү нарийн ховил дундуураа гүйлгэн челнокны цоожийг суулгана. Нарийн өрмөөр нүх гаргаад, цоожны пүршийг байрлуулна. Энэ мэтээр олон сэлбэгүүдийг өөрсдөө хийдэг болов.

Үйлдвэрийнхэн шинэ орсон балчир хүүг сонжин харж байсан нь мэдээж. Юм бүхнийг хийчих чадвартай, гарын уртай, техникт авьяастай. Авьяасыг “зан” дагадаг жамтайгаас хойш хүү зарим юман дээр “зан”-гаа гаргана. Юм хийж байхад нь хажуугаас хошуу нэмвэл

дургүйцэж, заавал өөрийнхөөрөө хийх гэж зүтгэдэг хор шартай. Ухаандаа өөрийн толгойгоор бодож, өөрөө л аргыг нь олоод юмаа хийчих гэж мачийж буй нь энэ. Үүнээс нь болоод ажилчид эхэндээ “Нусаа хүчрэхгүй жаахан юм байтлаа, зөрүүд нөхөр үү?” гэлцэж байж. Гэвч түүний зөрж зүтгэсэн нь зөв болох нь их. Нилээд хугацаа үрсний эцэст хүүгийн бодож олсон тэр л аргаар сэлбэг деталийг хийх нь цор ганц оновчтой зам байсныг бүгд ойлгоно. Ийм явдал хэд давтагдсаны дараа ажилчид “Эр хүнийг жаахан гэж басч болдоггүй юм байна. Зөрүүдэлж зүтгэдэг нь зөв болж таараад байх юм! Шаггүй хүүхэд байна шүү” хэмээн ярилцаж, үнэлж эхэлж. Хүүд хүмүүсийн юу ярих падгүй. Хоёр гурван өдрөөр дуугаа хурааж, хүний үгнээс зөрж байж хийсэн деталь сэлбэгийг нь тавьсан машин торохгүй ажиллаад эхлэх л хамгийн сайхан. Үүн шиг урамтай бахдалтай мөч гэж хаана ч үгүй.

Монгол аргын зүү шөвөг

Дайны цаг учраас үйлдвэр цэргийн зохион байгуулалтад орсон байлаа. Үйлдвэрийн дарга дуудаад, яг л цэрэг хүн шиг тушаал өгнө.

-Нөхөр слесарь. Зуузай оёдлын машиныг маргааш өглөө гэхэд засч бэлэн болго! гэж тушаана. Өгсөн үүрэг биелээгүй бол байлдааны тушаал зөрчсөнтэй адилтган хариуцлага тооцно. Тийм болохоор даргын тушаал яг таг биелдэг байлаа.

Челнок төрөл төрлөөр нь овоо олныг хийгээд, толгой өвдөхгүй болоод байтал дахиад л асуудал тулгарлаа. Гутал улладаг машин зүү шөвөггүй болж зогсох нь тэр. Тийм машины зүү шөвгийг хийнэ гэдэг их ярвигтай учраас хийгээд олигтой юм болно гэдэгт хэн ч итгэхгүй байлаа. Наваанлуvsан гуай тэгтэл,

-Зүү шөвгийг ч хийчихэж болмоор санагдаад байгаа юм. Даанч миний нүд үзэхгүй л дээ. Тийм болохоор би зааж зөвлөө. Энэ Доржсүрэн нүдтэй хүүхэд байна, хийнэ биз. Оролдоод үзвэл ямар вэ? гэж байна.

-Зүү шөвөг гэдэг чинь үйлдвэрийн аргаар, тусгай суурь машин дээр хийдэг зүйл. Нэг муу хуурай барьсан хүүхэд гараараа хийчихнэ гэвэл үлгэр. Тэр бүтэхгүй! гэж нэг нь эсэргүүцлээ.

-Хатаахад л ярвигтай. Түүнээс биш хийхийн хувьд хийчихнэ. Дахин дахин оролдоод байхад хатыг нь тааруулчихаж болох бий вий гэж Наваанлуvsан гуай түрүүчийн хэлснээ бататгалаа. Ингээд хөгшин залуу хоёр засварчин, дээр нь механик Шарав гуай гурвуулаа сууж, зүү шөвөг хийхээр болж материал хайлаа. Зүүг нь гурван миллиметрийн, шөвгийг нь таван миллиметрийн ган утсаар хийх нь зөв гэлцлээ. Зүү нь тахир, загасны дэгээ шиг сэртгэртэй. Сэртгэр нь олсон утсыг татаж ирэх зориулалттай. Шөвөг нь ч бас нарийн төвөгтэй хийцтэй. Гарандаа бэхлэгддэг хэсгийн хөндлөн огтлол дөрвөн өнцөгт, дунд хэсэг рүүгээ хөндлөн огтлол нь гонзгойдуу дөрвөн өнцөгт болоод цаашаа тахийгаад явчихна. Машин ажиллахад шөвөг нь цохиж нүхээ гаргаад зүү нь орж ирж, олсоо татаж улаа оёдог зохион байгуулалттай.

Доржсүрэн зүү шөвөгний хэмжээг сайтар авч байгаад, ган утсаар арван ширхэг зүү, мөн төчнөөн шөвөг хийчихлээ. Хийсэн зүү шөвгөө эхлээд хатаалгүйгээр туршиж үзэв. Ганцхан гутал уллаад тахийчихлаа. Тэгэхээр нь хатаав. 5 мм зузаантай хавтгай төмөр улайсгаад түүн дээрээ зүү шөвгөө тавиад, төмөртэйгөө адилхан улаан болонгуут усанд хатааж үзэв. Машиндаа тавиад ажиллуултал давгүй явчихмаар аятай. Гэвч арваад гутал уллаад байтал хуга үсэрлээ.

-Хат нь арай л чангаджээ. Догшин байна гэж Шарав механик хэлж байна. Доржсүрэн орос багшийнхаа заасныг бодлоо. Арай өөрөөр үзье гээд, халуун төмрийн тасагт хусны нүүрстэй саван дотор хийгээд, гал дээр савтай чигээр нь нилээд сайн улайсгаад, тосонд хийчихлээ. Гаргатал зүү шөвөг цав цагаан болчихсон харагдана. Хуурайдаад үзэх гэтэл хуурай хальтраад л байна. Хэтэрхий хатсан нь илт. Тэгэхээр нь зүү шөвгөө буцаагаад улайссан хавтгай төмөр дээрээ тавиад, дөнгөж хүрэнтээд ирэхээр нь хямсаагаар аваад усанд хийчихлээ. Хэт чанга хатаагаад буцааж уяруулаад, хоёр дамжуулаад хатаачихаж байгаа нь энэ.

Машиндаа тавиад гутал уллаж туршиж эхэллээ. Өнөөх чинь дажгүй яваад байх бололтой. Ингээд л яг тэр аргаараа хатаагаад овоо хэдэн зүү шөвөг хийчихлээ. Зарим нь гучаад гутал урлачихна. Зарим нэг нь арай цөөн уланд яваад хугарна. Маргаашнаас нь эхлээд Доржсүрэн ган утсаар зүү шөвгөө хийж, Наваанлуvsан гуай өнөөх хоёр дамжуулж хатаах аргаар хатааж зүү шөвөг үйлдвэрлэж эхэллээ. Уллагааны машинууд хэвийн ажиллаж эхэллээ. Зүү шөвөг хугарчихлаа гэхэд дахиад тавих сэлбэг бэлэн. Ингэж л монгол аргын зүү шөвөгтэй болж байж.

Жаахан хүүхдэд их мөнгө өгөхгүй

Үйлдвэр дээр том дарга нар үе үе ирнэ. Маршал Чойбалсангийн нэрэмжит Аж үйлдвэрийн комбинат гэдэг байсан болохоор маршал зочлох нь элбэг. Бумцэнд гуай гээд томчууд ч бас ирнэ. Тэднийг ирэх сургаар үйлдвэр тэр аяараа бужигнах нь сүртэй. “Маршал ирнэ. Машинаа арч!” гэж дарга нар тушаана. Ажилчид их цэвэрлэгээнд гарч, бөөн ажил болно. Хана адартаа “Ялалтын төлөө!”, “МАХН мандтугай!”, “Монгол Зөвлөлтийн найрамдал мандтугай!” гэх мэтийн уриа лоозонгуудаа улаан даавуун дээр цагаан шохойгоор бичиж зүүнэ.

Доржсүрэн Маршал Чойбалсан гэдэг тэр мундаг хүнийг ойроос харахсан гэж бодно. Гэвч энэ мөрөөдлөө биелүүлнэ гэж саналтгүй. Түүнийг арван хэдтэй хүүхэд болохоор сахилгагүйтээд Маршалын нүдэнд өртчихнө гэж дарга нар нь болгоомжилдог байсан уу, бүү мэд.

-Маршал 11 цагт ирнэ. Явтал нь өрөөнөөсөө гарч болохгүй шүү! гэнэ. Хүү слесариудын өрөөнд ороод нам сууна. Ганцаараа бүгэж суугаа хүнд цаг гээч явахгүй нь тамтай. Хаалганы цаанаас Маршал үг хэлж байгаа бололтой намуухан хоолойтой хүний яриа бүдэг бадаг сонсогдоно. Хүмүүс байсгээд л нижигнэтэл алга таших дуулдана. Арайхийж Маршал явав бололтой слесариуд өрөө рүүгээ орж ирээд шуугилдаж эхлэхэд, хүү зөрж гараад туг лоозон унжуулсан уулзалтын талбайг нь, Маршалын зогсож үг хэлсэн индрийг нь гунигтай харж, санаа алддаг байлаа. Энэ мэтчилэн түүнийг “Чи насанд хүрээгүй хүүхэд” гээд их олон зүйлээс хоцроодог байсан гэдэг.

Илүү цагаар ажиллаж челнок, зүү шөвөг, бусад сэлбэгүүд хийсэнд нь эдийн засагч үнэлгээ гаргана. Бүтээгдэхүүний тоогоор мөнгө бичигдэж, шагналын хөлс олгогддог нарядын системтэй. Арван дөрөвтэй хүүгийн ажлын хөлс, сарын нийлбэр дүнгээрээ нилээд их мөнгө болчихно. Тэр цагийн ханшаар мянга гаран төгрөгийн шагнал бичигдчихсэн байх энүүхэнд. Улсыг Аюулаас Хамгаалахын байцаагч, ахлах офицер хүний сарын цалин 350 орчим төгрөг, малын зах дээр нас гүйцсэн эр хонь 30 төгрөгийн ханштай байсан гээд бодохоор тэр цагтаа шаггүй их цалин! 33 бүдүүн эр хонь авчих мөнгийг сарын шагналдаа авна гээд ойролцоогоор бодохоор өнөөгийн ханшаар 6 сая 600 мянган төгрөг авсантай тэнцэх нь! Гэтэл үйлдвэрийн захиргаа Доржсүрэнг хүүхэд гээд их мөнгө өгөхгүй. Жаахан хүүхдэд тийм их цалин өгчих нь тэр үеийн зарчимд нийцэхгүй байсан хэрэг. Тэр ч бүү хэл шагналын цалинг нь комбинатын захиргааны шийдвэрээр хаачихсан байж.

-Жаахан хүүхдэд ийм их мөнгө өгч яаж болох вэ? Хар багаас нь мөнгөний шуналтан болгож эвдэх нь..! гэж хурал дээрээ хэлэлцсэн нь тэр. Харин энэ бүхэн еврей удамтай, орос мэргэжилтэн Рачуновт таалагдсангүй. Тэр хүн арван дөрөвхөн настай слесарьтаа их сайн байсан учраас захиргаа руу гүйж очив.

-Та нарт ичих нүүр алга уу? Жаахан хүүхдийн шагналын цалинг яагаад хаачихаж байгаа юм бэ? Насанд хүрээгүй, юугаа ч мэдэхгүй хүүхдийг луйвардсантай ялгаа алга! гэж уурлан бөөн хэл ам хийлээ. Дарга нар өнөөх тайлбараа хэлж, ятгаж сэнхрүүлэх гэж оролдсон ч, еврей эр бууж өгөлгүй үзэлцсээр байгаад хүүгийн шагналын цалинг хагас дутуу ч болов олгуулах шийд гаргуулж байж. Тэр үед орос мэргэжилтэн гэдэг их эрх дархтай, эвэртэн туурайтнуудыг айлгаж чаддаг хүмүүс байсан хэрэг.

Механик Рачунов хүүд зааж зөвлөнө. Ямар ч зүйлийг юухан хээхнээр орлуулаад “монголчлоод” хийчихдэг авьяасыг нь үнэлнэ. Орос мэргэжилтэн өөрөө ч гарын дүйтэй, юм юманд гаажтай эр. Наваанлуvsсан гуай гайхамшигт гуулин гагнуураа хийх болоход бушуухан гүйж ирээд биширсэн нүдээр харж, ажиж зогсоно. “Чөтгөрийн нүдийг гуулиар хуурлаа” гэж шоолж байснаасаа ичиж байгаагаа ний нуугүй хэлнэ. Түүгээр ч барахгүй механик хүн байтлаа ичиж зоволгүйгээр слесарь Наваанлуvsсан гуайд шавь орж гуулин гагнуур заалгалаа. Монгол дархны ур ухааныг бүрмөсөн хүлээн зөвшөөрсөн нь энэ. Рачунов гуай төд удалгүй монгол дархны гуулин гагнуурыг цэвэрхэн гэгч хийгээд сурчихсан, “Монгольская сварка, самая лучшая! Во..!” гээд эрхий хуруугаа гозойлгодог болсон гэдэг.

Ийнхүү хонон өнжин ажиллаж байтал 1945 оны 5 дугаар сарын 9-н болж, Зөвлөлтийн Улаан арми, холбоотнуудын хамт Фашистын Германыг бут ниргэж, дайсан үг дуугүй бууж өгөх хэлэлцээрт гарын үсэг зурсан тухай мэдээ орон даяар түгэхэд хүн бүхэн баярлалаа.

-Одоо л нуруу тэнийх нь гэцгээлээ. Гэтэл дайн дуусаагүй болж таарав. Бүгд Найрамдах Монгол Ард Улс дэлхийн дайнд оролцохоор болж, Япон улсад дайн зарласан гэлээ. Ингээд Үйлдвэр комбинат бүр ч хатуу чанга хамгаалалттай болчих нь тэр. Үйлдвэрийн бүх цонхнуудыг бор эсгийгээр битүүлчихлээ.

-Шөнө гэрэл гаргаж болохгүй! гэсэн даргын тушаалтай. “Яагаад ингэж байгаа юм бол оо?” гэж хүү гайхна. Шарав механикаас асууж,

-Дайсны агаарын довтолгооноос сэргийлж байгаа юм гэж тайлбарлаж өгөхөд нь л учрыг нь мэдлээ. Гэрэл гаргах юм бол дайсны онгоцны нисгэгч тэр гэрлээр баримжаалж ирээд, бөмбөгдчихдөг юм байх нь гэж ургуулан бодож байж. Өдөр ч цонхны хаалтаа авахгүй, байнгын цахилгаан гэрэлтэй ажиллана. Гутлын үйлдвэрийн дээвэр дээр дөрвөн амтай зенитийн пулемёт зоолгоостой. Ягаан гэж ажилчид нэрлэдэг барилгын ойролцоо, Нэгдүгээр цахилгаан станцын зүүн баруун талд урт амтай зенитийн их буу байрлуулсан байлаа. Шөнө болохоор маш том прожекторуудыг дээш нь тусган сүлжилдүүлнэ. Энэ бүх хугацаанд Доржсүрэн гэртээ тоотой хоносон гэдэг.

Холбоотнууд Японы самурай нарыг бут цохиж, буулган авснаар дайн дуусаж, удтал хүлээсэн тайван цаг эхэлж байв. Үйлдвэрийн цонхны хаалт бор эсгийнүүдийг авахад нүд гялбаад юм үзэхгүй байсан гэдэг. Үйлдвэр цэлсхийгээд, цээжин дотор нар мандчих шиг болсон нь гайхамшигтай сайхан байж. Ийм сайхан мэдрэмж төрөхийг урьд өмнө үзэж байсангүй. Үйлдвэрийн эргэн тойрон дахь цэргийн харуул хамгаалалтыг буулгаж, дээш сэрийсэн зенитийн буунуудыг авч явлаа. Үйлдвэр комбинатын бүх ажилчдын хурал хийж,

-Дайн дуусч, энх тайван тогтлоо хэмээн зарлаад, нормоо давуулан биелүүлсэн сайчуудаа сайшаан шагнаж, Зөвлөлт Монголын арми хэрхэн яаж баатарлаг ялалт байгуулсан тухай ярьж таниуллаа. Хурлын төгсгөлд, “Дайн дууссан. Одоо харьцгааж болно” гэсэн юм. Ингэж л дөрвөн жил үргэлжилсэн дутуу нойртой шаналгаат өдрүүд эцэс болов. Арван дөрөвтэй үйлдвэрт орж ирсэн хүү эрийн цээнд хүрчихсэн байлаа. Энэ дөрвөн жил дөчин жил шиг удаан өнгөрсөн гэдэг.

Нөхрийн шүүх

Үйлдвэр дээр үндсэн ажлын хажуугаар өчнөөн аахар шаахар ажлууд явагдаж, тэр бүрт ирц бүртгэнэ. Намын, Залуучуудын эвлэлийн, Үйлдвэрчний эвлэлийн дугуйланд долоо хоног бүр цугларна. Хагас сайны өглөө бүр “Сонин уншлага” гээч юм болно. Ажилчид түүнд нь заавал сууж, дэлхийн улстөрийн байдал, ах дүүгийн найрамдалт Зөвлөлт Орос улсын тухай сайн сайхан мэдээ, Англи, Америк, Япон гээд хөрөнгөтөн ертөнцийн хар бараан чимээг заавал сонордон сонсох үүрэгтэй. Арван хэдтэй хүү өнөөх Сонин уншлагад нь унтчихаад ирж чадахгүй. Хэд хэдэн удаа тасалчихлаа. Хоёр эгч нь үглэж “Ингэж унтаж байж шийтгүүлнэ дээ, чи!” гэх боловч нойрондоо өөрийн эрхгүй дийлдчих нь хяслантай.

Нэг өдөр түүнийг “Нөхрийн шүүх”-д дуудсан байлаа. Муу ажилласан, ажлаасаа хожигддог, залхуу хойрго базаахгүй ажилчныг Нөхрийн шүүх гэгчээр оруулдаг гэдгийг хүү мэднэ. Улс төрийн идэвхгүй, нам эвлэлийн дугуйлан, сонин уншлагад явдаггүй нөхдүүдийг ч бас шүүдэг байж.

Улаан булан руу хулгаж, зовсоор орлоо. Танхимын суудал дүүртэл ажилчдыг суулгасан байх агаад, тээр урд олны нүдэн дээр нэг сандал тавьсан харагдана. Доржсүрэнгийн хөлс урсаад, нүүр халуу шатаж яг л түймэрт орчихов уу гэлтэй. Намын үүрийн дарга түүнийг өнөөх “гэмт хэрэгтнийг” шүүдэг суудалд аваачиж суулгахыг дэн дун мэдлээ. Өмнө эгнээнд Үйлдвэрийн дарга, Намын үүрийн дарга, Үйлдвэрчний хорооны дарга, Залуучуудын эвлэлийн үүрийн дарга суусан байх агаад ширүүн харцаар түүнийг нэвт шувт төөнөн цоргих нь аймшигтай. “Ямар ч олон даргатай юм бэ? Би ч өнгөрлөө дөө., Ажлаас хөөчих байх даа?” гэж бодогдлоо. Ашгүй ардын төлөөлөгч, Нөхрийн шүүхийн шүүгч хоёр орж ирж, суудлаа эзлэхэд эвэртэн туурайтангуудын хурц нүд тийш шилжлээ. Шүүгч түүнээс,

-Чи яагаад сонин уншлага удаа дараа тасалсан билээ? гэж асуух нь нухацтай.

-Би унтчихаад байдаг юм., гээд хүү толгойгоо маажлаа.

-Хоёр эгч чинь ирж болоод байгаа. Гэтэл чи яагаад босч чаддаггүй билээ? гэхэд нь хэлэх үг олдсонгүй. Дарга нарын харц бүр ч ширүүн болчихлоо. Чи яагаад дуугарахгүй зогсоод байна? гэж намын дарга ууртай зандрах нь сүртэй. Улс төрийн шалтгаан байгаа юм биш биз? Сонин уншлагыг санаатайгаар эсэргүүцээд тасалдаг юм уу? гэж залуучуудын эвлэлийн үүрийн дарга дутахгүй ширүүн асууж байна.

-Үгүй ээ. Би санаатай тасалдаггүй. Унтчихаад байдаг юм., гэж хүү бүлтэгнэв.

-Шөнө унтдаггүй хүн үү, чи..? Орой эрт унтаж байхад яадаг юм? гэж ардын төлөөлөгч аашиллаа. Дуугүй зогсвол буруудахыг мэдэрсэн хүү,

-Орой эрт унтсан ч өглөө сэрж чаддаггүй юм гэчихлээ. Асууж байцааж, загнаж шүүмжилж, удтал хуралдсанаас Доржсүрэнгийн хөвөнтэй цамц хөлсөндөө бараг л нэвтрэв. Хайлж урсдгийн даваан дээр ашгүй нэг юм шүүх хурал өндөрлөлөө. Нөхрийн шүүх яг л жинхэнэ шүүх шиг хуралдаанаа явуулж, ихээхэн ноцтой зөрчилтэй бол зуун төгрөг, арай гайгүй бол

тавин төгрөг гэхчлэн торгох шийтгэл оногдуулдаг байсныг хүү өмнө харж байсан. Шүүх хурлаас “Улстөрийн идэвхгүй байдал үзүүлж, удаа дараа Сонин уншлага тасалсан нөхөр Доржсүрэнг тавин төгрөгөөр торгож шийтгэсүгэй!” гэсэн тогтоол гаргалаа. Тавин төгрөг гэдэг тэр үедээ хоёр хязаалан эр хонины үнэ.

“Надад харин ч гайгүй шийтгэл оногдууллаа. Тэр нэг хэргийг мэдсэн бол энэнээс нэт юм болохгүй юу...” гэж хүү бодон зогсож. Учир юу гэвээс найз Равжиртайгаа хамт явж, хотын Хувьсгалт залуучуудын эвлэлийн хороон дээрээс батлахаа авахдаа өдүүлсэн гэмийг нөхрийн шүүх мэдсэн бол Эвлэлийн гишүүнээс хөөж ч мэдэх байсан хэрэг. Насанд хүрээгүй ажилчин болсон хоёр хүүг “Заавал эвлэлийн гишүүнд элсэх ёстой” гэж үүрийн дарга мундагдаад, шууд гишүүн болгочихоор нь дургүйцмэр аядаад, “Энэ цусаар яадаг юм..!” гэж эсэргүү үг хэлж, эвлэлийн гал улаан батлахаа гутлынхаа түрүүнд хийчихээд буцаж ирж байж.

Тэр үед ноцтой зөрчил гаргавал Эвлэлийн товчоогоор хэлэлцэнэ, бүр цаашлаад Намын товчооны хурлаар оруулж бут ниргэдэг. Хэтэрсэн их зөрчилтэй хүнийг нам, эвлэлийн бүх гишүүдийн хурлаар оруулж, эвлэлээс хөөхийг сануулж хатуу донгоддог байсан юм. Даамай ноцтой юм болж эвлэлийн гишүүнээс хөөгдвөл, давхар ажлаасаа халагддаг байж.

Коммунист субботник, капиталист бизнес

Хүүгийн тогтмол цалин 400 орчим төгрөг болно. Бас Рачунов мэргэжилтний ачаар нарыдаа бодуулж шагнал авдаг болчихсон. Сарын эцэст наряд хэмээх далбайсан хуудсуудаа бариад, эдийн засагч руу очиж мөнгөө бодуулна. Сэлбэг их хийсэн болохоор цалин дээр шагнал нийлсэн овоо юм гардаж авна.

Гэвч тэр их цалингаасаа нэг ч улаан мөнгө авалгүй ахдаа тушаана. Гомбо ах гэрийн бүх хүмүүсийн цалинг хурааж мөнгө санхүүгийн эрх мэдлийг гартаа атгана. Доржсүрэн дүүгийн хувцас муудвал цэрэг ногоон өмд цамц авч өгнө. Дотоод үйлдвэрийн бакал гутлаар голдуу хөл жийрэглэнэ. Өвөлд хөвөнтэй хүрэм, эсгий гутал авч өмсүүлнэ. Ажилчин хүмүүс болохоор хувцасны сайхан муухайг мэдэх ч үгүй. Ажлын бус цагаар сэгсүүргэн дотортой үстэй дээлээр “гангарна”. Тэр дээл хуучрахаар өнгийг нь хуу татаж хаяад, шинэ өнгө татуулчихна. Мах килограмм нь 3 төгрөг 50 мөнгөний үнэтэй. Талхны хажуугаар боорцог хайрч идэцгээнэ. 70 килограммаар савласан гурилыг шуудайгаар худалдаж аваад, хөлсний морин тэргээр гэртээ авчирна. Тэр үеийн ажилчид ийм л амьдралтай байж.

Нэгдүгээр цахилгаан станц “ЯАЗ” хэмээх таван ширхэг ачааны тэргээр нүүрсээ зөөдөг байснаа болиод, нарийн төмөр замаар галт тэргээр зөөж эхлэв. Тэр нь сахил хүртээд шал дордов гэлтэй. Өвөл төмөр зам нь цасанд дарагдахаар галт тэрэг нь явж чадахаа больчихно. Цас их унасан жил бол нэгдүгээр цахилгаан станц бараг л зогсоход хүрдэг байж. Үйлдвэр комбинатын ажилчдыг цас цэвэрлэгээнд дайчилж, Доржсүрэн хүү сэгсүүргэн дээлээ өмсөж, байдгаараа дулаалж аваад гарна. Машин тэрэг гэхээр нүдээ ухаад өгөх нь холгүй хорхойсдог болохоор модон кабинтай “ЯАЗ” машины тэвш өөд хүмүүсээс өрсөн авирч гараад, хамгийн өмнө зогсож явах дуртай.

Хүүхэд болохоор өдөржин цас цэвэрлэхээс уйдаад, зүтгүүтмээр санагдах нь мэдээж. Нүүрс ачсан галт тэрэг ирж явааг харвал баярлаж, ойртож ирэхийг анаж хүлээнэ. Дэргэдүүр өнгөрөхөд нь үсрээд суучихна. Нарийн төмөр замын галт тэрэг гэж хүүхдийн тоглоом шиг хөгийн жижигхэн, удаан явдалтай юм байсан нь энэ. Субботник гээд тооцчихдог болохоор цас арилгасны хөлс бодогдохгүй, ажилчдын сард авдаг цалин хөлсөнд нь сүйтгэлтэй. Томчууд “Дахиад л цас арилгах нь! Нэг өдрийн ажлын хөлс салхинд хийслээ” гээд урамгүй. Харин слесарь хүү цас орвол “Машинд сууна, галт тэрэгнээс үсэрч зүүгдэнэ” гэж бодохоос бөөн баяр болно.

Төмрийн тасгийн дарга герман Бадарч гэгч хүн Доржсүрэн хүүтэй сүрхий найзлана. Найзлах гэхээсээ илүү түншилж, одооны хэлээр бизнесийн хамтрагч нь болно. Амралтын өдөр болохоор хятадын хээ хуар болсон гоё морин тэрэг хөлсөлчихөөд гэрээс нь зайдуухан хүлээж зогсоод, айлын хүүхдээр сэм дуудуулсан байна. Хүүг хүрч ирэхэд,

-Багажаа бүрэн авсан уу? Юм мартаагүй биз? гэж герман Бадарч заавал асууна. Хамгийн чухал юмаа мартаж болохгүй нь мэдээж хэрэг. Ингээд “түншүүд” Усны гудамж руу шогшуулна. Энэ гудамжинд янз бүрийн үйлчилгээ, худалдаа наймаа эрхэлдэг хятад иргэд олноороо суудаг байлаа. Хүрээнийхэн сайван гэж нэрлэдэг хятад оёдолчдыг хэсч, Доржсүрэн эвдэрхий машин засах үүрэг хүлээнэ. Бадарч гуай түрүүлж яваад, хэний оёдлын машин

эвдэрсэн байгааг судлаад тогтоочихсон болохоор аяллын чиглэл тодорхой. Хятадууд юмны чанарыг мэддэг, айхавтар улс болохоор голдуу л герман машинууд байх бөгөөд машины ажиллах зарчим нь ижилхэн болохоор засна, тохиргоо хийнэ гэдэг амархан.

Засвар дуусахад хөгшин түншийн “ажил” эхэлнэ. Ширээний ард суугаад арааны шүлс асгаруулсан, гоё амттай хятад хоолоор дайлуулна. Хүү хоол руу шунгаад орчихдог бол хөгшин сархад зооглонгоо нарийн хоолыг амтархан савхдаж сууна. Нанчид хүртэх нь Бадарч түншийн нэгдүгээр “ажил”. Хоёрдугаар ажил нь хөлсөө нэхэж авах. Арван хэдтэй хүү хүнээс мөнгө нэхэх бүү хэл өгсөн мөнгийг нь авахгүй гээд, зугтааж ч мэдэхээр. Хөгшин түнш нэхэж авсан мөнгөө тэр чигт нь хүүд өгнө.

-Мөнгө авч яах гэсэн юм бэ? гэж Доржсүрэн нэрэлхэхэд,

-Чи юу гэнэ ээ? Мөнгө заавал авна шүү! гэнэ.

-Тэгвэл мөнгөө тэнцүү хуваая л даа гээд хүү дахиад л царайгаа улалзуулна.

-Тэр ярихгүй. Чиний л хийсэн хөдөлмөр. Би далимд нь үнэгүй хоол архи зөндөө л хүртлээ шүү дээ! гэнэ. Түншүүдийн ажил дуусахад орой ч болсон байх агаад, Бадарч гуайн нүд ч талимаарч, сайхан зантай болж амжина. Ердөө хоёрхон сайванд машин засч өгсөн хэрнээ зуу гаруй төгрөгийн олз олчих энүүхэнд. “Гуанзны мөнгөтэй болчихлоо. Самдан, Цагаан хоёр яаж баярлах бол?” гэж хүү тэсч ядан догдлоно. Олноосоо арав хорин цаас өөртөө авч үлдээд, ээждээ эсвэл хоёр эгчдээ ч юм уу, ахдаа өгчихнө. Өчигдөр өдөржин цас арилгаж үнэ хөлсгүй коммунист субботник хийсэн хүү герман Бадарч гуайн буянаар капиталист бизнес хийж, найзуудаа дагуулж хятад гуанзанд орох мөнгө олчих нь урамтай.

Наадам эсвэл нандин бараа

Тэр үед улсын баяраар ажилчид арван тав хоног амардаг байлаа. Бүхэл бүтэн арван тав хоног шүү дээ! Долоон сарын нэгэнд бүх үйлдвэрийн суурь машинуудыг зогсоож, тог цахилгааныг нь салгаад, жижүүр харуулуудад хүлээлгэж өгнө. Комбинатын Хэрэгцээний хэлтэс гэж ажилладаг, тэдний дарга нярав нар,

-Гутлын үйлдвэр олон хүнтэй. Хоёр үхэр өгье! гэх зэргээр хүнс хуваарилна. Зарим жил хоёр бод, зарим жил арван хэдэн бог гэх зэргээр наадмын хүнс оногдоно. Хамт олноороо Туулын эрэг рүү очоод, майхан барьцгааж, үхрээ унагааж аваад, хорхог, хуушуур хийцгээнэ. Айргийг хувин саваар биш хөхүүр хөхүүрээр нь сөгнөнө. Доржсүрэн хүүхэд болохоор голын усанд шумбаж, гол өгсөж уруудан тоглоод алга болчихно.

-Хоол гарлаа шүү! гэх дуу сонсогдохоор хүрч ирж жаахан юм шоглочихоод, айраг ууж аваад буцаад гүйчихнэ. Томчууд хөзөр даалуу тоглож, дуртай ганц хоёр нь нанчидаа хүртэцгээж, дуу шуу болцгооно. Туулын хөндийгөөр уртын дуу шуранхайлж, тасаг хэсгүүдийн найр хавтгайрна. Айргаа ууж, хуруудаж, дэмбээднэ. Ийнхүү зугаалга хийж, хонож өнжин найрлаж байтал наадам эхэлнэ. Тэр үеийн баяр наадам бүтэн долоо хоног үргэлжилдэг байлаа.

Наадмын талбайд үйлдвэр бүр гэр барьчихна. Үйлдвэр комбинатын гэрүүд урт эгнээ болж харагдана. Гутлын үйлдвэрийнх гээд хоёр том гэр байх. Дарга цэрэг гэж зэнзийлэхгүй, гэрээрээ орж гарч, айраг ууж, хуушуур эргүүлэн наадамдана. Ажилчид наадамдах гэхээсээ илүү дэлгүүрүүдийн үүд сахин урт дараалалд зогсоцгооно. Наадмын үеэр дэлгүүрүүд хав дарж байсан ховор живэр бараагаа зарж хөдөлмөрчин ард түмнийг “баярлуулдаг” учраас энэ. Хонон өнжин дараалалд зогсохдоо хэн ч уурлахгүй нь гайхмаар. Харин ч эсрэгээрээ нарийн нандин бараа ирлээ гэж баярлана. Үүрийн таван жингээр дэлгүүрийн гадаа очиж, очер авсан хүн ховор бараа олж авна. Хүмүүс шивэр авирхийлцэн,

-Дэнжийн дэлгүүрт дээлийн торго ирсэн гэсэн. Шар дэлгүүрт орны орос аравч зарах юм гэнэ лээ! гэх зэргээр чухал мэдээгээ сэтгэл харамгүй хуваалцана.

-Долоо хоног үзсэн харсан ч юм байхгүй дэлгүүрт очерлоод таарлаа даа, гээд айлын эзэгтэй нар сэтгэл хангалуун инээлдэнэ. Ор, толь гээд хэрэгтэй юмаа олж авсан болохоор баяртай байхаас ч яахав. Цагаан төмөр ор, түмпэн савны төлөө хүртэл очерлож, алалцах шахдаг байсан цаг. Халуун наранд хөлсөө гоожуулан зогсож, шахцалдаж түлхэлцсээр байж, авсан цагаан төмөр ороо тостой нь үүрээд маадгар алхсаар айлын эзэгтэй гэртээ ирнэ. Боодлыг нь хуулж, тосыг нь арчиж тулсныхаа дараа гэрийнхэн лүүгээ нүүр дүүрэн хардаг байж.

Доржсүрэнгийн гэрт ажил үүргийн хуваарь арай өөр. Өрх гэрийн санхүүч Гомбо ах ийш тийш сураг ажиг тавьж, очер дугаарт зогсож ховор живэр юмнуудыг хамж ирнэ. Доржсүрэн хүүхэд болохоор нандин барааны төлөө гүйхгүй, тэр ч бүү хэл наадмыг ч тэгтлээ сонирхохгүй. Гомбо ахынхаа өгсөн хэдэн төгрөгөөр сугалаа сугална, чихэр авч иднэ. Ах нь нэг удаагийн наадмаар л их өгөөмөр загнаж, хүүд зуун төгрөг өгсөн түүхтэй. Тэр наадмын өмнө Доржсүрэн мянга гаран төгрөгийн өндөр цалин авсан учраас тэгж шагнасан хэрэг. Түүнээс биш наадмын халаасны мөнгө гээд хорь гуч, сайндаа тавийг л өгдөг байж.

“Тарвагант” гээд хайрцган дээрээ тарваганы зурагтай орос тамхи тэр үед худалдаанд ирдэг байлаа. Дотроо арван ширхэгтэй, янжуур маягийн эд. Хайрцаг нь арван мөнгөний үнэтэй. Саваагүйтээд тэр тамхинаас авч, наадмын талбайгаас холдож, Туулын бургас руу ирж нууцаар татна. Ингэж зүггүйтсээр нэг л мэдэхэд тамхинд орж, байнга баагиулдаг болчихсон гэдэг. Гэрийнхээ завган доогуур хайрцагтай тамхиа нуух бөгөөд, гарахдаа сэм сугалж өвөртлөнө.

Тэр үеийн Улаанбаатарт бүх үйлчилгээг хятадууд явуулж байлаа. Эрээн цоохор хээ хуартай морин тэрэгтэй хятадууд таксиний үйлчилгээг орлоно. Хятад гуанзны хуйцаа шиг амттан ховор. Төмс хүнсний ногоо, нарийн боов бүгдийг хятадууд залгуулна. Хамгийн уран мужаан, нимгэн төмрийн чадвартай дархан бас л хятад. Шинэ цагийн гангачуудын гоё хувцсыг хятад сайвангууд л оёно.

Таван гудамж гээд одоогийн Тэнгис кинотеатрын орчимд нилдээ хятадууд сууна. Хөнгөн амьдрал хайсан монгол хүүхнүүд гүйлдэж очоод хятадуудтай суучихсан байх агаад ажил хийхгүй, аль үнэтэй хувцас гоёлыг өмсөж эдлэн сууцгаах нь дэндүү жаргалтай. Мөрийтэй тоглоом тэрхүү Таван гудамжинд л явагдаж, сэргийлэх цагдаагийнхан тэндээс л тоглоомчдыг барьж авна. “Буу, күйдэн гэгч сүрхий тоглоом тоглож байсан хэдэн хүнийг барьсан гэнэ” гэх зэргийн сүртэй цуу яриа амнаас ам дамждаг байлаа.

Олзны япончуудтай

1945 онд хүү 18 нас хүрлээ. Энэ насанд хүүхдүүд дунд сургуулиа дүүргээд, ямар дээд сургууль сонгохоо ярилцаж, шийдэж ядаж байдаг бол Доржсүрэн дөрвөн жил ажилласан хашир засварчин, туршлагатай догь слесарь болж амжчихаад байлаа. Юуг ч хийчихэж чаддаг адтай, юм бүхнийг өөрөө сэтгэж, өөрийн гараараа хийх гэж зүтгэдэг махруу зөрүүд хүүг үйлдвэрийн хамт олон, ажилчид бүгд хүндэтгэнэ. Гэтэл үйлдвэрт өсөж өндийсөн хүү нь цэргийн албанд явах насанд хүрчихээд, юу юугүй албанд татагдчих гээд байдаг. Дарга даамлууд чадалтай засварчнаа алдчих вий гэхээс яс нь хавтайна. Яаж ийж арга саам хийгээд энэ хүүгээ авч үлдээд л байх юм шүү хэмээн хоорондоо ярилцаж байж. Гэтэл ашгүй асуудал нааштай шийдэгдэв.

1945 оны чөлөөлөх дайнаас олзлогдсон 112 япон цэрэг 46 оны өвлөөс эхлэн Гутлын үйлдвэрт ажиллаж байлаа. Эднээс 15 хүн Доржсүрэнгийн удирдлагын дор ажиллаж байсан учраас “Олзны хүмүүсийг харгалзах нь цэргийн алба хаасантай ялгаагүй хариуцлагатай ажил мөн болно” гэж дээрээс үзэв. Ингээд л хүүд цэргийн алба хаасан гэсэн бичиг олгогдож, үйлдвэрийн даргын санаа амрав.

Өглөө ажил цуглахын өмнө яг долоон цагт жадтай буутай харуулын цэргүүд япончуудыг жагсаалаар тууж авчраад, гадаа зогсооно. Ажилчид цуглаж дуусаад, бүгд ажлын байраа эзэлсний дараа л олзныхныг үйлдвэр лүү оруулна. Хөөрхий арлын дулаан орны хүмүүс өглөөний жаварт даараад, үйлдвэр лүү бушуухан орохыг тэсч ядан хүлээж зогсдог нь мэдээж. Цонхийтлоо даарч, бээрчихсэн тасаг руу орж ирцгээгээх нь өрөвдмөөр. Япончуудын ахлах дарга нь үйлдвэрийн боловсон хүчний өрөөнд цуг суудаг боллоо. Ийм болохоор муу ажилласан олзны цэргийн тухай мэдээ даргад тэр дороо л хүрнэ. Дарга бүх хүмүүсээ жагсаасны дараа ажил муу хийсэн хүнээ бусдынх нь нүдэн дээр алгадаж шийтгэнэ. Өвөрмонгол хэлмэрч нааш цааш завгүй гүйж хэл залгуулна. Орой таван цагт олзныхныг гадаа гаргаж жагсаан тоо аваад, шийтгэх нэгийг нь шийтгэсний дараа Цагаан сүм рүүгээ туугаад явна. Ийм нэртэй эзгүй хуучин сүмд тэднийг байрлуулж хорьж байлаа.

Хүү олзны цэргүүдийг их өрөвдөнө. Гэтэл дээрээс “Олзны хүмүүстэй найзалж, дотно харьцаж болохгүй” гэж анхааруулсан байдаг. Заримдаа хүүхдийн зүтгүй зандаа хөтлөгдөөд элдвийн зүйл асууна.

-Чи хичнээн хүн алсан бэ? гэж асууна. Энэ асуултад нь бүгдээрээ,

-Би хүн алаагүй! гэж сандран хариулна.

Монгол ажилчид өрөвчхөн сэтгэлтэй болохоор тэдэнд хүн бүр тусалж, хоол унд илүүчлэхсэн гэнэ. 12 цагт япончуудыг үдийн хоолонд нь жагсаагаад аваад явахад,

-Олзны хоригдлууд болохоор ямар л олигтой хоол өгөө гэж. Сайндаа л шар будаатай усан шөл байгаа биз..! гэж авгайчууд халаглана. Хэдий дээрээс “болохгүй” гэж хатуу анхааруулсан ч яаж ийж байгаад халаасанд нь талх, боорцог, ааруул шургуулчихна. Ингэх үед хөөрхийс нүд нь гэрэлдээд, бөөн баяр болох нь бүр ч өрөвдмөөр. Доржсүрэн ч дүүрсэн хэрэг албан

тушаалаа ашиглая, нутгаасаа хол зүдэрч байгаа хүмүүст тус больё гэж шийдлээ. Япончуудын хийсэн ажлын хөлсийг монгол слесариудын нэр дээр бичээд, сарын сүүлээр мөнгө буухаар нь хурааж цуглуулав. Дэлгүүрээс мах, талх, гурил будаа, төмс ногоо, цуглуулж бэлтгүүлээд, япончуудын ахлах даргад нь,

-Өнөөдөр ажил их байна. Нааш цааш явуулж цаг алдаж байхаар, хариуцдаг арван таван хүнээ энд нь хоол өгөөд, бушуухан ажилд нь гаргая гэлээ. Ахлах дарга нь харин ч олзуурхсан байдалтай хараад,

-Бололгүй яахав. Харин хүмүүсээ сайн харж хянаарай! гэх нь тэр. Ингээд л арван таван япондоо хүнсний зүйлсийг өгөөд,

-Энэ бол та нарын ажлын хөлсөөр авсан юмнууд. Өөрсдөө дуртай хоолоо хийж идэцгээ гэж. Олзны цэргүүд бөөн баяр болов. Шар тоосгон дээр ховил гаргаад, пүршин утас ил суулгаж хийсэн гар хийцийн плиткэн дээр өнөөдүүл шөл хийж ууцгаалаа. Монгол үхрийн өөх нь шаргалтсан тарган махны шөл ханатлаа ууж, гэдсээ цадтал мах ногоо хольж идсэн харийн хөөрхий цэргүүдийн нар нь гараад, Доржсүрэн дарга руугаа гүйж ирээд “Аригато Дооржоо сан!” гэж бөхөлзөнө. Өмнөө хүн бөхийлгөх бүү хэл номхон зогсоож ч үзээгүй хүү ихэд эвгүйцэж сандрав.

-Бөхөлзөөд хэрэггүй ээ. Би ноён биш! Манайд хаад ноёд гэж байхгүй. Бүх ардууд тэгш эрхтэй. Хэний ч өмнө бөхөлзөх хэрэг байхгүй гэж тайлбарлаж байж. Үүнээс хойш болж л өгвөл өнөөх “Өнөөдөр ажил ихтэй” гэдэг үгээ ахлагчид хэлж, япончуудаа авч хоцрох боллоо. Доржсүрэнгийн удирдлага дор байсан олзныхон нэг мэдтэл подойтол царай зүс ороод, бусдаасаа ялгарах янзтай болчихсон гэдэг.

Япончуудын тус

Доржсүрэн арван ес хүрсэн хэдий ч хүүхэд ааш нь хэвээрээ. Цагаан сүм рүү очоод япончуудын байраар явж үзье гэж бодогдоод, сониуч зан нь хөдлөөд болохгүй. Нэгэн амралтын өглөө дарга нар мэдээд шийтгэвэл шийтгэг, япончууд дээрээ зочилж оччихоод ирье гэж шийдээд, Цагаан сүм рүү алхчихлаа. Гэвч тийшээ ойртсон биш жадаар сүлбүүлчих шахсан нь инээдэмтэй. Харуулын цэрэг өмнөөс нь гэнэт гарч ирээд,

-Зогс, буудлаа! гэж хахирган дуугаар хашгирч, винтов бууны хурц жад тулгахад цочоод нам хөшлөө. Айсандаа үнхэлцэг хагарах дөхсөн хүү үйлдвэрийн ажилчны үнэмлэхээ үзүүлж, нилээд хөглөж байж харуулын ахлагчийн гараас мултарч байв. Япончууд дайны олзлогдогсод, бас тэднийг шоронд хорьж байгаа гэдгийг яагаад ч юм ор тас мартчихсан байсан хэрэг. Хүүгийн хувьд харь хүмүүс дайсан биш найз нөхөр юм шиг л ойр дотно байж ирснээс тэр болов уу. Андындаа зочилж дайлуулах гэж байгаа хүн шиг л яваад очсон нь хоржоонтой.

Ийнхүү хөглөөд, гэр лүүгээ буцаж явахдаа “Шорон гянданд орж үзнэ, хүнтэй уулзана гээд хээв нэг алхаад очдог тэнэг хүн надаас өөр байдаг болов уу? Ажлынхан сонсчихгүй байгаа? Тэгвэл ч бөөн доог тохуу болно доо” гэж өөрийгөө зэмлэж явж. Маргааш өглөө нь олзны ажилчдадаа ажил хуваарилж зогсохдоо өөрийгөө шоолон өөрийн эрхгүй жуумайсан гэдэг. Япончуудаас дөрөв нь слесарийн үүрэгтэй ажилладаг байлаа. Тэдний дундаас Карадэ гэх хууз сахалтай эр их сэргэлэн. Дохио зангаагаар байнга ярьж, инээж хөгжиж явна. Харь нутагт олзлогдож ирсэн ялтан бус аяллаар ирсэн жуулчин шиг л өөдрөг. Харин нэгэн настайвтар нөхөр гарын алга харж мэргэлнэ. Ажилчид тэр япон хөгшний хэлсэн нь яг таарч байна гэлцэн, мэргэлүүлэхээр слесариудын өрөө рүү сэм гүйлдэнэ. Дарга даамлууд ч нууцаар өрөөндөө дуудаж мэргэлүүлсэн тухай яриа чих дэлсэж байсан удаа бий. Хүн болгон мэргэ таарсныг гайхаад, бишрээд байхаар нь Доржсүрэн ч сонирхож, мэргэлүүлж үзэв. Алгыг нь удаан харж байснаа,

-Чи хорь гарангуут авгай авна. Маш олон хүүхэд гарна. Их урт насална. 85 нас хүрээд паанаа! гэж мэргэлж байж. “Паанаа” гэж үхнэ гэхийг хэлсэн хэрэг.

Гүйцэтгэх тасагт нэгэн доожоогүй нөхөр ажилладаг байлаа. Намхандуу нуруутай залуухан эр хэрнээ залхуурдаг ч юм уу, яадаг ч юм дандаа л ажил муу хийсэн гэж шийтгүүлж алгадуулж зогсох. Ажилчид хөөрхийг өрөвдөхийн ихээр өрөвдөнө.

-Залуу хүүхэд болохоор гэрээ санасандаа л ингэж доожоогүйтэж, унжийж явдаг биз.., гэж хөгшчүүл ярилцаад, олны нүдэн дээр алгадаж шийтгэдэг харгис даргыг буруушаана.

Япон слесариуд нууц цоожийг уран нарийн аргаар хийнэ. Монгол цоож шиг даруулга, цүү нь данхайгаад байхгүй, шүүгээнд ганц жижигхэн нүх л харагдана. Ганц дарахад тапхийн түгжигдэнэ. Нааш цаашаа холхио байхгүй, гараар гарна гэж зангүй. Уран хийцтэй нарийхан түлхүүрүүд нь хоорондоо ердөө таарахгүй. Ийм гайхалтай цоожийг хараад, механик ня-богоос эхлээд слесариуд бүгдээрээ ширээ, шүүгээндээ япон цэргүүдийн хийсэн далд цоожийг тавьж, гангардаг боллоо. Ямар сайндаа үйлдвэрийн дарга Доржсүрэнг дуудаад,

-Чи цаад япончуудаараа миний ширээнд цоож хийлгээд орхи гэж байхав дээ. Карадэ даргын ширээнд гараа гарган гоё цоож хийж магтаалын үг сонсож байв. Доржсүрэн хийх аргыг нь сурч аваад, гэрийнхээ авдар сав, багажныхаа шүүгээ бүгдэд нь тийм цоож хийсэн нь одоо ч бий. Карадэ бас токарийн машинд гаргууд. Чичиргээ донсолгоо ихтэй хуучин муу токарийн машиныг нь асаагаад, олзны хүн гэж хэлэхээргүй сэтгэл хангалуун инээмсэглэн ажлаа эхэлнэ.

-Хутга сайн бол токарь сайн. Хутга муу бол токарь муу гэж хэлэх дуртай. Машины сэлбэгүүдийг төмрийн заводод захиалж зоруулдгаа больж, япончуудаараа хийлгэх болов. Тэд элдэв төрлийн гол, нарийн деталиудыг маш дадамгай зорно. Талхыг японоор пан гэдгийг ажилчид бүгдээрээ тогтоочихсон байлаа.

-Чи пан идэх үү? гэж асуухаар япон цэргийн царай гийж, толгой дохино. Хоёр жил болоод япончууд буцах болоход гуниг төрж, харь хэлтэй хэдий ч дулаан сэтгэлтэй цэргүүдэд дасчихсан байснаа мэдэцгээв. Өнөөх арван тав бүгдээрээ Доржсүрэнг тэвэрч, салах ёс хийж, хүүгээ юм шиг л элгэмсүү байсан гэдэг. Ихэнх нь нутагтаа очно гээд баярлаж байхад, зарим нь баргар. Хөгшчүүлээс ганц нэг нь,

-Биднийг очихоор амьд үлдээхгүй. Алчих байх гээд л уйлаад байсан гэдэг. Уран гартай, ажилсаг япон цэргүүд хоёр жил хэртэй ажиллахдаа юм бүхнийг хийж, монголчуудад багагүй зүйл зааж, их тус нэмэр болоод буцсан байдаг.

Барууны кинон дээр чөлөөлөх дайнаас олзлогдсон япон цэргүүд Сибирьт яаж зовж зүдэрч, даарч хөрч байсан тухай гардаг бол манайд байдал шал өөр байж. Дулаан зузаан хөвөнтэй хүрэм, эсгий гутлын бүрэн хангалттай болохоор гаднаасаа даарахгүй. Ажилчид тэдэнд элэгсэг дотно ханддаг болохоос дотроосоо ч бас дулаацчихдаг байсан биз. Олзны цэргүүд Монголоос буцахад нь бүх хүнд шинэ цагаан нэхий дээл, хурган малгай, бор эсгий гутал өмсүүлээд явуулж байж. Гэсэн ч Монголын идэр есийн хүйтнийг далайн дулаан орны хүмүүс яаж даах вэ, урт холын аян замд эндэж осолдсон хүн гарч байсан гэдэг.

Доржсүрэн Сэлэнгийн Цагаан эргийн дамжлага баазаас сэлбэг хэрэгслээ авахаар очихдоо буцаж байгаа япончуудыг хилээр гаргаж байхтай тааралдлаа. Тэгтэл хэд хэдэн хүн холын замыг даалгүй эндсэн байв. Хөөрхий цэргүүдийн хөлдүү цогцсыг тавцан дээр эгнүүлээд өрчихсөн гараас нь цагаан даавуун пайз зүүсэн нь нүд хальтрам харагдаж байж. Олзны цэргүүд Засгийн газрын ордон, Гадаад яам, Дуурийн театр гээд олон сайхан барилга бариад, Монголд их юм хийж өгөөд буцаж байгааг нь бодохоор харамсмаар санагдсан гэдэг. Слесарийн бригадад нь ажилладаг арван таваас эндсэн байх вий гэж бодохоос бүгдийнх нь царай нүдэнд харагдаад өрөвдөлтэй. Сэлбэгээ ачаад буцаж ирэх замынхаа туршид тэр тухай бодоод, ирсэн хойноо ч хэсэгтээ тэр аймшигт дүр зургийг нүдэндээ харж хиртхийсээр л байсан юм.

Морьт отряд, соёлын довтолгоо

Үйлдвэрийн ажилчдад Цэрэгжлийн хичээл гэж ордог байлаа. Тэр хичээл дээр модон буу үүрээд, жагсаалын бэлтгэл хийнэ. Модон хутгаар гардан тулалдаж, хиймэл гранат шиднэ. Нам төрийн бодлогоор бүх сум баг, хороодод өөрийгөө хамгаалах “Морьт отряд” гэдгийг байгуулах компанит ажил явагдаж, тэр нь Аж үйлдвэрийн комбинатад ч хүрсэн хэрэг.

Үйлдвэрийн дарга автоматаар Морьт отрядын штабын дарга болно. Тасгийн дарга нар цэргийн дүрмийн дагуу ёсолж,

-Нөхөр штабын даргад илтгэх нь. Өөрийгөө хамгаалах цэрэгжилтийн сургуульд Гутлын үйлдвэрийн засварын тасгийн ажилчид бэлэн жагссан! хэмээн рапорт илтгэл өгнө.

Дайны жилүүдэд гэртээ ч харилгүй ажилд нухлуулснаас болоод хүүхдүүдтэй чавх, чулуугаар байлдахаа болиод, энэ бүхнээ эргэн санагалзаж, уйдаж байсан хүүд морьт отрядын байлдааны сургууль их зугаатай сайхан байх нь мэдээж. Цэрэгжилтийн хичээл сургууль явуулах тухай зарыг сонсоод сэтгэл хөөрч, яардаг болсон гэдэг.

Зарим албан газрынхан морьт отрядын сургуульдаа хөдөө хол гарч, хоёр гурав хоногийн марш, манёвр хийгээд ирнэ. Харин үйлдвэрийн ажилчдыг хол явуулдаггүй байж. Комбинатын ойр орчмоор нь тойруулж гүйлгэж, гар хөлийн сургууль хийлгэж, марш тактикийн хичээл орно.

Дайсны онгоц, өөрийн онгоц, танк, машин механизмуудыг таниулах хичээл ч бас явагдана. Агаараас эсэргүүцэн хамгаалах сургалтад их ач холбогдол өгнө. Үйлдвэрийн нутаг дэвсгэрт бөмбөг унавал яах вэ, яаж өөрийгөө хамгаалах вэ гэдгийг заадаг нь их сонирхолтой. Гутлын үйлдвэрээс хойшоо гардаг хаалганы ойролцоо хоргодох байрны орц байна. Түгшүүрийн дохио дуугармагц яаран гүйлдэж, хоёр давхар зузаан хаалгаар дамжин хонгилоор гүйлдсээр газар доогуурх хоргодох байранд орно. Түгшүүрийн дохионы яндан улин гийнаж маш муухай дуугарна. “Юу болчихов оо? Дайн эхэлчих нь энэ үү?” гэх бодол толгойд зурхийж, айдас төрж, ар нуруу руу хүйт даагаад л явчихна. Үйлдвэр дотор түгшүүрийн дохио өгөх зориулалттай яндан суурилуулсан байдаг нь энэ. Тэр яндангийн товчийг морьт отрядын шуурхай жижүүр даргын тушаалаар гэнэт дарж, ажилчдын цэрэгжлийн бэлтгэлийг шалгадаг байлаа.

1946 онд шинэ бичиг гарлаа. Соёлын довтолгоо гэгч улс орон даяар өрнөж бүх нийтийг шинэ үсэгт тайлах аян дайн болов. Ингээд ажилчид бүгдээрээ кирилл үсэгтэй болчихсон нь гайхамшиг гэмээр. Соёлын довтолгоо гэгч зүйл тэр үеийн хүүхдүүдийн сэтгэлд гүн мөр үлдээсэн байдаг. Үйлдвэрийн албан тушаалтнууд орой үдэш айлуудаар явж шалгана. Маршал ирнэ, машинаа арч гэдэг шиг Соёлын довтолгоо ирж мэднэ шүү, солионы даавуугаа хөнжилдөө хийгээрэй гэлцдэг боллоо. Шөнө дуг нойрондоо байтал баахан хүмүүс орон гэрт дайраад ороод ирнэ.

-Усанд ордог ваннаа үзүүл. Саван, оо бий юу? Орны цагаан даавуу хэдтэй вэ? хэмээн байцааж яс тоолж, шалгана.

-Гэр бүлийн хүмүүсийн тоогоор шүдний сойз байгаа биз? гэж ширүүн асуугаад тоолж үзнэ. Гутлын тосоо хаана хадгалдгийг шалгана. Ийнхүү орондоо нүцгэн шалдан хэвтэж байсан гэр бүлийнхнийг үүрээ эвдүүлсэн шоргоолж шиг бужигнуулж, дэвгэртээ бүртгэл тэмдэглэлээ хөтөлж дуусаад гарцгаана. Гэхдээ соёлын довтолгоог шоолж шүүмжлэх зүйл биш. Энэ компанит ажлын ачаар дээлээ майханчилж нөмрөөд унтчихдаг байсан монголчууд цагаан даавуу, хөнжил дэвсгэр хэрэглэж сурсан. Олон ч арчаагүй айл хир даг, бөөс хуурснаасаа салсан гэдэг.

Хань

Доржсүрэн бүдүүн хадуун гэхээр эр хүн. Уран дархны сургуульд сурч байхдаа Самдан, Цагаан хоёр найзтайгаа нийлж зүггүйтэж, хятад гуанзны хоол эргүүлж, унадаг дугуй л сонирхож явснаас охинд захиа занга өгч үзсэнгүй. Тийм зүйлийг мэддэг ч үгүй явж. Хар нялхаараа слесарь, механикаар ажилласан болохоор түүний бодол санааг найз охин биш техник, машин л эзэмдчихсэн байж. Энэ деталийг яаж монголдоо хийх вэ, ийм машиныг яаж засах вэ гэж л өдрийн бодол шөнийн зүүд болж байснаас охинд татагдаж зүрхээ шархлуулж үзсэнгүй явж. Тэгээд ч өсвөр насыг нь дайны хүнд бэрх өдрүүд мангас шиг залгичихсан. Охидын бараа харах бүү хэл гэртээ ч тоотой хонож, өдөржин шөнөжин үйлдвэрийн машинуудтай ноцолдсоор таван жилийг ардаа орхисон хэрэг.

1946 он гарлаа. Тайван цаг ирж, хүмүүс амар амгалан болцгоов. Цагаан, Самдан хоёртойгоо нийлж энд тэндхийн нийтийн бүжиг, олон нийтэд очдог боллоо. Хосоор амьдрах ертөнцийн жамаас зугтаадаг хүн гэж байх биш, нэг л мэдэхэд түүний сэтгэл гэгэлзээд эхэлсэн гэдэг. Тэр үед нийтийн бүжиг моод байсан цаг. Өмдийг нь гар эсгэтэл индүүдсэн хар кочоом өмсөөд, гялалзтал зүлгэсэн лаакан хар шаахай жийгээд Ленин хөлөөв рүү гараад өгнө. Офицеруудын ордон, Намын дээд сургууль, Комбинатын хөлөөв гээд Улаанбаатарт нийтийн бүжиг болдог газар хэд хэдтэй. “Өнөөдөр тэнд бүжигтэй гэнэ” гээд л гурвуул гүйлдэж очно. Хятад шийяанз дээр ч хааяа бүжиг болдог. Хожим Монголыг шуугиулсан нэртэй жүжигчин, гавьяат цолтон болсон Цогцолмаа тэнд саксофон тоглодог байлаа. Тэр үеийн нийтийн бүжиг амьд хөгжимтэй, их тансаг болно. Голдуу гуулин хөгжимтэй бүжиглэнэ. Ленин хөлөөв дагшаа найрал хөгжимтэй. Офицеруудын ордонд бүх цэргийн чуулгын гуулин хөгжим эгшиглэнэ. Намын дээд сургууль дээр голдуу баян хуур хөгжимтэй бүжиг болох бөгөөд хааяа гуулин хөгжим ч ирнэ. Бас дагшаа хөгжмийн цөөхүүл тоглоно.

Симфони оркестрийн хийл хөгжимчин Цэдэв гэх аятайхан бүсгүйг Доржсүрэн нууцхан хардаг боллоо. Комбинатын сургуульд доод ангид сурдаг байсан охин болохоор танина. Танил болохоор мэндтэй устай байх нь мэдээж. Гэвч вальс бүжигт урьж, “учиртай болсноо” хэлье гэхээр зүрх оволзоод, орчлон хорвоо тэр аяараа нүдний өмнүүр эрээлжлэн эргэлдээд эхлэх нь хяслантай. Бүсгүйд ойртож зогсоод “Одоо л урья” гэж өөртөө тушаана. Гэвч бүжгийн ая эхэлмэгц хаана юу хийх гэж ирснээ бүү хэл, нэрээ ч мартан догдлоод, гэгэлзэж дэгэлзэж байтал өөр залуу уриад эргэлдэн бүжээд алга болно. Хоёр найз нь түүнийг зоригжуулж,

-Очоод урьчихаач. Юунаас нь айгаа вэ? гэнэ.

-Чамайг хазчих гээд байна уу? гэж нэг нь бүр уурлалаа. Хоёр гурван ая яваад дуустал мэлрээд л зогсоод байсан тул Цагаан, Самдан хоёр түүнийг түлхэж, хөтөлж чирэх шахаж байж доод ангийн охиныг уриуллаа. Бүсгүйн гараас хэдэн зуун вольтийн цахилгаан гүйдэл гүйх шиг болж, аль хэдийнэ өөрийн ухаангүй болж жингүйдээд, хөлөөвийн танхим нүдний нь өмнүүр хөврөн эргэлдэж байхыг бүүр түүрхэн мэдэрч байж. Бүжиг дуусчихсан байтал бага сургуулийн танил охины зөөлхөн гар алган дээр нь тавиастай хэвээрээ мэт. Эргэлдэн бүжих зуураа инээмсэглэж байсан хоёр нүд нь өмнөөс ширтээстэй хэвээрээ ч юм шиг.

1940-өөд оны сүүл үеийн Монголын радиод дуу бичлэгийн төхөөрөмж өргөн нэвтрээгүй,

нэвтрүүлгээ студиэс шууд хийж, намын лекторууд, эрдэмтэн түүхчид, зохиолч яруу найрагчид радиогийн студиэс шууд ярьдаг байлаа. Шууд нэвтрүүлэгт Улсын төв театр, Комбинатын театр, Хятад ажилчдын театр гээд урлаг соёлын газруудын дуучид, хөгжимчид оролцож студиэс шууд дуулж хуурддаг байлаа. Тэр үеийн нэртэй нэвтрүүлэгч Дамиранжавын танил хоолой хүнгэнэж, яг л концертийн зарлагч шиг “Ардын дуу Сүнжидмаа, Комбинатын театрын Самдан дуулж, Цэдэв хөгжимдөнө” хэмээн зарласны дараа амьд дуу хөгжим эгшиглэдэг байж. Найз бүсгүй нь шугамын арааживт очиж, өдөржин хөгжим тоглоод оройтож тардаг нь Доржсүрэнд ойртож дотносох сайхан далим. Одоогийн баруун дөрвөн замын хавьцаа байх радио нэвтрүүлгийн байрны гадна хүлээж байгаад шөнийн 11 цагт тарсан бүсгүйгээ тосч авч хамтдаа алхах шиг аз жаргалтай мөч үгүй.

Сайхан бүсгүйд татагдаж, дотносоно гэдэг нэгдүгээрт өөрт сайхан. Хоёрдугаарт ажил албанд жаахан муу талдаа. Өдөржин түүнийгээ бодон гэгэлзэж, орой Намын дээд дээр болох нийтийн бүжгийг хүлээнэ. Зав л гарвал түүн рүүгээ гүйчих гэнэ. Өмнө нь бол сиймхийл гарвал юуг шинээр хийх вэ, явал тийм машиныг сайжруулах вэ гэж боддог байж. Цэл залуухан слесарь ажил дээрээ тогтвор муутай болчихсоныг засварчид нь ажаад жуумалзана. Улаанбаатар тэр үед жижигхэн зуугаадхан мянган хүнтэй байсан болохоор хэн хаана юу хийж явааг андахгүй. Түүний хөгжимчин бүсгүйтэй жиг ургуулсан тухай яриа хэдийнэ үйлдвэр дээр тарчихсан байлаа.



Ингээд л Гутлын үйлдвэрийн слесарь Доржсүрэн, Комбинатын театрын хөгжмийн багш Цэдэвтэй 1948 онд гэр бүлээ батлуулж байв. Урлагийн хүнтэй нэг гэрт орсон болохоор амьдралын хэвшил өөрчлөгдөх шинжтэй. Гэргийгээ дагаж жүжиг үзнэ. Тэр бүрт зав гарахгүй. Заримдаа хүчээр явахад хүрнэ. Үзвэр үзэж суугаа хэрнээ л ажил руугаа очих юмсан гэж бодогдоод байна. Концерт үзэж суухын оронд төмөртэй ноцолдох нь түүнд илүү сайхан. Хэдэн удаагийн жүжигт явахаас чөлөө авсны ацагт арван ширхэг нотны тавиур пюпитр хийж

өгч байж. Комбинатын театрт хийж өгсөн тэрхүү эвхдэг төмөр тавиурууд нь гадаад улсад хийсэн, завод хийцийнхээсээ ялгагдахааргүй болж байлаа.

Гэр барьсан түүх

Мөнгө хурааж хуримтлуулах тухай бодож санах юмгүй, олсон хэдийгээ ахдаа мэдүүлчихээд явж байдаг байсан залуугийн толгойд нь гэнэт өөр бодол харвасан нь мэдээж хэрэг. Авгай авч амьдрал зохиох гэж байгаа болохоор гэр барих хэрэгцээ урган гарсан нь ойлгомжтой. Үүнд их мөнгө хэрэгтэй учраас дарга нараас гуйж байгаад, хоёр ээлжинд гарч эхэллээ. Нэг ээлжинд нь машин засах үүрэгт ажлаа, нөгөө ээлжинд нь сэлбэг хийх ажлаа хийнэ. Нойр хасч зүтгэсний хүчинд овоо хэдэн юм цуглуулж амжаад, гэр босгох тухай бодохтой боллоо.

Салдаггүй хоёр найз Самдан, Цагаан хоёр нь гүйж судалгаа хийгээд, тэр мужаан сайн, энэ нь хямд гэх зэргээр мэдээлэлтэй ирнэ. Хамт ажилладаг хашир слесариуд нь ч бас зааж зөвлөнө. “Мөнгө нь байгаа хойно, сайхан гэр оронтой болно шүү!” гэж найзууд нь ташуур өглөө. Ингээд аль уран гэсэн хятад мужаанд захиалж, их үнэтэй мод хийлгэж эхэллээ. Нэг унийг л гэхэд 9 төгрөгөөр урлуулж байж. Наян нэгэн уньтай болсныхоо дараа тооноо, бас баганаа гэхчлэн увуулж цувуулан захиалж, хийлгэсэн моднуудаа морин тэргээр зөөж ирнэ. Их ч удалгүй Доржсүрэнгийн хашаанд маш том зургаан ханатай гэрийн өвч цоохор мод босчихсон байлаа. “Ийм гоё мод байдаг аа?” хэмээн харсан бүхэн дуу алдана. “Ийм том гэрийг юугаараа бүрнэ дээ? Арай л томдуулчихаж!” гэх хүн ч бишгүй.

Модоо бэлэн болгоод бүрээсний тухай яриа болтол, комбинатын хэрэгцээний хэлтсээс 12 ширхэг бор эсгий ачиж авчраад, гадаа нь буулгаад өгчихлөө. Мөнгийг нь цалингаас бага багаар суутгаад явчих болохоор төвөггүй. Үүгээр ч зогссонгүй ажилчдаа томилж, дээвэр, туурга, өрхийг нь оюулж өглөө. Цуу ямбуу аваад иртэл хамт ажилладаг бүсгүйчүүд нь ирээд цагаан бүрээсийг дор нь оёчихсон нь сайхан. Тэр үеийн Улаанбаатарын хүмүүс бүрэн “хотжиж” амжаагүй байсан учраас бие биендээ их тусархуу байсан нь энэ. “Слесарь шинэ гэр бүрж байгаа. Очиж туслая” гэлцээд л тал талаас гүйлдээд ирнэ.

Олон хүмүүс тал талаас зөвлөж заасан болоод ч тэр үү хамгийн онцгой сайхан гэр босов. Мөөртэй шалтай. Доор нь хайрга дэвсэж илүү ажил болохгүй, тусгай ховил дэгээнүүдээр шалыг нь угсарчихдаг. Гэрийн унь, тооно, багана, хаалга битүү эрээн цоохор хээтэй. Ажилчид нь хошигноод “Доржсүрэн ч хааны өргөө босголоо доо” гэж байж.

Тавилганы асуудал ургахад эхнэрийн талаас жаал зугаа юмнууд ирж. Өөрийн талаас хэдэн юм тавьж. Тэгсээр босоод л ирсэн гэдэг. Дараа нь авдар, шүүгээ, хоолны шүүгээ зэргээ гэрийн модтойгоо ижилсүүлэн өнөөх мужаануудаараа хийлгэж бүр ч гоё айл болж байв. Цагаан ор гэж эрээд олддоггүй эрдэнэ, сураад олддоггүй сувд мэт ховор бараа. Нэг хүнийх нь 200 төгрөг, хоёр хүнийх нь 250 төгрөгийн үнэтэй. Орыг нь Гомбо ах нь гаргаж өгч байв. Тээврийн товчоо орчимд байсан захаас жаахан хойшоо хятадын мужааны цехүүд, төмрийн дархнууд байх. Тэдэнд захиалаад зуух яндангаа авчихаж. Ингээд л Гомбын Доржсүрэнгийнх гэдэг айлын гал голомт бадраад ирж.



Гэргий нь зүгээр суухгүй гэрээ гоёно. Ажилчны соёлын ордонд орой үдэш буцаж, завгүй ажилтай байдаг ч орос маягийн цагаан утсан нэхмэлүүд их хийнэ. Кружева гэж нэрлэдэг энэ гоё эдийг орны өмнүүр унжуулна. Гараар оёсон гоё хөшгөө ч кружевагаар чимнэ. Арслантай хоёр эрээн авдар, хувцасны цоохор шүүгээ нь гэрийн модны хээ хуартай зохицоод их гоё харагдана. Дөрвөн цагаан орны толгой нь цайрдсан, бөөрөнхий чимэглэлүүдтэй. Гэр нь их том болохоор хоймрын ор тээр хойно их хол харагддаг комбинат хавьд байхгүй том гэртэй гоё айл болчихлоо.

Тэр үеийн Аж үйлдвэрийн комбинатын ажилчид бас ч гэж гайгүй хангамжтай байлаа. Зун болохоор үйлдвэрийн тэргээр уулын ам руу зусланд гараад, гэрээ барьчихна. Түлээний талон өгдгөөр нь 4 тонн нүүрс авна. “Нүүрсэндээ явах гэсэн юм. Унаа өгөөч” гэхэд үйлдвэрээс унаа гаргаад л өгчихнө. Налайхын уурхайд очоод талоноороо нүүрс ачуулаад ирнэ. Түлшний модоо хэрэгцээний хэлтсээс авна. Хэдхэн жилийн өмнө ээжийнхээ мөөмнөөс гарч чадахгүй байсан хүү амьдралаа давгүй авч явах болсон нь энэ байлаа.

Эхнэртэй болсон биш саван гэгч асуудалтай тулгарч байж. Урлагийн хүнтэй гэр бүл болсныг хэлэх үү, угаалга гээчийг хэмжээгүй их хийх нь мэдээж. Тэр үед айлууд орос үйлдвэрийн барааны саван хэрэглэдэг байлаа. Манай мах комбинат бараг л тосоороо шахуу хар саван үйлдвэрлэнэ. Орос саван тасраад аргаа барсан үед тэрийг нь хэрэглэнэ. Үйлдвэрт одоогийн угаалгын нунтагтай ойролцоо, цэвэрлэгээний зориулалттай нойтон ногоон бодис байдаг байлаа. Түүнээс нь авчраад хувцсаа угаачихна. Саванг бодвол сайхан хөөсөрнө. Гар худгаас ховоогоор татан ус зөөж, тэр нүсэр их угаалгыг гэртээ амжуулна. Хороо бүр тусдаа худагтай. Өвлийн цагт голоос мөс зөөчихнө. Усанд мөнгө зарна гэхгүй. Тэр үеийн ажилчны гэр бүл иймэрхүү л ахуй хангамжтай аж төрж байлаа.

Хашаанд Доржсүрэнгийнх, ээжийнх, хоёр хүргэнийх гээд дөрвөн гэрээрээ аж төрж байснаа тал тал тийшээ нүүцгээсэн. Доржсүрэнтэй адил арван хэдхэн насандаа эсгүүрчин, оёдолчин болсон ихэр эгч нар нь аль хэдийнээ нэртэй төртэй ажилчид болцгоож, хоёулаа ударник цол авч, нэг нь эд шалгагч, нөгөө мастер болон дэвшсэн. Эгч Дэндэв нь нэгдүгээр станцын анхны дарга Дагвабазар гэх хүнтэй суусан бөгөөд хамгийн анх баригдсан байрнуудын нэгэнд ороод хашаанаас нүүсэн. Морин тэрэгчин байснаа сайн ажиллаж, өөрийгөө хэн болохыг харуулж, сурч боловсорсоор Нэхмэлийн үйлдвэрийн анхны дарга болж байсан Намсрай гэгч хүнтэй нөгөө ихэр эгч Сэрээтэр нь гэр бүл болж, гал голомтоо бадраасан. Хаана, аль үйлдвэрийн ажил нурж байна, тийш нь Намсрайг томилдог байсан гэдэг. Намсрай ах нь Ноосны үйлдвэрийн дарга болж, тэднийх ч бас байранд ороод явчихсан. Тэр том хашаанд Доржсүрэн,

ээжтэйгээ, бас хадмынхтайгаа нилээд удаан аж төрж байж.

Гэргий Цэдэв нь айлын өргөмөл хүүхэд. Архангай аймгийн Их Тамир сумын хүн бөгөөд аав нь гурван настайд нь, ээж нь зургаан настайд нь нас барчихсан гэдэг. Дарьсүрэн гэж их өгөөмөр хүн түүнийг өргөн авч өсгөсөн. Доржсүрэнгийнх хадмынхтайгаа олон жил хамтдаа айл амьдарцгааж байж. Цэдэв олон дүү нартай. Тэд нар нь бараг л бүгдээрээ Гутлын үйлдвэрт ажиллаж амьдралтай золгож байж. Зарим нь Гутлын үйлдвэрээс дамжаад Чех улс руу явж, тэндээ олон жил болж байна. Дарьсүрэнгийн охин Төгсжаргал Архи пивоны үйлдвэрийн даргаар 40 жил ажилласан хүн байдаг. Ингээд бодохоор эднийхний бахархал бол Аж үйлдвэрийн комбинат. Доржсүрэнгийн гэргий, ээж, ах, ихэр эгч, хоёр хүргэ ах, гэргийн дүү нар бүгдээрээ Аж үйлдвэрийн комбинат гэх том гэр бүлийн гишүүд нь.

Өдөн малгай

Хувийн хэрэгцээндээ мөнгө маш бага зарцуулдаг, илүү олсноо хүнд өгчихдөг байсан залуу эрс өөрчлөгдлөө. Ингэхээс ч өөр аргагүй гэдэг нь ойлгомжтой. Эхнэр авчихсан болохоор гэр орон, амьдрал ахуйдаа мөнгө зарцуулах хэрэгцээ гарлаа. Энд тэнд уригдаж оёдлын машин засч мөнгө олохоороо гэргийдээ бушуухан авчирч тушаадаг боллоо. Урлагийн хүн гэдэг дэгжин хээнцэр. Хөгжимчин гэргийгээ дагуулчихаад парвийсан ажлын гутал, тостой хөвөнтэй цамцтай алхаж явалтай биш, өөрөө ч бас аятайхан хувцаслах хэрэгтэй.

Ахдаа, хоёр эгчдээ олсон мөнгөө бүгдийг нь өгчихдөг байснаа бүр мөсөн зогсоов. Харин ээждээ бол олсноосоо заавал өгнө. Нэгэн удаа болсон хөгтэй явдал санаанаас нь гардаггүй. Доржсүрэн олсон мөнгөнийхөө нилээд хувийг ээждээ сэм оруулж өгөөд “Цэдэвг битгий хэлээрэй. Артелийн машин засч олсон мөнгө шүү” гэж. Тэгээд гэмгүй царайлан, гэр лүүгээ ороод “Артелийн машин заслаа” гээд гэргийдээ мөнгөө өгөв. Маргааш орой нь гэртээ иртэл Цэдэв элгээ дараад л инээгээд байх юм гэнэ. Тэгтэл гэргий нь бас нөхрөөсөө нуугаад хадам ээждээ хэдэн төгрөг илүүчилдэг байсан болж таарав. “Доржсүрэн артелийн машин засчээ” гээд мөнгө өгөх гэсэн чинь, ээж нь гэнэдээд “Харин тийм байна лээ. Өчигдөр надаа...” гэснээ амаа дараад таг болчихож. Ингэж л эхнэр нөхөр хоёр биенээсээ нуугаад л нэг хүнийг “санхүүжүүлдэг” байснаа мэдэж хоёулаа түсхийтэл инээв. Ээж рүүгээ орж “Өчигдөр хэн танд, юу зассан гэж мөнгө өгсөн бэ?” гэж байцааж, тоглоом тохуу хийж, гурвуул бас баахан инээдэм болцгоож байлаа.

Пагвий даргатай гутлын артель, Оёдлын зургадугаар артель гэх мэт газраас урилга заллага ирэхээр их баярлана. Өмнө нь энд тэндээс хүн ирэхээр “Завгүй байна аа. Чадахгүй ээ, чадахгүй!” гэж төвөгшөөж, өчнөөн гуйлгаж байж очдог байснаа болилоо. Урилга ирмэгц бушуухан гүйж очоод, машинуудыг нь засч, тохиргоо хийж өгнө. Ажил хийсний хөлсөө аваад гэргийдээ тушаана гэдэг энэ орчлонгийн хамгийн урамтай таашаалтай мөч.

-Пагвий дарга машинаа засуулаад өгсөн хөлс гэнэ. Гэргий нь,

-Ээжид хэдийг нь өгье гэж заавал хэлнэ.

Улаанбаатарын бүсгүйчүүд их ганган. Доржсүрэн хүн л болсон юм хойно тэр бүхнээс гэргийгээ дутаахгүй юмсан гэж мачийна. Жил жилд янз бүрийн юм моодонд орно. Заримдаа эр хүний бүдүүн хадуун нүдээр харахад арай ч дээ гэмээр хөгийн зүйл моод болсон байхыг нь яана.

-Өдөн малгай авахуулмаар байна. Хүүхнүүд өмсдөг болчихлоо гэнэ.

-Ямар малгай гэнэ ээ? гэж Доржсүрэн гайхна.

-Цагаан малгай байдаг юм аа. Их гоё. Харин их үнэтэй гэсэн шүү! гэж гэргий нь анхааруулна. “Үнэтэй гэж уурлавуузай!” гэсэн дохио.

-Аваад өмсчих дөө, миний хань гэж нөхөр хэлнэ. Ингээд л маргааш нөгөөдрөөс нь тэр өдөн

малгай гэгчийг эхнэр нь авчихсан байна. Зүгээр л нэг арзайсан хиймэл үстэй, зөөлхөн хөвсгөр малгай. Хүүхнүүд гээч улс шал хэрэггүй юманд дурлах юм даа. Энэний үнэ юундаа байна аа? гэж бодож байвч чимээгүй өнгөрөхгүй бол болохгүй. Ханийхаа сэтгэлд сэв хийгээд яахав, дуугүй байсан нь дээр. Тэр малгайг Улаанбаатарын бүх бүсгүйчүүд өмсөх гэж хайж, мөрөөдөж байсан цаг.

Орос бүдэрсний төлөө монголыг ташуурдсан нь

1949 оны үе. Нэгэн амралтын өдөр Доржсүрэн захаас хонь авч гаргав. Гэргий нь гэдэс чанаж, мань эр махаа эвдээд сууж байж. Тэгтэл Лувсанжав, Ванчиг гээд хоёр найз нь ороод ирлээ гэнэ. Гэдэс нь тогоон дээр пор порхийтэл буцлаад л байна. Орж ирсэн хоёр цай ууж сууснаа өндөлзөөд,

-Гурвуулаа кинонд явья гээд байх юм гэнэ.

-Тэгье. Гэхдээ гэдэс идчихээд явья. Одоохон гарлаа шүү дээ гэсэн чинь,

-Хоцорчихно оо, бушуу явья гээд, яаруулаад байж. Ингээд Доржсүрэн Савхин эдлэлийн үйлдвэрээр хийлгэсэн складтай савхин дээлээрээ гангарч аваад, гарч. Тэр үед Энхтайваны гүүрийн сураг ч гараагүй байлаа. Модон гүүрээр гарч, шороон замаар алхсаар хотын төв рүү хүрч гэнэ.

Тэгтэл зорьж очсон кино нь орчихож. “Хонины гэдсэндээ хоргодож байж, киноноос хоцроочихлоо” гэж найз нь үглэв. Дараагийн киног хүлээж, Элдэв-Очир кинотеатрын дээд давхар дахь зоогийн газарт суухаар шийдэцгээв. Шар айраг нилээд их хүртлээ гэнэ. Найр цааш хавтгайрч цаад талын ширээнд сууж байсан хоёр орос хүрч ирж ширээнд нийлж, хонины гэдэс ч, кино ч хоёулаа худлаа болов бололтой. Үе тэнгийн таван эр ярьж хөөрч, дал мөрөө алгадалцан, Монгол Зөвлөлтийн найрамдлын билэгдэл болон сууцгааж байтал, зоогийн газар хаах боллоо. Нэг хартал цагдаа ороод ирчихсэн,

-Үнэмлэх байна уу? гээд төрийн хүний төмөр нүүрээр ширвэж байна. Мөрөөрөө зоогийн газарт суугаад наргиж болдоггүй хэцүү цаг байж. Доржсүрэн үнэмлэхтэй явсан хэрнээ байхгүй гэж зөрлөө.

-Бид ямар зөрчил гаргачихаа вэ? гэж оросууд эгдүүцэхэд цагдаа зөөлрөөд, Лувсанжавын сарвайсан үнэмлэхийг үзчихээд явахдаа аваарай гэж халаасандаа хийчихээд холдов. Тавуул явахаар болоод шат руу буух гэтэл цагдаа Лувсанжавын үнэмлэхийг өгдөггүй гэнэ.

-Бид ямар ч гэм хийгээгүй. Одоо гэр гэртээ харих гэж байна гэж залуучууд маргалдан, үнэмлэхээ авах гэж чаргууцалдсан нь буруудав. Төрийн хүний эрх чөлөөнд халдсан гээд барьж эрүүлжүүлэх юм боллоо гэнэ. Буу зүүчихсэн цагдаа их сүржин. Гэтэл нэг оросын зэвүү хүрэв бололтой анаж байснаа, тэсгэлгүй цагдааг цохиод унагачихаж. Хөөрхий цагдаа шат руу нэлмийтэл өнхөрч, тээр дор ойччихоод арай ядан өндийж байна. Зодуулчихсан байтлаа оросуудын өөдөөс юу ч хэлж чадахгүй юм гэнэ. Өнөөх “Төрийн хүнд халдлаа” гээд хууль ном ярьж байсан хүн шалдаа буучихсан зогсов. Хоёр орос, гурван монгол найзаа дагуулан Төв номын сангийн баригдаж байсан барилгаас урагш гаргаж өглөө.

Зэгсэн халамцсан гурван залуу мэддэг дуугаа солгой мурий хоолойгоор орилсон шиг ээ, шороон замаар явж байтал машин ирэв. Гараа өргөтөл зогсчихлоо гэнэ. Баярлаад тэвшин дээр нь гарч суугаад хөдөлтөл, зөндөө цагдаа нартай зэрэгцээд суучихсан байх нь тэр. Аваачаад өрөөнд түгжчихээр нь шинэ савхин дээлтэйн хэрэг юу билээ нөмөрч хэвтсээр

шөнийг өнгөрөөв. Өглөө нь гурван этгээдийг байцаагчийн өрөөнд оруултал ахынх нь дарга байсан Рэнцэнхорлоо байна.

-Гомбын энэ хөх нохой ерөөсөө болдоггүй юм! гээд л загнаж эхэлж. Арай л алгадчихсангүй баахан загнаж, сургаал айлдаж байгаад суллаж байж. Төрийн цагдааг цохиж унагасан хүн нь ах дүүгийн найрамдалт орны хүн байсан учраас гайгүй өнгөрч. Харин өнөөх цагдаа гайгүй эр хүн байж таараад, “Орос нь зодсон, наад гурван монгол нь гэмгүй” гэж мэдүүлсэн бололтой байв. Ингэж л хонины гэдэс ч үгүй, оройн кино ч үгүй, эрүүлжүүлэхэд хоносон хэрэг. Орос бүдэрсний төлөө, монголыг ташуурддаг их хачирхалтай цаг байж.

Эхний бөгөөд эцсийн янжуур

Үйлдвэр эхэндээ орос, монгол хоёр механиктай байлаа. Орос механик хэдэн жил ажиллаж байснаа нутаг буцсанаар Шарав гуай үйлдвэрийн механикийн албан тушаалыг ганцаараа хаших боллоо. Тэр бол Монголын Үйлдвэрчний Төв Зөвлөлийн Тэргүүлэгч гишүүн, их том хүн байв. Монхордуу хамартай болохоор нь хүмүүс түүнийг Монхор Шарав гэгцгээдэг. Нэгэн өдөр Комбинатын Намын хорооны дарга Бодь ерөнхий механик Шаравыг өрөөндөө дуудав. Гутал улагч машин зүү шөвөггүй сууж, уллаагүй гутал үйлдвэрийн адарт тултал өндөр хураагдаж төлөвлөгөө тасарч магадгүй болсон учраас дарга тэвдсэн нь энэ.

Коммунизм, социализмын онолыг дагасан тэр цаг үед төлөвлөгөө биелүүлэхийн төлөө улс орон даяараа нойр хоолгүй, сунаж унатлаа зүтгэдэг байж. “Төл!” гэх язгуураар эхэлдэг энэ үг зайлшгүй төлөх ёстой томоос том өр. Төлөвлөгөө биелүүлээгүй ажилчин цалингаа хасуулж, хуралд цугласан бүх ажилчдын өмнө донгодуулж үйлээ үзнэ. Харин төлөвлөгөө тасалсан дарга суудлаасаа мулт авахуулж, ял сонсож шоронд ч явж мэднэ.

Бодь даргад дуудагдсан Шарав механикийн бие базаахгүй байгаа нь илт. Тэр өдрийн үдээс өмнө бие нь муудаад Үйлдвэрчний төв зөвлөлийн орос эмчид үзүүлэхэд нь ажлаас чөлөөлөх акт бөглөж өгөөд, эм тариа бичээд, “Ажилдаа явж болохгүй. Хэд хоногтоо гэртээ хэвтэж эмчүүл” гэсэн байж. Гэтэл Шарав гуай бол гэртээ амраад хэвтэж байх хүн биш. Зүгээр суудаггүй, үргэлж ажлын төлөө гүйж байдгийг нь хүн бүгд андахгүй. Бодь дарга,

-Өнөө шөнийн дотор машиныг засаад, үйлдвэрт овоорчихоод байгаа гутлыг уллаж гарга! гэсэн шахуу үүргийг Шарав гуайд өгсөн байлаа. Механик өвчтэй байгаа гэдгээ хэлсэнгүй. “Би өвчтэй” гээд тайлбар тавиад зогсож байж чадаагүй хэрэг. Өмнөө барьдаг хоёр слесарийнхаа нэгийг нь өрөөндөө дуудуулаад дарга ямар үүрэг өгч байгааг хэлж, тэр даруй ажилдаа орохоор бэлтгэлээ. Бас нэг мундаг сайн слесарь болох Наваанлуvsан гуайг настай болохоор нь шөнө нойргүй ажиллуулж ядраагаад яахав гэж бодсон байж.

Тэр өдрийн ажил дуусч, ажилчид тарж байлаа. Шарав гуай “Хэдэн гутал уллаад зүү шөвөг хугарна хамаагүй, би уллаад байя. Хүү минь, чи тасралтгүй зүү шөвгөө бэлэн болгоод бай!” гэж хэлэв. Хүү ч зүү шөвөг хийгээд байлаа, Шарав гуай ч гутлаа уллаад л байлаа. Яаруу сандруу хийснээс хэмжээ алдсан, эсвэл хат нь таараагүй зүү шөвөг хэдэн гутал уллаад л хугарах юм уу, тахийчихна. Тэр хооронд дараагийн зүү шөвөг бэлэн болсон байна. Механик зүү шөвгийг машинд тавьж, тохиргоо хийгээд л цааш гутлаа уллана. Яг үүр цайж байх үед хураалттай гутлуудыг уллаж дуусгалаа.

Шарав гуай үргэлж татдаг нандин тамхи болох, барилдаж байгаа бөхийн зурагтай “Бөхт” гэж олонд алдаршсан янжуураа гаргаж асаалаа. Тэгснээ хайрцагтай “Бөхт”-өөсөө Доржсүрэнд нэгийг өгч хамтдаа сууж тамхилах нь тэр. Механик намайг тоож байна шүү гэж залуу дотроо догдолж байж. “Чи жаахан хүүхэд байж тамхи татаж болохгүй!” гэж загнаад өмнө нь ердөө өгдөггүй байсан учраас гайхаж, бас баярласан нь энэ.

-Механик нь гэртээ харьж, дугхийе. Ойрдоо бие өвдөөд байгаа. Жаахан амарч байгаад арав, арван нэг гээд ирье гэснээ Шарав гуай тос болсон хөвөнтэй хүрмээ өмсөөд гарлаа.

Доржсүрэн залуу болохоор гэр рүүгээ явах гэсэнгүй. Слесарийн өрөөнийхөө вандан дээр гараад, унтаад өгөв. Хэн нэгэн түүнийг угзрахад нойрондоо харамссан хүн, дуртай дургүй өндийлөө.

-Хүүш ээ, танай Шарав механик чинь нас барчихжээ! гэж цаадах нь хэлэхэд хүү цочоод, юу ч гэхээ мэдэхгүй таг болсон гэдэг. Хоёрхон цагийн өмнө татаж байсан “Бөхт” тамхины иш нь бараг л унтарч амжаагүй шахам үнсний саванд харагдана. Нас барчихсан гээд бодохоор итгэж өгөхгүй.

Өнөөх ажилчныг дагаад гарч гүйлээ. Тэгтэл Шарав механик нь гэртээ харьж чадаагүй замдаа түрүүлгээ харж унаад бурхан болчихсон байлаа. Комбинатын гуравдугаар байр дөрөвдүгээр байр хоёрын дунд талийгчийг тойроод хүмүүс шавчихсан, хөөрхийг өндийлгөтөл хацар нь хавтайгаад дарагдчихсан байж. Дөнгөж түрүүхэн “Механик нь гэртээ харьж, жаахан амарч байгаад ирье” гэсэн нь чихнээ сонсогдох шиг. Улсын төлөвлөгөө биелүүлэхийн төлөө нэгэн сайхан хүн халуун амиа үрчихсэн нь энэ.

Тэр үеийн ажилчид үйлдвэрээ гэхээр амь биеэ ч үл хайхардаг байж. “Би өвчтэй байгаа шүү дээ” гээд хэлчих байтал, Шарав механикийн үйлдвэрээ гэсэн сэтгэл дотроос нь хориод байсан хэрэг. Хүн чанартай, ичих нүүртэй хүн байсан учраас л “Би өвчтэй” гэж хэлж чадаагүй нь тэр. Үйлдвэрчний төв зөвлөл, Үйлдвэр комбинат тэр аяараа хөдөллөө. Гутлын үйлдвэрийн улаан буланд шарилыг нь байрлуулан салах ёс хийж, Шарав механикаа их хүндэтгэлтэйгээр үдэв. Түүнийг Алтан-Өлгийн хөрсөнд мөнх нойрсуулсан юм. Механик нь тэр үүрээр эхний бөгөөд эцсийн удаа слесарь хүүгээ “Бөхт” янжуураараа дайлсан байж.

Өрөөнөөсөө айдаг механик

Шарав гуай талийгаач болсноор үйлдвэр механикгүй болов. Дарга нар хэлэлцээд хорь дөнгөж шүргэх аядаж байгаа, хүүхдээрээ шахам залууг тэр том албан тушаалд томилчихлоо. Одоогийнхоор бол дээд сургуулийн нэгдүгээр курсэд сурч байгаа оюутан хөвүүн шүү дээ. Ажил хүлээлцүүлэх комисс гаргаад, механикийн өрөөний түлхүүрийг гардуулж, ширээ сандал, шүүгээ сав, багаж хэрэгслийг нь хүлээлгэн өгөөд, Доржсүрэнгийн нэр дээр дансалчихлаа. Монголын Үйлдвэрчний Төв Зөвлөлийн Тэргүүлэгч гишүүн, их том хүний өрөө болохоор утас, бичгийн хэрэгсэл, ширээ сандал бүх зүйл нь том.

Хэдхэн хоногийн өмнө амьд сэрүүн, “Бөхт”-өөр дайлж байсан хүндтэй хүний бүх зүйл тэнд байна. Бичиг цаас нь хэвээрээ. Ширээний шүүгээнд нь өөрийн хөлдөө тааруулж хийлгэсэн гутлын колодка нь байна. Зөвхөн өөртөө гутал хийлгэхэд л ашигладаг энэ колодкийг хэнээр хэрхэн хийлгэж байсныг нь Доржсүрэн мэднэ. Энэ л колодкоо бариад, гутлын тасгийн хамгийн сайн гуталчин руу очиж,

-За, чи надад нэг гутал хийнэ дээ гэж байсан нь чихэнд сонсогдох шиг. Ширээний шургуулган дотор хайрцагтай нандин тамхи нь байна. Шургуулга, хөшигнөөс нь Шарав гуайн “Бөхт” янжуурын танил үнэр анхилна.

Маргааш өглөө нь шинэ механик өрөө рүүгээ айсаар орлоо. Эргэн тойрны бүх зүйлийг Шарав гуай хэрхэн яаж хэрэглэдэг байсан нь нүдэнд харагдаад болохгүй. Өмнөө байгаа үзгийг авах гэхээр л механик энэ үзгээрээ захиалгын хуудас бичиж суугаа нь нүдэнд харагдана. Хүү өрөөнд байгаа юм бүхнээс сүрдэж байгаагаа мэдэрлээ. Механик нас бараагүй, ширээний ардахь өөрийнх нь сандал дээр суугаа хүү рүү “Чи яагаад миний сандалд суугаад байна..?” гээд эгцэлж ширтээд ч байх шиг санагдана. Өрөөнд таван минут ч сууж чадалгүй гарч гүйв. Үүнээс хойш айгаад өрөөндөө орж чадахаа байлаа.

Өглөө ажилдаа ирчихээд шууд л слесариудын өрөөнд яваад орно. Өрөөндөө орохоосоо айгаад байна гэж хэлбэл хэдэн сардаа шоолуулах нь мэдээж. Ийм учраас аль болох хэнэггүй царай гарган, хуучин өрөөндөө слесариудтай элдвийг ярин сууна. Хуучин өрөөнөөсөө салахгүй байгааг, бас шинэ өрөөндөө ердөө суухгүй байгааг нь ажилчид анзаарцгаав.

-Чи механик болсон биз дээ? Өрөөндөө очооч гэж ах зах нэг нь хэлнэ. Хүү айгаад байгаагаа тас нууж,

-Эндээ та нартайгаа бужигнаж баймаар байна гэж нэрэлхэнэ. Захиалга бичих, наряд бичих гээд зайлшгүй шаардлага гарахаар өрөө рүүгээ орохоос өөр аргагүй. Өнөөх бичиг цаас нэхсэн хүнийг арга саам хийж, заавал дагуулж орно.

-Чи наанаа зогсож бай, би бушуухан захиалгыг чинь бичээд орхиё. Хүлээж байгаарай гэж сандарна. Ширээг буландан яг л хүний ширээн дээр юм шиг суугаад, хам хум захиалгын хуудсаа сараачсан болно. Захиалгын хуудас авсан хүн гарах гэхээр,

-Хүлээж бай. Хоёулаа хамт гарья гээд бушуухан өрөөгөө түгжиж авна. Ийм байдлаар удаан

явлаа. Сүүлдээ аргаа бараад өрөөгөө сольё гэж гуйлаа. Дарга арайхийж гуйлтыг нь зөвшөөрч, өрөөгөө сольж байж нэг юм “Механик” гэсэн хаягтай өрөөндөө тогтож суудаг болж байв.

Ерөнхий механик, үйлдвэрийн хариуцлагатай удирдах албан тушаалтан хүн намын гишүүн байх ёстой гэж дарга нар шахлаа. Элсэхгүй гэлтэй биш. Намд элсэх өргөдлөө гаргачихлаа. Хэн дуртай нь намд гишүүн болчихдог байсан цаг биш. Үйлдвэрийн намын үүрийн даргаар Дэлдэн Пэрэнлэй гэх сүрхий хүн ажиллаж байсныг хэлэх үү. Шаардлага өндөртэйгөөрөө зартай, тун ч яггүй хүн.

-Нөхөр Доржсүрэн. Намын гишүүн болоход биеэ бэлд. Юм унш, судал, мэд! гэж үүрэг даалгавар өгөх нь нухацтай агаад сүртэй. Бүтэн жил бэлдсэний дараа орлогч гишүүнээр элсэж, дахиад нэг жил өөрийгөө харуулсны эцэст арайхийж Намын товчооны хурлаар орох эрхтэй болдог. Тэр том хурлаар намд элсүүлэх эсэхийг шийддэг байсан цаг. Доржсүрэн баахан ном сэтгүүл, сонины хайчилбар уншиж, дүрэм цээжилж үзээгүй юмаа үзэв. Тийнхүү бүтэн жилийн турш шар махтайгаа хатаж байж арайхийж намын гишүүний батлахыг өвөртөлж байлаа. Их зовж хөлсөө дуслуулж байж тэр батлахыг гардсан болохоор эвлэлийн батлах шиг хайнга хандаж гутлын түрүүндээ хийгээгүйгээр барахгүй ихэд нандигдаж гэртээ авчраад нилээн дээш нь залсан гэдэг.

Ажилчны эрэлд

Тэр үед үйлдвэрт ажиллах хүн олддоггүй байлаа. Нам, засгийн шийдвэр гарч ажилгүй хүмүүсийг хөдөлмөрт татан оролцуулах компанит ажлыг өргөнөөр явуулж байлаа. Хороо хорины бүртгэл судалгаа явуулж, ажилгүй хүмүүсийг тогтоогоод, нийгмийн тустай хөдөлмөрөөс зайлсхийсэн хэмээн буруутгаж, албан журмаар ажилд оруулдаг байж. Сонин хэрэг шүү. Одоо тэгтэл эсрэгээрээ ажилгүй хүмүүсээ яаж ажилтай болгох вэ гэж засгийн газар толгой гашилгаж байна.

Үйлдвэр комбинатын боловсон хүчний зааварлагчаар Равжир гэх Доржсүрэнтэй үе тэнгийн залуу ажилладаг байлаа. Хоёулаа адилхан насанд хүрээгүй байхдаа ажилд орж, тоглож наадаж явсан болохоор тэд дотно. Равжир байн байн хүний эрэлд мордоно. Учир юу гэвээс албан журмаар ажилд оруулсан хүмүүс хэд хоног ажиллаад л хаашаа ч юм алга болчихдог. Тэдний сургийг гаргаад араас нь хайж явах болно. Налайх, Төв аймаг хүртэл явж байж, олж чирч гулдарч ирнэ.

Тэр үед хятадуудтай суусан монгол хүүхнүүд ажил хийдэггүй байж. Яг л кинонд гардаг шиг арван хуруундаа алтан бөгжтэй, үйтэн хуараар гоёсон ганган хүүхнүүд урт янжуур татаад зүгээр сууна. Үйлдвэрийн хариуцлагатай албан тушаалтнууд, хороо хорины ажилтнууд, цагдаа нартай хүч хавсран хятадын гудамжаар явж, хятадуудын авгай нарыг ажилд дайчилдаг байлаа. Тэдний байшин сууц нь зоорь хонгил руугаа ордог нууц хаалгатай. Түүгээрээ орж нуугдчихаад олдохгүй. Хятад айлын хашаа, байшин гэгч учир нь олдохгүй тахиралдаж мушгиралдсан гудамж хонгилуудтай. Яг л төөрдөг байшинд орчихсон мэт толгой эргэчихнэ. Тагнуултай кинон дээр гардаг шиг хана шал тогшин хайж байж, нууц хана, зоорийг илрүүлнэ. Хятадын эхнэр байснаа албан журмаар ажилчин болж, цаашдаа сайн ажиллаж, үйлдвэр комбинаттай хувь заяагаа холбосон сайчууд хэд хэд байдаг. Гэхдээ тэднээс тогтвортой ажилласан нь ховор.

Цэргийн дарга нарын авгайчууд бас ажил хийхгүй. Тэдний судалгааг явуулж, ажилд ор гэж ятгаж ухуулна. Нөхрийнх нь албан тушаалаар далайлгаж, цэргийн анги нэгтгэл рүү нь албан бичиг явуулж байгаад гэр бүлийн хүнийг нь авчирч ажилчин болгоно. Бас лам хүмүүсийг ч ажилчин болгож байлаа. Лувсандорж, Лувсандамдин, Балжиржанцан гээд лам байсан хүмүүс ажилчнаар элсэж байсныг Доржсүрэн мэднэ. Анх ирэхдээ лам хувцастайгаа явсаар л байсан гэдэг. Яваандаа энгийн хувцас өмсдөг болж, бригад хамт олны бүрэн эрхтэй гишүүн, сайн ажилчид болж байж.

Доржсүрэн ч үйлдвэрээс албан томилолт авч хөдөө орон нутгаар явж, ажилчин элсүүлж байж. Говь-Алтай аймгаас олон хүн элсүүлээд ирж байлаа. Тэднээс гурван ч хүн насаараа Аж үйлдвэрийн комбинатдаа ажиллаж, нэртэй төртэй явсаар байсан гэдэг. Дөчин хэдэн он, Гомбо даргын үед Равжир баруун аймаг руу яваад, хоёр машин дүүрэн ялтан ачиж ирж байв. Үйлдвэрийн хашаанд бор эсгийгээр түр сууц барьж, хоригдлуудыг байрлуулж, хянагч нар нь ч хамт байж харгалзан ажил хийлгэж байлаа.

Механик

Үйлдвэрийн ерөнхий механик гэдэг Үйлдвэрийн дарга, ерөнхий инженер хоёрын дараа орох том албан тушаал. Тэгсэн хэрнээ дээр суугаа хоёроосоо илүү их ачаалалтай ажиллах болдог, хариуцлага өндөр. Бүхий л тоног төхөөрөмж ерөнхий механикийн хяналт дор байна. Цахилгаан, усан хангамжийг ч бас хариуцна. Шөнө гэртээ амарч байснаа тангараг өргөсөн цэргийн хүн шиг буцаж дуудагдана. Үйлдвэр лүү хүрээд ирэхээр ийм машин доголдлоо, тийм машин зогслоо гээд л бөөн сандралдсан хүмүүс хүлээж байна. Өөрөө чадах бол засна, чадахгүй бол тэр машинаар мэргэшсэн слесарийг бас дуудуулах болно. Ийнхүү асуудлыг шийдэх гэж ажил болж байтал үүр цайна. Ингээд л шууд маргааш өглөөний ажилдаа орж байсан тохиолдол олон.



Механик өглөө ирмэгцээ бүх тасгуудаар явна. Ямар машин эвдэрсэн, юу доголдсон гээд бүх мэдээллийг цуглуулна. Давхирхай халаадаг машин халахаа больчихсон байдаг ч юм уу, тиймэрхүү жижиг сажиг юм гарна. Холбогдох хүнийг нь дуудаж янзлуулна. Машинуудаа бүрэн ажилтай байгаа эсэхийг магадалсны дараа өрөөндөө орж ирээд, засварчидтайгаа уулзаж шуурхай хурал хийнэ. Дутагдаж байгаа сэлбэг хэрэгсэл, хийж болох болохгүй сэлбэг, эд ангиуд гээд өдөр тутмын асуудлуудаа ярина. Засварчдын саналыг сонсож, шийдвэрээ гаргаж, хамтын хүчээр, бүгдээрээ хэлэлцэж, бүх асуудлаа шийднэ.

Механик хүн ажилчдынхаа ар гэр, амьдрал ахуйг мэддэг байх ёстой. Хамт олонтойгоо харьцахдаа ажлын цагаар дарга цэрэг, ажлын бус цагаар анд найзууд байна. Бие биенийхээрээ орно. Баяр ёслолыг хамтдаа тэмдэглэж, бага зэрэг найрлачих ч тохиолдол гарахгүй гэх газаргүй. Ажилчдынхаа амьдрал ахуйг мэддэг хүн тэдэнд ямар туслалцаа

хэрэгтэйг андахгүй нь мэдээж. Хүйтний цаг наашлахад өвлийн бэлтгэлээ базаахад нь тусална. Шалны шороо хайрга татна, гэрийг нь давхарлана. Тэр бүхэнд хамт олноороо хөдлөх ёстой.

-Засварчин Лувсанцэрэн шалаа тавьж, гэрээ дулаалж барина гэсэн. Та хоёр явж тусал! гээд хоёр хүнээ ажлаас чөлөөлөөд, ажилдаа ирснээр тооцож, цалин мөнгийг нь бүтэн бичнэ. Бригадынхан хамтын хүчээр бүх зүйлээ хийдэг байж. Өөрөө слесарь хийж байсан амьдрал мэддэгийн ач аар шаар гэхээр зүйл дээр ч илт мэдэгдэнэ. Слесарь хүний гар хуруу нь байнга тос болчихсон явдаг. Алчуур даавуу авах гэхээр ийм ялихгүй юманд мөнгө үрээд яах вэ? гээд санхүүч хөдлөхгүй. Залуу механик засварын төсөв, юухан хээхэнд хавчуулж байгаад даавуу олоод л авчихна. Ингээд слесариуддаа алчуур даавуу өгдөг болж байж.

Механикийн хариуцаж хийлгэдэг бас нэг том ажил бол долоо хоног тутмын цэвэрлэгээ. Ажилчид амрахаар явахын өмнө машинаа заавал цэвэрлэх ёстой. Механик хяналт тавьж машинуудыг бүрэн цэвэрлэсэн эсэхийг үзэж шалгана. Үүргээ биелүүлээгүй ажилчинд шаардлага тавьж, цэвэрлэгээг бүрэн хийлгэнэ. Социализмын үед нийтээр тэмдэглэдэг наадам, шинэ жил, октябрь, майн нэгэн зэрэг баяр ёслолын өмнө бас бүрэн цэвэрлэгээ хийлгэдэг заншилтай байж. Үйлдвэрийн дарга, инженер, механик гурав бүх машинуудыг үзэж шалгаж, хүлээж аваад, Арьс ширний үйлдвэрийн нэгдлийн комисст хүлээлгэж өгдөг байлаа.

Механик ажил үүргийн хуваарь хийх үүрэгтэй. Доржсүрэн слесариудыг төрөлжүүлж ажиллуулах хуваарь хийж байлаа. Ингэснээр слесарь чадваржиж мэргэшихэд дөхөмтэй. Олон юм руу үсчээд байхын оронд нэг төрлийн машиныг дагнаж засаад байвал хэн ч түүндээ гаршиж дадлагажих нь мэдээж хэрэг. Засварчид уллагааны, оёдлын, татлаганы, үрлэгний, колодкны, зачёшка, пентовой гээд машин бүрээр төрөлжиж мэргэшиж эхэллээ. Ингээд хуваарь хийчихтэл зарим хүн их аминчхан болоод, надад бусад машин хамаагүй гээд хамтач байх бригадын зарчим эвдрэх дээрээ тулав. Залуу механик хатуу үг хэлж, журманд нь оруулж байж. Хорь ч хүрээгүй насандаа ерөнхий механик болчихоод шаардлага тавьж эхлэхэд, “Энэ нэг жаахан юм чинь юу гэнэ вэ?” гэх хүн ч гарч байж. Энэ бүхнийг тоолгүй ахмад хүнд ч хатуу үг хэлж үзэж байж. Тун удалгүй бүгд механикаа хүндэлдэг, үгэнд нь ордог, болж байлаа.

Механик хүнийг хөндлөнгөөс ажихад, хүнд тушаал өгч, хүнээр ажил хийлгэчихээд явдаг амар хялбар ажил мэт харагддаг. Доржсүрэн ч өөрөө слесарь байхдаа ч ийм бодолтой явж байсан гэдэг. Тэгтэл хэрэг дээрээ тун ярвигтай ажил болохыг яс махаараа мэдэрч байж. Нэг машин их засварт орох боллоо гэхэд засварын хугацаанд оронд нь ямар машин тавих вэ? гэсэн толгойны өвчин гарч ирнэ. Ирэх онд хийгдэх их засварын график гаргах гэж хонон өнжин сууна. Графикт хугацаанд засвар хийгдэх машины сэлбэг байгаа эсэхийг шалгаж үзнэ. Энэ бүхний дараа их засварын төсөв бичнэ. Эд ангийг угаах солярк, тос товуд, будаг шунх гээд бүх материал, үл ялих гэмээр зүйлийг ч нэг бүрчлэн тооцоолох ёстой. Машин арчих даавуу хүртэл хэрэгтэй болно. Их засварт орж байгаа машинд бүрэн задаргаа хийж, эвдэрсэн, элэгдсэн бүх эд анги, сэлбэгийг сольж тавьдаг. Угсарсны дараа будаж шунхдана. Энэ бүхэнд сайн тооцоотой төсөв хэрэгтэй. Цэл залуухан механик энэ бүхнийг амжуулж, өөрийгөө хөгжүүлж суралцсаар л байсан юм.

Хэзээ ч орхихгүй хобби

Механик болж тушаал дэвшлээ гээд дуртай ажлаа орхисонгүй. Элдвийн юм сэдэж, юмхнаар юм хийсэн хэвээр. Челнокны түгжээний пүршийг юугаар хийвэл таарах вэ гэж байнга бодож, хүүхдийн эвдэрхий тоглоом ч задалж үзнэ. Тэр пүршийг орлох пүрш амархан олдохгүй. Өөр пүршийг уярааж, эсвэл хатааж хийхээр тэр бүр агшилт тэнийлт нь таарахгүй. Асаагуурын пүршийг үзтэл таармаар харагдаж баярлалат бүдүүдчихнэ.

Нэгэн удаа утсаар ярих гэж холбоо руу очоод хүлээж зогстол толгойд нь шинэ санаа сэрхийлээ. Залгагч бүсгүйчүүд урт гэгч сунадаг ишнүүрийг татаж хэрэгтэй үүрэнд холбох байх нь сурмаг. Холболтоо салгаад ишнүүрийг буцааж тавихад утас агшиж байгаа их сонирхолтой. Мэдээж энэ утасны дотор талд пүрш хийсэн байгаа, бүр хэд хэд ч байж мэднэ гэж бодлоо. Холбооны техникч нартай уулзаж, учраа хэлэн гуйж эвдэрсэн пультнээс хоёр гурван ишнүүр утас салгаж авлаа. Задлаад үзтэл нээрээ л утасны бүрээсэн доогуур хэдэн давхар пүрш байх нь тэр. Хамгийн дотор талын нарийхан нь челнокны түгжээнд яг захиалсан юм шиг таарчихлаа. Ингээд л пүршний талаар бодож, толгой өвдөх юмгүй болж байж. Холбооны нэг ишнүүр олоод хадгалчихад, түүнээс бараг л зуун ширхэг түгжээний пүрш гарчихна.

Нэг өглөө слесариуд механикаа ганган эрээн соруул зуучихсан тамхи угзарч суугааг харав.

-Ямар гоё соруул вэ? Хаанаас хэн ирээд ийм гоё бэлэг өгчихөв өө? гэж дуу алдацгаав.

-Би өөрөө хийсэн юм аа гэх хариу сонсоод,

-Механик аа наадхаа үзүүлээч гэж гуйлаа. Соруулаа тэдэнд үзүүлвэл, та энэ гоё өнгө хосолсон эрээн хэсгийг нь юугаар хийсэн юм бэ? гэж шалгаалаа. Мушийн удаан гэгч сууж, тэднийг нилээд бодуулж, гайхшийг нь барсныхаа дараа, дэлгүүрт хоёр төгрөг хэдэн мөнгөөр зардаг өнгө өнгийн шүдний сойзны ишээр хийснээ хэлж байж.

Орос үйлдвэрийн плитк дэлгүүрт ирдэг ч амархан шатдаг хэврэг эд учраас айлууд хоол хошоо хийж чадахгүйд хүрчихнэ. Механик харин гар хийцийн плитк гэртээ тавина. Төмөр хүрээнд хоёр тоосго зэрэгцүүлж суурилуулаад, ховил гарган спираль утас гүйлгэсэн, энгийн хийцтэй эд. Эвдэрчихлээ гэхэд засахад хялбар. Үүнийг нь айл хөршүүд үзчихээд “Манайд хийгээч өгөөч” гэж гуйдаг боллоо. Нэг л мэдэхэд бүгдээрээ Доржсүрэнгээр плитк хийлгээд тавьчихсан байж. Хамаатан садан бүгд ийм гар хийцийн гал голомттой. Тасарчихлаа гээд л Доржсүрэнг дуудаж, очиж залгаж өгнө. Механикийн гэрт хос тоосго байнга өрөөстэй. Бас нэг айлд цахилгаан зуух хийж өгөхөөр бэлдсэн нь мэдээж.

Аж үйлдвэрийн комбинат боловсон хүчнээ сургаж мэргэшүүлэх, боловсролтой болгох тал дээр анхаарч байлаа. Ажилчны эгнээнээс дэвшиж үйлдвэрийн хариуцлагатай албан тушаалд томилогдсон хүмүүсээ МУИС-д сургаж, дээд боловсрол эзэмшүүлэх шийд гарав. Ингээд Цахилгаан станцын орлогч дарга Пэлжээ гуай, комбинатын ерөнхий нябо Намсрай гуай, залуугаас ерөнхий механик Доржсүрэн гээд хэдэн хүнийг их сургуулийн оройн ангид сургаж эхлэх нь тэр.

Сурч буй хөгшин оюутнууддаа комбинатын захиргаа их анхаарч буй нь илэрхий. Тусгай автобус гаргаад хичээлд нь зөөнө. Орой хичээл тарахад өнөөх автобус нь бэлэн сойлттой зогсож байх нь таатай. Гэвч хэдэн хөгшин оюутан маань хичээлдээ үнэн голоосоо дургүй. Нэг давхрын зам руу харсан цонхтой ангид хичээллэдэг байсныг ч хэлэх үү, цонхоор элдвийг хараад л сууна. Муу сурлагатай сурагч шиг арын эгнээнд шигдэж байснаа сэмхэн нэг нэгээрээ цувран гараад явихна. Би төмөр нүдэх л тавилантайгаас биш тоо нухах одонд төрөөгүй хүн байсан юм билээ гээд Доржсүрэн инээдэг. Түүний хобби тоо бодлого биш, төмөр хэвээрээ л үлдсэн хэрэг.

“Шкода”-ны үнэтэй шбос

Оросын машинууд бориг бөх болохоор сайхан. Бараг л бүх сэлбэгийг нь өөрсдөө хийж, “монголчилдог” болчихоод байсан гэдэг. Түүгээр зогсохгүй Гутлын үйлдвэрийн механик, слесариуд нилээд олон төрлийн машиныг өөрсдөө хийдэг боллоо. Үрлэгний машин, фрезер машиныг өөрсдөө хийгээд тавьчихна. Онкилов гээд машин, колодка сугалдаг машиныг ч монголдоо үйлдвэрлэчихлээ. Харин гуулин хадаасаар ажлын гутлыг хаддаг пянтовой машиныг л хийж чадахгүй байлаа.

Доржсүрэн механик болсныхоо дараахан гутлын улыг фрезерддэг машин зохион бүтээлээ. Тэр үед ашиглаж байсан машинууд хөх ширэнд явдаггүй байсныг сайжруулья гэж бодож, хэдэн өдөр сараар толгой гашилгасаар байж, давхар хутгатай болгох санаа сэдсэн хэрэг. Энэ шинэ машинаар гутлын ул фрезердэхэд маш сайхан болно. Хүмүүсээс магтаал сайшаал сонсоод урамтай байтал дарга нар Үзэсгэлэн чимэглэлийн ордонд болох Шинийг санаачлагчдын улсын анхдугаар зөвлөгөөн, үзэсгэлэнд оролц гэж үүрэг өглөө.

Үзэсгэлэнгийн танхимын үүдний шат өөд машинаа гаргах гэж хэдүүл хамжин зүтгэлээ. Тэгтэл гай газар дороос нуруундаа юм оруулчихдаг байна. Зөвлөгөөнд сууж чадсангүй. Слесариуд нь хамжиж дэмжээд, үзэсгэлэнгийн танхимд Доржсүрэнгийн өөрийн гараар урласан челнок, бусад сэлбэгүүд, ул фрезерддэг шинэ машин гээд бүх зүйлсийг нь өрж тавив. Нуруу нь өвдөөд хөдөлж чадахгүй болчихсон хэвтэж байтал ажлынхан нь гүйлдэж ирээд,

-Үзэсгэлэнгийн дүн гарсан. Чиний шинэ машин хоёрдугаар байранд орсон гээд баяр хүргэцгээлээ. Түүгээр ч барахгүй Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнах болсон байх аж. Слесариуд нь баярлаад сүйд. Залуу механик харин “Энгэрт нэг төмөр зүүж хуураад өнгөрлөө дөө” гэж бодож байж. Учир юу гэвээс Цахилгаан станцын Пүрэвцэрэн гэх Доржсүрэнгийн таних залуу нэгдүгээр байр эзлээд “Шкода” машинаар шагнуулснаас тэр. Дараа жил бүр янзтай сайн машин бодож олъё байз. Машинтай болоод, Цагаан, Сандаг хоёрыгоо суулгаад давхиж явах ч юм билүү? гэж залуу бодож байж.

Нурууны өвчин овоо намдаад байтал Төрийн ордонд дуудагдаж, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Самбуу гуайгаас Хөдөлмөрийн хүндэт медаль гардаж авч мандсанахаа дараа “Энэ чинь бас ч гайгүй том медаль юм уу даа?” гэж дотроо бодсон гэдэг. Түүнээс биш өмнө нь насанд хүрээгүй хүүхэд гээд шагнал урамшил, юм юмнаас Доржсүрэнг хасчихдаг байлаа.

Амралтаа авахаараа жолооч

Дөчөөд онд жолооч хүн од болчихоод байсан үе. Хүүхнүүд жолоочтой суух гэж хошуурна. Сургуулийн хүүхдээс том болоод ямар мэргэжилтэй болох вэ гэж асуухад бүгдээрээ шахам жолооч гэж хариулж ч мэдэхээр. Доржсүрэн хүүхэд насны дэвэргэн шохорхолдоо хөтлөгдсөндөө биш техникт дур сонирхолтойдоо энэ мэргэжил рүү өөрийн эрхгүй татагдана. Машин тэргэнд сэтгэл санаагаа бүхэлд нь зориулна. Яг л мөрийтэй тоглоомд донтчихсон хүн шиг.

Тэр үед комбинат хориод тэрэгтэй, түүгээрээ ноос арьс шир, түүхий эдээ хөдөө аймгуудаас татдаг байлаа. Комбинатын гарааж гээд тусдаа даргатай, жолооч ажилчидтай газар байх. Хөдөө аймгуудын бараа бааз, сумдын худалдаа бэлтгэлийн ангиудад түүхий эд цуглуулаад хураачихсан байдгийг үйлдвэр лүүгээ татаж тээвэр хийнэ. Үйлдвэрийн хашаагаар явахад энд тэндгүй машин харагдаж Доржсүрэнгийн хорхойг хүргэнэ. Ямааны арьс ачсан жолооч Шевроны үйлдвэрт ачаа буулгаж байна. Шевретийн үйлдвэрт хонины арьстай тэрэгний ачаа бууж харагдана. Том ширний үйлдвэрийн өмнө үхрийн шир ачсан машин зогсоно. Энэ бүгдийг харахаар тээвэрт явах юмсан гэж тэсч ядна.

Доржсүрэн үнэн голоосоо машинд дурлаж, жолоо барихын төлөө хар толгойгоо тасдаад өгөхөөс ч буцахгүй. Нэг харахад гарааж руу оччихсон зогсож байна. Автогараажийн слесариар үнэ хөлсгүй ажиллаж өгнө. Хүн ирээд өмнөөс нь ажил хийхэд автомеханик слесариуд дуртай байх нь мэдээж. Гараажийн хэдэн машинуудыг засч, ойр зуур хөдөлгөж, хашаан дотуур тойрч гэлдэрсээр байгаад нэг л мэдэхэд Доржсүрэн “хар параачиг”-ийн жолооч болчихлоо. Машин бариад сурчихсан болохоор тээвэрт явахыг мөрөөдөөд нойр хүрэхгүй. Хүрд мушгиад алс хол хөдөө аймаг руу салхи татуулан давхихсан гэхээс хорхой хүрнэ. Ээлжийнхээ амралтыг аваад, Лувсанбазар, Дамдинсүрэн, Баярцогт гээд жолооч нарыг дагаад хөдөө аймаг руу тээвэрт явчихдаг болов. Гутлын үйлдвэрийн ерөнхий механик том албан тушаалтай байтлаа тээврийн жолооч нарт зарагдаад л хэнэг ч үгүй явж байх. “Энэ Доржсүрэн галзуурчихаа юу?” гэж зарим нэг жолооч гайхна. Харин түүний занг мэддэг хүмүүс, “Цаадах чинь жолоо мушгихын төлөө толгойгоо ч өгч мэдэх хүн. Тэгээд л тэр байхгүй юу” гэж өмөөрнө.

Доржсүрэн дагаж яваа жолоочоо бушуухан айлд буугаасай гэж хүснэ. Айлд буувал архи ууна. Уучихвал тэргээ Доржсүрэнд өгөхөөс аргагүй болдог. Айлын бараа харагдахаар “Тэр айлд буух уу? Би өлсөж байна” гэж жолоочдоо худлаа хэлнэ. Эзэгтэй холын зочдод нэрмэл сөгнөх нь мэдээж учраас заль зохиож буй тэр. Тэр үед хөдөөгүүр тээвэр ховор явдаг байснаас жолооч гэдэг хөдөөний айлын хувьд хүндтэй зочин байж.

Дагаж тээвэрт явдаг ах нараасаа нэгэнтэй нь явах гэж дурлах боллоо. Учир юу гэвэл мань эр жаахан балгах дуртай. Замын айлуудыг хэсээд, өнөөхийг хүртээд эхлэхээр нь баярлана. “Та уучихсан юм чинь жолоо бариад хэрэггүй. Би бариад явъя” гэнэ. Яван явсаар түүнтэйгээ ах дүүс шиг дотно болж байж. Тэр сайхан гүндүүгүй жолооч эр дэргэд машин бариад явчих, архи удаггүй найдвартай хүн байгаа юм чинь гэж тайвшраад л нанчид хүртчихдэг байсан нь мэдээж. Нэгэнт л машин бариад сурчихсан болохоор жолооны шалгалт өгөөд үнэмлэхээ авчихлаа. Жолоо мушгих хорхой нь хөдөлж, нойр хулжсан хэвээр. Хорхойгоо дарахын тулд

Ээлжийн амралтаа авч, хүний машинаар алсын тээвэрт явсаар л байлаа.

Айлд өргүүлэхгүй бол өнгөрнө

1949 онд Доржсүрэнгийн нэг хүү гараад эндчихлээ. 1951 онд охин Гэрэлмаа нь гарлаа. Гэтэл бас л шөнө өдөргүй уйлж зовооно. Айл хөршийнхөн нь эднийх нэг чөтгөрийн охинтой боллоо, шөнөжингөө уйлчих юм гэлцэнэ. Аргаа бараад хоёр хацарт нь яр шавчихсан охиноо бээлийтэй унтуулна, яранд нь товуд ч түрхэж үзнэ. Юу ч тус нэмэр болохгүй нь гачлантай. Маршал Чойбалсан нас бараад орон даяар эмгэнэл болж байхад, юун гашуудах манатай охиноо сахиад эмнэлэгт л хэвтэж байлаа. Эм авах санаатай төв эмийн сан руу давхиад очтол далбаа бөхийлгөчихсөн байх юм гэнэ. Эмнэлэг рүүгээ буцаад иртэл бас нэг далбаа бөхийж байж. Орж ирснийхээ дараа л төрийн том хүн нас барсныг дуулсан гэдэг. Охин нь эмнэлэгт хэвтэж жаахан гайгүй болсноо гарч ирээд л уйлаад эхэлнэ. Мэддэг бүх эмчээ дуусгаад, цөхөрнө гэгч болоод байв.

Нэг удаа орос эмчид үзүүлвэл эмчилчихгүй байгаа даа гэж горьдоод охиноо авч очив. Нүүрээрээ дүүрэн яртай охиныг нь хараад эмч дуу алдан үглэж дуулж эхлэх нь хэтэрхий сүр бадруулаад байх шиг. Охины нэхий өлгийг харж ярвайж байснаа тайлаад шидчихлээ. Доржсүрэн шоволзсон түргэн хөдөлгөөнтэй хүн болохоор ухасхийн хүүхдийнхээ өлгийг шалан дээрээс шүүрч аваад, эмч рүү ууртай харлаа. Тэгтэл цаадах нь,

-Ийм юманд өлгийдөхөөр хүүхдийн чинь нүүрэнд яр гаралгүй яах вэ? гээд байдгаараа ярвайлаа. Эмчийн маяг дэндлээ гэж бодсон залуугийн уур дүрсхийлээ.

-Чи хүүхдийн өлгий шиддэг хэн юм? Монголчууд нэхий өлгийд хүүхдээ өлгийддөг. Болоод л ирсэн, цаашдаа ч болно гэж уурлалаа. Орос эмч хэт халуун чанартай нэхий өлгийнөөс болж хүүхдийн чинь арьсанд харшил өгч ярандаа баригдсан гэж тайлбарлахыг оролдсон ч, залуу эцэг сонсох ч үгүй хүүхдээ тэвэрч, “Хүүхдийн өлгий газар шидээд, яадаг муу орос вэ?” гэж уурласаар гарч байж.

Охин нь өдөр шөнөгүй орилчихоор ээж аав хоёр ч ядарч зүдэрч гүйцэв. Цэдэв ажлаасаа цаг үргэлж чөлөө аваад байх аргагүй. Оройд тоглолтдоо явна. Нэг орой тараад иртэл Доржсүрэн ганцаараа унтаж байх юм гэнэ. Хүүхдээ яачихаа вэ? гээд сандралд автлаа. Тэгтэл өмнүүрээ авбал орноос унагачихаж магад гэж айгаад араараа хэвтүүлсэн өлгийтэй охин нь орны арын хөндийд унаад цэлдэн хөх болтлоо даарчихсан хэвтэж байж. Өвлийн хүйтэнд хөлдчихөөгүй нь гайхмаар. Бүсгүй нөхрөө учир зүггүй загнаж байснаа, “Уйланхай охиноо харж нойргүй хоносоор байгаад, хань минь ядарч гүйцэж дээ” гэж дотроо өрөвдсөн гэдэг.



Түрүүчийн хүүхэд эндчихсэн. Удаах нь цаг үргэлж уйлж зовоогоод байхаар, үр хүүхдээ алдчихгүй тогтоохсон гэсэндээ аргаа барлаа. Ах дүүс, ахмад ажилчид “Ламд оч, өөр арга байхгүй” гээд хүн зааж өгнө. Шашин гэгчээс хол хөндий өссөн, бүдүүн бараг хүн болохоор эхэндээ ичиж зэнзийлнэ. Арга барагдаад, дүүрсэн хэрэг гээд нэгэн мэргэ төлгө тавьдаг авгайд очив. Тэгтэл “Айлд өргүүлэхгүй бол энэ охин чинь бас л тогтохгүй” гэж айлдах нь тэр. Цэдэв “Бүтэн долоон сар нойргүй энэ хүүхдийг харлаа. Цаашаа тэсэхгүй. Айлд өгөхгүй бол бас л тогтохгүй гэж байна шүү дээ” гэж арга ядсан өнгөөр хэлэхэд, Доржсүрэн чимээгүй суугаад л байж. Охиныг танил айл өргөж авахаар болоод, бэлэг хадгаа барьж, өдөр судраа товлов.

Айлын хүмүүс ирэхийн өмнө залуу эцэг “Охиноо ганц шөнө өвөртөлж унтчихаад явуулъя даа” гээд бүсээрээ оосорлож хүзүүнээсээ уяад хэвтэж байж. Өмнө орны араар унагаж хөлдөөх шахсанаасаа айсан хэрэг. Маргааш нь айлын хүмүүс ирээд, охиныг авах гэхэд, аав нь нулимстай нүдтэй зогсож байснаа охиноо тас тэврээд “Би охиноо өгөхгүй ээ!” гээд уйлчихсан гэдэг. Ингэж л том охин Гэрэлмаагаа гэртээ авч үлдсэн түүхтэй. Өргүүлэхгүй бол өнгөрнө гэсэн охин нь одоо жар гарчихсан, үр хүүхдүүд ач зээ нараа тойруулаад, энх тунх явж байна.

Тарнийн хүч

Гарангуутаа л уйлж эхэлсэн, бүтэн жилийн турш өвдөж зовж, уйлж шаналааж байгаа, ямар ч эмнэлэг эдгээж чаддаггүй охиныхоо төлөө эцэг эх хоёр чөтгөр лүү ч очиход бэлэн болов. Тэгтэл Дэндэв гэлэн гээд хүүхдэд ээлтэй лам Гурван буудалд байдаг сураг гарлаа. Доржсүрэн намын гишүүн хүн болохоор лам руу нууцаар, сэмхэн очихгүй бол болохгүй. Хэрвээ мэдэгдвэл намаас арга хэмжээ авч, ажилгүй ч болж мэдэх цаг. Гурван буудал руу өнөөх гэлэн рүү очтол бурхан тахил, ном судар гэх сүртэй их юм гэрт нь харагдсангүй. Лам ганцаараа гэртээ суучихсан, мэнд ус ч үгүй. Урдаас цэхэлзээд, ёозгүй гэж жигтэйхэн. “Ямар муухай ааштай хүн бэ?” гэж бодож амжаад, учраа хэлвэл шургуулга татаж нэг ёотон аваад амандаа ганц хоёр тарни уншсан болоод, үлээж шүлэмдсэнээ “Энийг өгчих” гэв. Буцаж явахдаа “Энэ ч худлаа биз дээ. Шинжлэх ухааны эмнэлэгт, эрдэмтэй чадалтай эмч нар хүчрэхгүй байхад, ганц ёотон идээд эдгэнэ гэж лөө лөө...” гэж бодож явж. Тэгтэл охин нь уйлахаа болиод, яр шарх нь эдгээд эхэлсэн гэдэг.

Тэрхүү Дэндэв гэлэн их сонин хүн байж. Танилцаад, гурав дөрвөн жил наашаа цаашаа явж, ирж очив. Занг нь мэдээд ирэхээр тийм ч муухай ааштай хүн биш. Хүүхэд өвдлөө гэхээр бусад лам шиг үзэж харж, тэрнээс болсон, энэнээс болсон, ийм ном уншуул гэж хэзээ ч хэлэхгүй. Өнөөх шургуулгаа татаад л тарниа уншаад эхэлдэг. Өгсөн чихэр, ёотонг хүүхдэд өгчихөөр өвчин нь эдгэчихнэ. Дэндэв гэлэн нэгэн улсын баяраар комбинат руу гэрт нь хүрээд ирлээ гэнэ.

-Хоёулаа явж наадам үзнэ ээ гэж. Доржсүрэн “Урал” гурван дугуйттай болчихсон, түүгээрээ гэлэнг гэртээ ганц нэг авчирсан байж. “Урал”-аа асааж аваад, ламаа шаахайд нь суулгаад гарлаа. Тэр үед Яармагт наадам болдог, наадмын өдөр Туулын гүүрийг хаачихаад машин мотоцикл явуулдаггүй, зөвхөн сайд дарга нарыг л нэвтрүүлдэг байлаа. Энгийн ард Сонсголонгийн гүүрээр тойрч очих ёстой. Тийшээ эргэх гэтэл Дэндэв гэлэн,



-Чи чигээрээ яваач! гэж зандрах юм гэнэ.

-Энүүгээр явна гэж саналтгүй. Сайд дарга нар л явдаг зам гэвэл,

-Зүгээр ээ, шууд урагшаа яв! гэлээ. Тэгэхээр нь зориг ороод урагшаа чигээрээ давхичихлаа. Замаар дүүрэнцагдаа байгаа хэрнээ нэг муу гурван дугуйттай, хажуудаа хэний ч танихгүй

хөгшин суулгачихсан эрийг огт зогсоохгүй юм гэнэ. Өөр мотоцикл машиныг бол тасхийтэл шүгэлдэж зогсоогоод л, торгож буцааж хөөж байгаа харагдана. Айгаад зогссон чинь гэлэн,

-Чи яагаад зогсчихов оо, хүү минь? Зүгээр яваач! гээд байх юм. Дахиад л цаашаа явлаа. Одоо ч цагдаа шүглээ тасхийлгэнэ дээ гэж бодтол зүв зүгээр явсаар байгаад Яармагийн дэнжид наадмын талбайд хүрчихэж.

-Мотоциклоо энэ шугам дотор тавиад цаашаа явган алхдаг юм гэсэн чинь,

-Зүгээр зүгээр. Яв яв! гэлээ. Тойрог болж суугаад бөх үзэж байгаа хүмүүс рүү шаахайтайгаа давхиад очлоо. Бас л цагдаа ирсэнгүй. Зогсоолд мотоциклоо дүрмийн дагуу тавиагүй хүнийг торгож, сүйд хийх ёстой байлтай!

Яагаад ингэж чөлөөтэй хүрээд ирэв? Яагаад цагдаа зогсоосонгүй вэ? Бусад машин мотоциклыг зогсоосон хэрнээ ганц бид хоёрыг явуулаад байдаг нь ямар учир байна вэ? гээд л бодож сууж. Их сонин тохиолдол. Тарни номын хүчээр л тэр олон цагдаа нарын дундуур нэвт гарч, наадмын талбайд хүрсэн юм болов уу гэж гайхаж байж.

Доржсүрэнгийн бүх хүүхдүүд эрүүл энх өссөн юм гэхэд арван хоёр хүүхэдтэй байх байж. Гэтэл хүүхдүүдээс нь зургаа нь эндчихсэн гэдэг. Олон хүүхдээ алдаад байна гэдэг үнэхээр хүнд. Аргагүйн эрхэнд л нууцаар ламдаж явсан хэрэг. Комбинатын сэлбэгийн нярав, номтой лам Банзар гуай дээрээ сэмхэн очиж үзүүлж харуулна. Агуулахад нь орж түгжиж байгаад сэм асууна. Бас нэг эмэгтэй байх. Хүүхэд халуурахад аргалаад л өгнө. Самбуу дарга Энэтхэгээс дагуулж ирээд их сургуульд англи хэлний багш хийлгэж байсан нэгэн сайн лам бий гэж хүмүүс яриад байх. Гэтэл тэр лам нь комбинатын байранд хөрш аж төрдөг болж таарав. Тэр ламыг ч нууцаар гэртээ залж, ном уншуулж хүүхдүүдээ даатгаж байлаа. Самбуу даргын лам өдөр л махан хоол иддэг, өглөө оройд цагаан хоол зооглодог, магниг хөнжилтэй их сүрхий хүн. Тэр бага хүүд нь Аюурзана гэж нэр хайрлаж байж.

Доржсүрэн, Цэдэв хоёр амралтанд явах их дуртай. Хоёр хүүхэдтэй болчихоод байхдаа Тарнийн амралтанд явах гээд урт дараалалд зогсож байж. Бүртгүүлэх ээлж нь ирээд, хоёр хүүхдээ бичүүлэх гэтэл Доржсүрэн хүүгийнхээ нэрэн дээр түгдрэв. Бүртгэлийн ажилтан,

-Хоёр дахь хүүхэд чинь хэн юм бэ? ...Хурдлаач! гээд уурласан ч эцэг таг хэвээр. Өглөөнөөс хойш дараалалд зогсож халууцаж, ундууцсан хүмүүс уурлаж,

-Түргэн гараач ээ. Хүүхдийнхээ нэрийг мэддэггүй, эцэг нь биш юм уу, хаашаа юм? гээд л шуугилдана.

-За за, яршиг Шомбойдой гээд биччих гэхихээд час улайж, хөлс нь гоожсон хүн дарааллаас бушуухан гарч ирж байж. Ингэж хүүгийнхээ нэрэн дээр гацсан нь бас учиртай. Эрэгтэй хүүхэд тогтохгүй болохоор лам “Хүүгээ тав хүртэл нь нэрээр нь огт дуудаж болохгүй. Дуудвал амь насанд нь цөвтэй” гэснээс тийнхүү балмагдаж таг дуугүй болсон хэрэг. Амралтад явахын тулд хүүгийнхээ нэрийг бичүүлнэ гэж огт бодоогүй, санамсаргүйгээр дараалалд зогсож байж.



Ламын үгийг дагаж 1953 онд төрсөн Зоригт гэдэг хүүгийнхээ нэрийг гэрийнхэн тийнхүү цээрлэнэ. Сав л хийвэл өлгийнөөсөө мултраад шомбогосхийгээд гараад ирдэг, аавыгаа дуурайсан сэргэлэн, түргэн хөдөлгөөнтэй хүү учраас Шомбойдой гэх болсон хэрэг.

Тийнхүү бүртгэл дээр хөглөөд, Тарнийн амралтанд очтол Төв хорооны Пэлжээ гуай зэргэлдээ өрөөнд амарч байлаа. Хоёр гэр бүл залуу болохоор хань татаж бүжгэнд явах дуртай. Пэлжээ гуай цонхны гаднаас мангас болж дуугаран охин хүү хоёрыг нь айлгаж унтуулдаг. Унтчихаар нь цоожлоод бүжгэнд явцгаадаг байж.

Балган ноёны хиа

Тавь жараад оныхонд гэгээлэг нэгэн чанар бий. Тэр үеийнхэн одоогийн биднийг бодвол урлагт ойрхон амьдардаг байж. Нийгмийн амьдрал, нийгмийн бүхий л харилцаанд нь урлаг чухал. Тэр үеийн залуус гол төлөв нийтийн бүжиг дээр танилцана. Үлээвэр хөгжмийн яруу тунгалаг эгшиглэнд уусч, вальс бүжгийн цоглог хэмнэлд гишгэл тааруулан, уян налархай эргэлдэн бүжнэ гэдэг тэнгэрлиг мэдрэмж. Энэ их гэрэл гэгээн дунд насны ханьтайгаа учирч, анхны үгээ хэлэлцсэн байна гэдэг гайхамшиг. Насан туршийн гэгээн дурсамж.



Үйлдвэр дээр урлаг, уран сайхны олон ажлууд зохиогдоно. Хувьсгалт залуучуудын эвлэлийн үүрээс ажилчин залуучуудын урлагийн үзлэг, баярын тоглолт концерт зохион байгуулж, ханын сонин гаргаж, шүлэг найраг нийтэлнэ. Ажилчин залуус уран сайхны дугуйланд явж, Комбинатын клубт чөлөөт цагаа өнгөрөөнө. Одоог бодвол арав дахин бага хүн амтай Улаанбаатар хотод арван хэдэн театр, соёлын ордон ажиллаж байж. Комбинатын клуб орон тооны овоо хэдэн хүнтэй. “Аман хуур” киноны өхөөрдөм хоржоонтой өвгөний дүрээрээ ард түмний сэтгэлд хоногшсон Цэрэнлхүндэв гэгч агуу хүн найруулагчаар ажиллана. “Хөхөө гэрлэх дөхлөө” кинонд дүр бүтээсэн Баньдхүү, “Төөрсөөр төрөлдөө” киноны Балтын эхнэр Сумъяа, “Өндөр ээж”-ийн Цэмбэлмаа, “Таксийн цоохор” дуугаараа олонд алдартай Цэнд-Аюуш гээд олон алдартан комбинатын театрт ажиллаж байлаа.

Гэргий Цэдэв нь тэр гайхамшигтай хүмүүстэй мөр зэрэгцэн урлагийн фронтод зүтгэнэ. Түүнтэй хамт Алтанцэцэг, Рэнцэнханд, Цэрэндулам гээд хөгжимчид ажиллаж байлаа. Хөгжмийн багшийн нөхөр болсон, бас багын найз Самдан нь жүжигчин болохоор Доржсүрэн бас урлаг уран сайхан руу өөрийн мэдэлгүй татагдана. Комбинатын клубийн үнэнч үзэгч болсон нь мэдээж. Тэгтэл нэг өдөр түүнийг “Учиртай гурван толгой”-д тоглуулна гэж тулгах нь тэр! Үгүй гээд баахан цааргалаж зугтаалаа. Тэгтэл эхнэр нь “Олны хэсэгт хүн дутаад байна. Балган ноёны хиа л болох юм. Дагаж тайзан дээр хоёр удаа гардаг. Хүн айгаад байх юм биш” гэж гуйж ятгалаа. Ингэж л албан шахалтаар театрын туслах жүжигчин болж, алтан

тайзнаа гарах нь энэ. Доржсүрэн далбагар дээл өмсөөд, эртний малгай духдуулчихаад Балган ноёныг даган гарч ирнэ. Түүнийгээ “Балганыг дагасан хэдэн навсгар юм байдаг даа. Тэрний нэгэнд нь тоглоод оо” гээд инээдэг байж.

Ийнхүү том дуурийн “чухал дүр”-д тоглоод оройтож харьдаг боллоо. Хүүхдүүдийг нь өвчин ороогоод их зовоож байсан үе болохоор шүд зууж л энэ дуурь тоглогдсон хэдэн үдшийг өнгөрөөж байж. Тоглолт дуусмагц хүүхдүүд рүүгээ яарч, өнөөх салбагар дээлээ бараг л тайлалгүй гэр лүүгээ гарч гүйх шахна. Тэгж байтал үйлдвэрийн дарга Төмөр-Очир өрөөндөө дуудаад,

-Чи дуурьт тоглоод байгаа гэлүү? гэж асуулаа. Ерөнхий механик, намын гишүүн, хариуцлагатай хүн байтлаа салбайж навсайсан хачин хувцастай олны нүдэн дээр гарч ажилчдынхаа доог боллоо гэж загнах нь дээ гэж айв. Гэтэл дарга шал өөр зүйл ярьж эхэллээ.

-Гадаад улсаас том хүн ирсэн. Чамтай уулзаж ярилцана. Үгээ бодож цэнэж яриарай. Улс эх орныхоо нэр төрийг гутаах зүйл хэлэв ээ! гэж анхааруулав. Даргын заасан Элдэв-Очир кинотеатрын залгаа хойд тал дахь зочид буудалд явж очлоо. Тэгтэл цагаан толгойтой, сахалтай эр инээмсэглэн угтав. “Хэдийд ажилдаа орж байсан? Яаж ажиллаж байсан?” гэх зэргийн асуулт тавьж, баахан шалгааж байснаа, “Баярлалаа” гээд буцаасан гэдэг. Гарч ирээд том дарга гээд байсан чинь биш л байж шүү дээ гэж бодсон гэдэг. Тэр хүн бол Шинэ Зеланд улсаас ирсэн сонины сурвалжлагч байсан гэдэг. Гадаадын сурвалжлагч ирснийг үйлдвэрийн дарга “Гадаадын том хүн” гэж битүүдээ хэлсэн байж.

Багын гурван найз эхнэр хүүхдүүдтэй буурьтай суурьтай эрчүүд болсон болохоор зүггүйтэж явдгаа мартав. Гэхдээ л салдаггүй нь хэвээрээ. Нэгнийдээ цуглаад багын хөгтэй явдлуудаа ярьж эхнэрүүдийнхээ элгийг хөшөөх дөхнө. Хоол унд хийж идэцгээнэ. Бага насаа дурсаж хийцтэй цай чанаж ууцгаана. Цагаан багшийн гэргий их сайхан хоол ундтай. Голдуу тэднийхээр очиж сайхан зоогоор амтлах мэдрэхүйгээ баясааж суух дуртай байлаа. Доржсүрэнгийн гэргий олон нялх уйланхай хүүхдээ харахын эрхэнд ажлаа өөрчилж цэцэрлэгийн дуу хөгжмийн багш боллоо. Үдэш бүр буцаж явж хүүхдүүдээ зутраах болдог нь хэцүү байсан нь мэдээж шүү дээ. Тэр цэцэрлэгт нь Самдангийн эхнэр ажиллана. Хоёр бүсгүй нөхрүүдээрээ дамжиж найзалж байснаа улам ойр дотно найзууд болцгоосон гэдэг. Хэдий ажил өөрчлөгдсөн ч хөгжмөө орхисонгүй. Доржсүрэнгийнх гэх айл дуу хуур эгшиглэсэн, инээд наргиа бялхсан айл хэвээрээ л үлдсэн гэдэг.

Адуучин ах

Гомбо ах нь 1915 онд төрсөн, их юм үзсэн толгой. Зургаахан настай жаахан хүү байхдаа гамингуудаас амьд гарсан гэдэг. Эдний гэр бүл гамингийн хөлд нэрвэгдэж, их зовлон амсаж байж. Униа гэж авгайлдаг садангийн эгч нь гаминд түнхээрээ буудуулж суугаа болсон, Уваа гэгч хөгшин нь гэртээ буудуулж нас барсан эмгэнэлтэй түүх бий. Тэр хоёр хөгшнийг буудаж, гэр орныг нь онгичиж, дээрэмдэх үеэр Гомбо хүүхдэд баймгүй самбаа гарган, хөгнөөтэй хурган дотор орж хэвтсэн байдаг. Ингээгүй юм гэхэд бас л амь алдаж мэдэх байсан гээд хөгшчүүл залбирдаг. Харин Доржсүрэнгийн аав Гэндэн, ээж Лхамжав хоёр нь аз болоход малд явсан байж таараад, дээрэмчдийн хөлөөс хол үлдсэн гэдэг.

Гомбо ах нь их томоотой хүн байв. Адуунд үнэн голоосоо дурладаг. Сайхан морь харах л юм бол сэтгэл нь хөөрчихнө. Хар багаасаа адуу маллаж, Хангайн салхи сөрөн, морин дэл дээр давхиж өссөн энэ эрд хотод байсан он жилүүд нь ямаршуу өнгөрсөн бол доо. Магадгүй шөнө бүр адуугаа зүүдэлж, адуу харах гэж ойр орчмын ам, зуслан өвөлжөөнүүд рүү зав гарган явдаг байсан биз.

Ах архи дарс амсана гэж үгүй. Ээжийгээ дуурайгаад тамхийг бол харин зэгсэн угзарчихна. Нуруу турууны хувьд ээжийгээ дуурайгаагүй гэхээр, тийм ч өндөр биш хүн. Адуутай их ноцолддог болохоор хөлөө гурав ч хугалж байж. Хөдөө хээр мориноос унаж хөлөө хугалчихаад, хөлийн ороолтоороо шилбээ дангинатал боочихоод морио унан гэртээ ирсэн, тийм л эрмэг, гүжирмэг эр. Ийм тэвчээртэй хүн гэж байх уу гээд бодоход, санаанд огт багтамгүй.

Булганд аж төрж байхдаа Гомбо ах нь Жамъянжав гуайн адууг хариулдаг байв. Шөнө болохоор адуу манана гээд явна. Аль эмнэг, атар тарган морьдийг унаж номхруулна. Омголон морин дээрээ хазгайдуухан суугаад, амыг нь ангалзуулан татаж, эргэцүүлж буйг нь харсан хэн хүн “Монгол эр хүн гэдэг ийм байдаг даа!” гэж өөрийн эрхгүй дуу алддаг байж.

Эднийх Хар бухын голд аж төрж байхдаа мал бараг л байхгүйтэй ижил байж. Саалийн ганц үнээтэй. Чөдрийн ганц морьтой. Хэдэн хонь байдаг юм уу, үгүй юм уу гэхээр. Гомбо гэж том хүүгээрээ овоглосон өрхийг Гурванбулаг сумын ард Жамъянжав гэгч буянтай ард л тэтгэж, авч явдаг байж. Гомбынх өвөл ч, зун ч тэр айлын хаяанаас салахгүй, дагаж нүүнэ. Тэр буянтай хүн,

-Зуны дэлгэр цагт айлаас айраг хараад сууна гэдэг юу гэсэн үг вэ? Та хэд манай хээр азарганы хэдэн гүүг барьж, айраг ууцгаа гэнэ. Жамъянжав гэгч, жирэвгэр сахалтай энэ хүн дөлгөөн зантай. Нутаг усны хэн ч байлаа гэсэн “Тайхам сайн хүн дээ” хэмээн магтана. Эхнэр нь өндөр Дуламжав гэх эмэгтэй байх. Зунд энэ айлын сүү сааль нь бялхаж байдаг байлаа.

-Та нар сүү аваачиж хөөрүүлээд, өрөм идэцгээ л гэнэ. Доржсүрэнгийн ээж Лхамжав гуай ч, Гомбо ах нь ч, хоёр эгч нь ч хотод ирээд байхдаа Булган нутгаа санаж, Жамъянжав гэх энэ буянтай хүнийг үргэлж сайнаар ярьж, дурсдаг байлаа. Түүний хүү нь хожим нь гавьяат болсон, нүдний эмч Жамъянжавын Баасанхүү үе удам залган Доржсүрэнд буян болж, нүдийг нь эмчилж байж. Дэндэв эгч нь Баасанхүү эмчтэй байнга холбоо барьж, уулзаж нутгаа ярьж,

ах дүүс шиг ойр дотно байдаг.

Дөчөөд оны цагдаагийн албан хаагчдыг цэрэгт татдаггүй байлаа. Тэгтэл яагаад ч юм 1948 онд Гомбо ахыг нь түр цэрэг гэгчид татчихлаа. Энэ бол ахынх нь амьдралд эргэлт гаргасан сонин үйл явдал болж байв. Хэнтий аймагт алба хаагаад буцаж ирэхдээ гэргий дагуулаад ирэх нь тэр! Ах нь ийнхүү Цэдэндамбаа хэмээх буриад бүсгүйтэй насны амьдралаа холбосон байдаг. Тэр цагдаагийн албанаасаа гараад Гутлын үйлдвэрийн эсгүүрийн тасагт, гутлын ул цавчдаг машин дээр ажиллаж эхлэв. Ингээд хоёр жил хэртэй ажиллаад адуу гэгч тэнгэрлиг амьтандаа татагдсан нь мэдээж, хөдөө гараад явчихсан гэдэг.

Гомбо ах Хэнтийд очоод Батширээт сумын иргэн болж суурьшсан аж. Сумынхан нь түүнийг “Адуучин Гомбо”, “Хүргэн Гомбо”, “Шүд Гомбо” гэж янз янзаар цоллоно. Алтан соёотой болохоор нь шүд гэсэн хэрэг. Буриадын хүргэн болж очсон төв халхын хүү отрын адуу хариулж, өртөөний алба залгуулж, сүүлд нь нэгдлийн адуучин болж нутаг усандаа нэр хүндтэй сайхан аж төрж байлаа. Ямар ч хар бор ажлыг голдоггүй, ажилсаг хөдөлмөрч, олон түмэнтэй нийцтэй болохоор амьдрал нь дорхноо л дэвжиж цэцэглээд явчихсан нь мэдээж. Гомбо ахынх нь тоймгүй олон хүүхэдтэй өнөр өтгөн айл. Цэвэлмаа, Дэнсмаа гэсэн ойролцоо нэртэй олон охидтой. Нэгдлийн мянгаар тоологдох адуу хариулж, хажуугаар нь ойр ойрхон төрсөн олон нялх нойтон хүүхдээ гэсээр хот хүрээ оролгүй их олон жил болж. Ижийгээ бурхан болоход очиж чадаагүйгээр барахгүй нэг л мэдэхэд хэдэн дүү нараасаа хэл сураг тасраад арван жил болчихсон байлаа.

Жараад онд сонин дээр гарсан гурван дүүгийнхээ тухай нийтлэлийг ах огт санаандгүй уншсан гэдэг. Гэндэнгийн Сэрээтэр, Гэндэнгийн Дэндэв, Гомбын Доржсүрэн гэсэн нэрсийг хараад нүдийг нь нулимс бүрхэж, “Миний гурван дүү сонинд гарчихаж!” гээд гэрийнхэн, айл саахалтдаа үзүүлж сүйд болж байж. Гэр бүлээрээ үйлдвэрт ажиллаж, хоёр нь Ударник цол хүртэж, нөгөө нь Хөдөлмөрийн хүндэт медаль авч, алдар хүндтэй ажилчид болцгоосон эгч дүү гурван ажилчны тухай сурвалжлага гэрэл зургийн хамт сонин дээр гарсан нь энэ. Ингээд Гомбо ах нь гэргийтэйгээ хот руу ирж, сураглаж хайсаар дүү нартайгаа уулзаж, уйлаан майлаан болж байсан нь сонин. Арван жил өнгөрөхөд ах нь ч дүү нараа сурагладаггүй, дүү нар нь ч ахаа эрж хайлгүй аж төрсөөр явж.

Ингээд Доржсүрэн ахтайгаа холбоотой байх болж, жил болгон Батширээт рүү давхидаг болсон гэдэг. 1963 онд ахынхаа том хүү Бадам-Очирыг авчирч хотын сургуульд оруулж байлаа. Сахилга бат тааруу хэрнээ хичээлдээ сайн, сүрхий шүү гэж багш нар хэлдэг, тэр хүү том охин Гэрэлмаатай нь нэг ангид суралцсаар хотод долдугаар анги төгсөж байж.

Гомбо ах дандаа малгайтайгаа байдаг сонин араншинтай хүн. Унтахдаа л осолдохгүй малгайгаа авна. Орон дээрээ өндийж суумагцаа л бушуухан малгайгаа толгой дээрээ тавьчихдаг.

-Орон сууцанд ирчихээд малгайгаа аваач! гэхээр аваад дэргэдээ тавина. Ярьж суух зуураа хэдийнээ өөрийн мэдэлгүй малгайгаа аваад л толгой дээрээ тавьчихсан байна. Унтах гээд орон дээрээ суучихсан, цамцаа тайлчихсан хэрнээ толгой дээрээ малгайтайгаа л байдаг хүн байлаа. Архийг “Мана” гэж нэрлээд ойртохгүй. “Ах минь ганц татчих даа?” гэхээр, “Мана уухгүй ээ!” гэх. Гуйж байж ганц хоёр хундага уулгана. Цаашаа ахиж нэмэхгүй. Нэг хөл нь

гурав хугарч байсан болохоор гишгээ доголон. Хөөрхий, нартаас буцахаа зөнгөөрөө мэдсэн юм байлгүй, Доржсүрэнг явж очиход өмнө нь огт тэгдэггүй байсан хүн хэрнээ хань татаад л, дүүгээ явуулахгүй хоргоогоод байсан гэдэг.

Хоёр дугуйтай машин

Нэг өдөр Доржсүрэнг үйлдвэрийн дарга Төмөр-Очир өрөөндөө дуудуулав. Яваад орсон чинь,

-За, Доржсүрээн. Чамд машин өгнө өө! гэж байх юм гэнэ. “Албанаас машин өгөх нь энэ үү? Ямар сайхан хэрэг вэ!” гэж дотроо баярлаж, уушиг зүрх амаараа гартлаа догдлов. Машинтай болох гэдэг түүний насны мөрөөдөл, олон шөнийн зүүд. Будаг нь ханхалсан цоо шинэ ногоон тэрэг нүдэнд нь харагдсанаас, хүүхэд шиг дороо дэвхцэх холгүй болов.

-Юун машин бэ, дарга аа? гэж асуулаа.

-Хоёр дугуйтай машин! хэмээн дарга их донжтой хэлээд,

-Чамд бичиг хийж өгнө. Үүнийг аваад бараа бааз руу яв! гэж тушаав. Тэгтэл энэ нь Доржсүрэнгийн бодож, зүүдэлдгээс тэс ондоо машин байсан нь хоржоонтой.

1952 онд Аж үйлдвэрийн комбинатад хоёр ширхэг орос мотоцикл хуваарилсан байлаа. “Иж” нэртэй, 1560 төгрөгийн үнэтэй, сүрхий эд. Тэгтэл өнөөхийг нь сайн дураараа авах хүн олддоггүй. Комбинатын захиргаа аргаа бараад үйлдвэрүүддээ “хүч хэрэглэж” хуваарилахаар шийдэж. Ингээд нэгийг нь Гутлын үйлдвэрт, нөгөөг нь Арьс ширний үйлдвэрт тулгаад өгчихөж.

“Үйлдвэр комбинатын Гутлын үйлдвэрт хуваарилсан, 1560 төгрөгийн үнэтэй “ИЖ 49” мотоциклыг Г.Доржсүрэнд олгохыг зөвшөөрөв” гэсэн цохолт бичгийг хараад, үйлдвэр намайг мотоциклоор шагнаж байгаа юм болов уу? гэж бяцхан горьдов. Тэр үед Дунд голын урд талд “Чогсомын бааз” гэж хүмүүс нэрлэж заншсан Бөөний худалдааны бааз байж. Түүн рүү өнөөх бичгээ бариад явж очлоо. Нярав нь бичгийг үзээд,

-Аа за, за, гэснээ нэг мотоцикл гаргаад ирлээ. Тэгснээ нэмээд,

-Мянга таван зуун жаран төгрөг тушаачих гэлээ. Мөнгө байхгүй бөөн, сандралд орлоо. Ийм их мөнгийг өөрөө тушаахаа мэдсэн бол авахгүй гэх минь яав даа? гэж бодогдов.

-Надад мөнгө байхгүй ш дээ. Яах вэ? гэж хэлж үзлээ. Нярав эгдүүцэж,

-Хүү минь чи надаар даажин хийгээд байна уу? Мотоцикл авах гээд цохуулж ирчихээд мөнгөгүй гэх! Чамд үнэгүй мотоцикл хэн өгөх вэ? гэж байна. Ичсэн ч гэж арга байхгүй. Дарга руугаа буцаад гүйж очвол цалин дээрээсээ суутгал хийлгэж, бага багаар төлж барагдуулах болзолтойгоор үйлдвэр мотоциклын үнийг дансанд шилжүүлэх боллоо. Доржсүрэн урт амьсгаа авав. Хэдий өрөнд орж байгаа ч, дотроо бол хурдан унаатай болж байгаадаа баярлаж догдлох аястай. Есдүгээр зэрэгтэй болохоор 450 төгрөгийн тогтмол цалинтай, түүн дээрээ хийсэн сэлбэг хэрэгслийн шагнал наряд бичигдээд сард мянга гаран төгрөг авчихдаг болохоор тэгтлээ айгаад байх их өр биш байж. Бөөн баяр болсон хүн цоо шинэ унаагаа хөтлөөд гэртээ ирлээ. Хэт хөөрсөндөө үйлдвэрийн тосыг нь арчихаа ч мартчихаж. Яндангийн тос өмдний шуумганд арчигдаад, бакны тос цамцны бөөрөнд

нялагдаад, хувцас хунар авах юмгүй болсон байлаа.

Арьс ширний үйлдвэрт хуваарилсан нөгөө мотоциклыг нь Лувсаншарав гэж слесарьт өгсөн сургийг тэр өдөрт нь дуулав. Лав асаагаад унасан байх, туршлага судлая гээд очвол, бас л мотоциклоо хараад, яахаа мэдэхгүй сууж байна гэнэ.



-Хоёулаа яаж энэ сүрхий унаагаа унах вэ?

-Харин тийм ээ. Би ч бас аргаа олохгүй сууж байна...

Ийм яриа хоёр мотоциклтны хооронд өрнөлөө. Мотоциклоо үйлдвэр лүү түрж ирээд, слесарийн өрөөнд оруулаад тосыг нь цэвэрлэж, баахан арчиж зүлгэлээ. Слесариуд ч ханцуй шамлаж дайраад, гялалзуулаад хаях нь тэр. Эрхбиш үйлдвэрийн түмэн янзын машинуудтай ноцолдож байдаг хүн байна даа, асаалаа. Шууд үйлдвэрийн барилга дотроо асаачихсаныг хэлэх үү пад падхийн айхавтар чанга дуу хадаад явчихлаа. Мордоод хөдлөх гэтэл хоёр ч ойчихлоо. Слесариуд хөхрөлдөж байснаа болиод, араас гүйлдэж ирээд дэмнэж түшлээ. Нэгдүгээр араагаар нь муухан яваад тойроод л байлаа. Тэгсээр зориг орж хоёрдугаар араанд нь хийж үзлээ. Давгүй тогтоод, яваад байх бололтой. Далбагар хар эмээл нь унадаг дугуйныхыг бодвол том, түшигтэй, эвтэйхэн ч юм шиг. Залуу байсан болохоор тэр оройноо л давгүй унаад сурчихсан, хүн сундалдаад давхиж явж.

Ингээд мотоциклын хоббитой болох нь тэр. “ИЖ 49” маркийн тэр мотоцикл нь 18 морины хүчтэй хөдөлгүүртэй, 100 километр 4 литр бензин иддэг, дөрвөн араатай, бас ч үгүй хүчтэй эд байлаа. Доржсүрэн техник мэддэг болохоор үйлчилгээ тохиргоонуудыг нь хийж сураад, зарим нэг зүйлийг нэмж монголчлоод, хаа сайгүй давхиж явдаг боллоо. Үүний дараа Чехийн “Ява” мотоцикл, сүүлд нь оросын “Урал” гурван дугуйт хөлөглөж байж. Хамгийн сүүлд өнөөх зүүд мөрөөдөл болсон суудлын машинаа авч унаж байлаа.

Ижий

Доржсүрэнгийн ээж Дагжийн Лхамжав гээд буянтай буурал байлаа. Их намуухан, хэр баргийн юманд уурлана гэж үгүй. “За яах вэ” гээд л сууж байдаг. Хамаг ажлаа өөрөө л хийх гэж мачийж, хүүхдүүдээ болж өгвөл юманд хүргэхгүй. Дуугүй гараад л явчихна, ганцаараа түлээгээ хөрөөдөөд л эхэлнэ. Нуруу өндөр, том биетэй, чадалтай эмэгтэй болохоор хөрөөгөө огцом татаж, ямар ч бүдүүн модыг торохгүй хөрөөддөг байлаа. Хөрөөдсөн модоо хагалаад оруулчихна.

-Ээж минь та амар. Бид хөрөөдчихнө гэхээр,

-За яах вэ.., л гэнэ.

Ээж нь мод толгойгоо гаргаад тамхи нэрэх дуртай. Юм л бол тамхиа баагуулах гэнэ. Сайхан зан хөдөлсөн үедээ Доржсүрэн ээждээ санаагаараа ажил хийж өгнө. Тэгэхээр их баярладаг байж. Түүнээс биш хүүхдүүдээ “Чи энийг хий. Тийм юм хий” гэж хэзээ ч хэлж, тушаахгүй.

Хүүхдүүд нь бүгд ажил албатай завгүй болохоор ээждээ хааяа л түлээ хөрөөдөлцөж өгнө. Үйлдвэр комбинатын Хэрэгцээний хэлтсээс түлээ буулгахдаа ажилчид дараагийн айл руугаа яарснаас гуалингуудыг тарааж шидэлчихээд явна. Ээж бүдүүн гэгч гуалингуудыг ганцаараа ташаалдан сэвхийтэл өргөөд, хашааны ёзоорт нямбай гэгч хураачихсан байна.

-Та хүлээж байхгүй дээ. Бид ирээд хураачих л байсан шүү дээ гэхэд,

-За яах вэ л гэнэ.

Доржсүрэн Уран дархны сургуульд сурч байхдаа ээжээсээ насыг нь асууж байв. Ээж нь инээмсэглээд, “Тавин тавтай” л гэж байж. Сүүлд дөчөөд оны сүүлээр асуутал дахиад л “Тавин тавтай” гээд инээмсэглэж байсан гэдэг. Хөөрхий ээж нь бага наснаасаа ном эрдэм сурсан биш. Хөдөө байхдаа айлын сааль сүү сааж, мал ахуйд тусалж, хар бор ажил хийж байсан, хотод ирээд оёдолчин гуталчин л хийж байсан уу гэхээс сургуульд сурсангүй. Насаа мэддэггүй байсан болов уу.

1952 оны арван сарын сүүл рүү ээжийнх нь тэнхээ мэдэгдэхүйц муудав. Ер нь л тэсэхгүй шинжтэй. Хэнтий рүү гэргийнхээ нутагт аж төрөхөөр явчихсан ууган хүүгээ хүлээж байгаа нь илт. Үүд онгойх бүрт үүд рүү харна. Байнга л,

-Гомбо минь ирэх болов уу? гэж асууна. 11 дүгээр сарын 7-нд Октябрийн баярын жагсаалд явсныхаа маргааш үйлдвэрийн захиргаа руу орлоо.

-Ээжийн бие даамай муудчихлаа. Хэнтийн Батширээт рүү явж ахыгаа олж ирэхээс болшгүй нь гэж хэлэв. Дарга нь бодож байснаа,

-Чамд унаа гаргаж өгөлгүй яахав. Чи Хэнтий рүү эсгий ачиж хүргэх далимдаа ахыгаа аваад ирнэ биз гэж. Тавиад оны арваннэгдүгээр сар гэдэг их хүйтэрсэн, одооны арван хоёр сараас ч илүү жавартай байдаг байлаа. Ингээд л Доржсүрэн ах руугаа явав. Хэнтийн Батширээт сум

гэж шинээр байгуулагдаж, Биндэр сумаас дөнгөж салаад байсан үе. Ачсан эсгийгээ Батширээт сумын Худалдаа бэлтгэлийн ангид буулгаж тушаагаад, Гомбо ахынхаа нутаглаж байгаа газрыг хүнээр заалгаад давхиж хүрэв. Батширээтийн хүмүүс,

-Аа, хүргэн Гомбо уу? гээд л бүгдээрээ ахыг нь мэдэж байж. Яваад очтол хариугүй жижигхэн гэр голын бургасан дотор байх юм гэнэ. Ахынх нь эхнэр амаржаад дөнгөж жил болсон, зүүн орон дээр улаан маамуу унтаж байх. Гэргий нь бас ахиад жирэмсэн, нилээн том гэдэстэй харагдана. Гадуураа өөрийн хэдэн малтайгаа, дээр нь бас Батширээт сумын отрын адуу хариулдаг ажилтай. Хэдэн үнээ саадаг бололтой тугал уячихсан байж. Ахыгаа л аваад ирэх минь гэсэн зорилготой ирсэн хүн юу гэхээ мэдэхгүй самгардав.

-Ээжийн бие муу байна. Тэсэхгүй нь ээ. Таныг л хүлээгээд байгаа бололтой, асуугаад л байна гэж. Ах нь эхнэр лүүгээ нэг, дүү рүүгээ нэг харан бас л яах учраа мэдэхгүй байгаа бололтой.

Тэр өвлийн хүйтнийг хэлэх үү. Дүүгээ дагаад ээжтэйгээ уулзахаар явлаа гэхэд нялх хүүхэд, бие давхар гэргий хоёр нь хэцүүдэх нь ойлгомжтой. Ингээд ах дүү хоёр ярилцаад ахыгаа үлдээхээр шийдэв. Маргааш нь Доржсүрэн буцаж сум яваад буулгасан эсгийнээсээ хэдийг ачиж ирж гэрт нь давхарлага нэмэрлэлээ. Ах нь ээж дүү нартаа үхэр унагаж, төхөөрч өглөө гэнэ.

-Та эхнэр хүүхдээ бод доо. Ийм байдалтай байхад чинь таныг би яаж авч явна гэж зүтгэж чадах вэ? гэж. Хотод буцаж ирээд ээждээ юу гэж хэлэх учраа мэддэггүй. Бодож бодож, худлаа хэлэхээр шийдэв.

-Ээж ээ. Буцаад явах унаа олдохгүй гээд, ах араас мориор ирэх гэнэ ээ. Мөддөө ирж чадахгүй нь шиг байна шүү гэгчлээ. Ижийн нүд нь урамгүй болоод, урт гэгч санаа алдаж байна.

Хөөрхий ижий нь хаалга онгойх бүрд горьдсон харц илгээсэн хэвээрээ л гэнэ. Бие нь улам л дордсоор. Арван хэд хоноод хэдүүл ярилцав. Хүргэ ахаараа ахын өмнөөс захиа бичүүлэв. “Эхнэр жирэмсэн. Дээр нь ой дөнгөж хүрсэн нялх хүүхэдтэй. Өвлийн хүйтэнд очиж чадахгүй нь ээ, ээж ээ. Хүүгээ уучлаарай...” гэсэн утгатай захиаг ээждээ уншиж өгөв. Өтөл болсон ижий нь,

-Өө зайлуул даа. Одоо тэгвэл мөд ирж чадахгүй юм байна гэж байв. Ижий нь тэр шөнөдөө л бурхны орондоо заларчихсан гэдэг. Эх хүн хүүгээ хүлээгээд л, тэсээд л байж дээ. Тэр үед хот тэгтлээ тэлээгүй, хүн цөөтэй учраас талийгчдыг хуучны заншлын дагуу ил тавьдаг байж. Хайрт ижийгээ хүүхдүүд Нарангийн энгэрт ил хөдөөлүүлсэн гэдэг. Ижий нь “Яах юм..?” гэж эсэргүүцээд зургаа авахуулахыг их дургүйцдэг хүн байж. Түүнээс цор ганцхан фото зураг үлдсэн байдаг.

Ганцаараа бүдүүн гуалин хурааж, түлээгээ хөрөөдөж зогсоо ижийнхээ дүрийг хашаандаа орж ирэх бүртээ нүдэндээ харах шиг болдог болсон гэдэг. Доржсүрэн ажил алба ихтэйгээсээ болоод, ээж минь, би хөрөөдчихье гэж үргэлж хэлж чаддаггүй байсандаа харамсдаг. “Ямар ч гэсэн эрх хүүгээ сайхан гэргийтэй болохыг үзлээ. Уйланхай ч гэсэн охинтой болсныг нь харчихлаа” гэж хэлж суусан нь сэтгэлд үргэлж уяатай байдаг.

Хотын “томилолт”

Доржсүрэнг хүүхэд байхаасаа эхлээд л слесарь, механикаар ажилласан туршлагатай, аль ч улсын аль ч маркийн машиныг засчихдаг, ямар ч машины ямар ч эд ангийг хийчихдэг болохоор нь энд тэндээс урьж залах нь их. Үйлдвэрийн даргадаа дуудагдаад орохоор хахь хамаагүй, шал өөр чиглэлийн үйлдвэрийн дарга ирчихсэн,

-Манай машин эвдэрчихлээ. Та л аргалж өгөөч..? гээд, горьдсон, найдсан, цөхөрсөн харцаар ширтээд, сууж байна.

-Би гутлын үйлдвэрийн машинууд л мэднэ. Танай машиныг яаж мэдэх вэ? гээд Доржсүрэн бага зэрэг үнэд орно.

-Би даргатай чинь ярьчихлаа. Танд манайхаас томилолт өгнө. Шагнал хөлс ч гомдоохгүй. Уул нь чех машин байгаа юм. Сэлбэг нь хаанаас ч олддоггүй. Та чех машинд гаргууд гэсэн шүү дээ. Аргалж өгч тус болооч..? Та л чадна..! гээд өнөөх дарга бараг л сөгдөх нь холгүй гуйна.

Ингэж тэвдэхээс ч аргагүй. Үйлдвэр нь зогсчихоод, төлөвлөгөө нь тасарч, социалист уралдаанд авсан амлалт үүрэг нь биелэхгүй болчих гээд зовж байгаа хүн шүү дээ. Төлөвлөгөө тасарвал дээд газраас даргын намын гишүүний батлахыг хурааж, албан тушаалаас нь хусч, хариуцлага тооцно. Намаас арга хэмжээ авахуулвал тэгээд л тэр хүний насан туршийн амьдрал уруудаж, балардаг байсан хэцүү цаг. Доржсүрэн өнөөх үйлдвэр лүү слесариудаасаа дагуулж “хотын томилолт”-оор очно. Өнөөх олддоггүй сэлбэгийг нь яаж ийж байгаад орлуулж хийж өгөөд, машиныг нь ажиллуулж дөнгөнө. Балрах дээрээ тулаад байсан үйлдвэрийн дарга бараг л гар дээрээ өргөх нь холгүй механикийг үднэ.

Тэр үеийн Үйлдвэр комбинатад Гутлын үйлдвэрийн “Хар” Доржсүрэнгүй юм гэж байхгүй болоод байж. Машин эвдэрчихлээ гэхэд л “Доржсүрэнг дууд” гэнэ. Бүр хахь хамаагүй автомашин зогсчихоод байхад л “Доржсүрэн л дөнгөнө дөө” гэцгээнэ. Гэргий Цэдэв нь нөхөртөө аятайхан костюм авч өгөөд, “Битгий энүүнтэйгээ машин доогуур орчихоорой” гэж ахин дахин захиана. Цаадах нь орой шинэ хувцсаа нил тос болгочихоод л ирэх. “Гараажийн дарга машин үзээд өгөөч гэхээр нь доогуур нь орчихсон. Юм хийгээд тал дундаа орсон хойноо л шинэ косчоомоо саналаа” гэнэ. Машин тэрэг гэхээр ухаан алдталаа хорхойсдог нь энэ.

Нэгэн удаа Архи пивоны комбинат пивоо савлаж чадахаа болиод, бөөн сандралдаан болов. Төгсжаргал дарга нь Доржсүрэнгийн гэргий Цэдэвийн дүү болохоор хот даяар зартай механикийг нүүр бардам гуйсан нь мэдээж. Доржсүрэн Лувсанням гэдэг слесариа дагуулж, “хотын томилолт”-оор пивоны цехэд нь буув. Савлагааны машины хөх гээч юм нь байхгүй болсноос нам зогссон байлаа. Механик слесарь хоёр ноцолдсоор байгаад өнөөх хөхийг нь монголчлоод хийчихлээ. Түүнээс хойш хоёр “аврагч” Архи пивоны завод руу чөлөөтэй ордог болсон гэдэг. Жаахан наргимаар санагдахаараа тийшээ зүглэнэ. Цехийн дарга нь “Согтуу гуйвж л гарч болохгүй шүү! Төгсжаргал дарга мэдвэл би толгойгүй болно” гэж анхааруулаад үйлдвэр лүүгээ нэвтрүүлнэ. Ингээд “хотын томилолт”-ын хоёр хүндтэй зочиндоо идээний дээжээ торхоор нь сөгнөх дөхдөг байв.

Хөдөөний томилолт ч бас авна. Далаад оны үед Увс аймагт Спиртийн завод байгуулж байлаа. Нэрэх дамжлагууд, шүүлтүүрүүдийг угсрах, хоолой гуурсуудыг холбох ажилд хашир механик явуулахаар яамны дарга нар ярилцаж зөвлөж гэнэ. Ингээд Гутлын үйлдвэрийн механик, өнөөх алдартай Хар Доржсүрэнг явуулъя гэж шийдэж байв. Түүнийг яаман дээр дуудаад,

-Увсад Спиртийн завод байгуулж байгаа. Та очиж үзээд ажиллуулж болох нь уу, үгүй юу гэдгийг тогтоогоод ир! гэсэн даалгавар өгч, томилолт гардуулж байв. Харин Доржсүрэн очоод болох уу, үгүй юу гэдгийг нь тогтоох биш, бүр үйлдвэрийг нь ажиллуулчихаад ирсэн байдаг.

Үйлдвэрийн бүх дамжлагыг нь угсраад, сав хураагуур, дамжуулах гуурсуудыг нь холбоод спирт нэрж үзэж. Тэгтэл амсахын аргагүй гашуун спирт гарчихаад хэд хоног зовоов. Яаж ч ноцолдоод учир нь олдсонгүй. Буудалдаа ирээд унтах гэхээр нойр хүрэхгүй. Буцаж очоод л ноцолдоно. Нойр муутай хоноод, өглөө эрт гэгч босоод буудлын тагтан дээр, “Ажиллуулж чадахгүй л буцах болж дээ” гэж бодон зогсох зуур тамхилж байж. Тэгтэл төмөр тэрэг түчигнээд л байх юм гэнэ. “Айлууд нь төв гудамжаараа усаа зөөдөг юм байх даа?” гэж бодож. Зэрвэс хартал төмөр дугуйтай тэргийг илжгэнд хөллөчихсөн бололтой юм гэнэ. Лавлаж ажвал илжиг биш хүнийг тэргэнд хөллөчихсөн байх нь тэр! Гайхахын дээдээр гайхав.

Хүн тэргийг дагаад бас хоёр нөхөр гудамжны хог түүж, тэргэнд хийнэ. Өмнө нь хойно нь төрийн хувцастай цагдаа явж байх юм. Тэгтэл эрүүлжүүлэхэд хоносон хүмүүсээ хашрааж, хог түүлгэж, олны нүдээр нүүрийг нь “түлж” буй тэр байж. Сахилгагүй нэгнээ нийтийн хүчээр хүмүүжүүлдэг байсан нь энэ.

Тэр хүмүүсийг харж, “Архи уулаа гэж хүмүүсээ шийтгэх. Тэгсэн байтлаа өнөөх спиртийг нь гашуунгүй нэрэх гээд баахан хүн бөөн ажил болж байх. Уусных нь төлөө хүнийг ингэж хашраах байсан юм бол спирт золигийг үйлдвэрлэж яадаг байна аа?” гэх мэтийн юм бодоод зогсож байтал дахиад л өнөөх “Юундаа байгаа бол?” гэсэн шаналгаат бодол нь ороод ирж. Тэгтэл “Түүхий эдэндээ байгаа юм биш үү?” гэсэн санаа төрлөө гэнэ. Хаанаас ямар үр авсан бэ гээд асуутал Зүүнговь сумын Банзрагч гэдэг хүнээс улаан буудай авсан байж. Буудайг нь шалгавал нил царван. Ингээд ажилчдаа дайчлан, буудайны царванг нь арилгуулаад дахин нэртэл маш сайн спирт гарч байв. Ингэж л хот дотроо ч, хөдөө тийшээ ч томилолт авч, өөрийнхөө мэргэжлээс тэс өөр чиглэлийн машин техникийг засч, шинээр угсарч явж. “Болохгүй бол Гутлын үйлдвэрийн Хар Доржсүрэнг дуудъя” гэдэг хэлц үг тэр үеийн дарга нарын дунд дэлгэрсэн байсан гэдэг.

Нам засгийн “00”

Доржсүрэн ерөнхий механикийн ажил аваад удаагүй байхдаа үйлдвэрийн удирдлага болох Пэлжээ, Намсрай, Цэмпэлдорж нартай Гурван нуурын амралтанд амрахаар очиж гэнэ. Тэр үед амралт тэгтлээ сүртэй тохижоогүй, гаднаа энгийн бие засах газартай байж.

Хэд хоноод байтал хэсэг хүн бөөгнөрөөд л, газар ухаж нэг зүйл босгоод эхэллээ гэнэ. Ойртоод ажвал жорлон барих гэж байгаа бололтой. Хаа ч байдаг нэг муу модон жорлон босгохын төлөө ийм олуулаа, тэгтлээ нямбайлан, ур ухаан заран ажиллаж буйг хараад инээд хүрсэн нь мэдээж. Тэгтэл Сайд Нарын Зөвлөлийн дарга Жамбын Батмөнх гуай ирэх гээд бүгд сандралдаж эхэлсэн нь энэ аж. Тэр том даргыг боловсон “00”-д л морь харуулах ёстой гэцгээж, цоо шинэ банз авчруулж бүхээг босгож байгаа юмсанж. Банзаар боловсон жорлон босгохоор зүтгэж байгаа нь их сонин. Очоод хошуу нэмэрлэх гэвэл түүнийг анзаарах шинжгүй.

-Энийг яаж боловсон “00” болгох вэ? хэмээн хүн бүгд бодол болсон зогсож байх юм гэнэ. Суултуурыг хэрхэн хийж байгааг хэсэг харж байснаа явж хооллочихоод, буцаж ирэв. Харвал суултуурыг аль хэдийнэ дуусгаад,

-Яаж устай болгох вэ? гэцгээж, толгой гашилгацгааж байх юм гэнэ. Доржсүрэн хэсэг бодож байснаа, тэсгэлгүй,

-Бүхээгнийхээ ард 200-гийн поошгинд ус дүүргээд дүүжилчих гэчихлээ. Шатахууны төмөр торхыг хүмүүс ингэж дууддаг байсан хэрэг. Том даргад зориулсан чухал юм урлаж байсан чухал хүмүүс шавилхан залуугийн хэлж байгааг тоосонгүй. Доржсүрэн үгээ дахин давтлаа. Гэтэл “Энэ муу хүүхэд чинь юу ярина вэ?” гэсэн байдалтай харцгааж байна гэнэ.

-Өндөрт дүүжилсэн торхтой усаа хоолойгоор гүйлгээд, суултуурын ус хураагууртаа залгачих. Ус нь дээрээс буух даралтаараа хураагуурыг цэнэглэдэг байхаар хийчих гэхэд нь сая л ойшоосон байдалтай харцгаав.

-Болжэ мэдэхэш санаа байнав ш! гэж сүрхий мужаан бололтой буриад эр нь дэмжиж байна. Доржсүрэн ийм санаа хэлчихээд, хамт явж байсан хүмүүстээ дуудагдаад явчихаж. Хоёр хоногийн дараа Батмөнх дарга ирсэн гэцгээв. Өнөөх чухал “00”-ийнхоо дэргэдүүр өнгөрөхдөө харвал, өөрийнх нь хэлснээр поошиг дүүжилчихсэн харагдана гэнэ. Энэ тухайгаа хүнд ярьсан чинь,

-Чи үүнээс хойш “Надгүйгээр Нам Засаг явахгүй!” гэж ярьж бай. Чи байгаагүй бол Нам төрийн том удирдагч морь харж чадахгүй балрах байж шүү дээ гэж хоржоон хийж инээдэм болцгоосон гэдэг.

Тэвчээр алдарсан паян

Улсын төлөвлөгөө биелүүлэхийн төлөө цаг наргүй зүтгэдэг дарга даамал хүмүүст хөгтэй явдал тохиолдох нь олон. Нэг удаа Оёдлын тасгийн зуузай оёдог машины гол тахийчихлаа. Мурийж хэлтийсэн голыг тэгшлэх арга байхгүй учир шинээр гол зоруулахаас өөр аргагүй болов. Төмрийн тасагт зоруулахаар голоо аваачиж өгөөд, “Яаралтай шүү, түргэлээрэй” гэж, учирлаж хэлчихээд ирлээ. Үдээс хойш буцаад очтол “Ажил ихтэй зорж амжаагүй байна” гээд халгаасангүй. Ингээд голгүй сууж байтал зуузайны дамжлага дээр гутлууд овоорч үйлдвэр зогсохоос өөр аргагүй боллоо. Үйлдвэр зогсоосноос том асуудал дэгдэх нь мэдээж хэрэг. Төмөр-Очир дарга Доржсүрэнг хонтоортоо дуудуулаад баахан загналаа гэнэ. Хэт их уурлаж цамнасан дарга сүүлдээ уурандаа ухаангүй болчихож байгаа шинжтэй.

-Нөхөр минь чи, санаатай тэр машиныг зогсоосон! гэж улаан цайм дайрлаа.

-Үгүй ээ, дарга минь. Төмрийн тасагт зоруулах гээд өгсөн чинь гаргаж өгөхгүй удаагаад байна шүү дээ.., гээд учирлалаа.

-Чамаас ямар ч шалтаг сонсохгүй. Зуузай оёдлын машиныг одоохон ажилд оруул! гэж муйхарлаж тулгаад, тушаал буулгаад болох биш. Даргыг өөрийг дагуулаад төмрийн тасагт очиж нүдээр нь харууллаа. Төмрийн тасгийнхан,

-Танай гол гарах болоогүй. Нэг цагийн дараа ир гэж байна. Төмөр-Очир дарга түнхэлзтэл уурласаар өрөө рүүгээ орчихлоо. Цаг болсны дараа яваад очсон чинь өнөөх голыг бас л гаргаагүй хэвээр. Дарга Доржсүрэнг л загнаад байх нь тамтай. Өөрөөлийн бурууг мэдсээр байж муйхарлаад байхаар уур хүрч, “Битгий хуц” гэдэг үг аман дээр гарч ирээд л буцна. Чимээгүй тэвчиж, баахан загнуулж аваад, төмрийн тасаг руу очтол өнөөх гайтай голыг зорчихсон байна. Аваад ирж явтал дарга цаанаас харснаа өмнөөс угтаж ирээд л цамнаж эхэллээ.

-Та намайг загнаад яах юм? гэгчхлээ. Дарга овсхийтэл цочоод,

-Юу гэнэ ээ, чи..?! гээд чичирч харагдана. Доржсүрэнгийн уур бүр их оволзоод, өөрийн мэдэлгүй голоо бариад далайчихсан байлаа.

-Хүүе хүүе. Чи чинь яаж байна аа? гэснээ дарга цаашаа ухарлаа. Өмнөөс нь ууртай алхвал цаашаа гүйгээд явчихлаа. Хойноос нь гүйгээд өрөөнд нь орсон чинь ширээгээ тойроод зугтааж байна. Тэвчээр алдарсан механик,

-Төмрийн тасгийн бурууг мэдсээр байж яана гэнэ ээ? ...Чамайг би цустай чинь хольж байж л санаа амарна! гэж ууртай бархираад л, давшлаад байлаа. Өрөөнд болж буй дуу чимээ цехээр нэг тарсан нь ойлгомжтой. Нэг хартал ударник эгч нь ороод ирчихсэн,

-Хөөш Доржсүрэн, чи яаж байна аа? гээд гол далайсан гараас нь зуурч аваад, чирч гаргалаа. Эгчдээ бас баахан загнуулж, нилээд тайвшраад, цехэд оров. Өнөөх зовлонт голыг хэмжиж, тойрсон хэдэн нүхийг нь өрөмдөөд, тааруулж тавиад машиныг ажиллуулчихлаа. Хэр

ажиллаж буйг ажаад, доголдох нь уу гэж чагнаад зогсож байсан чинь оёдлын тасгийн хаалгаар Төмөр-Очир дарга шагайж байна. Доржсүрэн рүү хэсэг харж байснаа аяархан алхсаар, хажууд ирлээ.

-Ингээд л засчих юмыг чинь... гэж байна. Доржсүрэн мэдээж дуугарсангүй. Тэгтэл оёдолчингоос машин хэр явж байгааг асууж, ярилцаж эхэллээ. Оёдолчин,

-Машин сайхан явж байна гэлээ. Дарга,

-Энэ овоорсон гутлуудыг оёж дуусгана биз дээ? гэж байна.

-Дуусна дуусна. Илүү цагаар ажиллаж байгаад дуусгачихна гэж оёдолчин хэлээд, шаламгайлан ажиллаж гутлын зуузайнуудыг оёж гаргасаар л. Дарга машин руу харж хэсэг зогссоноо, механик руугаа эргээд,

-Доржсүрэн, уурлах юм алга л байгаа биз дээ? Ингээд л засчихвал болоо шүү дээ! гэж байж. Түүрүүнд багтрах нь холгүй уурлаж цамнаж байснаа, бас ширээгээ тойроод хөөгдөж явснаа ор тас мартчихсан зогсоо даргаа хараад Доржсүрэнгийн инээд тэсгэлгүй хүрлээ. Инээчих гээд болдоггүй. Бушуухан буруу хараад, өрөө рүүгээ орж түгжиж авав. Ширээндээ суугаад нуг нугхийтэл хэсэг ганцаараа инээж, тайвширч байлаа. Дарга механик хоёр ингэж л хөглөсөн түүхтэй.

Хөөрхий даргыг дээрээс комбинатын дарга нар нь дахин дахин дуудаж, “Улсын төлөвлөгөө тасрах гээд байна! Хэрвээ тасарвал хариуцлагыг нь чи үүрээрэй!” гэж загнаад байсан, мань эр тэдэнд загнуулсан уураа Доржсүрэнд ирж гаргаад байсан нь тэр юм байж. Улс орон даяараа төлөвлөгөө биелүүлэхийн төлөө, нялх нойтон хүүхэд, өвчтэй зовлонтой ээж аав, амралт зугаалга бүх зүйлээ умартан хөдөлмөрлөж асан цаг. Социалист нийгмийг цогцлоон босгож буй их хөдөлмөрийн жилүүдэд, “төлөвлөгөө тасрах” гэдэг үг “цаазаар авахуулна” гэдэгтэй утга нэг сонсогддог байж.

Төмөр-Очир дарга хүний эвийг сайн олдог хүн. Эвтэйхэн зальдаад Доржсүрэнд мотоцикл өгчихсөн. Хэрвээ зүгээр л “Чи мотоцикл авчихаач” гэж гуйсан юм гэхэд, Доржсүрэн “Би гэр орон барих гээд өчнөөн өр тавьсан. Яасан ч авч чадахгүй” гэж ороолно гэдгийг тооцоод сэм гэнэдүүлж чадсан. Ажилчдаа загнах үедээ загнаад, аргадах үедээ аргадаад хэний хэнбугайг ч дуулгавартай болгочихно. Төмөр-Очир даргын оронд муу санаатай, шартай хортой хүн байсан юм гэхэд “Даргаа зодох гэж дайрсан” гээд Доржсүрэнг хэрэгт хийчихэж ч болох. Гэтэл дарга нь тийм л сайхан гүндүүгүй, цагаан цайлган хүн байж. Төлөвлөгөө гэгч аймшиг л түүний ухаан санааг балартуулж, уурлуулж цамнуулсан хэрэг.

Учир битүүлэг дээл

1955 онд Гласс гэгч чех эр, Хятад, Монгол хоёр улсаар явсан байдаг. Тэр нөхөр Гутлын үйлдвэрийг шинэчлэх талаар хэлэлцээ хийж, Монголын Аж үйлдвэрийн яамны сайд, дарга нар, Гутлын үйлдвэрийн дарга нартай яриа тохироо хийх зорилготой аялж явсан хэрэг. Тэр үед гутлын үйлдвэрийн даргаар, Доржсүрэнгийн хүүхэд насны анд Равжир томилогдсон ажиллаж эхлээд байлаа. Нэг өглөө үйлдвэрийн дарга, Чех улсын мэргэжилтэн Гласс гэгч нөхрийг дагуулчихсан үйлдвэр лүү орж ирэв. Хэлмэрчээр дамжуулан Доржсүрэнг танилцуулаад, Гутлын үйлдвэрт техник, технологийн шинэчлэл хийх гэж байгаа тухай ярьж тайлбарлахад, ерөнхий механик тэсгэлгүй,

-Оросын төхөөрөмжөө яах вэ? гээд асуучихлаа.

-Оросын төхөөрөмж хоцрогдоод хэрэггүй болсон. Шинэ, орчин үеийн төхөөрөмж тавина. Өөрийг чинь Чех улсад явуулна гэж өнөөх чех ярьж байна. Механик арван дөрөвтэй хүүхэд байхаасаа эхлэн задалж, засч ноцолдсоор ижил дасал болчихсон орос машинуудаа хаях гэж байгаад эвгүйцлээ. Гэхдээ “Чехэд явуулна” гэхийг сонсоод дотроо баярлаж зогссон гэдэг. Тэр гадаад эр үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, ганц хоёр өдөр үйлдвэрээр явлаа. Явах боллоо гээд Доржсүрэнтэй ирж уулзахдаа, хоёр ном, хоёр монгол дээл өгөөд,

-Та үүнийг Чех рүү аваад очоорой гэлээ. Ерөнхий механик нүдээ бүлгийтэл гайхтал Равжир дарга,

-Чи долоо хоногийн дараа Чех рүү явах болсон. Энэ юмнуудыг нь аваад очих нь байна шүү! Наад хүн чинь одоо Хятад руу явах учраас чамд дайж байгаа юм гэнэ, хэмээн тайлбарлалаа. Гайхах баярлах зэрэгцсэнээс хэсэг алмайрсан механик, өнөөх юмнуудыг нь авч хоцорлоо. Орой нь очоод найзууддаа гадаад явах болсноо дуулгаж бяцхан тэмдэглэх аяс үзүүлсэн болоод өнгөрснөөс биш чех эр, түүний өгсөн ном дээл хоёрын тухайд таг мартчихсан явлаа. Өнөөх л орос машинуудтайгаа ноцолдсоор өдөр хоног нэг л мэдэхэд өнгөрчихсэн байна.

Нэг орой саарал дээл өмссөн залуу гэрт ороод ирлээ. Тэр хүнтэй ингэж уулзсанаа ерөөсөө мартдаггүй. Дөнгөж өчигдөр ярилцаж суусан юм шиг л, дээлийн товч шилбэ нь хүртэл нүдэнд яг л тэр чигээрээ харагдсаар л байдаг.

-Доржсүрэн гэж та юу?

-Тийм.

-Та Чех явах гэж байна уу?

-Явна гээд л байгаа. Гэхдээ паспорт арай л гараагүй байгаа... гэсэн яриа танихгүй хүн гэрийн эзэн хоёрын хооронд болж өнгөрлөө. Доржсүрэн гайхсан гэдэг жигтэйхэн. Тэр хүн эхнэр лүү нь хяламхийснээ,

-Би тантай уулзах хэрэгтэй. Гадаа гаръя гэж байна. Гадаа гарсныхаа дараа,

-Та надтай юу ярьснаа хэнд ч хэлж болохгүй. Бүр гэр бүлийнхээ хүнд ч хэлж болохгүй. Ойлгов уу? ...Хойш нь авч явах юм чинь бэлэн байгаа юу?

-Юмсаад байх ч юу байх вэ. Нэг муу чемодан бий. Явах дөхөхөөрөө л хэдэн хувцсаа чихнэ дээ.

-Чех хүний дайж өгсөн ном, дээлийг яасан бэ?

-Аан, тэр үү? Энд., гэрт байгаа.

-Та тэр юмнуудаа авч явах чемодан дотроо хийчих. Аваад надтай явна! гэж тэр залуу тушаангуй өнгөөр хэлэхэд нуруу руу зарсхийн хүйт оргилоо. “Энэ чинь өнөөх До-яам гэгчийн хүн болж таарах нь. Яасан юм бол оо? Арай намайг баривчлах юм биш байгаа..?” гэж ч бодогдов. Бүх юм цаанаа л айдас сэжигтэй. Тэр залуу,

-Паспорт чинь гараагүй байгаа. Маргааш нөгөөдрөөс явах болно шүү! гэж анхааруулан, бүхнийг мэдэж байгаа нь илт. Өнөөх нөхөртэй яваад Дотоод яамны үүдэнд ирж зогсоход зэвэргэн бодол бүр ч батлагдлаа. Өрөөнд ортол бас нэг нөхөр чемоданыг онгойлгоод, өнөөх номыг багласан нарийн олсны зангилаа зэргийг анхааралтай үзээд, зургийг нь авлаа. Ямар ч гэнэ вэ нэг зангилааны нэр хэлээд, тийм зангилаагаар уяжээ гэж байна. Айж бэмбэгнэн суутал чемоданыг авч үлдээд Доржсүрэнг явууллаа. Дотоод яамнаас гарч ирмэгцээ урт гэгч амьсгаа авлаа. Дотор уужраад нэг л сайхан. “Намайг бариад хорьчих вий” гэх айдсаасаа болоод хүйтэн хөлс чийхарч байгаагаа мэдэрлээ.

Хоёр хоног өнгөрлөө, таг. Явах юм болов уу даа гэж эргэлзэж байтал “Явна аа” гээд нөгөө нөхөр орж ирээд, вокзал руу хамт давхиад очлоо. Гадаад явна гэж сүр болоод л, найз нөхөд, ажлынхан гээд баахан үдэгч дагуултай. “Гаргаж өгөөд л дуу шуу болцгоогоод байдаг. Паспорт ч үгүй, тийз ч үгүй яаж явна даа?” гэж дотроо айна. Өнөөх нөхрөөсөө сэм асуулаа.

-Би тийз ч үгүй. Паспорт ч үгүй. Тэгтэл энэ олон хүмүүс хөөрцөглөөд намайг гаргаж өгөөд л байдаг. Тэгтэл өнөөх нь вагоноос хөөгдөөд буугаад ирж л нүдний булай болох вий дээ? гэлээ. Санаа битгий зов, явна гэж байна. Вагонд ортол өнөөх нөхөр суудал зааж өглөө. Хүлээж зогссоноо галт тэрэг яг хөдлөхийн өмнө өврөөсөө паспорт, тийз гаргаж гарт атгуулаад, “Баяртай, сайн яваарай” гэлээ. Тэр чехийн явуулсан юманд асуудал байгаа учраас манай дотоод яам шалгаад, хянаад байна гэдгийг муухан гадарлахтайгаа. Нарийн учрыг мэдэх арга байхгүй. Ах дүүгийн найрамдалт Чех улсын мэргэжилтний дайсан юмны төлөө ингэтлээ сүйд болдог нь ямар учиртай юм бол доо? гэж гайхна.

Сэлэнгийн гааль дээр ачаагаа шалгуулах боллоо. Гаалийн байцаагч чемодан руу ойртсон ч үгүй. Хил даваад Наушки орж явтал өнөөх саарал дээлтэй гайхал чинь купений өмнүүр өнгөрч байх юм. Хотод гаргаж өгөөд, “Баяртай” гэсэн хүн шүү дээ. Ачааг дагахаар өөр вагонд суусан бололтой. Зөвлөлтийн гааль ч чемоданд гар хүрсэнгүй. Явсаар байгаад Чехэд иртэл дайны үед герман офицерүүд байрлаж байсан байшинд байрлууллаа. Чех махлаг авгай үйлчилж, цай оруулж өгчихөөд гартал өнөөх Гласс гэгч нөхөр ороод ирлээ. Хятад руу явсан гэсэн хүн хэдийдээ ирчихсэн юм бүү мэд. Лайтай ном дээлийг нь гарт нь атгуулсны дараа л урт амьсгаа авлаа.

Доржсүрэн энэ явдлын учрыг ерөөсөө олоогүй гэдэг. Тэр дээл номонд л ямар нэгэн нууц учир байсан юм болов уу? гэж таамагладаг.

Чех багшийн багш

Ийнхүү тэр гайтай ном дээлнээс болж айж цочсоор Чехэд ирлээ. Түүнтэй хамт сурахаар цахилгаанчин Самданг бас ирүүлсэн байв. Тэр хоёр зургаан сар чех машинууд дээр дадлага хийж, шинэ машинуудыг эзэмшээд ирэх “намын” даалгавартай. Эхлээд гутлын үйлдвэрлэлийн дэлхийд нэрээ гаргасан томоохон төв болох Готвальдов хотод хоёр сар, дараа нь Партизанск хотод дөрвөн сар дадлага хийж байлаа.

Гэвч манай хоёрын хийсэн “дадлага”-ыг дадлага гэж нэрлэхэд их хүндрэлтэй. Очтол монгол дадлагажигчийг засварын өрөө бололтой юманд орууллаа гэнэ. Халзан толгойтой өвгөжөөр чех эрийг,

-Энэ бол чиний багш Досталь гэдэг хүн гэж Доржсүрэнд танилцууллаа. Багш нь уриалгахан инээмсэглэж, шавьтайгаа гар барьж танилцаад, өнөөдөр хоёулаа хадаасны машин засна гэж байна гэнэ. Машиныг оруулаад иртэл багш өөрөө задалж, энийг ингэж тайлна, энэ эд ангийг авахдаа үүнийг анхаарах хэрэгтэй гэх зэргээр үзүүлж, зааж тайлбарлаад л байх юм гэнэ. Энэ бүхэн Доржсүрэнд уйтгартай. “Мэдээжийн юмыг л нуршаад байх юм” гэж дотроо төвөгшөөж зогсов. Арайхийж тайлбар дууссаны дараа,

-Одоо чи өөрөө задал гэлээ. Шавь ч нүд ирмэхийн зуурт задалчихаж. Досталь багшийн нүд томорч, гайхсан бололтой харж байснаа, сайн задалж байна гэлээ. Тэгтэл багшийг хүн дуудлаа. Цаана цехэд л асуудал гарав бололтой, “Уучлаарай хүлээж байгаарай” гэхчээ, явчихлаа гэнэ. Тэгтэл өнөөх машинд тавих сэлбэгүүд бололтой хайрцагтай зүйлсийг нярав бололтой хүүхэн оруулж тавьчихаад явчихав. Багшийг хүлээгээд зүгээр суултай биш машиныг үзээд, арчиж цэвэрлэгээ хийгээд, юу эвдэрснийг нь оношлоод, эвдэрсэн хэсгүүдийг нь тайлж хаяад, шинэ эд ангийг нь тавьчихлаа. Багш ирээгүй хэвээр. Цааш үзээд, тохируулга хийж байтал Досталь багш буцаад ирлээ. Тэгснээ нүд нь оройдоо гартлаа гайхах нь байдгаараа айсан бололтой.

-Чи юу хийж байна аа? гэж дуу алдлаа гэнэ.

-Энэ машины ийм эд ангиуд нь эвдэрсэн байна. Тэгэхээр нь солиод тавьчихлаа. Одоо тохируулж байна аа, багш аа гэлээ. Тэгтэл багш толгой сэгсэрч байх юм гэнэ. Үргэлжлүүлээд хий гэхчээд хараад зогсчихлоо. Машиныг нь тохируулж байхдаа,

-Бас энд элэгдсэн байна, солих хэрэгтэй. Сэлбэг авчруул гэлээ. Багш өнгийж хармагцаа дахиад л дуу алдаад толгой сэгсэрч байна. Сэлбэгийг авчруулахаар нь элэгдээд юу юугүй дуусах гэж байсан хуучныг нь авч хаячихаад, шинэ сэлбэгийг нь тавьчихлаа. Тосолгоо тохиргоог нь хийлээ. Досталь багш харж, ангайгаад нам гөлөрсөн харагдана. Энэ бүхний эцэст машин зүв зүгээр ажиллаад эхэлсэн нь мэдээж хэрэг. Досталь багш сая сэхээ оров бололтой,

-Та эндээс яв! гэж шууд хөөх нь тэр. Энэ удаа харин Доржсүрэнгийн нүд оройдоо гарав. Айсан гэдэг жигтэйхэн. Би хаачих юм бэ? Намайг энд дадлага хий гэж ирүүлсэн шүү дээ гэж учирлалаа.

-Юу яасны чинь дадлага! Та бүгдийг мэдэж байна. Танд надаар заалгаад байх юм алга. Харин ч эсрэгээрээ та миний багш болох хүн байна. Тийм учраас явж үз гэж. Хамт очсон цахилгаанчин, Доржсүрэнгийн шавь Самдан нь бас чехүүдийг гайхшруулчихсан байлаа. Самдангийн багш нь бас,

-Чамд биднээр заалгах юм алга. Ирэх дуртай бол ирээд. Ирэхгүй цагтаа хотоор зугаалж бай гэсэн байлаа. Ингээд хоёулаа ханьтай хотоор аялж, үйлдвэрээр хааяа үзэгдсэн болж цаг нөгцөөх боллоо. Хоёул гудамжаар явж, дэлгүүрүүдээр хэсч хэдхэн өдөр алхаад л уйдчихлаа.

Дэлгүүрээс уйдчихсан. Гудамжаар яваад дуусгачихсан. Хийх юмгүй өрөөндөө бүгээд, хэвтээд байлтай биш, үйлдвэр лүүгээ очоод Досталь багшийнхаа ажилд тусалсан шиг ээ зогсдог боллоо. Халзан толгойтой чех эр байн байн гайхаж, нүдээ том болгон, эрхий хуруугаа гозойлгоно. Доржсүрэнг магтаалын үгээр булж, чин сэтгэлээсээ бахархаж байгаа нь илт.



-Тоглоом биш шүү. Би танд биш, та надад багшлах юм байна! гэж үнэн голоосоо хэлнэ. Ингээд мань эрд сайхан завшаантай юм болох нь энэ. Их засварт орж ирсэн машиныг Доржсүрэнгээр засуулчихаад, өөрөө гадуур хувийн ажлаа хөөцөлдөөд алга болчихдог боллоо. Ажил тарах дөхөхөөр буцаад ирнэ. Хийсэн ажлыг нь харж, баярлаж толгой дохиж байснаа,

-Нэг юм хэлье. Ингэж хурдан хийж болохгүй ээ! Удаан ганц хоёр эд ангиар нь аажуу уужуу явуул. Бид энэ машины их засварыг гурав хоногт хийх ёстой. Гэтэл чи өдрийн хагаст дуусгачих гээд байна. Чамайг явсны дараа биднийг ийм цахилгаан шиг хурдан ажиллах нормтой болгочихвол яах вэ? Би чинь цалин авч, ар гэрээ тэжээдэг, олон хүүхэдтэй хүн гэж.

Монголдоо Үйлдвэр комбинатдаа байсан юм гэхэд, задлаад угааж цэвэрлээд, солих сэлбэгийг нь тавиад, бушуухан гялалзуулвал өдөртөө дуусчих ажил. Тэгтэл заавал гурав хоногийн

хугацааг нь хүргэх ёстой гэж чех багш нь гуйна. Байдал ийм байгаа учраас багш шавь хоёр чөлөө завтай болчих нь ойлгомжтой. Чех социалист орнууд дотроо хамгийн сайн шар айрагтай гэгддэг байсныг хэлэх үү, багштайгаа бааранд ороод шар айраг шимсэн шигээ сууна. Ажлаа хийлгэж байгаа болохоор багш нь шавиа дандаа дайлдаг байлаа. Ингэж суухдаа амьдралаа ярина. Олон хүүхдийнхээ зургийг үзүүлж, энэ нь тэр, тэнд сурч байгаа гээд л нүд нь сэргээд ирнэ. Ажил тарах дөхөхөөр буцаж ирээд, бусадтай цуг тарцгаана. Чехийн машин судлах дадлагын хажуугаар, чехийн шар айраг амтлах дадлага явагдаж эхлэх нь энэ.

Социалист хүмүүжил

Тавин долоо найман оны үед Гутлын үйлдвэр дээр Социалист хөдөлмөрийн бригад байгуулав. Бригадын дарга нь механик Доржсүрэн, гишүүд нь дандаа засварчид. Тэгтэл үйлдвэрийн захиргаа, намын байгууллагаас “Алдаж эндсэн, буруу зам руу хазайсан нэгнээ социалист хамт олон дотроо засч хүмүүжүүл” гэсэн даалгавар өглөө. Ингээд засан хүмүүжүүлэх газраас дөнгөж суллагдсан Нацаг-Ориг гэх эрийг Социалист хөдөлмөрийн бригадын гишүүнээр бүртгээд, үйлдвэрт ажиллуулах болчихсон нь хачин. Үйлдвэрийн удирдлага түүнд хандаж,

-Энэ хамт олныхоо дунд ажил хөдөлмөр хий. Социалист нийгмийн үлгэр жишээ хөдөлмөрчин иргэн болж төлөвш. Чи эхнэр хүүхэдтэй хүн. Өнөөдрөөс эхлээд хүн шиг сайн сайхан амьдрахаа бод! гэж захилаа. Настай хашир ажилчид толгой сэгсрээд,

-Ээ дээ, ийм хүний засарна гэдэг ч дээ. Худлаа даа... гэцгээнэ.

-Өөрөө засарна гэдгээ амласан. Цоо шинэ хүн болно гэж андгайлсан. Тийм болохоор алзахгүй биз дээ гэж залуучууд Нацаг-Оригийг өмөөрлөө. Ингээд нэг сар ажиллалаа. Залуу ажилдаа давгүй дадаад, болоод явчихаар шинжтэй. Бүр жил өнгөрлөө. Ямар ч дутагдал доголдол гарсангүй. Социалист хөдөлмөрийн бригад хүнийг хүмүүжүүлж чаддаг юм байна гэж бүгд итгэв. Залуус урамтай. Өнөөх муу үгээр утаад байсан хөгшчүүдийн амыг асуумаар санагдаж байж.

Наадам болж, Доржсүрэн бөх үзэхээр цэнгэлдэх рүү очив. Тэгтэл социалист хөдөлмөрийн бригадын гишүүн залуу нь тааралдаж гэнэ. Энэ тэрийг яриад хамт цааш алхав. Тэгтэл цаадах нь,

-Та хуушуур идэх үү? гэж байна.

-За яахав, хоёулаа гурав дөрвөн хуушуур идвэл идчихье гэж бригадын дарга зөвшөөрөв. Тэгтэл өнөөх нь би аваад ирье гээд цаана дугаарлаж байсан хүмүүсийн ард очоод зогсчихлоо. Доржсүрэн хүлээж зогссоноо эргэж харвал, гайхал чинь овоорсон хүмүүсийн араас нүрээд, шахаад л байх юм гэнэ. Байдал нь нэг л биш. Лавшруулаад сайн ажтал хүний халаасанд гараа хийчихсэн харагдана. Доржсүрэнгийн нүүр халуу шатаад явчихав. Цаад гайхал нь бригадын дарга харчих вий гэж айж эмээж байгаа шинж огт үгүй.

“Наана чинь хулгай хийгээд байна!” гээд хашгирья гэтэл ам ангайдаггүй. Хэлэхгүй байя гэхээр бас болохгүй. Тэвдлээ. Тэгтэл өнөөх чинь буцаад ирлээ. Байж байгаа нь хээв нэг, хэнэггүй гэж жигтэйхэн.

-Эндээс хуушуур авна гэвэл бүтэхгүй юм байна, больё. Жаахан тийшлээ. Өөр газар хуушуур байхгүй гэх биш гэж байна. Бригадын дарга мэдээж тэссэнгүй,

-Чи яаж байгаа юм бэ? Харсаар байтал улаан цайм, хүний өврөөс мөнгө суйлчих чинь..! гэлээ. Цаадах нь гөлсхийснээ, дуугүй газар ширтгээд алхаад байж. Доржсүрэн загнасаар л

байж. Тэгтэл,

-Сурсан юм гэдэг чинь хэцүү юм. Тэр хармаанд мөнгө байх нь мэдрэгдээд, авчихмаар санагдаад болдоггүй. Тэгээд л авчихлаа..., гэсэн гэдэг.

Улаан цайм ийм үг хэлээд хэнэг ч үгүй алхаж байгаа хүнд үг хэлээд яахав, ёроолгүй хувин руу ус хийсэнтэй л ижил гэж Доржсүрэнд бодогдлоо. Зэвүү нь хүрээд болохгүй, бушуухан салж холдов гэнэ. Тэгтэл өнөөх гайхал автобусанд хөдөөний хүний өвөртөлж явсан мөнгө суйлаад, баригдчихсан байх нь тэр. Сурсан юм гэдэг хэцүү байж л дээ! Хөдөө аймгаас нэгэн хүн наадамдах, наадмын үеэр зардаг ховор живэр бараа олж авах санаатай боодол хорин тавттай ирснийгээ алдчихаад сэргийлэхэд мэдэгдсэн байж. Хорин тавтын боодол буюу 2500 төгрөг гэдэг тэр үедээ том мөнгө. Ажилчин хүний зургаа долоон сарын цалинг нийлүүлэх дүн. Шинэ багц дэвсгэртүүд учраас, аймгийн банкнаас ямар дугаартай мөнгө гаргасан нь тодорхой болсон байж. Нацаг-Ориг гэнэт олдсон их олзоо тэмдэглэж, наадмын талбай дээр авдраар нь ундаа сөгнөчихөөд, согтуурч байгаад, жаахан хүүхэдтэй ундааны хэрүүл хийснээсээ болж сэргийлэгчид сэжиг төрүүлж баригдсан байлаа. Ингээд л шорондоо буцчихсан гэдэг.

“Өөрийгөө барьж өгсөн хулгайч” гэсэн гарчигтай нийтлэл тэр үеийн сонинд гарч байв. Социалист хөдөлмөрийн бригадынхан тэр гайхлыг хүмүүжүүлчихлээ гэж эндүүрсэндээ ичсэн гэж жигтэйхэн. Тэр үед иймэрхүү байдлаар алдаж эндсэн олон аавын хүүд боломж олгож, Аж үйлдвэрийн комбинатын хөдөлмөрийн хамт олны дунд оруулж ирдэг байж. Тэднээс дахиж хэрэг хийгээд буцаж шорон орондоо явсан нь ч олон бий, засарч хүмүүжээд төлөв түвшин, сайхан амьдралтай болсон нь ч бий гэдэг.

Үйлдвэрийн өргөтгөл

Чех улсын тусламжаар Гутлын үйлдвэр, Арьс ширний үйлдвэрүүдийг өргөтгөх ажил эхэллээ. Доржсүрэн Готвальдов, Партизанскийн дадлагаас буцаж ирээд чехүүдийн барьж байсан гутлын үйлдвэрийн өргөтгөл дээр ажиллав. Гутлын, торгон савхины гээд конвейерүүдээ тавьж эхэлсэн учраас үйлдвэрийн ерөнхий механикийн хувьд бүх зүйлд оролцоно. Монгол хэдэн слесарь түүний дор ажилладаг нь дандаа барилгын талын хүмүүс. Тэд голдуу барилгын цахилгааны монтаж, сантехникийн монтаж зэргийг гүйцэтгэж, чех мэргэжилтнүүд тоног төхөөрөмжөө суурилуулж байлаа.

Чехээс ачаа байнга ирнэ. Тэр бүрд комбинатын гараажаас машин авах хэрэг гарна. Санааны зоргоор тэр болгон машин нь бэлэн зогсож байхгүй. Өөр ажилд хуваарилагдаад гараад явчихсан байна. Өөрийн тэрэггүй бол амбан явахгүй гэдэг нь тодорхой. Тэгэхээр нь дээгүүр доогуур хөөцөлдсөөр яваад жолооч нарын нэрээр “Поолуу тэрэг” буюу “ГАЗ-51” машин авч байлаа. Тэргээ өөрөө барьчихаад ийш тийшээ давхиж явдаг боллоо.

Тэр үед үйлдвэрийн зориулалттай хүчилтөрөгчийг Налайхад шахаж, савладаг байлаа. Кабиндаа нэг чех суулгаж аваад, Налайх руу ухасхийгээд баллонтой хүчилтөрөгчөө дөхүүлж ирнэ. Тийшээ долоо хоногт тогтмол нэг явна. Баазад Чехээс ирж буусан янз бүрийн тоног төхөөрөмж, материалуудыг татаж авна. Овор томтой ачаа ирвэл кран хайна. Баазуудаар явж ерөнхий инженерүүдийнх нь хөлд сууж, эр хүний арван гурван мэхээр ажлаа бүтээнэ.

Чехийн шинэ машинуудыг дагалдаад бага сага ч болов сэлбэг ирнэ. Ном журмаараа бол тэрхүү шинэ сэлбэгүүдийг Аж үйлдвэрийн комбинатын агуулахад буулгах ёстой. Хэрвээ тийш нь буулгачихвал юу болохыг хашир механик андахгүй. Гутлын үйлдвэрийн нэг машин эвдэрчихлээ гэхэд захиалга бичнэ. Тэгээд хэд хэдэн дарга дамжиж цохуулах гэж гүйж, бөөн чирэгдэл, хүнд суртал болно. Арайхийж дарга нарыг олж гарын үсэг зурууллаа гэхэд комбинатын агуулахын нярвыг хайх хэрэг гарна. Гэтэл тэр нярав нь өдрийн найман цагийн ажилтай, шөнийн цагт байхгүй. Шөнө нэг машин эвдэрчихлээ гэхэд өглөөг хүлээх болно. Нярав байлаа, сэлбэгээ авлаа гээд асуудал дуусахгүй. Нэгэнт л захиалгын хуудас бичигдэж, цохогдсон болохоор Гутлын үйлдвэр мөнгө төлөх өртэй болчихно. Машинаа дагаад зүгээр ороод ирсэн сэлбэгийг дахиж мөнгө төлж авна гэдэг утгагүй.

Ийм учраас Гутлын үйлдвэрийн сэлбэгүүдийг комбинатын агуулахад буулгадгийг болиулахаар шийдлээ. Шууд үйлдвэр дээрээ авч, тусдаа агуулахтай болгоод, өдөр шөнийн хоёр ээлжийн няравтай болгож байв. Ингэснээр сэлбэг хүлээгдэхгүй, хаашаа ч илүү явдал хийхгүй, үйлдвэр зогсолтгүй ажиллах нөхцөл бүрдэж байсан юм.

Өргөтгөлийн ажилд зүтгэж, чехүүдийн дунд байнга ажилласаар байтал тэдэнтэй их дотно болчихсон хэрэг. Чехийн барилгачид, мэргэжилтнүүдийг хариуцсан хяналтын инженер Иозеф Берка гээд залуу байх. Тэр Доржсүрэнг их үнэлдэг боллоо. Асуудал гарлаа гэхэд Доржсүрэнг дуудаад энийг яах вэ гэж зөвлөлдөнө. Ийнхүү ажилласаар, Гутлын үйлдвэрийн өргөтгөлийг явуулсаар байлаа. Гутлын үйлдвэрийн хоёр барилгын хажууд зэрэгцүүлээд өргөтгөлийн хоёр давхар ягаан байшин барьж, шинэ үйлдвэртэй болохоор ажиллаж байсан нь тэр.

Нийтэд зориул

Их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн гэргий Адьяа, Доржсүрэнгийн гэргий Цэдэв хоёр Сэлбийн амралтанд цуг амрахдаа танилцаад, ойр дотно үерхдэг боллоо. Цэдэвийн бие муу, байнга л зүрх нь өвдөнө. Ингээд Цэдэв, Адьяа хоёр Шанхай хот руу хамт эмчилгээнд явлаа. Хоёр эхнэр нь эзгүй, гэр дааж хоцорсон хоёр эр хааяа биенээ дуудаад аяга тагш юм хувааж ууж, ярьж хөөрч суудаг боллоо. Гаанс зууж тамхи татсан, яхийсан хачин нүүртэй, аймаар харцтай хүн гэрт ирэхэд Доржсүрэнгийн том охин Гэрэлмаа эхэндээ айдаг байж. Гэвч энэ хүнийг ирэхээр аав нь их сайхан зантай болж, охиноо хятад хорооллын дэлгүүр лүү явуулдаг болохоор тэр хүнийг бушуухан ирээсэй гэж их хүлээдэг болчихсон нь инээдэмтэй.

-Гурван төгрөг жаран мөнгөөр нь архи аваад, хариултаар нь дуртай юмаа ав, миний охин..., гээд аавыгаа таван төгрөг өгөхөд, охин гэрээс ойрхон хятадын хороололд байдаг дэлгүүр лүү ухасхийнэ. Хариултаар нь хорин мөнгөний үнэтэй модны бор бохь, хатаасан жимс гэх мэтийн зүйлс аваад их баяртай ирдэг байлаа. Найрагч, механик хоёр заримдаа зэгсэн сайн халамцдаг байснаас, Явуухулангийн хүү Энхээ нь аавыгаа ирж авна. 18 дугаар сургуульд сурдаг тэр хүүг Гэрэлмаа танина.

Нэг өдөр эхнэр эзгүй хоёр эрийн яриа уран бүтээл, яруу найраг руу шилжчихлээ. Эхэндээ Доржсүрэн,

-Би зохиол мэднэ гэх биш. Төмөр байвал харж шинжээд, аятайхан төмөр юм даа, цоож хийвэл болмоор юм гэхсэн. Шүлэгний тухай юу ярих вэ? зөрүүдэллээ.

-Яруу найраг гэдэг чинь хүний зүрх сэтгэлээс төрдөг дуулал. Чамд ч гэсэн Цэдэвийг хайрлах сэтгэл бий. Зүрх бий. Миний бичсэн “Би чамд хайртай” дууг сонс гээд Явуу найрагч шүлгээ уншлаа.

...Атар хээрийг чимэглэсэн

Алаг цэцгэнд би дуртай

Ариун хайрыг минь булаасан

Адьяа чамдаа би хайртай... гэх зэргээр дууныхаа дөрвөн бадгийг бүгдийг нь уншиж дуусгаад найрагч, механик руу додигор харлаа. Наад хүн нь харин уярсан шинж огт үгүй суух нь гомдмоор.

-Ямар байна? Чамд таалагдахгүй байна гэж үү? гэхэд, механик шулуухан,

-Таалагдахгүй байна..., гэхихлээ. Гэргийгээ санасан зовлон нэгтэй найзынхаа шүлгийг ингээд шууд унтраачих гэж байх уу? Явуу найрагч доош харж, гаансандаа тамхи нэрж, гомдож байгаа гэдэг нь илт. Чимээгүй боллоо.

-Чи наад дуугаа нийтэд зориулсан дуу болго. “Адьяа чамдаа” гэхихээр би бас хайртай хүндээ зориулж дуулж болохгүй биз дээ, аан? гэж Доржсүрэн учирлахад харин цаадахынх нь царай

шал өөр болчихлоо. Хэсэг бодоод,

-Хайртай бүсгүйнхээ нэрийг шууд оруулсан шүлэг дэлхийд ч, Монголд ч олон бий. Ардын аман зохиолд ч бий. Жишээлбэл чи Дүүриймаа дууг дуулахдаа Цэдэв болгож үгийг нь засдаггүй байх аа? Дүүриймаа гэдгээр нь дуулаад болоод л байдаг биз дээ? гээд л найрагч шүлгээ өмөөрч, хоёул маргалаа. Зургаа долоохон настай охин нь “Амраг, хайр гээд л, аав энэ хүнтэй ямар ичмээр юм яриад байна аа?” гэж бодоод гэрээ цэвэрлэн зогсож байж.

Удалгүй Явуу найрагч өнөөх шүлгэндээ ая хийлгээд, ноттой нь хамт дугтуйлаад, Шанхай руу Адъяадаа илгээчихлээ гээд ирж байж. Амрагаа санахын зовлонгоор дотноссон эрчүүд энэ сайхан үйл явдлыг тэмдэглэж дахиад л оройттол суулаа. Доржсүрэнгийн зургаан ханатай том цоохор гэрийн баруунтай байх бичгийн модон ширээний ард хоёул дундаа шил юм тавимагц яриа хөөрөө өрнөөд л явчихна. Тэр ширээг ерөнхий механик төсөв төлөвлөгөө гаргах ажлаа гэртээ хийх бол сууж байх гэж бас л өнөөх хятад мужаанууддаа захиалж хийлгэж байж. Явуу найрагч тэр үед Горькийн утга зохиолын дээд сургуулийн оюутан байсан бөгөөд удалгүй сургуульдаа сурахаар Москва руу буцаад нисчихэж. Гэрэлмаа охин бохь, жимсний мөнгөтэй болгодог хүн ирэхээ больчихсонд дурамжхан байсан гэдэг.

Дараа зун нь Сонгинын амралтанд амарч байхдаа яруу найрагч Гайтав гуайтай танилцаж байлаа. Их найрагч,

-Аугаа Лениний тухай найраглал бичиж байгаа. Одоохондоо “Ленин бидэнтэй” гэж нэрлэчихээд байна гээд л амралтын өвлийн байрны люкс өрөөнд ганцаараа сууж байна. Өрөөгөөр нь энд тэндгүй шидэлсэн хуудас цааснууд. Бүтэн хуудсан дээр хоёр гуравхан үг бичээд хаячихсан. Төмрөөр юм хийж байгаа гэж сэтгэвэл хайран материал гэж харуусмаар. Том гэгч төмөр хавтангийн голд ганц жижигхээн түлхүүрний бэлдэц эсгэж аваад л хайр найргүй хаячихсан гэлтэй. Ширээн дээр задархай улаан тамхи байх агаад тэр дүнснээсээ сонинд хааш яаш ороож татаад л. Архиа хүртээд л сууна.

-Энэ их цаасаа хамж авдаггүй юм уу? гэхээр ихэд сандарч,

-Хүрч болохгүй шүү! Санаа бичсэн юм! гээд хэний ч гарыг хүргэхгүй. Тэгж байтал Явуухулан зохиолын мөнгө авсан гээд авдар архи, хажуугаар нь өчнөөн шар айрагтай амралтанд буулаа. Гайтавыгаа эргэж байгаа нь тэр. Оройд дуудна. Очихоор л архи сөгнөөстэй. Доржсүрэнгийн зан хөдлөөд,

-Та нар чинь зохиолоо хэдийд нь бичдэг улс вэ? гэж ууртай асуугаад тэдний элгийг хөшөөх дөхөж байж. Тэгтэл хэдхэн хоногийн дараа Цэгмидийн Гайтавын “Ленин бидэнтэй” хэмээх найраглал радиогоор уншигдаж байсан гэдэг. Их найрагчийн бичиж байгаа найраглал нь урагшаа ахина гэдэг тун эргэлзээтэй байсныг Доржсүрэн санаад, “Хэдийдээ бичиж амждаг байна аа?” гэж гайхаж байж.

Чехүүдийн буян

Тавин найман он гараад, яагаад ч юм цахилгаан их тасалдах болов. Байсгээд л тас харанхуйлаад явчихна. Тог тасарсан үед олон лаа зэрэг асааж гэрэл гэгээтэй суух гэсэндээ Доржсүрэн гэртээ тохой илүү өндөр, зургаан лаа ордог сууртай, гоё тавиур урлаж тавьсан байж. Долоохон настай хэрнээ охин Гэрэлмаа нь бага дүү нараа асарч, гэрээ цэвэрлэж, түлээгээ оруулна. Аяга тавгаа гялалзтал угааж, авдар шүүгээнийхээ тоосыг арчина.

Нэг өдөр Гэрэлмаа гэрээ цэвэрлэж байтал тог тасарчихаж. Том тавиуртай лаагаа асааж бариад гал тогооны шүүгээгээ үргэлжлүүлэн арчиж эхлэв. Нэг хартал унинаас зүүсэн шанага халбага хийдэг, цацагтай гоё уутанд нь гал авалцаад шатаж эхэллээ. Дүү нар нь айж уйлаад сүйд майд. Сандраад алчуураараа цохиод байтал гал улам ихсээд байхаар нь яахаа ч мэдэхээ больсон охин чанга орилон уйллаа. Гал улам ихсэж дотуур цагаан бүрээсэнд авалцлаа. Аюул болох дөхөж байтал хажуу айлын эхнэр орж ирж, ус цацаж галыг унтрааж өгөөд, раам хаалга онгойлгон гэрээр нэг тархсан утаа майг гаргав. Ажлаасаа оройтож ирсэн аав нь гэрийн зүүн тал, гал тогооны шүүгээ хавийн хэсэг нилдээ шатаж, пад хар нүүрс болсныг хараад дуу алдав.

-Яаж байгаа юм бэ? Гэр орноо ийм болгочихдог.! гэж ууртай хэлснээ, бүлгийтэл айсан охиноо хараад, гараа түлснийг нь анзаарч тэвэрч авлаа.

-Миний охин зүгээр үү? Битгий уйл, энэ гэр яах вэ, хүүхдүүд минь л түлэгдчихээгүй бол боллоо..., хэмээн охиноо аргадаж, өөрөө ч уйлж, нулимсаа мэлтэлзүүлсэн гэдэг. Нэг хоногийн дараа хяналтын инженер Иозеф Берка,

-Танай гэр шатах дөхсөн юм уу? гэж асууж байна. Доржсүрэн, охин нь гэрээ цэвэрлэж байгаад бяцхан гал алдсан тухай, сүр бадруулаад байх юм болоогүй тухай учирлав. Гэвч энэ бүхэн гадаад хүний хувьд аймшигтай зүйл гэдэг нь мэдээж. Долоохон настай охин гэрээ дааж үлдээд, ойр ойрхон төрсөн жаахан дүү нараа асардаг. Чүдэнз зурж лаа асаадаг, бас пийшинд гал түлж гэрээ дулаацуулдаг гэхээр чех эрийн санаанд яагаад ч багтсангүй.

-Эсгий гэрт түймэр асвал тавхан минутад шатаад, үнс л үлддэг гэсэн. Ийм аймшигтай эрсдэл дунд хүүхдүүдээ үлдээж болно гэж үү? хэмээн гадаад залуу халаглаж, толгой сэгсэрч байж. Үйлдвэрийн өргөтгөл дээр ажиллаж байсан чехүүдийг хариуцсан инженер Берка гэх энэ залуу Доржсүрэнд их сайн. Урьд өмнө огт харж байгаагүй машинаа торох юмгүй шууд л задлаад, юу нь болохгүй байгааг оношлоод, тэр дор нь засчихдаг авьяас билэгтэй монгол механикийг биширдэг учраас л тийнхүү хүндэтгэлтэй дотно ханддаг байсан болов уу.



Яг энэ үед өргөтгөлийн ажил дуусах дөхөж, үйлдвэр комбинатын есдүгээр байранд аж төрж байсан зарим мэргэжилтэн буцаж эхэлсэн байж. Нэг өглөө Берка “Домин бушуухан хүрээд ир!” гээд дуудуулсан байх юм гэнэ. Доржсүрэн гэх хэцүү монгол нэрийг тэд хялбарчилж “Домин” гэж дууддаг байлаа. Яваад очтол, бүх чехүүдийг айлгадаг том дарга,

-Маргааш байранд ор! гэж байна. Өмнө жилүүдэд байр хүссэн өргөдөл өгч үзсэн ч дарга нар “Байр ховор. Хүрэлцээ муутай” гээд зөвшөөрдөггүй байсан болохоор гайхлаа.

-Ямар байранд вэ? гэж өөрийн мэдэлгүй асуучихаж.

-Юу ямар гэж? Хүн амьдардаг байранд орно! гэж дарга эгдүүцсэн өнгөөр хэллээ. Мань эр Доржсүрэнд уурласандаа биш жирийн механик, слесарь ажилчдадаа байр өгдөггүй хэрнээ өөрсдөө тохилог дулаан байранд тав тухтай сууцгаадаг монгол дарга нарт зэвүүцсэндээ тийнхүү асар эгдүүцсэн өнгөөр “Хүн амьдардаг байранд орно!” гэж хэлсэн юмсанж. Маргааш өглөө нь Доржсүрэн “Үйлдвэрийн дарга нарыг Берка ятгаад, манайхыг байранд оруулах болчихсон юм болов уу?” гэж битүүхэн горьдсоор чех дарга дээрээ яваад очиж. Тэгтэл,

-Байрыг чинь үзүүлнэ гээд хөтлөөд алхчихлаа гэнэ. “Гадаадын мэргэжилтний” гэдэг тодотголтой есдүгээр байр луу дөхөж ирээд, хэрэг бишдэж байгааг мэдрэв.

-Энэ гурван өрөө байранд орно оо. Энд байрлаж байсан манай мэргэжилтэн одоо буцна. Чи шууд л зөрөөд орчих! гэх юм гэнэ.

-Зөвшөөрөлгүй юм чинь бүтэхгүй. Би энэ байранд орж чадахгүй! гэж залуу толгой сэгсэрч, хөтөлж сураагүй даага шиг хойш ухран чарлаа.

-Домин минь. Чиний жаахан хүүхдүүд эсгий гэрт, чүдэнз зурж лаа асааж байгаад шатаад үхчих вий гэж би айж байна! Чамайг заавал байранд оруулж байж л миний санаа амарна гэж чех залуу ууртай хэллээ. Берка дарга шууд л чехүүддээ тушаал өгч, машин гаргаад, Доржсүрэнгийн эд хогшлыг нүүлгэж ирээд, өнөөх байранд тарааж тавиад, түлхүүр атгуулчихлаа гэнэ. Байдгаараа айсан залуу дэмий л “Дарга нарт алуулж дээ. Яана даа?” гэж дотроо халаглаж зогсов. Үдээс хойшоос нь эхлээд л бөөн хэрүүл шуугиан дэгдэх нь тэр!

-Үйлдвэрийн ерөнхий инженер орох гэж байсан байранд дур мэдэн дайрч орлоо. Яасан том толгойтой нөхөр вэ? хэмээн загнаад, хөөж гаргах юм болцгоов. Тэгтэл Берка дарга Домин механикаа өмөөрч,

-Дарга хүн сууж болдог, ажилчин хүн сууж болдоггүй байр уу? гэж зарга хийн дарга нарын өрөөнд давхиж очив. Буцаж ирээд,

-Домин битгий гараарай. Суугаад л бай. Бүр болохоо байхад би чамайг өмөөрнө гэчихээд яваад өгч. Маргааш нь орон сууцны комендант хөөхөөр ирж, бөөн бичиг цаас үзүүлж, механикийн эхнэр хүүхдүүдийг айлгаж бүлтэлзүүллээ. Сайн хүн санаагаараа гэгчээр Берка ороод ирж. Өнөөх мундаг бичиг сачигтай комендант гөлсхийв. Юу ч хэлж чадахгүй таг болоод, чех даргын ширүүн харцнаас далдичсаар гараад явчихаж. Залуу бүр ч их уурлав гэнэ.

-Эд нарт яасан ч бууж өгөхгүй! гэж ууртай хэлчихээд явж. Ингээд арваад хоног байрны зарга болж, “Хань, үр хүүхдээ айлгаж чичрүүлж байхаар гардаг ч юм уу?” гэж бодож байтал чимээ шуугиан намжив. Ингэж л чехүүдийн буянаар байранд орсон түүхтэй. Гадаадын мэргэжилтнүүдийн байр болохоор комбинатын бусад байрнуудаас шал өөр. Халуун устай, угаалгын өрөө, 00 нь тусдаа. Тийнхүү нэг л өглөө тухайн үеийнхээ жишгээр сайд дарга нарын хангамжтай амьдардаг боллоо!

Гурван өрөө байртай болсны хэрэг юу билээ, хятад мужаанаар хийлгэсэн эрээн модтой зургаан ханат цоохор гэрээ сүүлд нь Гомбо ахдаа өгч байв. Хоёр гурван жил чийгтэй амбаарт хураалгаастай байсан гэр нь их хааны нутагт баригдах нь энэ. Насанд хүрсэн эр хүн унийг нь бараг л дааж ядан өлгөдөг, битүү цоохор гэрийг Батширээт сумын ард олон шагшин гайхаж, хэдэн сардаа яриа болж байсан гэдэг. Ямар сайндаа л буриадууд хоорондоо, “Хүргэн Гомбын дуганыг очиж үзье” гэж ярилцаад, үзэх гэж хаа холоос зорьж ирцгээж байхав дээ. Дараа жил нь очвол ах нь гэрийн мөөртэй шалыг нь угсарч чадахгүй байна гээд пүнзэндээ хураачихсан, хаалга нь даагдахгүй юм гээд өөр хаалга барьчихсан байж. Ахынх нь хүүхдүүд тэр гэрийг одоо ч барьж, хэрэглэж байгаа гэдэг.

Берка барилгын инженер мэргэжилтэй хүн байж. Монголд ажиллаж байгаа Чех улсын бүх мэргэжилтнүүдийг хариуцна гэдэг залуу хүнд ахадсан гэхээр том алба. Чехүүд түүнээс айна гэж ухаан алдчихна. Түүний үг бол хааны зарлиг. Байранд ороод жил болж байтал барилгачин чехүүд багаж материалаа бариад, ороод ирлээ гэнэ. Айл андуурсан юм болов уу гэж гайхлаа.

-Танай байрыг засна.

-Яалаа гэнэ ээ? ...Хэн зас гэсэн юм?

-Бид мэдэхгүй ээ. Берка дарга зас гэсэн!

Ийм яриа гэрийн эзэн, барилгачин чехүүдийн хооронд болоод, өнөөдүүл шууд л ажилдаа орж явчихаж. Хотолзсон муу шалыг нь ховхолж хаяад, гадаад хийцийн зузаан хулдаасаар битүү хулдаасаллаа. Ханын шавар шохойг янзалж, одооны хэллэгээр бол супер засвар хийж өгөөд явж байж.

Гадаад байрны дотоод айл

Хоёр мундаг эрээн авдартай, хоёр зуун тавийн бөмбөлөгтэй цагаан ор тулчихсан, ор хөшгиндөө дэгжин цагаан хатгамал унжуулсан, зургаан ханатай битүү цоохор модтой гэртэй, комбинатын орчимд байхгүй гоё айл байсан бол байранд ороод нэг л биш болчихлоо. Тэдний орсон есдүгээр байр хожим дал наяд онд олноор баригдсан угсармал сууцуудыг бодвол их өндөр таазтай, маш том өрөөнүүдтэй. Тийм уужим цэлгэр өрөөнд тавьсан хоёр арслантай авдар нүдэнд торохгүй. Гэрт тавих зориулалтаар урласан оройноосоо тайранхай намхан шүүгээ нь унтлагын өрөөний буланд одой хүнийх шиг бяцхан харагдана. Гэрт чимэг болдог дөрвөн цагаан ор нь байшинд зохицохгүй, өрөөнүүд хоосон ханхай оргино.

Гэргий нь энэ байдлыг анзаарч, “Шинэ тавилганы юм бодно байгаа?” гэж санаа зовнисон бол ерөнхий механикийн толгойд үйлдвэрийн хэдэн машинууд нь эргэлдээд гэр орноо өөд татах тухай бодох завгүй, “Тэгж байтал болчихно доо” гээд л хэнэггүйхэн алхаж явж. Гадаад мэргэжилтний байранд нүүж ирсэн дотоод ажилчин айл чехүүдийн нүдэнд даржин харагдсан нь мэдээж. Тэд Домин найздаа тусалж, тавилга хэрэглэлээсээ өгч эхэллээ. Данх сав бүх зүйлээсээ илүүчлэх гэж гүйлдэнэ. Нутаг буцаж байгаа чех найз нь мебель шүүгээгээ өглөө. Бас нэг нь угаалгын машин оруулж тавилаа. Мөнхийн завгүй, их ажилтай аав шөнө оройтож ирэхэд, охин өмнөөс нь гүйж очоод,

-Аав аа, манайх угаалгын машинтай болсон! гэж баяртай хашгирлаа. Гэтэл аавд тийм ч сонин биш байгаа нь урам хугармаар. “Аан..?” гээд сүрхий харснаа, гал тогоондоо ороод хоол цай гээд суучихлаа. Охин хоол ундыг нь ойртуулж, аавынхаа хөлд нь суун, яаж ажиллуулахыг нь зааж өгөхийг гуйлаа. Гэртээ гоё юмтай болсондоо учиргүй баярлаж, хоол идүүлэхгүй шалгаах охиныхоо гуйлтыг аав хойшлуулж, “Өглөө зааж өгье” гэчихлээ.



Охин баярлахаас ч аргагүй. Угаалгын машинтай айл Улаанбаатарт өдрийн од шиг цөөхөн, сайд дарга нарын гэргий л тийм тансаг юмыг хэрэглэдэг, дэлгүүр хоршоонд их үнэтэй ирдэг болохоор тэр бүр энгийн ажилчин айл дийлж авддаггүй байсан үе. Тавиад оны угаалгын машин гэхээр инээдтэй юм байх. Хоёр хүн дамжилдаад чүү чаамай даахаар хүнд төмрөөр хийгдсэн, хувцсаа хатаахдаа одооных шиг төвөөс зугтаах хүчний үйлчлэлтэй бортгонд эргүүлэх биш хоёр ганж шиг юмны хооронд хавчиж гараар мушгин, булчингийн хүчээр усыг нь шавхардаг бүдүүлэг талдаа эд.

Шөнийн дөрвөн цагт үйлдвэрийн дамжлагад эвдрэл гарснаас яаралтай дуудлага ирж, Доржсүрэн буцаад явчихаж. “Хувьсгалын” эвдэрсэн машинтай өглөө болтол ноцолдсон болохоор, хувийн угаалгын машинаа таг мартаад, буцаж ирж цайгаа ч уусангүй шууд маргаашийн өдөр тутмын ажилдаа орж, шуурхай хурлаа хийхээр суучихаж. Шөнө дуудлагаар ирсэн слесариуд засвар дээрээ үргэлжлэн ажилласаар л, албаны ажил ундарсаар л байж.

Аав ийнхүү завгүй байх хооронд, охин угаалгын гоё машинаараа хувцсаа угаахсан гэж тэсч ядав. Доржсүрэнг орой ирэхэд нь охин паянтай угтлаа. Өмнө гэрээ түймэрдэх дөхсөн бол энэ удаа өөрийгөө тогонд цохиулж аюул болох дөхсөн байлаа.

-Нойтон гараараа хэзээ ч цахилгааны утас барьж болохгүй! гэж завгүй аав охиндоо хэлээд, өнөөх сүрхий машиныг яаж ажиллуулахыг зааж өгч байлаа. Тэр үеийн гэр ахуйн хэрэгслүүдийн цахилгааны тусгаарлалт муу хийгддэг байснаас тэр үү, бүгдээрээ тог цохидог муу зантай. Плиткээ гал тогооны угаалтуурын хажууд тавьчихсан нь бас л тог цохино. Хоол хийж байгаад угаалтуураас ус гоожуулах гэвэл “д-р-ррр-хийн” салгалаад л, гар наалдаад л явчихдаг. Охин нэг удаа тогонд цохиулаад гал тогоондоо муужирч унасан удаатай.

Удалгүй бас нэг чех айл буцаж, Гэрэлмаа охин тоос сорогчтой болж дахиад л бөөн баяр боллоо. Түрүүчийн явдлаас сургамж авч хаширсан аав нь хэрхэн яаж ажиллуулах, соруулдаг сойз хоолойнуудыг хаана нь залгах, хогийн уутыг нь дүүрчихвэл яаж авч цэвэрлэхийг сайн гэгч зааж өгөв. “Нойтон гараараа хүрэв ээ! Тог цохино шүү!” гэж хэд дахин хэлж анхаарууллаа. Гэвч охин дахиад л адал явдалтай угтав. Гэрээ соруулах гээд тоос сорогчоо залгатал сорох биш үлээгээд, хана тааз бүх юмаа хог тоосоор будчихаж. Айсандаа ханаа угаах гээд обойгоо халтартуулаад хачин юм болгочихсон байх нь тэр. Дээр үеийн тоос сорогч гэгч буруу угсрахаар буцааж үлээдэг адармаатай эд байж.

Түүнээс гадна чехүүд Пельзински шар айргаа бүтэн авдраар нь оруулж өгнө. Доржсүрэн салдаггүй найзууд Самдан, Цагаан хоёроо дуудаж дайлна. Мотоспортын тамирчин найзуудаа ч урьж залж, бяцхан найр хийхдээ тулна. Чехийн Пльзень хотоор нэршсэн энэ алдартай пиво бусад хүний хувьд ховор олддог тансаг идээ байж. Хэн хүний уугаад байдаггүй ундааг сөгнөөд найз нөхөд ярьж хөөрч, инээлдэж хөгжилдөн оройттол сууцгаана. Тэр үеийнхэн гэдэг одооных шиг цагт баригдсан, ийш тийш яарсан хүмүүс байсангүй. Бие биенийдээ зочилж, олдсоноо хувааж хүртдэг, жаргал зовлонгоо хуваалцдаг нийтэч улс байж.

Соёлын довтолгоо нүргэлсээр л

Ээж аав, хүүхдүүдийн хөгтэй адал явдлууд дуусахгүй. Өдөр хоног өнгөрөх тусам л шинэ паян нэмэгдсээр, элэг хөшөөсөөр байх нь зугаатай. Нэг орой ээж нь гал тогооноосоо гарч ирээд,

-Ээ, цаасаа шатаачихсан юм уу? Надад хэлэхгүй дээ. Яаж байгаа юм бэ? гээд л халаглаад байх юм гэнэ. Хүүхдүүд нь юу ч ойлгосонгүй.

-Цаас шатаахын төлөө таниас юуг нь асуух вэ? хэмээн Зоригт гайхлаа.

-Та хэрэгтэй бичгээ пийшинд хийчихээ юу? гэж нэг нь асуулаа. Ээж нь харуусаад л шогшроод байсан хэрнээ хүүхдүүддээ учраа хэлдэггүй. Аав нь болохоор нуг нугхийн инээдээ барьж ядаад л суугаад байх. Хүүхдүүд шалгаасаар байж, аав ээж хоёрынхоо нууцыг хэлүүллээ.

Тэгтэл бас нэг хөгтэй явдал нэмэгдсэн байх нь тэр. Ээж нь чихэрт дуртай. Дөчин наймын гэж нэрлэдэг тансаг чихэр идэх бөгөөд хүүхдүүдийнхээ шүдийг хайрлаад, тэднээсээ тас нууна. Хаана л нууна, хүүхдүүд олчихоод байдаг учир даавуун ууганд хийж, огт санаанд орохооргүй газар хадгалах санааг Доржсүрэн сэдсэн байж. Хүүхдүүд ажиг сэжиг авахгүй, наанаас нь цаас чихээд л. Ээж сэмхэн гал тогоо руу орж, пийшингээ дээрээс нь онгойлгон, дотор нь нуусан чихрээсээ авч идээд л яваад байсан болж таарав. Тэгтэл тэр гайтай өдөр цаас дүүрчихсэн байхаар нь Зоригт хүү гал асаачихсан хэрэг. Хоёр килограмм шахам амттай тансаг идээ нүүрс болчихсон учраас ээж тэгтлээ харууссан байлаа.

Аяга шаазан арчдаг марль нүдний гэм. Ховрын бараа болох бөгөөд хоёр метрийг олж аваад цоо шинээр нь хадгалж, шалгалт ирэхээр нь үзүүлнэ. Шалгалтын комисс айлуудаар явах сургаар ээж охин хүү гурав гэрээ жигтэйхэн цэвэрлэцгээв. Гал тогоо, угаалтуур, 00, зочны унтлагын өрөөнүүдээ гялалзтал угаагаад, шалгадаг юмнуудыг нь бэлдэж тавих гэтэл аяганы марлиа хайгаад олдоггүй. Хаалга дуугарахаар, “За ирлээ яана аа” гэлцээд л. Цэдэв, Зоригт, Гэрэлмаа гурвуулаа шүүгээ саваа онгичиж, гэрээ урвуулж хөрвүүлэх дөхөв. Аргаа бараад байтал ээж нь марлиараа толгойгоо ороочихсныг Зоригт харж, гурвуулаа элгээ хөштөл инээлдсэн гэдэг. Ээж нь охиноо учиргүй загнаад л, “Марлиа хаашаа хийчихдэг байна аа? Чи л алга болгосон” гэж үглэж байсныг яана.

Тавь жараад онд соёлын довтолгоо үргэлжилсээр, ажилчдын гэрээр явж, ор хөнжлийн даавуу, оймс дотуур хувцас тоолж, аяганы марль ариун цэвэр соёлжилт шалгасаар л байсан нь энэ. Айлууд шоо хээтэй цагаан даавуун алчуураа шинээр нь хадгалж, орны шинэ даавуунуудаа шалгалтынханд үзүүлэх гэж хайрлаад нөмрөхгүй. Нам эвлэлийн идэвхтэн сонгуультан, эмэгтэйчүүдийн зөвлөл, үйлдвэрийн захиргааны төлөөлөл орсон тусгай комисс явж үзлэг шалгалт хийгээд, муу гарсан ажилчныг хурал дээр донгодож, ханын сонинд бичдэг байсан учраас үзлэгийн сургаар айл бүхэн байлдааны өндөржүүлсэн бэлэн байдалд шилждэг байж.

Орон сууцны асуудал

Шуурхай хурлын дараа үйлдвэрийн дарга Доржсүрэнг авч үлдээд хууч хөөрч удаан гэгч суув. Чихэртэй халуун цайгаар дайлах зуураа, “Танай есдүгээр байр ч сайхан том өрөөнүүдтэй шүү. Цэлийсэн гурван өрөөнд та хэд биенийгээ бараг л олдоггүй байлгүй дээ?” гээд л хошигнолоо. Дарга нэг ноцтой юм тулгах гээд л цаг уур зөөллөөд, тохироог нь бүрдүүлэх гээд байгааг механик гадарлалаа. “Юу гуйж халаадаг бол доо?” гэж бодож суув. Нээрээ л бодсоноор болж, дарга хялбар биш юм гуйлаа.

-Хөдөөнөөс элсүүлсэн олон ажилчин орох оронгүй, байх айлгүй хэцүүдэж байна. Танайх хажуу өрөөндөө түр байлгаач. Өрөөнүүд чинь том болохоор та хэд хоёр өрөөндөө байчихаж болно шүү дээ..? гээд дарга гуйсан харцаар ширтлээ. Гэрийн эзэнд өөрт нь бол цааргалаад байх юу байхав. Гэргий Цэдэв нь “Үйлдвэрийн захиргаанаас хэлж байгаа бол хүн байлгая даа” л гэнэ. Харин гэрээ цэмцийтэл цэвэрлэж байж л санаа амардаг зантай, том охин эрс эсэргүүцнэ гэж бодогдоод чимээгүй эргэлзлээ. Доржсүрэнгийн нүүрний хувирлаас зөвшөөрөхгүй нь гэж ойлгов бололтой даргын царай барайчихлаа. Ажилчдын орон сууцны асуудал ямар хүнд байгааг мэдсээр байтлаа даргыгаа зовоогоод чимээгүй суух нь хүн чанаргүй санагдаад, “Дүүрсэн хэрэг, өөрөө мэдээд хариу хэлчихье” гэж шийдлээ.

-Яахав дээ, хүн байлгавал байлга даа.., гэчихлээ. Даргын царай гэрэлтээд л явчих нь тэр.

-Чамайг ойлгоно гэж мэдсэн юм аа. Хоёрхон хүн л оруулна. Түр хугацаанд шүү дээ. Тун удаахгүй! гэж уухайн тас дуу алдлаа.

Ингээд л Шаравжамц, Дамба гэх хөдөөний хоёр эр, нэг нэг төмөр ор чирээд ороод ирэх нь тэр. “Гутлаа үргэлж арчиж орох. Угаалтуур, суултуур цэвэрхэн хэрэглэх..” гэх зэрэг том охины болзлыг танилцуулж, хамтдаа амьдарцгаалаа. Удаагүй байтал өнөөх хоёр эр плиткээ хар нүүрс болтол шатаачихаад коридорын ханын шүүгээнд нуучихсан байхыг “гэрийн ариун цэврийн дарга” охин илрүүлэв. Өрөө рүү нь шагайж үзвэл плиткээ шатааснаар зогсоогүй гал авалцуулаад хана таазаа харлуулаад түймэр тавьчих дөхсөн болох нь илт. Орой аавыгаа ирэхэд охин,

-Энэ хоёртоо хэлээч! Өрөөний хана тааз авах юмгүй түймэрдчихэж. Чехүүд ямар гоё болгож засч өглөө дөө! гэлээ. Аавыгаа тэр бүтэлгүй хүмүүсийг зад загнана даа гэж охин бодож. Тэгтэл,

-За яах вэ. Галын дөл өөдөө гэдэг юм. Байр шатаачихаагүй л бол яахав, гэж байж. Төрсөн охиноо долоохон настай жаахан байхад нь гэрээ шатаачих шахлаа гэж загнаж байсан хүн шүү дээ! Гэтэл ийм үг хэлээд юу ч болоогүй юм шиг өнгөрөөчих нь энэ. Ховдоос ирсэн Шаравжамц нь наадхаа бодвол настай. Тэр л бүтэлгүйтээд плиткээ залгаатай мартчихсанаас хамаг юмаа шатааж, түймэр тавих дөхсөн байж.

Хоёрын хоёр хэнэггүй гудиггүй эр хүн угаалтуур, 00-ийн өрөөг яаж бохирдуулдаг, охин нь энэ бүхнийг яаж цэвэрлэж байдгийг харсаар байгаа ч, аав мэдээгүй дүр эсгэхээс аргагүй. Орон сууцны асуудлыг ингэж шийдэхээс өөр замгүйг дарга хүн өөрөө ойлгох ёстой. Ийнхүү

амьдарсаар удлаа. Шаравжамц орон нутагт ажлаар яваад, тэндээсээ хөдөөний бор авгай дагуулаад ирэв. Хажуу өрөөнийхөн бүл нэмчих нь энэ. Аав ээж хоёр аанай л “За яах вэ” гээд сууцгааж байж. Өрөөгөө түймэрдэх шахдаг нөхөр тийнхүү Доржсүрэнгийн гал дээрээс өрх тусгаарлаж гэр барин гарч байж. Харин нөгөө эр нь үлдлээ. Ногоон Дамба гэж ажилчид цоллодог, Гутлын үйлдвэрийн эсгүүрчин нийтийн бүжгийн хорхойтой. Гутлын улаа цоортол вальс эргэж, нийтийн бүжиг хэссээр, шөнө дунд өнгөрсөн хойно голцуу ирж, хаалга үүд тар нярхийлгэх нь төвөгтэй. Тэглээ гээд Доржсүрэн, Цэдэв хоёр нэг ч удаа үг хэлэхгүй. Хажуу өрөөний хүн ийнхүү удлаа. Үйлдвэрийн захиргаа түр байлгана гэсэн хүнээ бүр байлгачих нь энэ.

Аравдугаар анги төгсмөгцөө Хувьсгалт залуучуудын эвлэлийн илгээлтээр оёдолчин болсон, хэдэн жил сайн ажиллаж өөрийгөө харуулсан, тэргүүний залуу ажилчин яг энэ үед үйлдвэрийн захиргаанд орон сууцны асуудал тавьсан байлаа. Саяхан хоёр дахь хүүгээ гаргасан Рэнцэнханд гэх бүсгүй нөхөртэйгээ дөрвүүлээ эцэг эхийнхээ таван ханатад шахцалдаж буй зовлонгоо хэлж ирсэн нь энэ. Гэрт нь бас дүү нар нь хамт байдаг болохоор өрх тусгаарлая гэж хүсэх нь түмэн зөв. Дарга нар үгүй гэх аргагүй. Гэтэл байр сууц байхгүй. Доржсүрэн Рэнцэнхандыг ажилд ороход орлогч дарга байсан болохоор түүний амьдралыг андахгүй. Нөхөр нь Гүрбадам гэх их хөдөлмөрч, өнчин залуу гурван жил цэргийн алба хааж ирээд, гутлын үйлдвэрт ажиллаж байснаа жолооч болсныг мэднэ. Тийм болохоор “Рэнцэнхандыг танай хажуу өрөөнд оруулья” гэж даргыгаа хэлэхэд үгүй гэж яагаад ч чадаагүй гэдэг.

Ингээд залуухан эхнэр нөхөр, хоёр нялх хүү, бас дахиад нэг гоонь эр гээд тавуулаа хажуу өрөөнд нь дажигналддаг болох нь тэр! Дамба хөөрхий, хэцүүдсэн нь мэдээж. Төд удалгүй гарч, өрөөнд залуу гэр бүл үлдлээ. Рэнцэнхандын нөхөр хотын дарга Балбар гуайн жолооч учраас байнга оройтож ирнэ. Эхнэр нь ч бас үе үе оройтно. Цэдэв хоёр хүүхдийг нь өөрийн юм шиг хооллож ундлаад, хүлээж байна. Рэнцэнхандыг ч бас,



-Ингэж оройтсон хүн хоол бэлдэнэ гэж юу байхав. Манайд ор. Хоол ид гэнэ. Бүсгүй “Айлын өрөөнд байчихаад. Бас хоолыг нь хороогоод...” гэж санаа зовно. Аль болох л оройтохгүй юмсан гэж мачийх боловч социалист хөдөлмөрийн бригад нь “Төлөвлөгөөгөө зуун гучин хувьд хүргэж, давуулан биелүүлнэ” гээд шахуу үүрэг амлалт авчихсан болохоор илүү цагаар суухаас аргагүй. Одоо дал шүргэсэн настай болсон Рэнцэнханд “Цэдэв эгч надад төрсөн охин шигээ л ханддаг байсан. Ааш зан сайтай, сайхан сэтгэлтэй хүн. Бид дөрөв айлын хажуу өрөөнд биш төрөл садан, ах эгчийндээ байгаа юм шиг л амьдардаг байсан” гэж тэр үеэ эргэн

дурсдаг.



Ээж нь анх оройтсон үдэш Цэдэв гурван настай хүүг “Миний хүү аягаа авч ирээд, хоолоо идээрэй” гэж дуудаж гэнэ. Хүү гурил хийдэг том гэгч цагаан түмпэнгээ барьчихсан, гал тогооны хаалган дээр ирээд, дүрлийтэл хараад л зогсоод байж. Тэнд байсан хүмүүс бөөн инээдэм болсон гэдэг. Хүү яагаад ч юм Доржсүрэнгээс эмээнэ. Миний хүү орж ирээд хоол ид гэхээр, “Танай аав чинь байгаа юу?” гэж асууж томчуудыг инээлгэнэ. Энэ гэр бүл хажуу өрөөнд 1966 оны намар орж, хоёр жил аж төрсний дараа “Нэхмэлийн шар”-д байртай болоод тусдаа гарцгааж байж. Гүрбадамынхан Доржсүрэнгийнхэнтэй садан хамаатан шиг болж, одоо ч гэсэн ирж очиж, холбоотой байцгаадаг.

1968 онд тийнхүү хажуу өрөө суларснаар хүүхдүүд тусдаа өрөөтэй болж, нар нь гарлаа. Гэвч тэр нар үүлэн чөлөөний нар байж. Нэг орой аав нь шуудайтай юм тэвэрсэн, хөдөөний боллолтой хүн дагуулаад ирэх нь тэр. Том охин руугаа гуйсан харцаар ширтэж байснаа,

-Энэ хөөрхий, хөдөөнөөс ирсэн юм. Гэр оронгүй.., гэлээ. Ингээд л хажуу өрөө дахиад хүнтэй болчихож. Түр хүн байлгасан өрөө нь бүр хүн байлгадаг өрөө болж хувирлаа. Үйлдвэрийн захиргаа ч гуйна. Аав нь өөрөө ч хүн дагуулаад ирнэ. Хүүхдүүд нь “Бохир суудаг. Угаалгын өрөө завааруулдаг” гэж загнадаг байснаа болилоо. Олон хүн орж гарч хөлхөж байдагт дасч дөжирлөө. Түр ч байна уу, бүр ч байна уу тэдэнд хамаагүй боллоо. Хажуу өрөөнд Санжмятав гэж өвгөн ирж суулаа. Дараа нь Маамхүү, тэгээд Жамъянсүрэн гээд л үйлдвэрийн ажилчид хажуу өрөөгөөр нь дамжин гарсаар л. Жамъянсүрэнгийн анхны хүүхэд нь Доржсүрэнгийн гал дээр гарч байж.

Энэ хүмүүс голдуу Доржсүрэнгийн шавь нар байсан бөгөөд, бүгдээрээ хожим нь мастер, эд шалгагч болон тушаал дэвшиж сайн ажилласан гэдэг. УИХ-ын гишүүн хүн ч хажуу өрөөнөөс өсөж өндийсөн. Польшид улаан дипломтой төгссөн Гомбожав гэх залуу эднийхээс амьдралаа эхэлсэн нь хожмоо төрийн түшээ болж байж. Бадарч гэх Мах комбинатын элэгний нухаш, жигнэсэн мах зэргийг санаачилж хийсэн залуу бас эндээс гэрлэж гарсан. Ингээд тоолохоор арваад айл тэр өрөөнөөс гал голомтоо асаажээ. “Иш хөөрхий дөө. Үйлдвэр дээрээ л хоноод байх юм” гэсээр л модон хайрцгаа тэвэрсэн хүн дагуулаад ирдэг аавынх нь тусархуу сайхан сэтгэл үр хүүхдүүддээ насан туршийн үлгэр дуурайл болсон байдаг.

Хуучин гутлын аян дайн

1958 оноос Чех улсын машин тоног төхөөрөмж, шинэ технологиор гутал үйлдвэрлэх боллоо. Ард иргэд цоо шинэ аргаар хийсэн, илүү чанартай, илүү загварлаг гутал руу хошуурах нь мэдээж. Өмнө үед орос машинаар үйлдвэрлэсэн гутлууд төв хөдөөгүй “лангууны хог” болон овоорлоо. Аймгуудын Бөөний бараа баазын хашаа, агуулахуудад орос технологиор хийсэн туфль, ботинк, торгон савхи, шевро гутал, ажлын бакалууд тэвш тэвшээрээ хураалгаастай.

Ингээд өнөөх хуучин гутлуудыг яах вэ? гэдэг асуудал “шүдний өвчин” боллоо. Хөнгөн үйлдвэрийн яам, Төлөвлөгөөний комисс, Үнийн хороо гээд яригдаагүй газаргүй. Ярьж асуудал шийдэх гэж хуралдаж байтал дахиад хоёр жил өнгөрчихөж. Энэ хугацаанд өнөөх сүрхий гутлууд энд тэндхийн агуулахад тоосонд дарагдаж хэвтсээр бүр яах ч аргагүй хог болж хувирах нь тэр. Арайхийж дээд газрын шийдвэр гарав. Гологдол гутлуудыг бүгдийг нь актлаад “Дээд тал нь таван төгрөг, заримыг нь бүр гурван төгрөгөөр борлуул” гэсэн байлаа. Гутлын загвар хийц харж маягладаггүй болохоороо малчид, ажилчид, борчууд хямдарсан гутлыг нилээд ихийг авч, далдруулав.

Гутлын үйлдвэрийн ерөнхий механик Доржсүрэн Дорнод, Сүхбаатар, Хэнтий гурван аймагт томилогдон ажиллалаа. Хуучин орос технологийн гутлын тооллого хийж, үнийг нь бууруулах ажил хийж яваа нь энэ. Тэр үед хөдөөгийн малчдыг өргөн хэрэглээний бараа, хүнсээр хангах зорилгоор одоогийн ганзгын наймаачинтай төстэй агент гэж ажилладаг байлаа. Бөөний бараа баазаас бараа хүлээж аваад, өөрийн амбаар, илүү гэртээ хураачихдаг. Түүнийгээ малчдын хотоор явж борлуулаад, түүнээсээ цалинждаг хүмүүс. Өнөөх гайтай хуучин гутлууд хөдөө сумдын агентуудаар бас тараагдчихсан. Тэр бүрийг эргүүлэн татах ямар ч аргагүй. Тэр үед гутлын тос хоёр төгрөг орчим, гутлын сойз гурван төгрөг орчим үнэтэй байсныг бодохоор сойзны үнэтэй гутал борлож дуусалгүй яахав гэхээр. Гэтэл ийм хямд болгосон ч өнөөх гутлууд далдарсангүй. Ингээд сүүлдээ хаяж байв.

Тэр үеийн бөөний бараа баазууд гутлыг хайрлана хамгаална гэж мэдэхгүй. Агуулахад дээр дээрээс нь овоолоод хаячихдаг байж. Доод талын гутлууд нь дарагдаад нагчийсан хачин муухай юм болчихно. Аймгуудаар явж байхдаа бөөний баазын агуулахаар нь ороод үзэхээр гутлын үйлдвэрийн ажилчдын хөлсөө урсгаж хийсэн гутлуудыг шамшийж налчийсан юмнууд болгоод овоолчихсон байх нь даанч харамсмаар. Социализмын үеийн нийгмийн өмч гэгчид хүмүүс ингэж л ханддаг байлаа. Тийм муухай болчихсон гутлыг хүн буу тулгаад ч авахгүй нь ойлгомжтой.

Энэ байдлыг нь мэдээд гутлыг тав арваар нь модон хайрцагт савладаг болгож байж. Тэгээд ч нэмэр байхгүй. Төв бараа баазын агуулахын үүдэнд тавь жаран авдар гутал хураалгаастай удаад л байгаа харагдана. Цаад бөөний бааз нь мөнгийг шилжүүлж төлөөд, хүлээгээд авчихсан хэрнээ татахгүй, зориуд удаана. Бороонд норж муудахыг нь хүлээж заль гаргана. Борлуулах гэж зовж байснаас шууд актлуулчих нь тэдэнд хялбар учраас тэр. Энийг нь бодохоор даанч яав даа гэж гасалмаар. “Социалист өмчийн эс ширхэг бүрийг нүдний цөцгий мэт хайрлан хамгаална” гэж том дуугаар лоозогнож, ажилчдад цээжлүүлдэг нь амьдрал дээр ирэхээр шал хуурамч хоосон зүйл байдаг нь дэндүү гунигтай.

Мотоспортын мастер

Үйлдвэрийн даргын шахалтаар авсан мотоциклоо анх хөдөлгөх гээд, ойчихсондоо халирч хүмүүсээр түшүүлэн, нэгдүгээр араатай салгалуулж явсан хүн нэг л өдөр мотоспортын тамирчин болчихсон байлаа. Бартаат замын нугачаан дээр толгой эргэм өндөрт харайлган үзэгчдийг дуу алдуулах нь итгэмээргүй. 1957 оноос эхлэн Ардын цэрэгт туслах сайн дурын нийгэмлэг байгуулагдаж, мотоспортын секцэд ажилчин, сэхээтэн залуучуудыг өргөнөөр татаж хичээллүүлдэг болсон нь энэ. Төв авто мото клуб гэж байгуулагдаж орос багштай секц хичээллэж эхлэхэд Доржсүрэн орохоор очлоо. Мань эр орос “ИЖ 49” мотоциклоо элээж, чех “Ява” унаж байгаад, “Урал” гурван дугуйттай болчихсон байсан үе. Мотоциклийг сайн жолооддог болчихоод байж.

Ногоон нуурын ойролцоо Мото клуб бэлтгэлийн замтай агаад тэндээ тамирчид бэлтгэл хийнэ. Зарим нэг уралдаан ч энд болно. Орос дасгалжуулагч хичээл зааж, залуу тамирчид эхлээд арай хүч багатай мотоцикл дээр гараа, эргэлт, хурд хийхийг сурч эхэллээ. Хүч багатай мотоцикл гэдэг нь тэр үеийн Зөвлөлтийн Ковровец үйлдвэрийн “К 55” хэмээх 125 см³ багтаамжтай төмөр хүлэг бөгөөд юуных нь хүч багатай байхав, огцом хааз өгвөл хойт дугуйн дээрээ босоод ирдэг сүрхий эд. Анхан шатны дасгалын дараа харайлт, буулт заалаа. Сайн сурч, магтаал хүлээж байтал дөрвөн метр өргөнтэй жалган саадаар гарах боллоо. Өмнө нь тэгш талбайд зөндөө олон удаа харайлгаж дөрөв бүү хэл тав зургаан метрийн цаана буугаад болоод байсан болохоор “Юу байхав” гэж бодогдоно. Гэтэл дөрвөн метрийн цаадах цагаан зураас биш, жинхэнэ жалга тулчихаар хонхойж харлаад эвгүй. Зүрх алдраад нэг л биш. Жалганы наана овойлгосон товгор дээрээс хурдтай ирсэн мотоцикл хөөрөлт авч дөрөв таван метрийн цаана буух ёстой. Буухдаа хойд дугуй дээрээ биш хоёр дугуйн дээр нь буулгахгүй бол онхолдож унах аюултай. Доржсүрэн айсандаа болоод, хурд муу авахуулж харайлгаад жалгын ирмэг дээр дугуу буугаад ойчихлоо. Нэг хартал мотоцикл тээр хол дугуй нь сэнсрэн орилж, хүмүүс түүн рүү гүйлдэн ирж байна. Эрүүгээрээ рулиэ хүчтэй дэлссэн болохоор өвдөж байгаа гэж жигтэйхэн. Хүзүү рүү бүлээн оргиод цус садарч эхэллээ.

-Уруул чинь сэтэрчихэж! гээд гүйлдэж ирсэн залуучууд сандарлаа. “Ингэж нүдний булай болж, хөгөө чирэх гэж. Зоригтойхон шиг хаазлах минь яав даа!” гэж өөрийгөө дотроо зүхэж,

-Жаахан шалбараа л биз. Сүртэй юм биш! гэж нэрэлхээд, шууд ногоон нуурын усаар уруул амаа угаачихаад ахиж харайлгана гээд буцаад ирлээ. Орос багш нь,

-Чи мулгуу хүн үү? Бохир уснаас халдвар авна шүү дээ! гэж загналаа.

-Яах ч үгүй ээ. Зүгээр.., гэж тайвшруулаад, тоогоогүй дүр эсгэе гэтэл нээрээ л ноцтой юм болсон бололтой. Уруулын цус тогтсонгүй. Тэндээсээ шууд эмнэлэгт хүргэгдэж хоёр оёдол тавиулж байлаа. Ингэж л эр зоригийн бэлтгэл ялихгүй дутсанаас болж уруулаа сэтэлсэн түүхтэй. Уруул сэтэрлээ гээд хаширсангүй. Хашрах нь бүү хэл хор шар буцалсан хүн дараагийн хагас сайнд ирж, зоригтой, өндөр хаазаар хурд авч харайлган, өнөөх уруул авдаг жалгынхаа цаад эрэгт итгэлтэй бууж байв. Тэр жалган дээр Цэнджав гэдэг залуу бас өрөөсөн чихээ сэтэлж байсан гэдэг.

Секцэд ажлын цагаар явж чадахгүй учраас тогтмол бэлтгэл хийх гэж байхгүй. Амралтын өдрүүдэд л уралдана. Миеэгомбо, Шижээ, Дэмид жанжны хүү Элбэг, Налайхын Ичинхорлоо гээд шижгэр залуус мотоспортоор хичээллэж байлаа. Залуу тамирчид 125 см³ мотоциклоор уралдаж байснаа шат ахиж, илүү хүчтэй 250 см³, 350 см³ багтаамжтай мотоциклоор уралдаж эхэллээ. Богинын аманд болдог тэмцээнийг нь үзэх гэсэн хүмүүс бөөн бөөнөөрөө шавна.

Доржсүрэнгийн том охин Гэрэлмаа, удаах хүү Зоригт хоёр нь аавынхаа улаан фэн болчихсон, наадам, октябрь, майн нэгэн зэрэг баяраар болдог бартаат замын уралдаануудыг нь алгасалгүй очиж үздэг болсон байлаа. Аав нь мотоциклоо орилуулан аймшигтай өндөр хаазлан, жалга руу нисээд л орчихно. Охин өөрийн мэдэлгүй “Аав аа!” гээд л орилно. Тэгтэл цаад өөд нь үсрээд л гараад ирнэ. “Ёо оо” гээд л санаа нь амарна. Аавынхаа төлөө ийнхүү санаа зовж, догдолж, дэгэлзэж зогсоно гэдэг сайхан. Тэнд байгаа бүх хүмүүс аавыг нь шагшин магтаж, биширсэн нүдээр харж байгааг харах шиг аз жаргал хаа ч үгүй. Нэгэн удаа аавынх нь мотоцикл хоёр хүүхдийн нүдэн дээр унтраад зогсчихож. Тэгтэл хор шар нь буцалсандаа уначихаад, зүрх үхэн цааш уралдахаасаа бэргэж зогсоо залуугийн мотоциклийг шувт татаж аваад цааш давхиж, өмнөө байсан олон тамирчныг гүйцэж охин хүү хоёроо бишрүүлсэн гэдэг. “Аав минь ямар одтой, авхаалжтай юм бэ?” гэж охин бахархаж байж.

Уралдааны гараанд гарна гэдэг л хэцүү. Өөрөө уначих гээд, нэг бол өрөөлийг дайрч унагачих гээд, ихээхэн эв дүй, авхаалж самбаа шаардана. Харин гараад цуваанд орчихсон байхад сайхан. Өмнөө яваа хүний өөг л харж явна уу гэхээс айх юмгүй. Алдаа гаргахыг нь анаж байгаад хажуугаар нь дайрахаа л бодно. Огцом эргэлт дээр гадуур эргэвэл дотуур нь товчлоод дайрчихна, хэт дотуур эргэх гэж улайрч хурдаа хасвал гадуур нь хурдтай дайрчихна. Замын аль өөтэй газруудыг анаж байгаад өмнө нь орохыг бодно. Ийнхүү уралдаандаа улайрч хаазтайгаа ноцолдсоор яваад, гараа зулгарчихсан цус гарч байгааг ч анзаарахгүй. Хүн хэлэхэд л мэдэх энүүхэнд.

Тэмцээнд түрүүлэхэд 100 төгрөгөөр шагнуулна. Түүгээрээ тамирчид нийлж гуанзанд ороод, сайхан хоол идчихнэ. Үе тэнгийн залуус мотоциклоосоо унасан нэгнээ даапаалж явуулаад, бөөн инээдэм болцгоох нь сайхан. Баярын өдрүүдээс гадна Ардын цэрэгт туслах нийгэмлэгийн тэмцээнүүд их зохиогдоно. Заримдаа Улаанбаатараас Зүүнхараа хүртэл шулуун замын уралдаан хийж, Хараа голыг гатална. Мотоцикл бүхлээрээ усанд далд орчихоод байгаа хэрнээ яваад л байгааг хүмүүс хараад нүдээ оройдоо гартал гайхна. Агаар шүүгчдээ урт хоолой углан дээш нь гаргаад бүсэндээ хавчуулчихдаг болохоор мотоцикл нь тийнхүү усанд унтрахгүй. Ус гатлахын өмнө алх дөшин контактаа хамгаалж, цагаан арьсыг нь замын хараар шавдаг байлаа.

1961 онд Зөвлөлт холбоот улсын Хабаровск хотод болсон мотоциклийн бартаат замын олон улсын уралдаанаас анхны хүрэл медалийг Миеэгомбо авчирч залуучууд бөөн баяр болж байж. Мотоспортын тамирчид гээд амь нэгтэй болцгоож бие биенийхээрээ орж гарна. Мотоспортын заавал дагах ёстой хатуу дүрэм бол “Гишгүүрийн урдуур хөлөө тавьж хэзээ ч болохгүй” гэдэг. Энэ дүрмийг ягштал баримталж, рефлексээр биелүүлдэг болох ёстой.

Эрсдэл өндөртэй, эр зоригийн спорт болохоор осол бэртэл ихтэй. Найз Элбэг нь уралдааны үеэр хөлөө хугалж маш харамсалтай явдал болж байв. Ихээхэн ноцтой гэмтсэн болохоор Польш улсад очиж хөлөө тайруулаад, хиймэл хөлтэй болоод ирж байж. Миеэгомбо,

Ичинхорлоо, Шижээ, Доржсүрэн дөрвүүл үеийнхнээсээ түрүүлж Мотоспортын мастер цол авч байлаа. Эрхэм хүндтэй цол гардаж авахдаа хэн ч авахгүй байсан “ИЖ” мотоциклийг зальдаж өгсөн даргадаа баярлалаа гэж хэлье гэж бодогдсон гэдэг.

Орлогч дарга

1960 он гаргаад Доржсүрэн Гутлын үйлдвэрийн орлогч даргаар ажиллав. Орлогч даргын үүрэг тодорхой. Бөөнөөр үйлдвэрлэсэн түм буман гутлаа борлуулах гэж бараа баазуудаар өдөржин явна. Гутлын үйлдвэрийн даргаар Доржсүрэнтэй адилхан хүүхэд байхдаа үйлдвэрт ажилд орж, найз болцгоосон Равжир нь ажиллаж байлаа. Зургаан цагийн ажлын нормтой гэж эрт ажлаасаа тараад, өдөржин Туулын усанд шумбаж, жараахай барьж явсан нь дөнгөж өчигдөр юм шиг санагдана. Гэтэл хоёр жаахан хүү хэдийнээ гучин хэдтэй болчихсон, хүүхэд байхдаа босгоор нь анх алхсан үйлдвэрээ мөр зэрэгцэн удирдаад явж байна гэдэг гайхамшигтай сайхан хувь заяа.

Равжир удирдлагын албан тушаалд хэдэн жил ажиллаад, хэдийнэ нэр хүндтэй сайн дарга болж амжсан байлаа. Даргын хэлсэн үүрэг даалгавар ягштал биелэнэ. Үйлдвэрийн ажилчид даргадаа сайн гэдэг нь жигтэйхэн. Нэг удаа нилээд хоржоонтой явдал тохиож байж. Наряд, падаан гэх мэтийн ялих шалихгүй цаасан дээр заавал үйлдвэрийн даргын гарын үсгийг зуруулах болдог. Дарга яам, нэгдэл, зөвлөл гээд энд тэнд хуралд орчихоод гарч ирэхгүй хугас өдөржин хүлээх болчихдог нь тамтай. Тооцоо гаргагч Жүгдэрнамжил даргын гарын үсгийг нүгэлтэй адилхан дуурайлгаж зурна. Даргын чамин татлагатай, маягтай гоё гарын үсгийг түүгээр зуруулаад харьцуулаад харахад ямар ч ялгаа олдохгүй. Заримдаа хурлаас гарч ирэхгүй удвал аар саар зүйлийн гарын үсгийг өнөөх залуугаар зуруулчихдаг боллоо. Нэг удаа яам руу дуудагдсан даргыг хүлээж залхсан нябо Жүгдэрнамжилаар чекэн дээр гарын үсэг зуруулаад улсын банкнаас мөнгө авч ирээд, ажилчдынхаа цалинг өгчихөж байж.

Монголдоо том үйлдвэрийн дарга хүн хэрнээ Равжир машингүй явган таваргаж явах. Хэрэгцээ гарахаар гучдугаар баазаас цагийн тэрэг хөлсөлнө. Хэл үггүй хөлсөлчихдөг бол бас яахав. Хэмжээ хязгаар лимит гээч юмтай. Тэр үед яагаад тийнхүү улсынхаа том үйлдвэрт өөрийн унаатай байх эрх өгдөггүй байсан юм. Унаагүй дарга дээд газрууд яам тамганд болдог хурлаасаа буцаж ирэх гэж тэгтлээ удах нь ч аргагүй. Доржсүрэн ихэвчлэн дээд доод газрууд, бараа баазууд, албан газруудаар явж ажил хөөцөлдөх бөгөөд хөлсөө урсгаад л явган гүйх болдог нь хэцүү байж.

Үйлдвэрийн орлогч даргын гэрт утасгүй байж яагаад ч болохгүй нь мэдээж. Утас тавилаа. Тэр үед гэртээ утастай айл ховор байж. Утас дуугарахаар бүгдээрээ гүйлдэнэ. Гэвч гэрийнхний хэнтэй ч ярихгүй. Ганцхан Доржсүрэн даргатай л ярина. Сүүлдээ утас авах хүн олдохоо больж, би ав, чи ав гэдэг дээрээ тулдаг байж.

Хоёрдугаар ангид байсан Гэрэлмаа утсаараа яримаар хорхой хүрэвч ангид нь гэртээ утастай хүүхэд өөр байхгүй. Аав ээжийнхээ эзгүйд утсаараа хаашаа ч юм залгаад, чимээгүй чагнаж зогсоно. Утас авсан хүний дуу гарч, “Байна уу? Хэн бэ? ...Байна уу?” гэж хашгирч байснаа харилцуураа тавьж, “дийд дийд” гэсэн тасалдсан дохио дуулдана. Орцныхон, ойр хавийн хашааныхан утсаар ярих гээд хүрээд ирнэ. Огт танихгүй хүн хаалга нүдээд ярих албатай юм шиг “Танай утсаар чинь нэг яриадхая” гэнэ. Ямар ч сайхан амгалан цаг байсан юм. Оруулаад л утсаараа яриулчихдаг байж. Одоо цагт хэн нэгэн танихгүй хүн хаалга нүдээд утсаар ярих гэвэл юу болох бол.

Доржсүрэн орлогч дарга болсныхоо дараа Төв бараа баазтай заргалдлаа. Үйлдвэрийн хийсэн бүтээгдэхүүнийг гэрээгээр авахгүй байсанд нь зарга үүсгэсэн хэрэг. Улсын арбитраар ороод үйлдвэрийн талд заргыг шийдэж, бүтээгдэхүүнийг бараа баазад албан журмаар ачуулах болж байв. Барааны үнэ 300 мянган төгрөг цэврээр ороод ирлээ. Хөрөнгийн тооцоо хийж үзээд, энэ мөнгөөрөө үйлдвэрийн хоёр байраа холбоё гэсэн санал орууллаа. Дээрээс зөвшөөрч, барилгын улаан шугам тавигдаж, зураг төсөл гарч, холбоосыг бариулж байж. Эсгүүрийн байр, гутлын ягаан байр хоёрын хооронд дөчөөд метрийн зайд ажилчид гадуур тэргээ чирээд л материалаа зөөдөг, тэрэгний дугуй нь шороон замд гацчихдаг, бороо шороотойд эсгэсэн материал нордог бохирддог байсан үе халагдаж байж.

Орлогч дарга хүнд боловсрол хэрэгтэй нь мэдээж. Түүнийг суралц гэж намын даалгавар өгөгдлөө. Политехникийн дээд сургуульд суралцлаа. Тэр үед полийн дээд гурван жилийн сургалтын хөтөлбөртэй байж. Дариймаа гээд цагаан толгойтой эмэгтэй улстөр судлалын хичээл заана. Хатуу чанга гэж айхавгар. Санхүү эдийн засгийн хичээлийг сүүлд нь Сангийн яамны орлогч сайд болсон Долгор гуай орно. Тэр хоёр шиг ширүүн багш байхгүй.

Нэгэнт л орлогч дарга гээд бүтээгдэхүүний борлуулалт хариуцаж ажиллаж байгаа болохоор олон асуудалтай тулгарна. Бараа баазаас танай гутал борлохгүй байна, өндөр үнэтэй байна, чанаргүй байна гээд л хэл ам их татална. Тэр үед үйлдвэрлэгч зуучлагч хоёр үнээ тохиролцоно гэх зүйл байсангүй. Улсын үнийн хороо бүтээгдэхүүний үнийг тогтоогоод өгчихдөг байж. Үнэ тогтоох ажил нь их нарийн. Гуталд орсон хадаасны тоог хүртэл гаргаж, бүх орц материалыг бодно. Хөдөлмөр зарцуулалтыг тооцоолно. Үйлдвэрийн ашгийг тооцно. Энэ бүхний эцэст гутлын үнэ гарч ирнэ. Одооны үйлдвэрүүд шиг гарсан зардлаа шууд л хоёр юм уу, гурав нугалах гээд зүтгэчихдэггүй байж.

Адтай охин

Жараад онд Нэхмэлийн шар гэж нэршсэн байр баригдахаар болж тэр хавийн айлуудыг одоогийн Мишээл экспо байгаа газар луу нүүлгэж, нэгдүгээр хороо болгон зохион байгуулж байж. Яг тэнд нь комбинатын ажилчдын хүүхдүүд сурдаг арван жилийн дөрөвдүгээр дунд сургууль оршино. Сургуулийн дэргэд Галзуугийн эмнэлэг байрлана. Бас сургуулийн чанх ард хятадын хороололтой. Үнэхээр “есөн жор” гээч нь бүрдсэн байрлал гэж хэлэлтэй.

Доржсүрэнгийн том охин Гэрэлмаа нь комбинатын бусад хүүхдүүдийн адил энэ л сургуульд явна. Багадаа өвчин ороож бүтэн жил уйлж, аав ээжээ шар махтай нь хатааж, нэгэн мэргэчийн амнаас “Айлд өргүүл, үгүй бол эндэнэ” гэсэн үг сонсож байсан гэхээргүй том охин болчихоод байлаа. “Тэр төлөгчийн үгэнд итгээд охиноо айлд өгчихсөн бол яана аа?” гэж бодохоос эцэг эх хоёрын яс хавгайдаг нь мэдээж. Аав нь үйлдвэрийн машинуудаа маллаад оройтно. Ээж нь зургаан цагт ажлаа тарж ирдэг ч тоглолттой гээд буцаад гүйчихнэ. Гэрэлмаа л хэдэн дүү нараа асарч, хоолоо хийж, гэр орноо цэвэрлэдэг байлаа. Хичээл номоо ч сайн хийж, сургуулийн өмнөө барьдаг, улаан онц сурлагатан гэгдэнэ. Тэр их ажлын хажуугаар хэдийд нь хичээл номоо амжуулдаг бол доо гэж гайхмаар.



Гэрэлмаа дүү нараа бодвол том биетэй. Яг л аавынхаа ээж Лхамжав эмээгээ дуурайсан биерхүү. Сэргэлэн цовоо зантай. Айл хөршийнхөн нь “Доржсүрэнгийн тэнтгэр охин уу? Мөн ч адтай сүрхий амьтан шүү!” хэмээн шагшицгаана. Энэ яриа хоосон үг биш гэдгийг охины үйлдэл зан чанар батална. Социалист хүмүүжилтэй хүмүүст баймгүй сүйхээ охиноос гарна. Ойрхон байх хятад хороололд хэдийнэ түнштэй болоод амжчихсан “бизнес” хийгээд эхэлчихсэн байсан нь адтайг нь илтгэнэ. Хятадын хорооллын дааяа нар их сайн хүмүүс. Мужаан төмөрчний ажил эрхэлж, хашаандаа ногоо тарина. Огт зүгээр суухгүй хоёр нарны

хооронд ажиллана. Эхнэрүүд нь дандаа монгол. Байдгаараа гоёж гангалчихаад тамхиа татаад зүгээр сууж байна. Гэрэлмаа амттай боов авч идэх гээд дааяа нарт ус зөөж өгнө. Нэг хөгшин түүнд их сайн.

-Хай яа, Гилмаа. Энүү саваа дүүлгээд арваа зоосоо авав аа гэнэ. Жаахан охин өөртөө хэд дахин томдсон хувингаар ус зөөж том ганг дүүргэнэ. Бараг л арван хэд явж эцэж цуцаж байтал тэр ган нь дүүрч санаа амраана. Сурагчийн хүрэн формныхоо хормойг нортол, хоёр гараа чилтэл ус зөөсөн охин шагналдаа арван төгрөг амтат боов аваад нүд нь сэргэнэ. Тэр үеийн арван төгрөг гэдэг одооны хорин мянгаттай тэнцэх том мөнгө. Энэ олзоо охин ганцаараа үрчихгүй. Дүү нартаа чихэр авч өгнө. Бас дэлгүүрээс боов аваад Галзуугийн эмнэлгийн хашаанд хүлүүлчихээд зовж зүдэрч буй хөөрхий өвчтөнүүдэд аваачиж өгдөг байлаа. Бас гэртээ хоол хийгээд ч аваачиж өгдөг байсан гэдэг.

Багадаа зовоож хүн болсон болоод ч тэр үү Доржсүрэн том охиндоо дэндүү хайртай. Гоёж гоодож, эрхлүүлнэ. Гутлын үйлдвэрийн ерөнхий механикийн хэрэг юу билээ хамгийн гоё гутлыг тусгайлан оюулж өмсүүлнэ. Наймдугаар ангиа онц төгссөний шагнал болгож цав цагаан гутал хийлгэж бэлэглэлээ. Тийм гоё гуталтай хүн сургуульд нь байхгүй. “Миний охин дандаа онц сурч аавыгаа баярлуулвал, өөрөө ч баярлах нь байна шүү” гэж ээж нь хэлж байж. Гутлын үйлдвэрээс Прагийн үзэсгэлэнд зориулан бүтээж байсан илгэн гутлыг охиндоо хийлгэж өгнө. Сүүлдээ дотоод гутлаа болиод дандаа чехийн гутлаар гоёдог болж байж.



Наймдугаар ангид ороод байхдаа Гэрэлмаа сургуулийн бүлгэмийн зөвлөлийн даргаар сонгогдлоо. “Миний аавын ажлын газар” сэдвээр зохион бичлэг бичсэнийг нь багш нар их магтаж, аавдаа заавал уншуул гэсэн байж. Гэвч охин аавдаа шууд үзүүлэхээсээ айгаад хойшлуулаад л байж. Тэгтэл сургуулийн пионерийн ахлах удирдагч нь бүлгэмийн ажлаа аав ээжийнхээ ажлын газарт очиж, сонирхолтой хэлбэрээр явуул гэсэн үүрэг өгсөн нь охины сэтгэлийн дуудлагыг сонсчихсон гэлтэй. Гайхалтай хэрэг боллоо. Ингээд Гутлын үйлдвэрийн Намын үүрийн дарга руу явж очоод,

-Бүлгэмийн сурагчдаа оролцуулаад “Миний аавын ажлын газар” сэдэвт ажил зохиомоор байна гэж зөвшөөрөл гуйтал,

-Тэг тэг! Тэр бололгүй яахав гээд намын дарга маш дуртай зөвшөөрлөө. Ингээд Гутлын үйлдвэрийн 132 дугаар цехийн хоёр зуугаад ажилчны нүдийг оройд нь гарган, бүрээ үлээж, бөмбөр нижигнүүлсэн пионерүүд шугам жагсаалаар орж ирэх нь тэр.

-Бүлгэм дуулж бай! Номхон! гэж сургуулийн бүлгэмийн зөвлөлийн дарга Гэрэлмаа

командаллаа. Миний аавын ажлын газар сэдэвт бүлгэмийн ажил явуулах болсноо танилцуулж бүлгэмийн хэний аав, хэний ээж энэ цехэд ажилладгийг танилцуулж баяр хүргэлээ. “Миний аав 14 настайгаасаа энэ үйлдвэрт ажиллаж эхэлсэн. Энэ бүхий л хугацаанд үйлдвэртэйгээ бүхий л амьдралаа холбож, өнөөдөр үйлдвэрийн орлогч дарга болчихоод ажиллаж хөдөлмөрлөж явна” хэмээн, Гэрэлмаа зохион бичлэгээ уншив. Үүнийг дагаад сурагчид сэтгэгдлээ хэлж, аав ээждээ ямар их хайртайгаа илэрхийлэхэд, ажилчид уяраад нүдэндээ нулимстай зогсож байв. Тэр жил шинээр гарч нийтийн таашаалд хүрээд байсан Содномдорж гуайн “Аз жаргалын эрэлчин” дууг,

Ариун сэтгэлт ээжийнхээ

Үр нь болсон бид нар

Ачийг нь ачаар хариулахаас

Үнэндээ өөр замгүй.., хэмээн дуулахад хүмүүс их догдолж уярч, бүр уйлж эхлэв. Охиныхоо зохиож байгаа энэ ажил руу огт санамсаргүй орж ирсэн Доржсүрэн цехийн булангаас сэм чагнаж зогссоноо уярч уйлаад, дэргэдээ байсан ажилчнаасаа нэрэлхээд гараад явчихсан гэдэг. Намын дарга нь аавынх нь шавь Бэгзсүрэн гэгч хүн байсан бөгөөд, ажлын дараа чин сэтгэлээсээ баярласан хүн гүйх шахам хүрч ирээд, хүүхдүүдийн гарыг атгасан гэдэг.

-Маш сайхан ажил явуулж, ажилчдад их урам зориг өглөө гэж Гэрэлмааг магтаж сайшаалын үнэмлэх гардуулаад явуулж байв. Гэтэл орой аав нь ажлаасаа ирээд,

-Энэ мөн хэнхэгтэй хүүхэд шүү. Хоёр зуун хүний ажлыг бүхэл бүтэн гучин минут зогсоогоод..! гэж зэмлэх нь тэр. Охин ингэнэ гэж даанч бодсонгүй. “Сайхан ажил зохиосон, сайн охин” магтана гээд итгэчихсэн байсан учраас гомдсон гэж жигтэйхэн. Гэвч аав нь цехээс нулимс цийлэлзүүлээд гарсан гэдгийг хэд хоногийн дараа хүнээс сонсоод бараг л уйлчих дөхөж байж. “Аав минь тэр ажлыг сайнаар хүлээж авсан байж” гэж бодохоос цээжин дотроосоо бул хар чулуу аваад хаячих шиг хөнгөрөөд явчихсан гэдэг.

Дарга жолооч

Хоёр гурван жил завсарлаад, дахин Чехийн мэргэжилтнүүд ирж, Шевроны үйлдвэр, Шевретийн үйлдвэр, Эрдэм шинжилгээний төв, Том ширний үйлдвэрийн барилгуудыг барьж эхэллээ. Ийнхүү 1962 онд шинээр чехүүд ирэхэд Доржсүрэн үйлдвэрийн орлогч дарга байснаа дөнгөж болиод, материал хариуцсан мэргэжилтний алба хашиж байлаа. Тэгтэл нэг өглөө үйлдвэрийн намын хорооны дарга дуудлаа гэнэ. Яваад ортол,

-Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (ЭЗХТЗ)-ийн төлөөлөгчөөр, чех хүн ирсэн. Мэдэх үү? гэж байна гэнэ.

-Мэдэхгүй ээ. Нэг залуу ирсэн гэнэ лээ. Хараагүй л байгаа гэж. Намын дарга царайгаа нухацтай болгоод, ЭЗХТЗ-ийн төлөөлөгч, нөхөр Углекийн жолоочоор маш өндөр хариуцлагатай, намын гишүүн хүнийг томил гэж Төв хорооноос үүрэг өгсөн гэлээ. Доржсүрэн түүнээс хэн тохирох вэ гэж санал асуух нь гэж ойлгоод, “Хэн тохирмоор юм бэ дээ?” гэж бодол боллоо. Тулгамдаад тохирох хүн санаанд орж ирсэнгүй. Тэгтэл,

-Бид чамаар энэ хариуцлагатай ажлыг хийлгэх гэсэн юм. Жолоочоор ажиллаж чадах уу? гэж асуух нь тэр!

Үйлдвэрийн орлогч дарга хийж байсан хүнээ даргын жолоочоор ажиллаач гэх нь эрүүл ухаантай хүний хэлэх үг мөн үү? Хэрвээ өнөө цагт компанийн орлогч захиралд ийм санал тавибал яах бол? Тэсэртлээ уурлаад, хаалга саваад гарах нь мэдээж. Гэтэл Доржсүрэн энэ саналыг баяртай хүлээж авсан гээд бод доо! Намын дарга нь хашир хүн байсан учраас Доржсүрэнг судалчихсан байж. Жолоо мушгихын төлөө яахаас ч буцахгүй “хоббитой” гэдгийг нь тооцоолчихсон байсан хэрэг. Үйлдвэрийн ерөнхий механикийн сүрхий том албан тушаалтай хэрнээ Доржсүрэн ээлжийн амралтаараа хүний тэрэг гуйж унаад алсын тээвэрт явчихаад ирдэг байсныг нь сонссон учраас л ийм санал тавьсан байж. Ингээд л орлогч даргаас жолооч руу буучих нь энэ.

Хүн амьтан юу гэж бодох вэ? Ийм саналыг яах гэж хүлээж авч байгаа юм бэ? Чи өөрийн ухаантай хүн үү? гээд олон хүн түүнийг зэмлэж байсан гэдэг. Доржсүрэн хүмүүсийн загнаж зэмлэж байгааг тоосон ч үгүй. Даргын жолооч хийхийг зөвшөөрчихөөд байж байтал үйлдвэрийн захиргаа түүний нэрийг цалингийн жагсаалтаас хасаад, цалинг нь хаачихсан байна. Ня-бо болохоор,

-Мэдэхгүй ээ. Чамд цалин өгөхгүй гэсэн шүү дээ гэлээ. “Тэрэг барих дуртай байж болно. Гэхдээ цалингүй жолооч хийнэ гэдэг арай ч хэтэрнэ ээ!” гэж шөнөжин бухимдаж, бугшсаар нойргүй хонолоо. Өглөө босоод иртэл цээжин дотор нь том хар юм тээглээд болдоггүй. Хэдэн хүүхдээ яаж тэжээх болж байна аа? гэхээс хамрын самсаа шархираад тэсч сууж чадахгүй байсан нь мэдээж. Үйлдвэрийн захиргаа руу буцаж ороод,

-Хичнээн дуртай ч гэлээ, цалингүй ажиллаж чадахгүй ээ! хэмээн гоморхож бухимдсандаа болоод, уйлчих шахан цахиртсан өнгөөр хэлэв. Тэгтэл,

-Чи ЭЗХТЗ-өөс цалин авна аа, санаа зоволтгүй. Бүр 900 төгрөг шүү! гэх нь тэр. Энэ үгийг сонсоод урт гэгч амьсгаа авлаа. “Арай ч дээ, тийм байлгүй дээ. Дуртай гээд цалингүй ажиллуулна гэж юу байхав” гэж дотроо бодож, сэтгэл уужирлаа. Орлогч дарга байхдаа сард 700 төгрөгийн цалинтай байсан хүн, жолооч болчихоор яахаараа 900 төгрөг авдаг билээ? Дарга буруу хэлсэн байлгүй гэж бодож. Гэтэл ЭЗХТЗ-ийн цалин тийм өндөр жишигтэй байсан юмсанж.

Углек дарга гэхээр зангиатай, буурьтай төрхтэй, махлаг залуу байх даа гэж бодож. Гэтэл доонийсон өндөр нуруутай, бавайсан их сахалтай, энгийн хээгүй гэмээр залуу байхаар нь гайхсан гэдэг. Өмнө чехүүдтэй ажиллаж байсан, Чех улсад зургаан сар гахай шувууны мах идсэн болохоор ядахдаа мэндлэхтэйгээ. Тийшээ явна, энд зогсоно гэдгийг ямар ч гэсэн муухан ойлгуулчихна. Харин ярианы сэдэв түүнээс цааш гүнзгийрвэл дохио зангаа л хэрэглэхээс өөр замгүй.

Эхний өдрөө Углек дарга жолоочоо дагуулан Чех улсын элчин сайдын яаман дээр очлоо. Гэтэл тэндхийн гараажид даргын унаа гээд хоёрын хоёр цоо шинэ машин сойлттой зогсож байна. “Энэ хүн хоёр машин сэлгэх гэж байх. Гэтэл манайд үйлдвэрийн дарга машингүй, баазаас цагийн тэрэг дуудаж байдаг” гэж бодогдож, санаа алдсан гэдэг. Хоёр тэргийг үйлдвэрийн өргөтгөлд барьсан гарааж руу зөөж тавихаас жолоочийн ажил эхэлж байв. Чех дарга хот дотор “ГАЗ-21, Волга” гээд тэр үеийн сайд нарын хөлөглөдөг байсан тэргээрээ давхина. Хөдөө ажилдаа Румын улсад үйлдвэрлэсэн “ARO” гэгч тэргээр уухилуулна. Энэ тэргийг монголчууд “Румын 69” гэж нэрлэдэг байлаа. Сүүлд нь “ГАЗ-21, Волга” машинаа, шинэ маркийн “ГАЗ-24, Волга” болгон сольж байлаа.

Чех дарга, тарваганы мах

Залуу дарга нь заримдаа сахлаа хусчихна. Тэгснээ тэгтлээ их удаагүй байтал бавайсан хууз сахалтай болчихно. Жолооч “Хиймэл сахал наачихдаг юм болов уу? Ямар учиртай юм бол?” гэж гайхшаа барна. Тэсгэлгүй яагаад гэдгийг асуутал сахал хурдан ургуулдаг тос байдаг юм шүү дээ гээд үзүүлж, хоёул инээдэм болж байв. Чехийн мэргэжилтнүүд тусгай гуанзтай, тусгай тогоочтой. Тэр үеийн өндөр зэрэглэлийн зоогийн газрын хэмжээний амт чанартай хоол иднэ. Углек дарга үе үе ирж, хоолны амт чанар шалгана. Даргын жолооч гээд Доржсүрэн ч тусгай гуанзны хоолноос хүртэнэ.

Углек бусад чех орос дарга нар шиг загас жараахай хөөцөлдөх тийм ч дуртай биш. Харин чехүүд нь түүнээс машиныг нь гуйна. Дарга машинаа өгдөг боловч, цаадуулдаа жолоочийн хөлсийг заавал төлөх болзол тавина.

-Та нар энэ хүнийг хагас бүтэн сайн өдрөөр амраагаагүй. Тийм учраас жолоочид хөлс төл! гэж хэлнэ. Ингээд явсан цагийг бодоод тооцоо хийчихнэ. Юманд тооцоотой ханддаг чех зан нь энэ. Хархорин, Улаан цутгалан гэх мэт түүх дурсгалын газар, байгалийн үзэсгэлэнт газарууд руу аяллаар хааяа явна. Чехүүдээ тусдаа автобусанд суулгаад, өөрөө “ARO” тэргэндээ тухалж явна. Хөдөө явахад нэг зүсэм талх ч гэрээс авахуулахгүй. Яг даргынхтай нь адил хүнсний хангалтыг бэлдэн савлаад, жолоочид өгнө. Архи, пиво, ногоо, талх, гахай шувууны мах гээд тансаг зүйлсийг дарга цэрэг гэсэн ялгаваргүй яг ижилхэн ууталсан байна.

Чехүүд нарийн тооцоотой гэж жигтэйхэн. Үй зайгүй хоёр найз нуурын эрэгт хамтдаа ирчихсэн хэрнээ тус тусдаа хүнс гаргаад сууна. Арай ч дэндүү гэлтэй. Шил архи задалчихаад зөвхөн өөрөө л тэрнээсээ хийж уугаад, хээв нэг яриад л суух. Малчин монгол хүн харвал өшөө нь хүрмээр. “Нарийн тооцоотой байж болно. Ийм дэндүү байж болно гэж үү?” гэж жолооч гайхаж, эгдүүцнэ.

Тэд бас гахайны анд явж, маханд нь их дурлана. Хаанаасаа ингэж сурдаг байна аа гэмээр, гахайн ав хийхдээ дадамгай. Хонины маханд дургүй. “Мэргэжилтний хорь” гэж алдаршсан дэлгүүрээс үхрийн мах, хүнс ногоогоо авч иднэ. Яагаад хонины маханд дургүйг асуухаар, танай монгол хонины мах сайхан байна л даа. Манайх муу, шивтэр амтагдсан хачин юм байдаг. Тэгээд л чехүүд хонины махыг таашаадаггүй гэнэ. Инженер Цэмпилдорж, буриад Болд, Доржсүрэн гурав чех мэргэжилтнүүддээ газар үзүүлж, Хархорин, Төхөмийн хийд, Үүтийн тохойн рашаан, Улаан цутгалангаар аялал зугаалга хийгээд буцаж явж. Цэмпилдорж боодог их сайхан хийнэ. Элсэн тасархайгаас наахна хулгар шар нэгийг унагаад боодог хийж, чехүүдэд сонирхуулж гэнэ. Тарвага гэгч амьтан яг л хулгана харх шиг л зэвүүтэй харагдаж байсан нь ойлгомжтой биз, тэднээс нэг нь ч амссангүй. Тэгтэл Углек хуйх нь шаргалтаж тос даасан боодог руу харж байснаа, Доржсүрэнг сэмхэн дуудаад,

-Би амсаж үзье. Харин эхнэрт битгий хэлээрэй гэлээ. Тэгээд чехүүдээсээ нуугдаж амссанаа, цааш тэсгэлгүй идээд эхлэв.

-Их сайхан мах байдаг юм байна шүү дээ! гэж байна. Амсах биш намрын тарган бурхины өөх ихтэй, хуйхтай махнаас талхаар даруулаад нилээдийг явуулчихлаа гэнэ. Дараа нь үнэртэж

магад гээд ам гараа сайтар угаагаад, хөдөлж байлаа.

Чех хүмүүс цагийг маш чанд баримтлана. Тавхан минут хожигдоод очиход л асуудал үүсчихдэг. Гарч ирэх ч үгүй. Зургаан цагт ир гэсэн бол 6 цаг 00 минутдаа л гарч ирнэ. Доржсүрэн тэдэнтэй ажиллах болсноосоо хойш цагийг яг таг барьдаг зуршилтай болчихож. Дараа нь монголчуудтайгаа ажиллаж эхлээд, цаг хоцрох асуудлаас болоод байнгын бухимдалтай хэрүүлтэй явсаар байгаад, сүүлдээ даралтаа өсгөж сүйд болж байсан гэдэг.

Углекээс бүгд айна. Уурлавал чехүүд бүр ухаан алдах дөхнө. Нэг ууртай үг дуугарахад тэнд байсан бүх мэргэжилтнүүд нам болдог байлаа. Олон үг хэлэхгүй агаад барилга дундуур дуугүй яваад л, ажаад л байна. Контортоо орж ирээд тэрийг дууд, энийг дууд гэнэ. Өрөөндөө оруулж ирээд загнаж, нам авна.

Углек дарга хүнд анхаарал халамж тавьж зөөлөн хандаж ч бас чадна. Нэг удаа найзуудаа загасчлуулж Өгий нуур луу явав. Доржсүрэн тэр үед жаахан байсан Гүндэгмаа охиноо авч явсан байж.

-Охиноо дааруулчихгүй байгаа? Та хоёрт тухгүй байгаа юм биш биз? гээд л ахин дахин асууна. Цаадуулаараа майхан сав бариулж, жолооч охин хоёрын бүх тух тавыг хангаж өгөөд ярьж хөөрч, наргиж цэнгэж, загасчилж нэг хонов. Буцах гэтэл Доржсүрэнгийн бие өвдөж халуурлаа. Хордлого авчихсан бололтой. Маргааш өглөө нь бүгдээрээ ажилтай, хоцорч болохгүй байтал Углек явахаа хойшлууллаа.

-Явж болохгүй. Сайн эдгээж байж явна! гэсээр гурав хоног хүлээв. Чехийн том цагаан эм уулгаад л хэвтүүлээд байна. Хөлөрч магадгүй битгий босоорой гэнэ. Энэ гурав хоногт дарга залуу, монгол жолооч охин хоёрыг асарч тойлж, дээд зэргээр анхаарч байж. Ийм л энгийн хүн.

Нийгэм нэгдүгээрт

1964 оны 5 дугаар сарын 1-нд Үйлдвэр комбинатын ажилчдын Баян-Уул амралт нээгдэв. Гэргий Цэдэв нь амралтын зохион байгуулагчаар ажиллаж эхэлснээр Доржсүрэнгийнх зун болгон гэрээрээ Толгойтын Баруун салаанд зусах боллоо.

Тэр үеийн хүмүүс хүүхэд байхаасаа “Нийгмээ, нийгмийн тустай ажил хөдөлмөрөө бүхнээс түрүүнд тавина” гэсэн сэтгэлгээтэй болж хүмүүждэг байж. Энэ үзэл нь мах цусанд нь шингэчихсэн. Өнөөгийн бидэн шиг нэг хүүхэд гаргачихвал бүтэн хоёр жилээр ажлаас чөлөөлөгдөн хүүхдээ харж, сүйд болдоггүй байж. Амаржаад дөчин тав хоноод л ажилдаа орчихдог. Өдөрт хэдэн удаа гүйж ирж хүүхдээ хөхүүлчихээд л нийгмийнхээ төлөө зүтгэнэ. Түүгээр барахгүй олон хүүхэдтэйг нь яана. Тав зургаан хүүхэдтэй айл цөөхөн хүүхэдтэйд тооцогдоно. Тэр олон хүүхдийн түрүүчийн арай том нь жижгүүдээ асраад явахаас өөр аргагүй болно.

1965 он гэхэд дөнгөж зургадугаар ангид байсан Гэрэлмаа, дөрөвдүгээр ангид байсан Зоригт хоёр, бага дүү нараа асрах том үүргийг нуруундаа аваад хэдийнээ хоёр жилийн нүүр үзчихсэн байлаа. Аравтай, естэй болчихсон арай том Цэрэндулам, Цэндсүрэн хоёр охин дүү нь ч гайгүй өөрсдийгөө аргалчихна. Харин хамгийн бага хоёрыгоо агуулна гэдэг хэцүү. Тэд хоёр бага дүүгээ нэг нэгээр нь өмчилж аваад асарч тойлно. Хоёр настай бага дүү Аюурзана нь цаг үргэлж чацга алдана. Өмдөнд нь баалгачихвал угааж цэвэрлэх гэдэг тамтай учраас горшоокийг нь үргэлж бэлэн байлгана.

Хоёулаа бусад хүүхдүүдтэй адил кино үзмээр санагдана. Тийм үедээ хоёр уйланхайгаа ээлжилж харна. Гоё кино ирсэн сураг комбинатын байруудаар тарж, дуулиан шуугиан болоход хоёулаа хамтдаа явж үзмээр болно. Хоёр дүүгээ аваад кинонд орчихно. Дүүгийнхээ горшоокийг торонд хийгээд, Зоригоо нь үүрчихнэ. Кино тал дундаа ч ороогүй байтал өнөөх хоёр дүү нь уйлж эхэлнэ. Хажууд суугаа найз нар ч юм хэлэхгүй. Харин өмнө хойноос танихгүй хүүхдүүд уцаарлаж, “Наад лайтай уйланхай юмнуудаа аваад гараач ээ!” гэж хөөнө. Ажилчны соёлын ордонд бөөн орилоон болоод, киноноос гарахаас өөр аргагүй болох нь харамсмаар. Хяссан юм шиг киноны хамгийн эгзэгтэй үед нь уйлахыг яана. Маргааш нь өнөөх гоё киногоо нөхөж үзэхээр дахиад л тавин мөнгөний эрэл болно. Хүүхдийн киноны тасалбар тэр үед тийм хямдхан байж.



Хүүхдүүд ийнхүү дүү нараа асарч аав ээждээ дэм болоод зогсохгүй зуны амралтаараа ажил хийнэ. Гэрэлмаа зургадугаар анги төгссөн жилээ Баян-Уул амралтанд хоол зөөгч хийж эхлээд, анхны хөдөлмөрийн дэвтрээ тэндээс гардан авч байж. Зөөгчийн ажил тийм ч хялбархан боорцог биш. Үүрээр 6 цагт босч ширээнүүдэд цөцгийн тос, талх тавина. 300 амрагчийн ширээг засч, хоолыг зөөсөөр үдэш 11 цагт л гэртээ харина. Бүгд унтчихсан байдаг учраас охин өлмий дээрээ гишгэлэн гэртээ ороод, бага дүүгээ өвөртлөн унтана. Маргааш өглөө нь ажилд яваад ирсэн гээд ямбалаад унтаад байхгүй, бас л хар үүрээр босоод бага дүүгийнхээ баастай өмдийг угаана. Зоригоо дүү нь ой руу явж, түлээний гишүү түүж ирнэ. Хоёулаа ээлжлэн усандаа явна. Ээж нь бие муутай хэрнээ амралтын зохион байгуулагчаар ажиллаж, их ядардаг учраас ээждээ туслахсан гэсэндээ охин хүү хоёр ийнхүү өдөрт зүгээр суухгүй. Цэдэв амралтын зохион байгуулагч болохоор бүх зүйлд оролцож өдөржин ажиллаж их ядарна. Шинээр ирсэн амрагчдыг байрлуулж, хоолны ширээ хуваарилна. Аав чех даргын жолооч хийж байгаа болохоор голдуу оройтож ирнэ. Томчуудын хувьд нийгмийн ажил нэгдүгээрт тул хүүхдүүдийн хувьд жараад оны бор хоногууд ийм л байдалтай өнгөрдөг байж.

1966 оны аймшигт үер

1966 оны наадмыг гэр бүлээрээ Баян-Уул амралтанд тэмдэглэнэ гэж бэлдэцгээв. Доржсүрэн хонь авчирч төхөөрүүлж, шинэ шөл ууж, бүх монголчуудын адил бөхөө сонссон шиг наадамлах гэж байж. Үндэсний телевиз арай л нээгдэж амжаагүй байсан учраас наадмыг радиогоор л тайлбарладаг байсан үе. Гэтэл охин Гэрэлмаа нь дүү Зоригттойгоо явж наадам үзнэ гэж зүтгээд, хоёр нялх дүүгээ үүрээд дөрвүүл явцгаах юм болов. Том болсон хүүхэд наадам руу зүтгэх нь зөв. Голын цэнгэлдэхэд очоод амттай юм авч идэж, наадам үзээд ирэхэд буруу юу байхав гэж аав бодож. “Хоёр дүүгээ наршуулчихав аа. Хамаагүй юм идүүлээд гэдсийг нь өвтгөчихөв өө” гэх зэргээр ээж нь баахан захиа даалгавар хэлээд өнөөх дөрвийг өглөө эрт автобусанд суулгаж өгөв.

Амралтын хоолны газар зөөгч хийж байсан Гэрэлмаа наадмын урьд өдөр урьдчилгаа цалин 130 төгрөг авчихаад тийнхүү хот руу зүтгээд байсан хэрэг. Хоёр дүүгээ үүрч тэвэрчихсэн, баадантай горшоок мөрөвчилсэн хөгийн дөрвөн хүн Их дэлгүүрийн орчимд автобуснаас бууцгаав. Австри үйлдвэрийн каучукан ултай, наян төгрөгийн үнэтэй хөөрхөн гутал худалдаж авсан охин хөл нь газар хүрэхгүй шахам гүйлээ. Гутлын үйлдвэрийн ерөнхий механикийн охин гутлын хоббитой болчихоод, зөндөө гуталтай хэрнээ л дахиж авах гэж зүтгэдэг зантай. Ээж нь ажил хийж цалин авдаг охиндоо энэ удаагийн мөнгөө өөрөө мэдэж зарцуулахыг зөвшөөрөөд, “Дэмий үрчихэлгүй, өөртөө хэрэгтэй юм аваарай” гэсэн нь энэ. Тэр үеийн 130 төгрөг гэдэг бүтэн сар наадамдаад ч үрэгдэж дуусахгүй их мөнгө. Гоё гутлаар гангарсан охин дүү нартаа чихэр жимс авч, хэдэн дүүдээ элдвийг сонирхуулан наадмын талбайгаар баахан зугаалав.

Бөхөнд хорхойтох биш, наадмын хуушуур амталж, циркийн тоглолтыг гайхаж сонирхон үзлээ. Тэгтэл хүмүүс “Үер!” гэж орилолдоод гүйлдлээ. Хоромхон зуурт л ус нэлийж газрыг хавтгайд нь бүрхчихсэн нь аймаар. Гэрэлмаа шинэ гутлаа хайрлаж, дүүгийнхээ бааданд горшооктой хамт боож үүрчихээд хүмүүсийг даган яаран хөл нүцгэн алхлаа. Цэнгэлдэхээс гараад, “Зуун хорь”-ийн автобусны буудал хүрээгүй явж байтал ус гуяар тагчихав. Зарим нэг газар ус пүлхийн бүсэлхийд хүрэхэд амьсгаа давчдаад зүрх амаар гарчих гэнэ. Уйлаад л, дүүгээ тэврээд л зүтгээд байдаг. Дүү Зоригт нь араас дагаад дүүгээ үүрээд алхаад л байдаг. Энд тэндгүй орилж чарласан хүмүүс. Холгүйхэн нэг эмэгтэй хүүгээ алдчихсан бололтой. Толгойгоо тэврээд “Миний хүү! Миний хүү!” хэмээн галзуу юм шиг орилох нь нүд хальгирмаар. Хөлгүй ус руу харайж орох гэж зүтгэх түүнийг өөр нэг хүн хорьж, холдуулж чирч байгаа бололтой.

Гэрэлээ дүүгээ унагаачих гээд байх нь хэцүү. Хоёр нь гар нь цуцаад мэдээгүй юм шиг бадайрна. Эрэгтэй дүүгээ зоригжуулж,

-Миний дүү, хоёулаа одоохон гэртээ очлоо! гэж байн байн үглэж, уйлсаар л явлаа. Дүү нь эр хүн гэсэндээ нулимсаа урсган, шүд зуун зүтгэсээр л яваа харагдана. Тэгтэл цаахнатай аймшигтай болсон царай хальт харагдаж, айж хиртхийсэн охин бушуухан нүүрээ бурууллаа. Үерт эндсэн хүүхэд урсаж явсан нь тэр. Энэ нүд хальтрам дүр зураг охины нүдэнд хэдэн жилдээ харагдсаар, зарим шөнө зүүдлэгдсээр л байсан гэдэг.



Их ядарч байж гэртээ хүрвэл байрны гадуур битүү ус урсана. Орцондоо ороод хоёр давхарт гараад иртэл гэрийнх нь хаалгыг эвдээд нэг давхрынхан, гэр хорооллын танил айлын хүмүүс орчихсон, сандралдаж уйлалдаж байлаа. “Охин минь! Аав минь! Тэр минь..!” гээд л ухаан зулаггүй уйлцгааж хажуугийн хүмүүс нь тайвшруулахыг оролдоно. Үймж сандарсан хүмүүс хэдий хойно л Доржсүрэнгийн дөрвөн хүүхэд гэртээ орж ирээд уйлалдаж байгааг анзаарч, аргадаж тайтгаруулсан гэдэг. Хэзээ нь ч шилний хагархай гишгэсэн юм бүү мэд, Гэрэлмаагийн хөлийн таваг том гэгч зүсэгдсэнээс цус садарч байсныг айлынхан хөвөн шатаан дарж, боож өгөв.

Комбинатын таван давхар байрнуудын нэг давхар бүхэлдээ үерт автсан байлаа. Зарим байрныхан орцныхоо хаалгыг элстэй шуудайгаар манаж хамгаалж амжаад, нэг давхрын цонхоороо орж гарч байсан гэдэг. Хүмүүс учиргүй уйлалдахыг бодоход үхэл хагацал зөндөө юм болсон бололтой. Нилээн доош төмөр замын далангийн орчимд усны түвшин их өндөр байсан учир тэндхийн айлууд нилдээ усанд автсан байлаа. Орос цэргүүд усанд хөвөгч хуягт машинтайгаа нааш цааш явж усанд хашигдсан хүмүүсийг авч байгаа нь цонхоор харагдаж байж.

Баян-Уул амралтанд хашигдчихсан Доржсүрэн, Цэдэв хоёр хүүхдүүддээ санаа зовж, бараг л галзуурах нь холгүй байтал ашгүй хүүхдүүд нь гэртээ ирж утсаар хэл ул авалцаж санаа амарсан гэдэг. Гэхдээ л үерийн ус татарсны дараа хоёул сандчин явсаар байрандаа ирж, ус туулж алхсаар байж амьд мэнд үлдсэн хүүхдүүдээ тэвэрч нулимс мэлмэрүүлсэн гэдэг. Утас хангинаж, Доржсүрэн үйлдвэр лүүгээ дуудагдаад гараад явчихлаа. Харин Цэдэв хоёр бага хүүхдээ энгэртээ наан удтал суусаар байж. Хэрвээ дөрвөн хүүхэд нь амь үрэгдчихсэн бол эцэг эх хоёр шууд л галзуурах байсан гэдэг. 49 онд анхны хүү нь гараад нас барсан. 1954 онд ихэр охин гараад бас үрэгдсэн. Түүний дараа гурван хүү дараалаад эндчихсэн айл шүү дээ! 1951, 53 онд төрсөн Гэрэлмаа, Зоригоо хоёр, 62, 63 онд дараалж гарсан хоёр дүү Гүндэгмаа, Аюурзана хоёрыгоо тийнхүү чирч гулдарсаар амьд гарсан, 55, 56 онд төрсөн гурав, хоёрдугаар ангийн Цэрэндулам, Цэндсүрэн хоёр охин нь үерийн өдөр аав ээж хоёртойгоо Баян-Уул амралтанд үлдсэн байж.

Дангаа дарга Баян-Уул амралтын бүх ажилчдыг дуудуулсан байлаа. “Орон гэргүй болсон, өлсөж цангасан, энэ олон хүмүүст боорцог хийж өгнө” гэж тэр санаачилга гаргалаа. Амралтын бүх ажилчид, тогооч нарыг хот руу татаж, 28 дугаар цэцэрлэгийн гал тогоонд боорцог хийж эхлэв. Амралтын хоол зөөгч Гэрэлмаа боорцогны түгээгч боллоо. Өглөөнөөс

эхлээд боорцгоо хийж байтал, хүмүүсийн дараалал маш урт болчихно. Ядарсан зүдэрсэн хүмүүс хөлсөө гоожуулан зогсоод л. Нилээн том мушгиа боорцгийг хүний тав таваар өгөх хуваарьтай. Гэр орноо үерт алдсан, үхэл хагацал тохиосон хүмүүсийг Гэрэлмаа таних учир өрөвдөөд илүү боорцог өгдөг байлаа.

Түүхэнд хараар бичигдсэн тэр их аюул гачланг долоодугаар ангийн охин нүдээрээ харсан нь энэ. Үер зарим газраа охины бүсэлхийнээс ч дээгүүр татаж байсан гэдэг. Өмнө амьдардаг байсан хашааны хавь тэр чигтээ үерт орж, олон айл хохирсон байлаа. Автобустай хүмүүс тэр чигтээ урсаж, үхэл хагацал тохиосон нь аймшигтай. Газрыг хавтгайд нь бүрхэж нэлийсэн усан дотор, тэр их хүчтэй урсгал дунд долдугаар ангийн охин, тавдугаар ангийн хүү хоёр, дөрөвтэй, гуравтай хоёр дүүгээ хэрхэн тэвэрч, үүрч, чирч гулдарсаар амьд гарсан нь эргээд бодоход аймшигтай. Яаж амь үрэгдчихэлгүй ирснийг нь хүмүүс гайхдаг.

Үйлдвэр минь яагаа бол?

1966 оны наадмаар ийм их гамшиг тохиох юм гэж хэний ч санаанд ороогүй гэдэг. Үйлдвэр комбинатын удирдлага, ажилчид Голын цэнгэлдэхэд бөх үзэж, наадмын хуушуур амталж, зарим нь зусланд радио хүлээн авагч чагнаж, тааваараа сайхан сууцгаасан гэдэг. Хүчтэй аадар бороо орж эхлэхэд наадамчид бүгд шүхрээ дэлгээд цэнгэлдэхийн суудалд хоргодон, аварга арслангуудын барилдаанд шимтсээр л байж. “Бөх яаж дуусдаг бол?” л гэж санаа зовж байснаас, их устай борооны тухайд огт санаа зовоогүй гэдэг. Гэтэл үерийн ус наадмын талбай руу ороод ирэх нь тэр! Хүн бүхэн үймэлдэн сандарлаа. Нүд ирмэх зуурт олон айлын гэр урсаж, олон зуун хүн хохирчихсон байж. Маршалын гүүр унаж, хоёр ч автобус зорчигтойгоо урсаж, олон хүний амь эрсэдсэн байлаа.

Үйлдвэрт 1 метр 20 сантиметр ус орсныг хананд үлдсэн усны мөр харуулж байв. Бүх машин тоног төхөөрөмж усанд автаад, нилдээ шавар шавхай болсон нь хүн зориудаар шавраар шавчихсан юм шиг харагдана. Машиныудаа нэг бүрчлэн задалж цэвэрлэхээс өөр аргагүй болсон гэдэг илт. Энэ бол их хугацаа авах, луг том багтаамжтай ажил. Машин бүрээ задлаад, эд ангийг нь цэвэрлэн хатааж, халуун сэнсээр үлээлгэлээ. Зөөж болох эд ангиудыг нь гадагшаа гаргаж наранд дэлгэж ч хатаах арга сүвэгчлэв. Лаг шавар, элдэв янзын хог, зомгол холтос үйлдвэрийн байрны шалаар нэг тарчихсан байсныг цэвэрлэж, гадагш зөөж, олон машин хог руу ачууллаа. Ажилчид нойргүй ажиллаж байсан бөгөөд бүтэн долоо хоног гэртээ харилгүй ноцолдож байж үйлдвэрээ, машиныудаа цэвэрлэж дөнгөсөн юм. Найм дахь хоногийн өглөө гэхэд л үйлдвэрийн машинууд ажиллаад, үйлдвэрлэл жигдэрчихсэн байсан нь гайхмаар. Ингэж түргэн хугацаанд үйлдвэрээ хэвийн ажиллуулж дөнгөнө гэж удирдлагын толгойд огт багтаагүй байсан гэдэг.

Конвейер, ширээн дээр байсан гутлууд усанд урсаад хаалган дээр очоод бөөгнөрчихсөн байсан нь яг л амьд амьтад үерээс амиа хамгаалах гэж тэмцсэн гэхээр. Хаалганы завсар луу ус урсахаар тийшээ очиж овоорох зүйн хэрэг. Хүмүүс хонож ажиллаж байгаа болохоор ажилчдад өдрийн гурван хоол зөөж өгнө. Энэ өдрүүд нойргүй олон хоноод гөлийчихсэн явдаг байсан дайны жилүүдийг эргэн сануулж байж. Машины эд анги нэг бүрийг шалгаж, цэвэрлэх шиг тамтай урт ажил үгүй гэдгийг ерөнхий механик тэр өдрүүдэд мэдэрсэн гэдэг.

Хатааж буй машины эд ангиудыг шалгаад зогсож байсан чинь Доржсүрэнгийн ард маш танил жонгиносон хоолой сонсогдлоо гэнэ. “Юу билээ?” гэж бодогдлоо. Толгойгоо эргүүлж хараад нүдэндээ итгэсэнгүй. МАХН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Сайд нарын зөвлөлийн дарга Юмжаагийн Цэдэнбал ирж явна! “Олон хоног нойргүй байсаар хий юм харж, ухаан самуурч байна уу?” гэж эргэлзэв. Аж үйлдвэрийн яамны сайд, Аж үйлдвэрийн комбинатын дарга нар гээд баахан дагуулууд араас нь зүүгдээстэй. Яах аргагүй Цэдэнбал дарга мөн. Үйлдвэрийн дарга,

-Энэ манай Гутлын үйлдвэрийн хашир механик, намын гишүүн Доржсүрэн гэдэг хүн байгаа юм гэж түүнийг танилцууллаа. ЭЗХТЗ-ийн төлөөлөгч нөхөр Углекийн жолооч, үерт бохирдсон машин цэвэрлэхэд дайчлагдаад ажиллаж байгаа юм гэлтэй биш. Дарга зөв л танилцуулж.

-Нөхөр механик, та хариул даа. Энэ машинуудыг долоо хоногийн дотор цэвэрлэж, ажилд оруулна гээд байх юм. Та нар чадах уу? гэж Цэдэнбал дарга хоолойгоо жонгинуулан асуулаа. Гэнэтийн уулзалтанд тулгамдсан Доржсүрэн хэсэгхэн зуур түгдэрснээ,

-Чадна аа. Ажилчид өдөр шөнөгүй ажиллаж байгаа гэчихлээ.

-Сайн байна. Зүйтэй.., гэж дарга хэлээд цаашаа явлаа. Үйлдвэрийн дарга нар түүнд үерийн усны ороор ханан дээр гарсан зураасыг үзүүлж, метр хорин сантиметр ус орсныг тайлбарлалаа.

-Гүй мөн сонин юм аа. Ийм гүнзгий үер явсан байна шүү дээ! гэх жонгиносон дуу үйлдвэрийн дөрвөн хананд цуурайтав. Ингээд олон оцон шувуу шиг хар костюм цагаан цамцтай дагуулуудаа хуйлруулсаар Бал дарга гараад явчихлаа. Доржсүрэн тэр том хүнтэй ярилцаж үзлээ гэж баярлах байтал, сэтгэлд нь асар их гуниг хураад явчихсан гэдэг. Энэ санаандгүй уулзалт Маршал Чойбалсанг ирэхэд “Хүүхэд болохгүй” гээд слесариудын өрөөнд хорьчихдог байсан гунигт өдрүүдийг нь эргэн санагдуулснаас тийнхүү сэтгэл өвдсөн хэрэг байлаа.

Засварын бригадын ажилчдаас Наваанлуvsан гуайнх, Лувсанцэрэнгийнх гээд хэдэн айл үерт орсон байлаа. Гэр нь үерт орчихсон, хамаг юм нь норчихсон хэрнээ л амин хувийн эд зүйлсээ зуун задгай орхичихоод үйлдвэр лүүгээ гүйгээд ирсэн гэдэг. Ажилчид үйлдвэртээ тийм л их сэтгэлтэй ханддаг байж.

Үйлдвэрээс хүн хүч, машин гаргаж үерт орсон бүх айлдаа тусаллаа. Наваанлуvsан гуайн гэрийн бүх эд хогшил норчихсон, хэцүү байсныг засварчид нүүлгэж, гэр орныг нь барьж өгөөд ирж байлаа. Энэ үерийн сургамжаар Дунд гол орчим байсан гэр хорооллыг Яармаг руу нийтээр нь нүүлгэн шилжүүлэх шийдийг дээрээс гаргаж байв. Тэнд ингэж л Яармаг гэх хороолол үүссэн түүхтэй. Ажиллаж дассан газраа, өдөр бүр ажилладаг машинуудаа ажилчин хүн чин сэтгэлээсээ хайрладаг гэдгийг 1966 оны тэр их үер мэдрүүлж өгсөн гэдэг.

Нутаг буцаана!

Чех дарга хэдий хорин хэдэн настай ч их сүрхий. Юмны наана цааныг мэддэг, хатуу юмандаа хатуу, зөөлөн хандах зүйлдээ зөөлөн хандаж чаддаг залуу байлаа. Барилгын талбайгаа байнга эргэнэ. Ажилчдын байр, ажилчдын гуанзаар орж шалгана. Углек ирсэн гэж дуулвал тэнд байсан хүмүүс дарга цэрэггүй “түргэн жагсаал” зарлаж бэлэн байдалд ордог байлаа. Углекийг нэгэн удаа барилгын талбай руу хүрч иртэл нэг монгол цэргийг чех мэргэжилтэн зодож байгаад халз тулчихаж. Даргадаа яалт ч үгүй баригдсандаа өнөөх мэргэжилтэн гөлсхийгээд, хэлэх үггүй зогсчихлоо гэнэ. Углек муухай харж, чимээгүй хэсэг зогсоод,

-Энд юу болж байна? гэж ууртай асуулаа. Бригадын дарга түгдрээд,

-Энэ нөхөр залхуураад, ажлаа хийхгүй байсан юм.., гэж. Цэрэг ч хөөрхий гөлөлзөж, айж байгаа гэж жигтэйхэн. Толгойгоо маажин зогсож байв. Үйлдвэрийн барилгыг хариуцсан хамгийн том дарга ууртай харцаар мэргэжилтнээ нэвт шувт цоргиж байснаа явчихлаа гэнэ. Мэргэжилтэн “Гайгүй өнгөрөх нь энэ үү?” гэж горьдов. Гэвч мэргэжилтэн даргаа дутуу таньсан байж. Углек барилгын талбайгаар явахдаа олон үг ярьдаггүй. Чимээгүй хараад л, ажаад л алхаад байдаг. Харин яриагаа өрөөндөө хийж, зөрчил доголдол гаргасан этгээдийг юм үлдэхгүй болтол нь бут ниргэдэг зантай. Хэдхэн минутын дараа өнөөх цэрэг зодсон мэргэжилтнийг Углек дарга өрөөндөө дуудлаа.

-Чи монгол хүмүүст барилга барьж туслах гэж ирсэн билүү? Эсвэл монгол хүнийг зодох ирсэн үү? гэж ширүүн асуулаа. Мэргэжилтэнд хэлэх үг олдсонгүй. Хэсэг чимээгүй байснаа, зориг гаргаад,

-Тэр цэрэг удаа дараа залхуураад, бусаддаа муу үлгэр үзүүлээд байсан. Сургамж болоосой гэсэндээ л би гар хүрсэн.., гэж өөрийгөө өмөөрлөө.

-Цэрэг сайн муу байх нь энд хамаагүй. Чи түүнийг зодсон! Чиний буруу юу?

-Тийм. Миний буруу...

-Би одоохон чиний буцах онгоцны тийзэнд хүн явуулна!

Ийм яриа дарга мэргэжилтэн хоёрын хооронд өрнөлөө. Тэр хүн зодсон этгээдийг маргааш нь гэхэд л нутаг буцаачих нь тэр! Үүнээс хойш чех барилгачид Монголын барилгын цэргийн ангийн байлдагч нартай маш хүндэтгэлтэй харьцдаг болсон гэдэг. Монголд ажиллаж байсан чех мэргэжилтнүүд өндөр цалинтай, сайн хангамжтай учраас нутаг буцаах гэдгээс амиа гартал айдаг байж. Тэдний хувьд “Нутаг буцаана” гэх үг “цаазаар авна” гэсэнтэй л утга нэг сонсогддог байлаа.

“ARO” Ав!

Доржсүрэн зургаан жил Углек даргын тэргийг барилаа. Дарга жолооч хоёр өдрийн ихэнх цагийг хамтдаа өнгөрөөдөг болохоор бие биенээ мэдэж, ойртож дотносох нь ойлгомжтой хэрэг. Буцах болчихоод байх үедээ “ARO” тэргээ заагаад,

-Энийг чи ав гэлээ. Доржсүрэн чихэндээ итгэсэнгүй. Жолоочийнхоо гайхаж байгааг хараад, чех дарга үгээ дахин давган хэллээ. Хувьдаа машинтай болох гэдэг Доржсүрэнгийн насны мөрөөдөл. Гэвч тэр үнэтэй бэлгийг авья гэж хэлж яагаад ч чадсангүй.

-Ингээд зүгээр л бэлэглэчихэж болох юм уу даа? гэж асуулаа.

-Бололгүй яах вэ! Чи наад тэргээ дуугүй ав! гэж байна.

Авчихлаа гэж бодъё. Тэгтэл зөвхөн ганц хоёрхон сайд, дарга албан хэрэгцээндээ унадаг, Монголд тэгтлээ түгээгүй, Румын үйлдвэрийн ховор тэргийг хаанаа унах вэ? Улсын хэмжээнд ийм маркийн тэрэг хувь хүнд нэг ч ширхэг зарагдаагүй байдаг. Тэгээд ч тэр үед хувьдаа машинтай хүн маш ховор. Цөөхөн хэдхэн хүн л “Москвич” гэх суудлын тэрэг худалдан авч, унаж эдэлдэг байсан цаг. Энэ тухайгаа тайлбарлаж хэллээ. Тэгтэл,

-Тийм бол чи энэ тэргийг нэг газар аваачаад тавьчих. Хэзээ нэг цагт танайд ийм тэргийг хувь хүмүүс унадаг болно. Тэгэхээр нь гаргаад ир! гэж. Албан хэрэгцээнд л байдаг тэргийг авна гээд бодохоор яагаад ч санаанд нь багтсангүй. Тэгээд хаанаа аваачиж, хэдэн жил нууж, хувьд гарахыг нь хүлээх вэ? Аль ч талаас нь бодоод үзсэн тэр бэлгийг авна гэдэг учир утгагүй. Хэн нэг нь алтан хошуу хүргэчихвэл цагдан сэргийлэхийн ажилтнууд ирээд,

-Ийм машин хаанаас авсан? Хулгай хийсэн үү? гэж байцаагаад шорон оронд ч хийчихэж мэдэх. Ийм учраас авч яагаад ч чадахгүй гэдгээ хэлж. Углек өөртэйгөө дотносоод, ах дүүс шиг болчихсон монгол найзаа, сайн ажиллаж байсан жолоочоо баярлуулах гэж зүтгэсээр л байлаа.

Углекийн царай төрх нь гомдонгуй. “Болно шүү дээ. Ав л даа?” гэж дахин дахин ятгаад, бэлгээ өгөх гэж зүтгэлээ. Гэвч бүтсэнгүй. Жолооч нь үгүй гээд л гэдийгээд байх нь тэр. Чех залуу их гомдолтой буцлаа. Тэр “ARO” тэргээ яасан нь бүү мэд. Харин “Волга” тэргээ Үйлдвэрийн ерөнхий инженерт бэлэглэсэн байдаг.

Углек нутагтаа очиж нилээд хэдэн жил ажиллаж байгаад, сүүлд нь Чехсловак улсын Барилгын яамны сайд болж байлаа. Доржсүрэнг Чехэд дадлагын ажилчдыг авч ирснийг сонсоод гэртээ урьж долоо хоног хамтдаа байж, нанчид хүртэж, дайлж цайлж, аялал зугаалга хийж байж. Доржсүрэн ийнхүү зургаан жил чех даргын жолооч хийснийхээ дараа буцаад, Эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн төвд ерөнхий механикаар ажиллалаа. Энэ төв нь шинжилгээ туршилт хийж, үйлдвэрүүдэд загвар гаргаж өгдөг. Үйлдвэрийн технологи туршиж, шинэ технологи боловсруулдаг газар байлаа.

Генерал хүний сүрхий үг

Чех улсын тусламжаар шинэ үйлдвэрүүд баригдаж, оросынхыг бодвол илүү дэвшилттэй орчин үеийн технологи бүхий шинэ машинууд суурилуулагдаж, хүн бүхэн баяртай. Ирсэн дарга бүхэн үгээ олохгүй магтаж, Чехословак улс бол гутлаараа дэлхийд гайхагддаг. Тийм болохоор манай гутал ч бас тийм болно хэмээн бахдацгааж байлаа. Харин нэг л хүн эсэргүү үг хэлсэн гэдэг. БНМАУ-ын Батлан Хамгаалахын Сайд байсан Хурандаа генерал Жамъянгийн Лхагвасүрэн нэгэн удаа шинэ үйлдвэрийг ирж үзэв. Үйлдвэрийн дарга нар түүнээс,

-Сайхан үйлдвэр боссон байгаа биз, генерал аа? гэж асуув.

-Сайхан л үйлдвэр болж. Гэхдээ алдаж байна уу? Хожиж байна уу? бүү мэд дээ. Алдах алдахдаа алдаар алдав уу? Дэлмээр алдав уу, мэдэхгүй юм гэсэн гэдэг. Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл (ЭЗХТЗ)-ийн орнуудын тусламжаар Социализмын материал техникийн баазыг байгуулах ажил ид өрнөж, Чехийн тусламжаар шилдэг технологитой үйлдвэр байгуулчихаад байхад ийм үг хэлдэг хүн гэж байх уу? хэмээн дарга нар дотроо гайхаж, хурандаа генерал хүн байтлаа ийм ухаангүй мулгуу үг хэлэх гэж..? Энэ хүний толгой нэг биш болжээ... гэж бодож байж.

Жанжин Лхагвасүрэнгийн үг байны яг голд туссан сум байж. Сүрхий үг! Олон газар явж, олон үндэсний хүнтэй уулзаж, нүд тайлсан хүний хувьд чехүүдийн занг мэддэг байсан хэрэг. Доржсүрэн анх энэ үгийг сонсоод мөн л “Яаж ийм үг хэлж чадаж байна аа? Сайхан үйлдвэр шүү дээ!” гэж чехүүдээ өмөөрч байж. Гэтэл удалгүй генералын үг ортой болохоо харуулж эхэлсэн гэдэг.

Шинэ сайхан гээд байсан машинууд нь эвдэрч зогсох явдал тохиолдож эхэллээ. Дагаж ирсэн сэлбэгнүүд дотор нь гэтэл чухал хэрэгтэй сэлбэг байсангүй. Эвдэрсэн машины сэлбэгийг Чех улс руу захиаллаа. Тэгтэл удалгүй “Энэ маркийн машиныг Чех улсад хэрэглэхээ больсон. Тийм учраас сэлбэгүүд нь байхгүй, устсан болно” гэсэн хариу ирэх нь тэр. Өнөөх хариундаа цааш үргэлжлүүлэн, “Манайх ийм төрлийн технологийн ажиллагааг гүйцэтгэхийн тулд ийм маркийн шинэ машин хэрэглэдэг болсон. Тийм учраас энэхүү шинэ маркийн машиныг авах нь зүйтэй” гэсэн байна.

Механик Доржсүрэн өмнө дандаа оросын машинууд дээр ажиллаж байсан болохоор шинэ машинуудын өөг олж харлаа. Чехийн машин орос машинуудыг бодвол хэврэг. Дээр нь сэлбэг таарахгүй. Өмнө орос машины сэлбэгийг өөрсдөө хийдэг байсны хэрэг юу билээ, байхгүй сэлбэгүүдээс хийх нэгийгээ хийлээ. Гэвч зарим нэг сэлбэгийг нь яагаад ч хийх аргагүй. Машинууд их нарийн болохоор заавал тусгай багаж, суурь машин дээр деталийг нь хийх болчихно. Тэр нь байхгүй болохоор арга байхгүй. Деталийг ганц нэг миллиметр алдаатай хийхэд оросын машинд яваад л байдаг. Гэтэл чех машинд тийм алдаатай деталь тавих юм бол шууд л гацна. Их нарийн. Ойр зуурын сэлбэгийг нь л хийж чаддаг байлаа.

Өсгий хаддаг машин гэхэд нэг нэг хадаасаар нь тоншоод байхгүй. Ганц тасхийхэд 14 хадаас зэрэг хадагдана. Автоматаар хадаас нь орж сумлагдана. 14 нүхтэй шон элэгдээд уужирчихна. Нүхэндээ холхиж байгаа учраас хадааснууд нь гулзайдаг болчихно. Орлуулаад хийе гэхэд

нарийн төхөөрөмж нь байхгүй. Ингээд л зогсох болно.

Шинэ үйлдвэрийн машинуудад үйлчилгээ хийх, зарим эвдэрснийг нь засах гээд задална. Тэгтэл голдуу гадна арьсыг нь сайхан будчихсан хуучин машинууд байж таарна. Их засвар хийж, цэвэрлэж, будаж хайрцаглаад л нааш нь ачуулчихсан хэрэг. Бүр газар дээр нь Чех улсад нь очиж сэлбэг олж ирэх оролдлого ч хийж байж. Өнөөх л “Тэр машиныг хийхээ байчихсан. Шинэ машин ав!” гэсэн хариуг сонсоод ирж байв. Үйлдвэрийн дамжлагаа зогсоохгүйн тулд шинэ машиныг нь худалдаж авч эхлэв.

Чехүүд тийм л нарийн аргатай. Наймаан дээр чехүүдийг барж идэхгүй гэж ярьдаг нь үнэн болж таарав. Генералын эсэргүү үг, сүрхий үг байсан нь энэ.

Шавь нар

Социалист нийгэм байгуулж байгаа болохоор бүх зүйлд олон нийтэч хандах ёстой. Өөрөө ажлаа сайн хийгээд, төлөвлөгөө нормоо биелүүлээд явах яахав бусаддаа заавал туслах ёстой. Бригад, хамт олныхоо төлөө нийгэмд тустай үйл хийх ёстой. Залуу ажилчдаа сургаж, халамжлан хүмүүжүүлэх үүрэгтэй.

Арван дөрвөн настай дэлчгэр хөх хүү үйлдвэрт орж ирж байснаа бодвол нэг л мэдэхэд олон шавьтай хашир туршлагатай гэгдэх хүн болчихсон байлаа. Түүнтэй хамт Чех улсад явж, чех багш нарт чадвараа гайхуулж, нүдийг нь оройд нь гарган шагшруулж байсан цахилгаанчин Самдан гэгч залуу бол түүний шавь. Доржсүрэнг “Багш аа” гэж дуудна. Чадварлаг цахилгаачин маань санаанд багтамгүй өндөр нуруутай, цана шиг том хөлтэй.

-Надад хэр баргийн гутал таарахгүй юм аа, яах вэ гэж үглэж явна. Доржсүрэн шавьдаа зориулж хамгийн том колодкаар гутал хийлгэж байж. Тэгтэл өнөөх палбийсан том гутал нь таарсангүй. Яаж ч татаад хөлд нь орохгүй байлаа. Тэгэхээр нь ажлын хар бакалны хамгийн том колодка олж ирээд, урд талд нь юм нэмж барьж хадаж байгаад гутал хийж өгч байв.

-Эв хавгүй, муухай л юм болчихлоо доо гэсэн чинь,

-Хөлд таарч л байвал сайхан муухай нь яах вэ гээд инээж байж.

Доржсүрэнгийн шавь нарын тоо жил ирэх тутам нэмэгдсээр л байна. Гомбо, Болд, Гэлэгдорж, Жүрмэддорж, Бор, Дащэвэг гээд нэрлээд байвал урт жагсаалт болохоор олон шавьтай. Цэл залуухан хүүхдүүд механикийн гар дээр ирж байснаа удахгүй хөл нь дөрөөнд, гар нь ганзганд хүрээд, сайн слесарь, сайн засварчин гэж хүндлэгдээд явчихдаг. Өнөөдөр тэднээс хоёр нь ч ертөнцийн мөнх бусыг үзүүлчихэж. Тавин хэдэн оны үед Бэгзсүрэн гэгч хүү Орос улсад дээд сургууль төгсөөд ирж байлаа. Архи дарс уудаггүй, тамхи ч татдаггүй, их томоотой залуу. Тэр бас Доржсүрэнгийн шавь нарын тоог нэгээр нэмсэн юм.

-Чи дээд сургууль төгссөн хүн. Яалаа гэж би чиний багш байх вэ? гэхээр,

-Үгүй ээ, багш аа. Танаас би их юм сурсан. Яалт ч үгүй та миний багш шүү дээ гээд инээнэ. Доржсүрэн Гутлын үйлдвэрийн орлогч дарга болж дэвшихдээ, Бэгзсүрэн шавьдаа ерөнхий механикийн албаа хүлээлгэж өгсөн гэдэг.

-Бэгзсүрэнг би өөрийнхөө оронд, ерөнхий механикийн албан тушаалд томилох бодолтой байна гэж удирдлагын хуралд санал оруулж байлаа. Бэгзсүрэн Дондогтой хамт нэг жил төгсөж ирж байсан бөгөөд, хоёр залуу нэртэй төртэй, сайн ажиллаж, амьдралаа үйлдвэр комбинаттай холбосон. Эхнэр хүүхэдтэй болцгоож, өрх гэрээ босгоцгоож, гал голомтоо бадраасан. Хожим Дондог нь Арьс ширний үйлдвэрүүдийн нэгдлийн дарга болсон байдаг.

Сүүлд нь албан ёсны багш ч болж үзэв. Дангаа дарга, Шарав, Цоодол гуравтай хамт Чех рүү ажилчин хүүхдүүдийг авч явж байлаа. Арьс ширний үйлдвэрлэлийн нэгдлийн слесариуд болох арван найман хүүхдийг Доржсүрэн хариуцлаа. Арван найман хүний бүтэн жилийн

цалин, замын зардал, экскурс аялал хийх, бусад үйлдвэр үзүүлэх гээд бүх зардлыг Монгол банкнаас ажилчдыг хариуцсан хүнд олгодог байсан нь их сонин.

1991 онд тийнхүү Чехэд хэдэн хүүхэд хариуцаад байж байтал Монголд Ардчилсан хувьсгал болж байж. Чехийн телевизээр Монголын тухай байн байн гараад л. Чехүүд,

-Танай Монголд хувьсгал гарчихаж. Одоо тийшээ яваад хэрэггүй. Эндээ үлд гэцгээнэ. Удахгүй тэнд чинь дайн болно. Хэцүү! гэж байж. Ийнхүү Чех улсад бүтэн жил болоод, Углек даргатайгаа уулзаад, арван найман хөөрхөн шавьтай болчихоод ирж байж.

Өртэй биш авлагатай

Доржсүрэн Батширээт рүү ах руугаа жил болгон очно. 1985 онд очиход нь Гомбо ах нь бодлогошроод л, нэг л өөр болчихсон юм уу даа гэхээр байж. Хэд хоног амраад буцах гэтэл,

-Гурван дүүдээ гурван үхэр өгнө. Та нар маллаж чадах биш идшинд чинь нэмэрлэнэ. Өвөл идэш хөлдөх цагаар машинтай хүрээд ирээрэй гэж байх юм гэнэ. Өвөл болж, хүйтрээд ирэв. Ахын амласан үхрүүдийг авч ирмээр санагдаад, Хэнтий рүү явахаар шийдэв. Үйлдвэрийн дарга нараас үргэлж л машин унаа гуйж байдаг болохоор энэ удаа халшраад нэг л биш. “Хагас бүтэн сайн тааруулаад, гараажаас машин гуйгаад, сэм явчихаад ирье. Надад үгүй гэх биш” гэж бодогдов.

Үе тэнгийн болохоор их найзархдаг Самбуу гэж жолооч руугаа очив. Тэр саяхан шинэ самосвал авчихсан болохоор нууцаар явах ажилд, шуурхайхан ухасхийгээд ирэхэд хээр сууж саатчихна гэхгүй яг тохирно гэж тооцов.

-Хоёулаа “сайн эрийн” тээвэрт нэг яваад ирэх үү?

-Хаашаа вэ?

-Хэнтийн Батширээт рүү ухасхийх гэсэн юм. Найздаа яваад өгөөч.

-Үгүй. Би явж чадахгүй. Харин чи миний тэргийг аваад яв.

Ийм яриа хоёр найзын дунд болов. Үйлдвэрийн ерөнхий механик явсан, тэрэг техникт бузгай сайн болохоор жолооч нар түүнд тэргээ итгэж өгдөг нь энэ. Ингээд Доржсүрэн ч машиныг нь унаад явъя гэж зөвшөөрч. Найз нь хоёулахнаа хэрнээ, шивнэх шахам, “Гэхдээ, чи надад ганц хонины мах авчирч өгнө шүү” гэж байна. Доржсүрэн толгой дохив.

Явах бэлтгэлээ эртнээс базааж, үйлдвэрийн жолооч нараас арав хориор нь гуйсаар байгаад Хэнтий рүү бараг хоёр яваад ирэх бензин талонтой болчихсон учраас шатахуунд санаа зоволтгүй. Хагас сайны шөнө шинэхэн самосвал унаад гүйлгэж өгөх нь тэр. “Почоонк” гэж жолооч нар нэрлэдэг зам явах бичгийг гараажийн даргаар хийлгээд авчихсан болохоор Баянзүрхийн товчоогоор гарахад саадгүй. Харин Батширээт орохдоо Хэрлэнгийн товчоогоор оролгүй Мөнгөнморьтоор дамжаад, Хэрлэн голын мөсөн дээгүүр гарч давхив. “Үйлдвэрийн тэрэг энд юу хийж явна?” гээд шалгаж, хэл ам болж магад гэж айсан нь энэ.

Ирэнгүүт гурван үхэр хам хум төхөөрүүлээд, явна гэтэл ах нь дургүй. Хоноод явсангүй, шуурганд хөөгдсөн биш дээ гэж тунирхаад, дүүгээрээ хань татаад л байх юм гэнэ. Хөөрхий ах нь нэг л өөр байдалтай болсон нь илт анзаарагдана. Урьд өмнө нь ирээд буцахад нь ингэдэггүй байж.

Ингээд нэг өдрөөр хойшлоод, нэгдэх өдрийн ажил таслаад буцаж ирэв. Тэгтэл машин хулгайлж явсан хэрэг мандаад, бөөн хэл ам болчихсон байна. Дарга нар нь бүр цаашлаад Арьс Ширний Үйлдвэрлэлийн Нэгдлийн дарга Дондог руу оруулж банга хүртээв. Нэгдлийн

дарга,

-Яахаараа та машин хулгай хийдэг билээ? гээд л баахан загнав. Тэгснээ,

-Нөхөр Доржсүрэнд захиргааны шугамаар арга хэмжээ авна! гэж ууртай хэллээ. Тэгтэл нэгдлийн ерөнхий ня-бо Сүрэнхорлоо гуай ам нээлээ гэнэ.

-Чи юу хийж тийшээ явсан юм? Бидэнд хэлчихгүй дээ. Машин гаргаад л өгнө шүү дээ! гэж байна.

-Тэр ч үнэн л дээ. Нааш цаашаа явахад комбинат минь дандаа л унаа гаргаж өгдөг. Үнэнийг хэлэхэд дахин дахин унаа гуйхаасаа халширсан юм аа.., гэчихлээ. Доржсүрэнгийн ээжийн дүү Булганд амьдардаг. Түүний нөхөр аянганд ниргэгдэж нас барахад үйлдвэр “69” тэрэг гаргаж өгч тусалж байсан гээд л олон зүйл санаанд нь оров. Механикийн бодлогогүй үг Дондог даргын эгдүүг улам хүргэчихлээ бололтой,

-Гуйхаасаа халширсан. Хулгайн тээвэр хийхээсээ халшраагүй юм биз дээ? гээд улам уурлах шинжтэй харагдана.

-Батширээт рүү ирж очих зайг таксины тарифаар тооцоод энэ дураараа нөхөрт төлбөр тавь! гэж цухалдлаа. Тэгтэл Сүрэнхорлоо гуай дарга руугаа нухацтай харж, хэсэг азнаснаа шал эсрэг юм хэлэх нь тэр!

-Тэгж ярихдаа тулвал ч Доржсүрэн комбинатад биш, комбинат Доржсүрэнд өртэй гэдэг байгаа. Тэнд байсан дарга нарын нүд оройдоо гарчихлаа. Гэмтэн өөрөө гайхаад, “Юу билээ? Ямар өр авлага юм бол оо?” гэж бодов. Ерөнхий ня-бо үгэндээ итгэлтэй байгаа нь царайнаас нь илэрхий.

-Манай “ПАЗ” автобус яалаа даа? Нэлээн олон хүн тэр автобустай нэр холбогдож арга хэмжээ авахуулахдаа тулсан. Тэгтэл хэн босгосон билээ? Доржсүрэн л босгосон! гэж ерөнхий ня-бо хэлж буй нь тун нухацтай. Энэ үг өрөөнд байсан хүмүүсийн сэтгэлд маш жинтэй буулаа. Ингэж л тэр хүн чанартай эрийн ачаар Доржсүрэн арга хэмжээгүй мултарч байв.

Түүхий эдийн ажилчдыг Махкомбинат руу зөөдөг “ПАЗ” автобус төмөр замын гарман дээр вагонтой мөргөлдөөд, аз болоход хүн эндэж гэмтэлгүй өнгөрч байж. Гэвч зүтгүүртэй мөргөлдсөн машин авах юм үлдэхээргүй ямбий болсон нь мэдээж. Сэг болчихсон тэр автобуснаас Доржсүрэн явах анги, моторыг нь аваад, Хөгжим бүжгийн сургуулиас актлагдсан ижил автобусны кузов тавьж сэлбэн, босгоод ирж байсныг нь Сүрэнхорлоо гуай хэлсэн байж. Машин тэрэг ухаж төнхдөг хобби нь хөдлөөд, юу ч үгүй шамшийсан автобусыг босгоод ирэхсэн гэж хорхойсч гүйсээр тэр ажлыг хийсэн. Тэглээ гээд хэнээс ч шагнал хөлс нэхээгүй өнгөрч байж. Ерөнхий ня-бо харин “Чамайг тэгж байгаад урамшуулна аа. Хэдэн төгрөг өгөлгүй яахав” гэж хэлж байснаа огт мартаагүй нь энэ.

Ингэж л ахынхаа гурван дүүдээ амласан гурван үхрийг авах гэж нилээд паянтай явж. Ах нэг л өөр болчихсон харагдаад, дүүгээ явуулахгүй хоргоож хань татаад байсан нь цаанаа зөнтэй байж. Тэр өвөлдөө Гомбо ах нь бурхан болчихсон гэдэг.

Онц тээвэрчин

Наян тав зургаан оны үед Гутлын үйлдвэр улны резингүй суучихсан тул Улаан-Үд хотоос олж ирнэ гэгцгээлээ. Ингээд 12 дугаар сарын 25-нд хойшоо гарч байв. Дондог дарга Доржсүрэнгэй цуг явна гэхээр нь жолоочийг нь үлдээгээр өөрөө тэргийг нь барилаа. Замдаа Сэлэнгэ аймгаас чүдэнзний үйлдвэрийн даргыг авч давхисаар зорьсон газраа очлоо. Резинээ Улаан-Үдээс олоогүй ч Дондог дарга цааш Эрхүү рүү яваад хоёр вагон резин ачуулах болчихоод ирж.

Нэгэнт л ажлаа бүтээснээс хойш буриад даргын эхнэрийн нутгаар оччихоод буцахаар болов. Явсаар шөнө дундын үед очиход районы намын хорооны дарга, захиргааны дарга хоёр угтаж, хүлээн авалт хийлээ. Дондог дарга садангуудтайгаа буриадаар хөөрөөд л сэтгэл хөдөлж байгаа шинжтэй. Даргын садан хэд хэдэн айлаар ороод, “Би ядарч байна. Маргааш буцах зам хол” гээд унтлаа. Өглөө босоод өнөөх буриад айлдаа тарган үхрийн мах, буузаар дайлуулж аваад хөдөлж, 30-ны шөнө Улаан-Үд хотод ирэв гэнэ. Тэгтэл Дондог дарга,

-Гучин нэгний оройны 7 цагт хотод байхгүй бол болохгүй, үүрээр гарна гэж байна. Тэнд байсан хүмүүс, “Онгоц биш дээ? Тийм юм яаж байх вэ? Замдаа хил дээр шалгуулж зогссоор байтал л оройн долоо болно” гэгцгээв. Дондог дарга,

-Ямар ч байсан 18 цагаас өмнө Улаанбаатар орно шүү! Чи чинь Онц тээвэрчин биз дээ? гэлээ. Үүрээр гарахын өмнө түрүүвчээ үзвэл хувьдаа хорьхон рубльтэй явсан хүн буриад айлуудаас бэлэг авсаар, зуутай болчихож.

-Хил давж гадаадад гарсан хүн байна даа, эхнэртээ бэлэг авъя даа гэж хошигнолоо. Дарга Хиагтаас ав гэхээр нь Улаан-Үдээс гараад давхичихлаа. Нээрээ л Хиагтын хилийн шалган, гааль дээр өчнөөн цаг авлаа. Зогсох далимд зургаан шил “Столичная” архи, хөгшиндөө бугуйн цаг авч том ажил амжуулаад, хилээр гарсан боллоо. Хамт явсан чүдэнзний үйлдвэрийн дарга,

-Та хоёрын долоон цагт хот орох ч лөө лөө боллоо. Манайд амарч хоноод өглөө яв гэж байна. Дондог дарга “Нээрээ ч өнгөрлөө дөө” гэж бодож байгаа бололтой, царай нь баргар харагдана. Тэгэхээр нь,

-Амжина аа, амжина! гэхихээд гараад шидчихлээ гэнэ. Нэг ч зогсолгүй давхисаар оройн тав гучид Улаанбаатар орж ирж байв. Даргаа гэрээр нь оруулж хувцсыг нь солиулаад, Ажилчны соёлын ордон дээр хүргээд өгтөл,

-Чи буц. Ядарсан байгаа. Би өөрөө аргалаад харина гэж. Сүүлд нь сонсвол “Доржсүрэнг “Онц тээвэрчин”, сайн жолооч гэлцэхээр нь тоодоггүй байлаа. Тэгтэл нээрээ л сүрхий жолооч юм билээ” гэж дарга нарт ярьсан байсан гэдэг.

Зурагтай захидал

Хөгжимчин хүн үргэлжийн дуу чимээн дунд байдаг болохоор зүрх нь амархан муудчихдаг юм билээ хэмээн Доржсүрэн хэлээд санаа алддаг. Гэргий Цэдэв нь хөгжмийн нүргээн дунд өдөржин ажиллаад, оройд дахиад л тоглолт үдэшлэг гээд нэжигнээн дэжигнээн рүүгээ буцна. Гэртээ ирлээ гээд чих амрахгүй. Гарсан өдрөөсөө л эхлэн өвдөж уйлж эхэлсэн хүүхдүүдээсээ болоод олон шөнө нойргүй хонож, биеэ улам л ядраасаар байж.

Сайн гэгддэг олон эмчид хандаж, Шанхайд ч хүртэл явж эмчлүүлээ. Тэр их ачааллыг багасгах, нөгөө талаар хэдэн уйланхай хүүхдүүддээ ойр байх гээд цэцэрлэгт дуу хөгжмийн багшаар очиж үзлээ. Чимээ шуугианаас хол, цэвэр агаарт бай гэж эмч нар зөвлөдөг байсныг дагаж, Баян-Уул амралтанд зохион байгуулагч, соёл олон нийтийн эрхлэгчээр очлоо. Гэвч гэргий нь “Миний бие муу” гээд биеэ оторлоод сууж байх хүн биш. Хүний олон хүүхдийн төлөө өөрийн юм шиг зүтгэж, өнөөх л дуу чимээн дундаа гүйсэн. Цэцэрлэгээр дүүрэн орилолдож шуугилдсан хүүхдүүд дунд хормын төдий ч чих амар байгаагүй. Амралтанд ирлээ гээд ч амраагүй. Амрагчдыг угтах, байрлуулах, хоолны ширээ хуваарилахаас эхлээд түмэн ажилтай завгүй явдаг хүн болчихсон. Орой үдэш бас л өнөөх нийтийн бүжгээ явуулж, хөгжмөө тоглож, мөнхийн чимээ шуугиан дундаа байж, биеэ улам л ядраасаар байсан гэдэг.

1981 оны сүүлээр эмчлүүлж сувилуулья, тааруухан байгаа биеэ дээрдүүлье гээд нэгдүгээр эмнэлэгт хэвтэв. Гэтэл тэр эмчилгээ таараагүй гэдэг. “Яалт ч үгүй эмч нар буруу эмчилгээ хийчихсэн” гэж Доржсүрэн халагладаг. Нөхөртэйгөө энэ тэрийг ярилцан, зүв зүгээр алхсаар эмнэлэг рүү ирж хэвтсэн ханийнх нь бие эмч нарын гар хүрсэн биш эрс дордчихсон нь харуусмаар. Эмчилгээ хийлгээд сайжрах байтал эсрэгээрээ, өдөр хоногоор дордоод байгааг Доржсүрэн харж, юу болоод байгааг асууж, эмч нар луу ордог, “Эдгэнэ ээ. Санаа битгий зов” гэцгээдэг байж. Гэвч улам л муудсаар. Эцэст нь “Танай хүн эмчилгээгүй болчихлоо” гэж палхийтэл хэлснийг нь яалтай ч билээ.

-Хөлөөрөө ирсэн юмсан. Хүнээр өргүүлж гарлаа даа! гээд Цэдэв санаа алдаж байсан гэдэг. Хэвтэрт орсон ханьдаа гэрээр эмчилгээ хийлгэлээ. Хоёр бага хүүхэд нь Зөвлөлтөд сурч байсан болохоор дөрвөн том нь ээжийгээ асарна. Оюутны өвлийн амралт болж Гүндэгмаа, Аюурзана хоёрыг ирэхэд ээжийнх нь бие даамай дордчихоод байлаа. Арван дөрөвхөн хоногийн амралтын тал хугацаа нь ирэх очих замдаа үрэгдчихдэг болохоор оюутнууд үзэгдмэгцээ л буцах болцгоов.

-Ээж нь дажгүй ээ. Хоёр хүүхдээ гаргаж өгнө! гэж Цэдэв хэлсэн гэдэг. Доржсүрэн гэргий рүүгээ гайхсан нүдээр харвал,

-Юундаа гайхаа вэ? Чи юм бэлд! гэж. Мах чанаж, бууз чимхэж, дэлгүүрээс идээ ундаа ойртуулаад, ширээ засцгаав. Тэгтэл Цэдэв орноосоо босч ирж хувцаслаад, ширээнд суучихсан нь гайхмаар. Тэр их зовиур шаналлаа давахын тулд ээжээс асар их тэвчээр гарсан нь мэдээж. Хөөрхий, эрүүл хүн шиг байхыг байдгаараа хичээж, ярьж хөөрч, хундага дарс ч хүртэл татаж байж.



Хүүхдүүдээ гаргаж өгсний дараанаас ханийнх нь бие улам л дордсоор байлаа. 1982 оны 2 дугаар сарын 25-ны өдрийг Доржсүрэн хэзээ ч мартдаггүй. Энэ өдөр гэргий нь бурханы оронд явчихсан юм. Тэр үед бүх зүйлийг Орос маягаар зохион байгуулдаг байж. Ажилчны соёлын ордныхон ирж ханийнх нь оршуулган дээр эмгэнэлийн хөгжим тоглоод л. Зурагчин наана цаана гарч, гэрэл гялсхийлгэн зураг дараад л. Доржсүрэнд тэр хөгжим их эвгүй байсан гэдэг. Гэвч сэтгэл гаргаад ирж байгаа хүмүүст “Хөгжмөө боль. Дотор зураад байна” гэж хэлэлтэй биш. Чимээгүй л зогслоо. Зургийн аппаратны чимээ зүрхийг нь “шар-р-р, шар-р-р” хийтэл зүсээд байх шиг санагдаж байж. Тэр чимээний сэтгэлд чийртэй байсныг яана.

Ийм л байдалтайгаар ханийгаа эцсийн замд нь үдэж байлаа. Ертөнцийн нар харанхуйлчихсан юм шиг өдөр хоногууд өнгөрсөн гэдэг. Нэг нь Свердловскт, нөгөө нь Бакуд байгаа хоёр хүүхэддээ хэл дуулгаж чадсангүй. Хэл дуулгалаа ч ирж амжихгүй байсан хэрэг. Онгоцны шууд нислэг байхгүй. Виз даруулахын тулд заавал Москва орох ёстой. Хурдан ирлээ гэхэд дөрөв тав хононо гэдэг нь ойлгомжтой.

Доржсүрэн хоёр хүүхэддээ захидал бичихээр удаан суув. “Ээж чинь нас барсан шүү. Та хоёрыг ирж амжихгүй гээд хэл дуулгасангүй. Миний хүүхдүүд санаа сэтгэлээ хямраалгүй, хичээл номоо сайн хийгээрэй” гэх утгатай зүйл биччих санаатай бодож үзэв. “Ээж чинь нас барсан шүү” гээд шууд биччих гэдэг тун эвгүй. Нулимс асгараад болдоггүй. Тэгтэл өнөөх гэрэл зурагчин санаанд оров. Ингээд “Ертөнцийн жам ёсыг яалтай ч билээ. Миний хүүхдүүд сэтгэлээ бариарай. Хичээл ном чинь чухал шүү” гэх үгтэй захидал бичээд, оршуулгын зурагнуудаас дугтуйд нь хийн илгээж байж. Хэдэн мянган бээрийн алсад сууж байсан хоёр үр нь ижийнхээ тэнгэрт одсон болохыг гэрэл зурагнаас мэдсэн нь энэ.

2011 оны наадмаар Доржсүрэн телевиз үзэж суутал хуучны симфони найрал хөгжмийн тоглолт гарч эхэллээ. Гэтэл талийгаач хань нь хөгжмөө тоглоод сууж байгаа нь харагдаж гэнэ. Амьд юм шиг санагдаж, нүдэнд нь нулимс цийлэлзэв.

-Ээж чинь гарч байна! гэж хүүхдүүддээ сандран хэлтэл, эргэж харахын зуурт баримтат киноны дүрс солигдчихож байв. Ханийнх нь барьдаг байсан хийл хөгжим одоо хүртэл бий. Доржсүрэн энэ хөгжмийг нандигнан хадгалж байдаг.

Зүгээр сууж яасан ч чадахгүй

1983 онд Эрдэм шинжилгээ туршилтын төвөөс тэтгэвэртээ гарлаа. Тэгтэл төвийнхөн цаашаа ажиллаач гэгцгээв. Шинэ технологи туршина, шинэ юм хийнэ, шинэ багаж төхөөрөмж бүтээнэ гэдэг яг л Доржсүрэнд таарах ажил. Яснаасаа дурладаг зүйл нь. “Тийм шинэ машин, багаж хэрэгтэй байна. Та хийж дөнгөх үү?” гэхээр нүд нь сэргэдэг хүн. Бүхий л бие сэтгэлээрээ өнөөх хийж байгаа юман дотроо орчихдог. Хоол идэж байсан ч өнөөхөө яаж хийхээ боддог, унтаж чадахгүй өнөөхөө зүүдлээд босоод ирдэг, төмөртэй ноцолдох ясны хоббитой механикийг ямар ч дарга зүгээр л алдаад явуулчихыг хүсэхгүй. Тийм болоод л ийнхүү үлдээч, цаашаа ажиллаач гэсэн хэрэг.

Доржсүрэн хэсэг ажиллалаа. Ханиа алдаад удаагүй хүнд аль болох оройттол төмөртэй ноцолдон суух нь сэтгэлд амар. Гэртээ очихоор гэргийнх нь царай төрх нүдэнд тодроод, хийж өгдөг цай үнэртэх шиг болоод удаан сууж чадахгүй. Цалингаа ч аваад, тэтгэврээ ч аваад ажиллаад байна гэдэг олон хүүхэдтэй хүнд хэрэгтэй. Хойно сурч буй хоёр бага хүүхдээ төвхнүүлэх үүрэг эцгийн өмнө бий. Тэгтэл “Тэтгэврийн хүнийг ажиллуулж болохгүй” гэх тогтоол гараад ирлээ. Ингээд л тэтгэвэрт суухаас аргагүй боллоо. Гэртээ зүгээр сууж яагаад ч болдоггүй. Тэгэхээр нь Баян-Уул амралт руу сэмхэн очоод хүнсний тэргийг нь барьчихлаа. Тэтгэвэрт гарсан гэдгээ тас нуучихаад л, сарын 400 төгрөгийн цалин хүртчихээд л, жолоогоо мушгиад байлаа. Монгол жижигхэн болохоор илэрчихэлгүй яахав. Болдоггүй юм байж. Ажлаасаа гаръя даа, гээд урам муутай байтал “Тэтгэврийн хүмүүсийг ажиллуулж болно” гэсэн бас өөр шийдвэр гараад ирлээ.

Тэгэхээр нь цааш ахихаар шийдээд, буцаад комбинатдаа тэрэг барих санаатай гүйгээд очлоо. “Надад аргалаад нэг тэрэг өгөөч. Бие хаа сайн байна. Итгэл даагаад ажиллаад байж чадна” гэсээр дарга руугаа орлоо. Тэгтэл өмнөөс нь нухацтай хараад бодол болоод суучих юм гэнэ. “Үгүй л гэх гээд байна аа даа?” гэж бодогдов. Даргадаа гомдмоор. “Насаараа комбинатад зүтгэхдээ муу нэр дуулж яваагүй юмсан. Хөгшин болчихлоо гээд хаях гээд байгаа нь энэ үү?” гэж бодохоос хамрын самсаа шархирах гээд байх шиг. Тэгтэл дарга,

-Та гараажийн дарга хийгээч. Тэгэх үү? гэж тэс өөр юм хэлэх нь тэр. Ажилд авахгүй гэж татгалзах нь уу гээд итгэчихсэн, түрүүлээд гомдчихсон суусан хүн хачин байдалд орлоо. Ёстой л хамрын самсаа шархираад явчихав. “Тэгье, ажиллая” гэж зөвшөөрөөд, нэг жил хэртэй үйлдвэрийн авто гараажийн дарга хийлээ.

Гарааждаа дарга гэхээсээ илүү механик, слесарийн ажлыг нь их хийнэ. Тэргэн доогуур орох хоббитой болохоор нэг мэдэхэд л гар хацар, хувцас хунар, бүх юмаа нил тос болгочихсон, слесариудтайгаа нийлээд машин засаад зогсож байна. Даргын ажлаа огт хийгээгүй гэвэл бас худлаа. Яамны материал хангамжийн хэлтсийн Гомбо гэх өмнө таньдаг байсан нөхрөөсөө талхны тэрэг өгөөч гэж гуйсаар цоо шинэ талхны тэрэгтэй болоод, хуучин яадгаа алдсан тэргийг нь гараажийн буланд тавиулчихлаа. Өөрөө тостой зууралдах дуртай, машин мэддэг даргатай болсон болохоор слесариуд үгэнд сайн орж, ажлаа илт сайн хийдэг болчихлоо. Хэдэн тэрэгнүүдээ тордсоор овоо болгоод авлаа.

Гараажид ирж өдөр болгон машин тэрэг хардаг болсон биш “Тэрэг л барья” гэж бодогдоод

болохоо байлаа. Ээлжийн амралтаараа хүний тэрэг зөндөө л унасан, сүүлд зургаан жил чех даргын жолооч хийсэн, дараа нь амралтын хүнсний тэрэг барилаа. Яахаараа дарагдаж болдоггүй хорхой вэ? гээд өөрийгөө болдогсон бол загначихмаар.

Ингээд явж байтал талхны шинэ машинтай болоод гараажийн буланд хаячихсан хуучин муу “ГАЗ-53” нүдэнд торлоо. Өнөөхийг үзтэл босгоод ирж болмоор. Задалж засч тордоод, хайрцгийн мотор авч тавилаа. Кузовыг нь мод урлалын тасгаар хийлгэж шинээр будаад, талхны сайхан тэрэг болгочихлоо. Тэгээд л өөрөө бариад явж байдаг боллоо.

Гараажийн дарга хүн хэрнээ, Арьс ширний үйлдвэрүүдийн гуанзанд хүнс, талх, нормын сүү зөөгөөд л, хэнэг ч үгүй явна. Ингэснээс болоод даргын ажлаа өгмөөр санагдах боллоо. Сэтгэл санаа өнөөх машинаасаа холдохгүй шинжтэй. Тэгэхээр нь дарга руу ороод, “Гараажийн даргаа больё” гэж гуйлаа. Энэ өдрөөс хойш жолоочийн ажлаа албан ёсоор нь хийгээд санаа амар явах боллоо. Нэг гараад, дахиж буцаж орсоор олон жил ажиллав. Баян-Уул амралтанд очоод төмөртэй ноцолдож, янз бүрийн юм хийж өглөө. Сүүлдээ амралтын “ПАЗ” автобусыг барьж амрагчдыг зөөдөг ажилтай боллоо. Ийнхүү тэтгэвэрт гарч чадсангүй. Зүгээр сууж яагаад ч чадахгүй ажилласаар л байлаа.

Ингэж байтал 1990 он гарч Ардчилсан хувьсгал өрнөлөө. Аж үйлдвэрийн комбинатыг анхаардаг сайд дарга байхгүй болчихлоо. Бүх юм зуун задгай болж, үймж бужигнаж эхлэх нь тэр. Өргөтгөж шинэчилж, тордож сайжруулах бүрт нь гар бие оролцсоор ирсэн, төрсөн гэрээс нь өөрцгүй санагддаг төрөлх үйлдвэр нь тарж бутарч эхлэхийг нүдээрээ харна гэдэг хар дарсан зүүд байлаа. Зуун жилээр ч харамсаад ч барамгүй санагдана. Өөдрөгөөр инээж явдаг аав нь цаг үргэлж үглээд л, хэрээс хэтэрсэн их бухимдуу болчих нь хүүхдүүдэд илт мэдрэгдсэн гэдэг.



Хөдөөдөө ч хотын зах дээр ч, арьс шир ноос ноолуур хөглөрч байгаа хэрнээ үйлдвэр түүхий

эдгүй гэх нь хачирхалтай. Юмны үнэ гэгч зүйлийн хөл толгой нь мэдэгдэхээ байлаа. Үнэ ханшийн учир начрыг яагаад ч олох аргагүй. Түүхий шир аваад, өчнөөн боловсруулалт хийгээд зарах гэхээр авсан үнээсээ доогуур өгөх ёстой болчихно. Монголын үйлдвэрийг унагааж, түүхий эдийн зах зээлд нь ноёлох гэсэн гадны бодлогоор үнэ ханшийг тийнхүү хиймлээр хөөрөгдөж байлаа. Үйлдвэр эргэх ашиггүй гацлаа. Тавин зургаан жилийн турш оршин тогтнож, олон мянган хүнийг, хэдэн үеэр нь тэжээсэн Аж үйлдвэрийн комбинатын салбарууд зогсохоос өөр аргагүйдлээ.

Ажилчид зах зээлийн эргүүлэгт авгаж учраа олохгүй тэвдэв. Урдаа барьдаг оёдолчид, гуталчид, слесарь, механик гээд мэргэшсэн чадварлаг ажилтнууд хэдэн мянгаараа гадаадад гарсан нь харуусмаар. Овсгоотой нь ганзгын наймаанд гарч, хэр тааруу зарим нь гэдсээ тэжээхийн эрхэнд гудамжинд сонин зарж, гутал тосолдог боллоо. Ажилгүй болсондоо гундаж гутарсан олон хүн архинд орж амьдралаа сүйтгэсэн нь аймшигтай. Шунахай сувдаг хүмүүс, хурган албан тушаалтнууд үйлдвэрийн тоног төхөөрөмж, хамаг юмыг тонож зөөж ачиж эхэлсэн нь нүд хальтрам. Доржсүрэнгийн уур бухимдал эцсийн цэгтээ тулаад, “Одоо больё, тэтгэвэртээ сууя!” гэхихээд үйлдвэрээсээ гарч одсон гэдэг. Болж буй бүхэн тэвчихийн аргагүй байсан учраас л энэ.

Үр удам

Алс тэртээх 1946 онд, арван есөн настай хүүгийн алганы хээг шинжсэн япон цэрэг “Чи хорь гарангуут гэрлэнэ. Маш олон хүүхэд гарна. Их урт наслана. Наян таван нас хүрээд паанаа!” гэж мэргэлсэн байдаг. Нээрээ л Доржсүрэн хорин хоёр настайдаа Цэдэв хэмээх сайхан бүсгүйтэй гэрлэсэн. Их урт наслана гэсэн нь бас биелсэн. Харин наян таван нас хүрээд нүд анина гэсэн нь таарсангүй. Одоо Доржсүрэн наян долоо хүрчихсэн хэрнээ амьд сэрүүн, хөнгөн шингэн гүйж яваа. “Сумын наадамд хоёр давчихаж чадахаар тэнхээтэй байгаа. Харин нүд үзэхгүй, чих сонсохгүй болохоор андуураад, засуулаа шидчихэж мэднэ шүү!” гэж хошигнон инээж сууна. Цаашдаа олон жил амьдарч үр ач нартаа түшиг болж, алдаа оноог нь хэлэх үедээ хэлсээр л байх болно. Ахмад үеийнхэн яаж хөдөлмөрлөж, ямар хүнд бэрхийг давж, хэрхэн бүтээн босгож байсныг өнөөгийн залууст ярьж хэлнэ, мэдрүүлж мэдүүлнэ гэсэн өөдрөг бодолтой явна.

Япон цэргийн мэргэлснээр эднийд маш олон хүүхэд гарсан. Бүгд эсэн мэнд өссөн бол арван хоёр хүүхэдтэй айл болох байж. Харамсалтай нь зургаан хүүхэд нь нялхдаа эндчихсэн гэдэг. Ерөнхий механик Доржсүрэнгийн алба цаг наргүй. Цэдэв урлагийн хүн болохоор тоглолт, үдэшлэг цэнгүүн гээд орой бүр буцах ажилтай. Хүүхдүүд нь гарангуутаа л өвчин ороож, өдөржин шөнөжин уйлж зовоодог, хоёул улсын тэр их ажлыг амжуулах, олон нялх нойтон хүүхдээ асрах гэсээр их ядарч зүдэрч байсан гэдэг.


Багадаа уйлж ороож байснаа бодвол хүүхдүүд нь өдөр өдрөөр өсч, биеэ даацгааж, гэр орны ажилд эцэг эх хоёроо хүргэхээ больж, дунд сургуулиа цувран төгсөцгөөж эхэллээ. Эдний хүүхдүүд гэрээрээ сурлага сайтай хэмээн айл хөршүүд нь магтдаг. Бүгдээрээ онц сурч, ийш тийшээ сургууль соёлд одоцгоож, нэг л мэдэхэд эдийн засагч, механик, программист, технологи-инженер, маркшейдрийн инженер болчихсон эх орондоо зүтгэж эхэлсэн нь сайхан.



1951 онд төрсөн том охин Гэрэлмаа нь одоо компани удирдаж, тавь жаран хүний амьдралыг авч явна. Энэ охиныг хүмүүс аавыгаа дуурайсан гялалзуур, юмыг түргэн сэтгэдэг хэмээн магтацгаадаг. Ундааны үйлдвэрээр анх гараагаа эхэлж байсан түүний бизнес байнга л өсөж дэвжсээр ирсэн. Бэрхшээл саад ч зөндөө тулгарсан нь мэдээж. Тэр бүхнийг зориг гарган даван туулсаар явсан. Гэрэлмаа Өвөрхангай аймгийн алдар цуутай Хужиртын халуун рашааныг түшиглэн Элма-Хужирт шавар, рашаан сувиллыг ажиллуулж байна. Амралтаа орчин үеийн барилга, тоног төхөөрөмжтэй тохилог байртай болгосноор барахгүй цааш

өргөжүүлж амралтын шинэ цогцолбор барьж босгож явна. Үүний зэрэгцээ ээж Цэдэвийнхээ анхлан байгуулалцаж, өөрөө ч анхны хоол зөөгчөөр нь ажиллаж байсан Элма Баян-Уул амралтыг хувьчлалаар аваад, ажиллуулж байгаа.

1953 онд төрсөн Зоригт хүү аавыгаа дуурайсан уран гартай, техникийн авьяастай, бүхнийг хийж чаддаг нэгэн байж. Эхлээд ЗХУ-ын Фрунзе хот, дараа нь Румын улсад механикийн мэргэжлээр суралцаж ирээд Нэхмэлийн үйлдвэрт ажилласан. Яг л аав шигээ бүх машиныг засдаг болж, үйлдвэрийн урдаа барьдаг хүн нь болсон гэдэг. Зумаа даргатай Нэхмэлийн үйлдвэрийн бүх машиныг суурилуулж явж. Оёдлын машинаар гэрээ дүүргэчихээд л, засаад суудаг нь аавыгаа санагдуулдаг байсан гэдэг. Хэлэндээ мундаг учраас хаана л румын хүн ирнэ, тийшээ Зоригт дуудагддаг байлаа.



1955 онд төрсөн охин Цэрэндулам нь Эрхүү хотын Политехникийн дээд сургуулийг Автоматическая система управления буюу одоогийн нэршлээр программ хангамжийн инженер мэргэжлээр суралцаж төгссөн. 1988 онд Япон улс руу явж, сансраас ирсэн мэдээллийн задлан шинжилгээн дээр ажилладаг мэргэжилтэн болоод, тэндээ өнөөг хүртэл ажиллаж байна. 1956 онд мэндэлсэн удаах охин Цэндсүрэн нь техник мэргэжлийн сургуульд суралцаж хиамны технологийн мэргэжилтэй хүн болсон. 1962 онд төрсөн охин Гүндэгмаа нь ЗХУ-ын Баку хотын Нефть химийн технологийн дээд сургуулийг, технологи инженерийн мэргэжлээр төгсөж, Зүүнбаянд олон жил мэргэжлээрээ ажилласан. 1963 онд төрсөн бага хүү Аюурзана нь ЗХУ-ын Свердловск хотын Уул уурхайн дээд сургуулийг, маркшейдрийн инженер мэргэжлээр төгссөн, одоо эгч Цэндсүрэнтэйгээ хамт Баян-Уул амралтыг ажиллуулж байна.

Доржсүрэнгийн хүүхдүүд ажилтай албатай, нэртэй төртэй, сайхан амьдарцгаасан. Одоо

хамгийн бага нь хэдийнээ тавин нэгэн нас хүрчихсэн сууж байна. Тэд бүгдээрээ хүүхэд биш өвөө эмээ болж амжаад, ач зээгээ тойруулчихсан жаргаж сууна.

Сэтгэлийн эмзэглэл

Ерэн насыг шүргэх шахсан хөгшин одоо төрөлх Аж үйлдвэрийн комбинатынхаа хашаагаар ороход хов хоосон, эл хуль оргиод эвгүй байдаг. Эвдэрч нурсан, хоосорч тоногдсон, ханхай барилгуудыг хараад нулимс нь гарч ирдэг. “Орчлон хороололд аж төрдөг зээ охиныдоо очих гээд үйлдвэрийнхээ хашаан дундуур нэвт гарах болоход нүд хальтирч, цээж бачуурдаг” гэж хөгшин ярьдаг.

Эрдэм шинжилгээ туршилтын төв хоёр мянга хэдэн онд тэтгэврийн хөгшчүүдээ цуглууллаа. Олон жил биенээ хараагүй ахмадуудаа хооронд нь уулзуулж, сэтгэлийг нь сэргээе гэж хуучин дарга нар, ахмадын зөвлөл нь сайхан сэтгэл гаргасан нь энэ. Гэвч ажиллаж байсан төрөлх газраа арван хэдэн жилийн дараа эргэн харсан нь сэтгэлийн шархыг сэдэрээж, дотор бачууруулчихсан гэдэг.



Эрдэм шинжилгээ туршилтын төвийн барилгын аль өрөөнд юу байсныг ажилчид сайн мэднэ. Бүх тоног төхөөрөмжүүд, суурь машинууд ор сураггүй. Оёдлын тасаг байсан танхимд чулууны үйлдвэр орчихсон. Арьс шир боловсруулж туршдаг цехийг нь ханхай болгон хоослоод, агуулахын зориулалтаар түрээсэлчихсэн. Лаборатори нь хөндий өрөөнүүд болчихсон. Дотор харламаар байж. Хуучин цагт ажил хөдөлмөр буцалсан байгууллага байсан нь нэг л даржин. Хэдэн өрөөнүүдээ түрээсэлмэр аядаад, үлгэн салган амьдарч байгаа нь харуусмаар. Доржсүрэнгийн зүрх зүсэгдэх шиг болж.

Нэгэн жарны туршид өчнөөн хөрөнгө зарж, үе үеийн мянга мянган ажилчдын хөдөлмөрийг үрж байж босгосон Аж үйлдвэрийн комбинатаа өөд татаж, технологийн шинэчлэл хийгээд, додомдоод явж яагаад болсонгүй вэ? гэж Доржсүрэн шиг олон ахмадууд гайхдаг. Хэдэн үеийн ажилчдын хөлс хүч, сэтгэл оюун шингэсэн бүтээн босголтыг “Социализмын хоцрогдол” гэж адлаад, юу ч үгүй үрэн таран хийчихэнд настан буурлууд асар их харуусдаг. Хамгийн эмгэнэлтэй нь Аж үйлдвэрийн комбинатыг бодох санах юмгүйгээр нурааж дуусгасан дарга нар одоо Дархан хотод Арьс шир боловсруулах үйлдвэрийн цогцолборыг бүтээн босгоно гэж ярьцгааж байна.

Инээд ч хүрэх шиг. Эгдүү ч хүрэх шиг. Харуусал ч төрөх шиг. Тавь жаран жилийн туршид бүтээн босгосон Аж үйлдвэрийн комбинатыг тав зургаахан сарын дотор үрэн таран хийсэн энэ харалган алхам хорьдугаар зууны Монголын хамгийн эмгэнэлтэй гашуун түүх болон бичигдэн үлдэх биз ээ.

Баян айл

Мянга есөн зуун дөчөөд оны сүүл үед, одоогийн Нарны гүүрний өмнөд үзүүр орчимд, цэлгэр уужим хашаан доторх дэнхийсэн том гэр хэн хүний нүдэнд онцгой содон тусдаг байлаа. Энэ бол хүүхэд наснаасаа эхлэн улсдаа зүтгэсэн Доржсүрэн гэх энгүүн нэгэн хөдөлмөрчин хүмүүний өргөө цагаан гэр. Тэр гэрт хавийн хүүхдүүд гүйлдэж ирээд, хээ хуарыг нь сонирхон харж, нусаа ч татахаа мартан алмайрах нь өхөөрдөм. Айл хөршийн хүүхдүүд хоорондоо, “Гоё гэртэй, баян айл” хэмээн ярилцдаг байж.

Хүүхдүүдийн хэлдэг баян айл гэдэг яах аргагүй үнэн үг. Лхамжав ээжийн хэдэн хүүхэд Аж үйлдвэрийн комбинаттай хувь заяагаа холбоод бүгд баян хүмүүс болсон. Авдар бялхсан их мөнгөтэй баян хүмүүс биш, хоймор дүүргэсэн олон найз нөхөдтэй, хотойход түших хамт олонтой, түмэнд дуурсах алдар нэртэй, баян хүмүүс болцгоосон.

Одоогоос наян жилийн тэртээ Хар бухын голын хөндийгөөс нийслэл Улаанбаатарыг зорин, долоон өртөө холыг үхэр тэргээр туулах замдаа Лхамжав ээж “Бичиг эрдэмгүй намайг ажилчнаар авах болов уу, яадаг бол? Арван хэдтэй охид минь үйлдвэр комбинат гэгчийн ажлыг хийж чадах уу даа?” гэж санаа зовниж явсан нь лавгай. Долоо хүрсэн хэрнээ эрхэлж, мөөмөө хөхсөөр байсан Доржсүрэнг ажилчин болно гэж зүүдлээ ч үгүй биз.

Гэтэл тэр хүү нь хоёр эгч шигээ өсвөр насандаа Аж үйлдвэрийн комбинатын слесарь болж, төд удалгүй Гутлын үйлдвэрийн ерөнхий механикаар дэвшиж, үйлдвэрийн орлогч даргын албыг хүртэл хашсан хүндтэй нэгэн болсон. Ээжийнхээ энгэрт наалдаж эрхэлсэн тэр л хүү Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Самбуугийн гараар энгэртээ Хөдөлмөрийн хүндэт медаль зүүлгэж, Алтан гадас одонгоор шагнагдаж, түмэн янзын машиныг түүртэлгүй засдаг алтан гартай механик гэж олноо алдаршсан.



1934 онд, арван дөрвөн насандаа Гутлын үйлдвэрт эсгүүрчин, оёдолчноор орсон ихэр охид Дэндэв, Сэрээтэр нь хамт олноо манлайлан ажиллаж, ударник цол хүртэцгээж, улс орон даяар нэр алдар нь цуурайтсан тэргүүний сайчуудын эгнээнд багтсан. Ударник гэдэг бол таван жилд долоо наймаар зогсохгүй арван жилийн ажил хийсэн сайчуудад олгодог босго өндөртэй цол.

Дэндэв 1952 онд Монгол улсын төрийн тэргүүн Хорлоогийн Чойбалсанг нас барахад энэ хүндтэй хүний суудлыг орлож, Үйлдвэр комбинатаас Ардын Их Хурлын депутатаар

сонгогдож байсан. Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медалиар энгэрээ мялааж, Ардын Их Хурлын депутатаар хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж явсан гавьяатан болсон.

Сэрээтэр нь нормчин оёдолчноор хөдөлмөрийн гараагаа эхэлж, ударник цол хүртэж, Хөдөлмөрийн хүндэт медалиар хоёронтоо энгэр мялаасан. Том хүү Гомбо нь Аж үйлдвэрийн комбинатын цагдаагийн салаанд нэр төртэй зүтгэж, тэндээсээ түр цэргийн албанд мордож, Хэнтийн Батширээтийн ард түмэнд “Адуучин Гомбо” гэж хүндлэгдсэн сайн малчин болж, олон үр хүүхдээ тойруулсан өнөр өтгөн сайхан өрхийг тэргүүлсэн.

Ард Гэндэнгийн үр сад Аж үйлдвэрийн комбинат хэмээх том айлыг түшсэнээрээ түмэнд дуудагдах нэртэй, улсад дуурсах алдартай, хойчид дурсагдах түүхтэй амьдарсан нь маргашгүй үнэн. Лхамжав ээжийн хүүхдүүд баян хүмүүс болцгоосон.



Амнаас нь эхийн сүү үнэртсэн алдрай хөвгүүн байхдаа Доржсүрэн Аж үйлдвэрийн комбинат гэх энэ их айлын Алтан босгоор алхсан. Тэр мөчөөс эхлэн жулдрай хүүгийн хувь заяа үйлдвэр комбинаттай насан туршдаа гагнагдсан байдаг. Ард олон түүнийг “Гутлын үйлдвэрийн хар Доржсүрэн” хэмээн төрөлх үйлдвэрээр нь овоглон цоллосон. “Миний амьдралын хамгийн аз жаргалтай мөчүүд энэ хашаанд өнгөрсөн” гэж тэр хэлдэг. Доржсүрэн комбинатдаа их хайртай. Комбинатыг муу хэлсэн хүнд дургүй.

Аж үйлдвэрийн комбинатын бүх салбарт эдний гэр бүлийн төлөөлөл бий. Гутлын үйлдвэрт Доржсүрэн, ээж Лхамжав, ах Гомбо, ихэр эгч Дэндэв, Сэрээтэр, бэргэн Цэдэндамбаа дээр нэмэгдээд гэргий Цэдэвийнх нь ихэнх дүү нар ажилласан. Ажилчны театрт гэргий Цэдэв нь, Ноосны үйлдвэрт Намсрай ах нь, Цахилгаан станцад Дагвабазар ах нь, Архи пивоны үйлдвэрт Төгсжаргал эгч нь ажиллаж, улс эх орондоо хөдөлмөр зүтгэлээ өргөж явсан. Энэ бүх хүмүүсийн амьдралын их мөрөн комбинат гэх далайгаас эхтэй. Аж үйлдвэрийн комбинаттай насан үүрд холбогдсон амьдралын түүх нь сонин содон агаад үлгэр дууриалтай. Тэд бүгдээрээ, үр хүүхэд, ач зээ нь энэ түүхээрээ бахархдаг.

“Ажилчид гэдэг сайхан хүмүүс. Олуулаа цуглараад ярьж хөөрөх нь хүртэл өөр. Ажлаа тараад цугтаа алхацгааж, биенээ явуулж, хөгжицгөөнө. Биендээ оносон хоч өгнө. Харуулын хаалганаас гараад ийш тийшээ бутарцгаахад, маргааш хурдан болоосой гэх бодол өөрийн эрхгүй толгойд ирдэг. Ийм сайхан хүмүүсийн халуун дулаан уур амьсгалд амьдралынхаа ихэнх цаг мөчөө өнгөрөөсөн би их хувь заяатай хүн” гэж Доржсүрэн хэлдэг.

Доржсүрэн тавин жил үйлдвэртээ зүтгэхдээ засварчин, слесарь, ерөнхий механик, орлогч

дарга, материал хангамжийн мэргэжилтэн, жолооч гээд олон албыг залгуулж иржээ. Засварчин жолооч байлаа гээд гутарч гуниагүй, ерөнхий механик, орлогч дарга боллоо гээд хамраа сөхөж сэхээгүй. Ажлын төлөө алд биеэ хайр найргүй үрж, авч идэх шуналгүй, ариун цагаан хөдөлмөрийнхөө буяныг хүртсээр нэгэн насны амьдралаа туулжээ. Арван дөрвөн настайдаа “том хүн” болсон, эгэл нэгэн хүмүүний амьдралын түүх ийм болой.

Table of Contents

Урт нүүдэл	
Зүлгэн дээр гэрээ барив	
Комбинатын сургуульд	
Насан туршийн найзууд	
Арав үзсэн кино	
Хурууны үнэтэй аялал	
Үнэгүй хонь	
Эмч болчих дөхсөн нь	
Хамгийн сайхан хичээл	
Ардын жүжигчний машинд	
Хэлмэгдлийн бараан сүүдэр	
Галзуу чоно, мөрийтэй тоглоом	
Хөлөөвийн хөрш	
Арван дөрөвтэй “том хүн”	
Авьяастай бас зантай	
Монгол аргын зүү шөвөг	
Жаахан хүүхдэд их мөнгө өгөхгүй	
Нөхрийн шүүх	
Коммунист субботник, капиталист бизнес	
Наадам эсвэл нандин бараа	
Олзны япончуудтай	
Япончуудын тус	
Морьт отряд, соёлын довтолгоо	
Хань	
Гэр барьсан түүх	
Өдөн малгай	
Орос бүдэрсний төлөө монголыг ташуурдсан нь	
Эхний бөгөөд эцсийн янжуур	
Өрөөнөөсөө айдаг механик	
Ажилчны эрэлд	
Механик	
Хэзээ ч орхихгүй хобби	
“Шкода”-ны үнэтэй шбос	
Амралтаа авахаараа жолооч	
Айлд өргүүлэхгүй бол өнгөрнө	
Тарнийн хүч	
Балган ноёны хиа	
Адуучин ах	
Хоёр дугуйтай машин	
Ижий	
Хотын “томилолт”	

[Нам засгийн “00”](#)
[Тэвчээр алдарсан паян](#)
[Учир битүүлэг дээл](#)
[Чех багшийн багш](#)
[Социалист хүмүүжил](#)
[Үйлдвэрийн өргөтгөл](#)
[Нийтэд зориул](#)
[Чехүүдийн буян](#)
[Гадаад байрны дотоод айл](#)
[Соёлын довголгоо нүргэлсээр л](#)
[Орон сууцны асуудал](#)
[Хуучин гутлын аян дайн](#)
[Мотоспортын мастер](#)
[Орлогч дарга](#)
[Адтай охин](#)
[Дарга жолооч](#)
[Чех дарга, тарваганы мах](#)
[Нийгэм нэгдүгээрт](#)
[1966 оны аймшигт үер](#)
[Үйлдвэр минь яагаа бол?](#)
[Нутаг буцаана!](#)
[“ARO” Ав!](#)
[Генерал хүний сүрхий үг](#)
[Шавь нар](#)
[Өртэй биш авлагатай](#)
[Онц тээвэрчин](#)
[Зурагтай захидал](#)
[Зүгээр сууж яасан ч чадахгүй](#)
[Үр удам](#)
[Сэтгэлийн эмзэглэл](#)
[Баян айл](#)